

Шоронгоос бичсэн захидлууд

Виллиям Макдоналд

Гарчиг

ЕФЕСИЙН ЧУУЛГАНД БИЧСЭН

ЗАХИДАЛ	1
Оршил.....	1
I. ХРИСТ ДОТОРХ ИТГЭГЧДИЙН БАЙР СУУРЬ(бүлэг 1-3)	10
II. ИТГЭГЧДИЙН ЭЗЭНТЭЙ АЛХАХ АМЬДРАЛ (бүлэг 4-6)	132

ФИЛИППОЙН ЧУУЛГАНД БИЧСЭН

ЗАХИДАЛ	229
Оршил.....	229
I. Паулын мэндчилгээ, магтаал болон залбирал (1:1-11).....	239
II. Паулын шорон дахь нөхцөл байдал, ирээдүйн төлөв, тэсвэрлэн туулахыг гуйсан хүсэлт (1:12- 30)	248
III. Христийн даруу байдал болон золиосын үлгэр дууриаллаар нэгдэх тухай уриа (2:1-16)	261
IV. Паул, Тимот, Епафродит гурвын христгэч үлгэр жишээ (2:17-30)	281
V. Хуурамч багш нарын эсрэг сануулга (3:1-3)	290
VI. Паул Христийн төлөө өв залгамжлалаасаа татгалзаж, хувийн ололт амжилтаа үгүйсгэв (3:4-14)	295
VII. Элчийн үлгэр жишээгээр тэнгэрлэг алхаанд дуудсан уриа (3:15-21)	312

VIII.	Эв эе, харилцан туслалцаа, баяр хөөр, тэвчээр, залбирал ба оюун бодолдоо сахилга баттай байх тухай уриалга (4:1-9) ······	321
IX.	Ариун хүмүүсийн өгсөн мөнгөн тусламжийн төлөөх Паулын талархал (4:10-20) ······	331
X.	Төгсгөлийн мэндчилгээ (4:21-23) ······	341

КОЛОССАЙН ЧУУЛГАНД БИЧСЭН

ЗАХИДАЛ ······	344
Оршил ······	344
I. ХРИСТ БҮХНЭЭС ДЭЭД ГЭХ СУРГААЛ (бүлэг 1, 2) ······	356
II. БҮХНЭЭС ДЭЭД ХРИСТИЙН ӨМНӨ ХРИСТИТГЭГЧДИЙН ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ (бүлэг 3, 4) ······	444

ФИЛЕМОНД БИЧСЭН

ЗАХИДАЛ ······	500
Оршил ······	500
I. МЭНДЧИЛГЭЭ (1-3) ······	506
II. ФИЛЕМОНЫ ТӨЛӨӨХ ПАУЛЫН ТАЛАРХАЛ БА ЗАЛБИРАЛ (4-7) ······	509
III. ОНЕСИМЫН ТӨЛӨӨХ ПАУЛЫН ГУЙЛТ (8-20) ······	512
IV. ТӨГСГӨЛИЙН ҮГ (21-25) ······	522

Нэмэлт тайлбар ······	526
------------------------------	------------

ЕФЕСИЙН ЧУУЛГАНД БИЧСЭН ЗАХИДАЛ

Оршил

“Элч Паулын бичээсүүдийн титэм”

– Ж. Армитаж Робинсон

“Паулын гурав дахь тэнгэрийн захидал”

– А.Т. Пийрсон

I. БИЧЭЭСТ ЭЗЛЭХ ОНЦГОЙ БАЙР СУУРЬ

Мэндчилгээ, талархал, сургаал номлолын тайлбар явснаа тэдгээрийг хэрэгжүүлэх бидний үүргийг сануулах, хаалтын үг буюу баяртайлах хэв маягаараа Ефес ном бол Паулын бичдэг ердийн захидал мэт. Гэхдээ захидал боловч бараг л номлол тэр байтугай залбирал, магтаал бүхий хүндэтгэлийн цаг шиг гэлтэй.

Энэ захидлын тухай Муурхээд “Бид ариун газрын аниргүйн дунд ордог...Энд амар амгалан, бясалгал, магтан хүндэтгэл, энх тайвны уур

амьсгал ноёрхдог”¹ гэжээ.

Дээр дурдсан Робинсоны үнэлэмжтэй олон шүүмжлэгчид санал нийлсээр байтал өнөөгийн зарим судлаач эрдэмтэд Ефес номыг Паул бичсэн байж таарахгүй гэж үздэг нь арван наймаас арван есөн зууны түүхтэй Христчин сургаалыг үгүйсгэж дүгнэсэн хэрэг юм. Тэгэхээр үүнд нотлох баримт байна уу?

II. ЗОХИОГЧ

Гадаад нотолгоогоор нь Ефес номыг Паулын бичсэн захидал гарцаагүй мөн гэж хэлж болно. Паулын бичсэн захидлуудын алийг нь ч ийм эртнээс, ийм тасралтгүй гэрчилж байгаагүй. Үүнд Ромын Клемент, Игнатиус, Поликарп, Хермас, Александрын Клемент, Иренеаус, Хипполитусыг дурдаж болно.

Марсион өөрийн бүрдүүлсэн “ариун бичээс”-т “Лаодикчууд” нэрээр оруулсан. Мураторын бичээст Ефес номыг Паул бичсэн гэж жагсаасан.

Дотоод нотолгоо нь бичээч өөрийгөө Паул гэж (1:1, 3:1) хоёр ч удаа дурддаг бөгөөд захианы агуулга нь Колоссай номынхтой (*зарим* талаараа) тун төстэйгээс харахад тэднийг цаг хугацааны

хувьд ойрхон бичсэн байж таарна.

Өмнө дурдсанчлан Ефес номын бүтэц зохион байгуулалт нь ердийн л Паулын захидал. Паул энэ номоороо хэд хэдэн шинэ санааг дамжуулсан нь үнэн. Гэхдээ шинэ санаа гаргаж тавих л юм бол хуурамч гэж үзвээс Библийг бичсэн хүмүүст христитгэгч ариун хүмүүсийг төлөвшихөд нь туслах боломж олдохгүй шүү дээ!

Энэ захидлыг Паул бичээгүй гэж анх удаа либерал үзэлт Шлаермахер гэгч герман хүн хэлсэн. Уг тунхагийг Мофат, Гүүдспийд зэрэг олон хүн дагасан.

Үгсийн сан, бичлэгийн хэв маяг, "гүн гүнзгий" номлол болон бусад субъектив зүйлс дээр үндэслэн энэ номыг элч Паул бичээгүй гэж няцаахыг оролджээ. Гэсэн ч эдгээр үзэл онол нэг бүрд бүрэн дүүрэн хариу өгч болно.

Гадаад нотолгоо асар их байгаагийн зэрэгцээ олон тооны эрдэмтэн судлаачид энэхүү захидлыг яг Паулын хэв маягаар бичсэн гэж үзээд зогсохгүй, Колериджийн хэлснээр түүний хамгийн "тэнгэрлэг бичээс" гэж үздэгээс захидлыг жинхэнэ үнэн хэмээн хүлээн авах хэрэгтэй.

III. БИЧИГДСЭН ОГНОО

Ефес ном Колоссай, Филиппой, Филемон номуудын нэгэн адил "Шоронгоос бичсэн захидал" юм. Аль шорон гэдгийг (3:1, 4:1) тойрсон маргаан байдаг. Зарим нь Паулыг Кайсарид хоёр жил хоригдох үедээ бичсэн, тэр байтугай ямар ч нотолгоогүйгээр Ефест хоригдох үедээ бичсэн гэж итгэдэг боловч Ромд анх удаа хоригдсон үедээ (М.Э. 60 оны дараахан) бичсэн гэх баталгаа нь илүү жин дарж байна. Энэ захидал Колоссай номын нэгэн адил (4:7-9) Азид Тухикаар (6:21-22) дамжиж ирсэн. Сургаал номлолууд нь хоорондоо төстэй байгаа нь үүгээр тайлбарлагддаг. Эдгээр захидлыг бичиж байхад ижил төстэй санаанууд элчийн оюун бодолд шинэхэн бөгөөд тодхон байжээ.

IV. ТҮҮХЭН НӨХЦӨЛ, ХӨНДСӨН СЭДЭВ

Паулын "нууц" гэж нэрлэсэн зүйл нь Ефес номын гол сэдэв болно. Нууц гэж тэр тайлбарлахын аргагүй зүйлийг хэлээгүй, харин өмнө нь далд байж байгаад одоо тайлагдан илчлэгдэж байгаа гайхамшигтай үнэнийг хэлжээ.

Номын сэдэв болох энэхүү агуу үнэн нь итгэгч иудейчүүд болон итгэгч харь үндэстнүүдийг Христийн дотор нэг болж байгааг зарласан тунхаг юм. Тэд одоо Христийн бие болох чуулганы ижил гишүүд болов. Өнөөдөр тэд тэнгэрлэг газарт Христийн дотор заларчээ. Хожим тэд бүхний Тэргүүн болох Түүний алдрыг хуваалцах юм.

Энэ нууц Ефес номын зургаан бүлэгт бүгдэд нь дурдагдсан байна.

Нэгдүгээр бүлэгт үүнийг Бурханы хүслийн нууц гэж нэрлэсэн бөгөөд тэнгэр газар дээрх бүх юмс Христийн тэргүүлэл дор орох цагийг хүсэн хүлээсэн байдлаар дурддаг (ишлэл 9, 10). Итгэгч иудейчүүд (ишлэл 11 “бид”) болон итгэгч харь хүмүүс (ишлэл 13 “та нар”) тэр өдрийн алдраас өөрсдийн хувийг хүртэх болно. Тэд Түүнтэй хамт, Түүний бие бөгөөд Түүний бүрэн дүүрний хувьд орчлон ертөнцийг бүхэлд нь захирна (ишлэл 22, 23).

Хоёрдугаар бүлэг нь иудейчүүд хийгээд харь үндэстнүүд Бурханы нигүүлслээр аврагдсан, тэд хэрхэн Бурхантай болон бие биетэйгээ эвлэрсэн, Христтэй нэгдэн хэрхэн нэг шинэ хүн болсон,

хэрхэн Бурханы Ариун Сүнсээрээ оршдог ариун сүм болсон үйл явцыг дүрслэн харуулдаг.

Гуравдугаар бүлэг нь тэр нууцыг бүрэн төгс тайлбарладаг. Тэнд үүнийг Христ тэргүүн нь, харин бүх итгэгчид бие нь болох “Христийн” нууц гэж хэлдэг (ишлэл 4). Итгэгч харь үндэстнүүд энэ Биений дотор Бурханы амлалтын хамтран өвлөгчид, гишүүд бөгөөд хамтран оролцогчид юм (ишлэл 6).

Дөрөвдүгээр бүлэгт энэ Биений эв нэгдэл бөгөөд тэрхүү Биенийг төлөвшил рүү өсгөх Бурханы төлөвлөгөөг онцолжээ (ишлэл 1-16).

Тавдугаар бүлэгт тэр нууц бол Христ ба чуулган гэж хэлсэн байна (ишлэл 32). Христ чуулган хоёрын харьцаа нь итгэгч эхнэр, нөхөр хоёрын харьцааны үлгэр загвар ажээ.

Эцэст нь, зургадугаар бүлэгт Паул сайн мэдээний нууцыг ярьдаг бөгөөд өөрөө тэрхүү сайн мэдээний хорионд байгаа элчин сайд болсон ажээ (ишлэл 19-20).

Энэ мэдээ тэдгээр итгэгч харь үндэстнүүдэд яаж нөлөөлөхийг бодоод үз дээ. Тэд иудейчүүдийн нэгэн адил зөвхөн итгэлийнхээ улмаас нигүүлслээр аврагдаад зогсохгүй, анх

удаагаа тэдэнтэй эн тэнцүү эрх бүхий байр суурьтай боллоо. Тэд Бурханы эзлэх байр суурийн хувьд иудейчүүдээс өчүүхэн ч доогуур биш байсан. Тэд бас Есүстэй хамт сэнтийд заларч, Түүний Бие бөгөөд Сүйт бүсгүйн хувьд ертөнцийг захирах алдрыг нь хамтран хүртэх хувь заяаг хүлээн авчээ.

Ефес номын бас нэг чухал сэдэв бол хайр (*аганэ*: гр. “шийдвэрээр дамжин илэрхийлэгдэх хайр” гэсэн утгатай). Паул захидлаа эхлэхдээ ч, төгсгөхдөө ч энэ санааг (1:4; 6:24) илэрхийлсэн бөгөөд Ефест энэ нэр үг болон үйл үгийг бусад захидлуудаас олон хэрэглэсэн байна. Яагаад гэвэл гучин жилийн дараа олон хүнтэй, идэвхтэй чуулган хуурамч сургаал, буруу номлолтой тэмцэх тушаалыг дуулгавартай биелүүлж байсан боловч Эзэн Ефес дэх чуулганд хандаж бичсэн захидалдаа анхны *хайраа* орхисон байна гэж зэмлэсэн. Үүнээс Ариун Сүнсний урьдчилан мэдэх чадвар харагдсан байж болох (Илч 2:4).

ТОЙМ

I. ХРИСТ ДОТОРХ ИТГЭГЧДИЙН БАЙР

СУУРЬ (бүлэг 1-3)

А. Мэндчилгээ (1:1, 2)

Б. Нигүүлсэл-ивээлийн төлөө Бурханд өргөх Паулын магтаал (1:3-14)

В. Ариун хүмүүсийн төлөөх Паулын талархал ба залбирлууд (1:15-23)

Г. Бурханы хүч харь үндэстнүүд ба иудейчүүдийн авралаар дамжин илэрхийлэгдсэн нь (2:1-10)

Д. Итгэгч иудейчүүд, итгэгч харь үндэстнүүдийн Христ доторх нэгдэл (2:11-22)

Е. Ярианы завсар нууцын тухай өгүүлсэн нь (3:1-13)

Ё. Ариун хүмүүсийн төлөөх Паулын залбирал (3:14-19)

Ж. Паулын магтаал (3:20, 21)

II. ИТГЭГЧДИЙН ЭЗЭНТЭЙ АЛХАХ АМЬДРАЛ (бүлэг 4-6)

А. Христитгэлт нөхөрлөлийн эв нэгдлийн төлөөх уриа (4:1-6)

Б. Биеийн гишүүдийн зохистой ажиллагааны хөтөлбөр (4:7-16)

В. Шинэ ёс суртахууны төлөөх уриа (4:17-5:21)

Г. Христигэлт гэр бүлд хүн бүр ариун байх тухай уриа (5:22-6:9)

Д. Христигэлийн тулааны тухай сэрэмжлүүлэг-ятгалга (6:10-20)

Е. Паулын хувийн мэндчилгээ (6:21-24)

I. ХРИСТ ДОТОРХ ИТГЭГЧДИЙН БАЙР СУУРЬ (бүлэг 1-3)

1. Мэндчилгээ (1:1, 2)

[1:1]

Паул гэдэг нь “жижиг” гэсэн утгатай нэр. Түүний бие нь энэ нэрэндээ таарсан жижиг байж болох ч сүнсний хувьд нөлөө нь асар өргөн билээ. Тэр өөрийгөө **Есүс Христийн элч** гэж танилцуулжээ. Энэ нь дээш өргөгдсөн Эзэнээс тусгай даалгавар хүлээн авсныг нь илтгэж байна. Тэрхүү даалгавар нь харь үндэстнүүдэд *сайн мэдээг* тунхаглах, *чуулганы* тухай агуу үнэнийг зааж сургах даалгавар байсан (3:8-9). Ефес ном чуулганы тухай ярьж байгаа, тэрхүү үнэн нь эхлээд элч нар болон эш үзүүлэгчдэд илчлэгдсэн (3:5) учраас Паул өөрийгөө элч гэж танилцуулах нь зүйн хэрэг. Энэ нь бардамнал бус, харин уг сэдвээр яагаад ийм эрх мэдэлтэй ярьж буйн тайлбар нь тэр. **Бурханы хүслээр** гэсэн үгээр энэхүү эрх мэдлийн эх сурвалжийг хэлжээ. Паул ажлаа мэргэжил сонгож байгаа юм шиг сонгоогүй. Эсвэл хэн нэгэн хүн түүнд энэ

үүргийг өгөөгүй. Энэ бол анхнаасаа эцэс хүртэл Бурхан түүнд өгсөн дуудлага байсан (Гал 1:1).

Захидлыг **Ефес хотод байгаа Есүс Христийн итгэмжит, ариун хүмүүст хандан** бичжээ. **Ариун хүмүүс** нь Бурханы төлөө дэлхийгээс тусгаарлагдсан хүмүүс. Энэ нь ШГ-д гарч байгаа дахин төрөгсдөд өгсөн нэр. Үндсэндээ энэ үг итгэгч хүмүүс ямар вэ гэдгийг илэрхийлэхээс илүү **Христ дотор** ямар байр суурьтайг нь илэрхийлж байгаа хэрэг. Итгэгчид ямагт ариун байдаггүй ч **Христийн дотор** байгаа итгэгч бүр **ариун хүн**. Жишээ нь Коринт хотын итгэгчид тэр бүр ариун амьдралаар амьдарч байгаагүй нь дараа дараагийн хэсгүүдээс тодорхой харагдаж байгаа ч Паул Коринт хотынхныг ариун хүмүүс гэж дуудсан (1Ко 1:2).

Гэсэн ч Бурхан бидний амьдрал байр суурьтай минь адил байгаасай гэж хүсдэг, **ариун хүн** ариун амьдрах учиртай. **Христ Есүс доторх итгэмжит. Итгэмжит** гэдэг үг нь “итгэдэг нэгэн” гэсэн утгатай болохоор жинхэнээсээ итгэсэн христитгэлт бүх хүний тодорхойлолт мөн. Мэдээж, итгэгчид найдвар алддаггүй, итгэл даах чанараараа ч **итгэмжит** байх ёстой. Гэхдээ энд

өгүүлсэн гол санаа нь тэр хүмүүс **Есүс Христийг** өөрийн цорын ганц Эзэн бөгөөд Аврагч гэж хүлээн зөвшөөрсөн гэж байна. **Ефест байгаа** гэдэг үг хамгийн эртний хоёр гар бичмэлд байдаггүй ч ихэнх гар бичмэлүүдэд байдаг. Энэ захидлыг итгэгчид орон нутгийн цуглааны үеэр дамжуулан унших зорилготой байсан гэж үздэг бөгөөд тэдгээр цуглаан дотроос Ефес хотынхон хамгийн нөлөөтэй нь байв. Аз болоход, энэ асуудал уг захидлын үнэн бодит эсэхэд эсвэл бидэнд ямар үнэ цэнэтэй вэ гэдэгт огт нөлөөлөхгүй.

[1:2]

Итгэгчдэд хандсан элчийн мэндчилгээ дараа нь байна. Мэндчилгээ нь өнөөдөр бидний хэрэглэдэг утгагүй шахам хоосон үгс биш харин ч үг бүр нь сүнсний утга учир ач холбогдлоор дүүрэн.

Нигүүлсэл гэдэг нь өдөр тутмын амьдралд минь ирдэг тэнгэрлэг тусламж. Паулын захидлыг уншигчид нь авах зохисгүй байхад төөрч алдагдсан хүмүүст Бурханы өгдөг таалал буюу нигүүлслээр аврагдчихсан хүмүүс байв. Тэдэнд

одоо амьдралын нугачаа, зовлон зүдгүүр, уй гашуутай нүүр тулан, даван туулахад **Бурханаас** ирэх хүч хэрэгтэй. Элч тэдэнд үүнийг хүсэн ерөөж байна.

Амар амгалан гэдэг нь амьдралын хувьсан өөрчлөгдөж байдаг нөхцөл байдлуудын алинд ч тайван хандаж чадах сэтгэл. Ариун хүмүүс Бурханд итгэсэн цагтаа Бурхантай амар тайван болсон. Гэхдээ бүхнийг Бурханд залбирлаар өргөсний улмаас ирдэг, нөхцөл байдлаас үл хамаарах тайван байдал, сэтгэлийн амарлингуй буюу Бурханы **амар тайван** тэдний өдөр тутмын амьдралд хэрэгтэй байсан (Флп 4:6-7).

Эхлээд **нигүүлсэл**, дараа нь **амар амгалан** ирдгийг мэдэж байх нь чухал. Энэ дараалал байнга хадгалагддаг. Нигүүлсэл гэм нүглийн асуудлыг шийдсэний дараа л амар амгаланг мэдэх боломжтой. Бурханы өдрөөс өдөрт өгдөг, бидний авах зохисгүй байсан хүчээр л итгэгч хүн хувиран өөрчлөгдөх эрээн бараан амьдралын дунд **амар амгалан**, төгс **амар амгаланг** мэдэрч чадна.

Нигүүлсэл (*charis*) нь грек хэлний онцлог үг байсан. Иудейчүүд мэндлэхдээ **амар тайван**

(shalom евр.) гэдэг үгийг хэрэглэдэг. Тэднийг зэрэгцүүлэн тавихад бүх дэлхийд хандсан товч сайн мэдээтэй болно. Тэднийг хамтад нь тавьснаар Ефес номд Паулын бүрэн төгс тайлбарлаад байгаа ШГ-ний чуулганы тухай үнэнийг буюу иудей болон харь үндэстнүүд хамтдаа Христийн Бие болон нэгдэж байгааг харна.

Нигүүлсэл ... ба амар амгалан нь бидний Бурхан эцэг болон Эзэн Есүс Христээс ирдэг. Эзэн Есүсийг Бурхан Эцэгтэй нэг зиндаанд зэрэгцүүлэн тавихдаа тээнэгэлзээгүй байна. Тэр Хүүг Эцэгийн нэгэн адил хүндэтгэдэг байв. Бид ч мөн ингэх учиртай (Иох 5:23).

Бидний Бурхан Эцэг гэдэг гайхалтай холбоо үгийг орхигдуулж болохгүй. **Бурхан** гэдэг үг нь өөрөө хязгааргүй агуу, хүрч болшгүй дээд Нэгэн гэдэг сэтгэгдэл төрүүлж болох юм. Харин **Эцэг** буюу аав гэдэг нь маш ойр дотно, хүрэх боломжтой Нэгэнийг хэлнэ. Энэ хоёр үгийг бидний гэдэг хамаатуулах төлөөний үгээр холбоход үүрд мөнхөд оршигч, дээд хүч чадалт **Бурхан** Эзэн Есүст итгэснээр дахин төрсөн хүн бүрийн хайртай **Аав** буюу **Эцэг** мөн гэдэг

гайхалтай үнэнийг харна.

Бидний Аврагчийн нэрийг бүтнээр нь **Эзэн Есүс Христ** гэдэг. **Эзэн** гэдэг нь Түүнийг бидний хамгийн дээд Эзэн бөгөөд биднийг, бидэнд байгаа бүхнийг захиран зарцуулах бүрэн эрх мэдэлтэйг харуулж байна. **Есүс** гэдэг нь биднийг гэм нүглийн шийтгэлээс аварсныг илэрхийлнэ. **Христ** гэдэг нь Түүнийг бидний Бурханаас томилогдсон Эш үзүүлэгч, Тахилч бас Хаан болохыг хэлж байна. Түүний нэр нь сонсогч бүрд ямар ихийг тайлан илчилж байна вэ!

2. Нигүүлсэл-ивээлийн төлөө Бурханд өргөх Паулын магтаал (1:3-14)

[1:3]

Товчхон мэндчилгээг залгаад тэрээр ШГ-д гардаг хамгийн сүрлэг магтаалуудын нэгийг өргөжээ. Эндээс бид нигүүлслийн ивээлийн төлөө зүрхний гүнээс бялхан гарах магтаалыг харж байна. Эдгээр ишлэлд (3-14) Паул Бурханы өнө мөнхөөс одоог хүрээд, цаашид мөнх үргэлжлэх авралын үйлсийг дурдаж байна. Үүнд итгэгч иудей болон харь хүмүүс алдарт өвийг хамтран эзэмших Бурханы хүслийн нууц

зайлшгүй хөндөгдөж байна.

Тэрээр эхлээд **Бурханыг** мэддэг бүхнээс Түүнийг ерөө гэж хүссэн буюу хайрын улмаас гарах магтаал хүндлэлээ өргөхийг уриалсан байна. **Ерөөгдсөн Нэгэн бол бидний Эзэн Есүс Христийн Бурхан ба Эцэг** юм. Есүс заримдаа Бурханыг **Бурхан** (Мт 27:46) гэж дуудаад зарим тохиолдолд **Эцэг**, Аав (Иох 10:30) гэж нэрлэж байжээ. **Ерөөгдсөн Нэгэн** мөн Ерөөгч билээ. Бид Түүнийг магтаалаараа ерөөнө. Тэр биднийг Өөрийн нигүүлслийн баялгаар бялхаан ерөөж, баярлуулдаг.

Тэрээр **Христ дотор, тэнгэрлэг газар дахь алив сүнслэг ерөөлөөр биднийг ерөөсөн.** Нигүүлслийн пирамид ийм ажгуу:

ерөөлүүд

сүнслэг ерөөл

алив сүнслэг ерөөл

Тэнгэрлэг газар дахь алив сүнслэг ерөөл

Христ дотор, тэнгэрлэг газар дахь алив сүнслэг ерөөл

Алив сүнслэг ерөөл гэснээс Түүний зүрх сэтгэл болоод гар нь ямар өгөөмөр болохыг

юуны түрүүнд анзаарна уу. Эдгээр нь *сүнслэг* ерөөл гэснийг мөн анхаарна уу. Үүнийг хамгийн ойлгомжтойгоор тайлбарлахын тулд израильчуудад хуулийн дор олддог байсан ивээл ерөөлтэй харьцуулахад болно. Хуучин гэрээнд итгэмжтэй дуулгавартай иудей хүний авдаг шагнал нь урт нас, өнөр өтгөн гэр бүл, арвин ургац, дайснаас нь хамгаалах хамгаалалт байжээ (Дх 28:2-8). Харин христитгэлийн ерөөлүүд нь **сүнслэг** буюу материаллаг бус, үл үзэгдэх, устаж алга болдоггүй эрдэнэс байна. ХГ-ний ариун хүмүүс зарим сүнслэг ерөөлийг мөн авдаг байсан нь үнэн гэхдээ өнөөдрийн христитгэгчид урьдын цагт мэддэггүй байсан ивээл ерөөлүүдийг авч байгааг бид харна. Бидний ивээл ерөөлүүд *тэнгэрлэг газарт* буюу шууд хэлэхэд *тэнгэрт* байгаа. Дэлхий дээрх материаллаг ивээлүүд биш *тэнгэр дэх сүнслэг* ивээлүүд. **Тэнгэрлэг газарт** гэдэг илэрхийллийг Ефес номонд таван удаа хэрэглэсэн буй:

1:3 - Бидний **сүнслэг** ерөөлийн цар хүрээ

1:20 - Христ сэнтийдээ заларч байгаа өнөөгийн дүр зураг

2:6 - Одоо бидний Христийн дотор сэнтийд заларч байгаа дүр зураг

3:10 - Чуулганд байгаа Бурханы мэргэн ухааныг тэнгэр элчүүд харж байдаг газар

6:12 - Бузар сүнснүүдийг эсэргүүцдэг бидний өнөөгийн тэмцлийн талбар

Эдгээр ишлэлийг нийлүүлээд үзвэл **тэнгэрлэг газар** гэдгийг Бичээс хэрхэн тодорхойлдогийг харна. Унгер үүнийг итгэгчид Сүнсээр баптисм хүртэн Христтэй нэгдсэнээр олдог байр суурь буюу үзэж мэдрэх зүйлийн оршин байгаа газар гэж тодорхойлжээ. **Сүнслэг** ерөөл *Христийн* бүр дотор байдаг. Тэдгээрийг Тэр загалмай дээр гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнд бидэнд зориулан худалдан авсан. Одоо тэдгээрийг Түүгээр дамжуулан авах боломж нээгдсэн. Бурханы итгэгчдэд өгөх гэсэн юм бүхэн Эзэн Есүсийн дотор байдаг. Уг ивээлүүдийг авахын тулд бид итгэлээрээ Христтэй нэгдэх ёстой. Хүн *Христийн дотор* орох мөчид тэр бүгдийн эзэмшигч нь болдог. Чафер аврагдсан хүн бүрийн хүртэх хувь буюу "Христийн дотор байх" Христийн хийсэн бүгдэд оролцож, Түүний

бүхэлдээ хэн болох, хэн байхыг нь хуваалцахыг хэлнэ " гэж бичжээ.²

Христийн дотор гэдэг нь Ефес номд гардаг чухал үг хэллэгүүдийн нэг. ШГ-д хоорондоо нягт холбоотой хоёр үнэн бий. Тэдгээрийн нэг нь итгэгчдийн байр суурийн үнэн, нөгөө нь түүний аж амьдралын үнэн.

Эхлээд, итгэгчдийн байр суурь байна. Дэлхийн хүн бүр нэг бол "Адам дотор" эсвэл "Христ дотор" байгаа. "Адам дотор" байгаа нь нүгэл дотроо байгаа учраас Бурханы өмнө ялтай. Тэд өөрсдөө Бурханы таалалд нийцүүлэх буюу Түүний тааллыг олохын тулд юу ч хийж чадахгүй. Тэд Бурханы дотор ямар ч хувьгүй бөгөөд тэдний хүртэх ёстой хувь нь гэвэл мөнхийн сүйрэл, шийтгэл.

Хүн Бурханд итгэхэд Бурхан түүнийг Адамын яллагдсан хүүхэд гэж харахаа больдог. Харин түүний оронд түүнийг **Есүс дотор** байгаагаар харж, тэр үүднээс хүлээж авдаг. Үүнийг ойлгох нь маш чухал. Итгэгч нүгэлтэн хэн гэдгээсээ биш **Христийн дотор** байгаа учраас хүлээн авагдаж байна. Тэрээр **Христийн дотор** байгаа цагт, Бурханы өмнө зогсохдоо Христийн хүлээн

зөвшөөрөгдөх бүхнээр хучигдсан байдаг. Тэгээд Христ Бурханы таалалд нийцэж байх үед буюу мөнхөд итгэгч хүн ч Бурханы таалалд нийцсээр байх болно. Тэгэхээр итгэгч хүн **Христийн дотор** хэн болох нь итгэгчийн байр суурь байх нь.

Гэвч үүнд бас өөр нэг тал буюу итгэгч хүний аж амьдрал байна. Тэр бол итгэгч өөрөө хэн бэ гэдгийг илтгэнэ. Итгэгчийн байр суурь нь төгс боловч амьдрал үйлс нь төгс биш. Тэгэхээр Бурхан итгэгч хүнийг өөрийн байр сууриндаа улам бүр ойртож очсоосой гэж хүсдэг. Гэхдээ энэ нь тэнгэрт очих хүртэл хэзээ ч бүрэн төгс болохгүй. Харин энэ дэлхий дээр байх хугацаанд ариусах, өсөж төлөвших, Христтэй улам адилхан болох үйл явц үргэлжилсээр байх учиртай.

Итгэгчийн байр суурь, төлөв байдал хоёрын ялгааг ойлгоод ирэхээр бидэнд эсрэг тэсрэг мэт харагдаж байсан дараах ишлэлүүдийн уялдааг ойлгож чадна:

Итгэгчид төгс (Евр10:14)	Итгэгчид төгс байх ёстой (Мт 5:48)
Итгэгчид нүгэлд үхсэн (Ром 6:2)	Итгэгчид өөрийгөө нүглийн хувьд үхсэн гэж үзэх ёстой (Ром 6:11)
Итгэгчид бол ариун үндэстэн (1Пт 2:9)	Итгэгчид ариун байх ёстой (1Пт 1:15)

Эхний багананд байр суурийн талаар, дараагийн багананд байр байдлын талаар өгүүлжээ.

Ефес хотынхонд бичсэн Паулын захидал өөрөө энэ үнэнийг зэрэгцүүлэн харуулдаг 2 хэсэгтэй. (бүлэг 1-3): Бидний байр суурь - бид Христийн дотор хэн болох. (бүлэг 4-6): Бидний байр байдал- бид өөрсдөө хэн болох. Эхний хагас нь сургаал, сүүлийн хагас нь үүрэгтэй холбоотой. Эхний гурван бүлэгт бидний байр суурийг "Христ дотор", "Христ Есүс дотор", "Түүний дотор" зэрэг үгсээр илэрхийлсэн байна. Сүүлийн гурван бүлэгт, Христ Эзэний өмнө хүлээсэн итгэгчдийн үүрэг хариуцлагыг илэрхийлэхэд "Эзэн дотор" гэдэг үг түлхүү хэрэглэжээ. Эхний хэсэг нь итгэгчдийг тэнгэрлэг газарт, Христ дотор байлгадаг дүрслэл бол сүүлийн хэсэг нь

тэднийг гал тогоонд байгааг нь харуулсан гэж нэг хүн тун онож хэлсэн.

Одоо бид **тэнгэрлэг газарт байгаа, Христийн доторх сүнслэг бэлгүүдийнхээ заримыг авч үзье.**

[1:4]

Эхэнд сонголт гэдэг асуудал явж байна. **Түүний өмнө биднийг ариун бөгөөд гэм зэмгүй байлгахын тулд Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Түүний дотор сонгосончлон хайраараа.**

Тэр биднийг сонгосон гэдэг нь үгүйсгэсэн биш эерэг хэлбэрээр илэрхийлэгдсэн байгааг анзаараарай. Тэгээд байр суурийн талаас нь харвал **Түүний дотор** гэдэг үнэн байна. Эзэн Есүсийн мөн чанар ба хийсэн ажлаар бүх хүний төлөөх Бурханы зорилго биелсэн. Бурханы сонголт хийсэн цагийг ертөнцийн сууриас урьд гэж тодорхойлжээ. Зорилго нь **Түүний өмнө биднийг хайраараа, ариун бөгөөд гэм зэмгүй байлгах ажээ.** Бид тэнгэрт очихоос нааш энэ зорилго бүрэн биелэхгүй (1Иох 3:2), гэхдээ энд байгаа амьдралын турш энэ үйл явц тасралтгүй

явагдана.

Залбирал:

"Ариун болгох нь Таны хэтийн зорилго тул
Эзэн, намайг одоо ариун болгооч. Амен"

ТЭНГЭРИЙН СОНГОЛТ

Сонголтын тухай сургаал нь хүний үзэл бодолд ноцтой асуултыг үүсгэдэг тул бид энэ тухай Библи бүхэлдээ юу гэж хэлдгийг (мөн юу гэж хэлдэггүйг) бодох хэрэгтэй.

Нэгдүгээрт, Бурхан хүнийг аврахдаа сонгодог хэмээн заадаг (2Тс 2:13). Итгэгчдийг "Бурханы урьдаас мэдэх мэдлэгээр сонгогдсон" гэж хэлсэн байна (1Пт 1:2). Хүмүүс сайн мэдээнд ямар хариу өгөхөөсөө хамааран сонгогдсон эсэхээ мэдэж болно гэж сургажээ. Сонсоод итгэсэн нь сонгогдсон байна (1Тс 1:4-7).

Нөгөөтэйгүүр, Бурхан хүмүүсийг алдагдахаар сонгосон гэж Библид огт айлдаагүй. Хэн нэгнийг аврахаар сонгоно гэдэг үлдэснийг нь яллахаар сонгоно гэсэн үг биш. Авралыг авах ёстой хүмүүсийг (ийм хүн нэг ч үгүй) яллахаар сонгосон гэж Библийн хаана нь ч гардаггүй. Харин ч яллагдвал таарах зарим хүнийг сонгож

байна. Сонгогдсон хүмүүсийг Паул "Тэрээр алдрын төлөө урьдаас бэлдсэн өршөөлийн савнууд" (Ром 9:23) гэсэн бол алдагдагсдыг тэр "сүйрэлд зориулагдсан уур хилэнгийн савнууд" гэж хэлжээ (Ром 9:22). Бурхан алдрын төлөө өршөөлийн савнуудыг бэлтгэдэг гэхдээ Тэр хүнийг сүйрүүлэхээр бэлтгэдэггүй. Тэд итгээгүйгээсээ болоод өөрсдөө ийм байдалд хүрдэг.

Сонголтын тухай сургаал нь Бурханыг Бурхан гэдгийг харуулдаг. Тэр бүхнээс дээд эрх мэдэлтэй. Өөрөөр хэлбэл таалсан зүйлээ Тэр хийж чадна. Гэхдээ хэзээ ч шударга бусыг таалдаггүй. Хүмүүсийг зөнд нь орхивол бүгд л алдагдана. Заримд нь өршөөл үзүүлэх эрх Бурханд бий юу?

Гэхдээ үүнд бас өөр нэг тал бий. Дээрх сонголтыг өгүүлдэг Библи маань хүний үүрэг хариуцлагын тухай заадаг. Хэн ч сонголтын тухай сургаалийг аврагдаагүйнхээ шалтаг болгож чадахгүй. Бурхан бүх хүнд аврагдах боломжийг хаа сайгүй дэлгэн тавьсан билээ. (Иох 3:16; 3:36; 5:24; Ром 10:9, 13). Гэм нүглээ улайн гэмшиж, Эзэн Есүст итгэсэн хэн боловч

аврагдана. Тэгэхээр аврагдаагүй хүн байвал өөрийн сонголтоороо л аврагдахүй үлдэнэ. Тэрнээс биш Бурхан түүнийг алдагдаасай гэж хүссэн юм биш.

Үнэндээ сонголтын тухай өгүүлж буй Библи хүлээж авах хүн бүрд үнэгүй авралыг тунхагладаг. Энэ хоёр сургаал хоёулаа орсон нэг ишлэл байна. "Эцэгийн Надад өгдөг бүхэн Над руу ирнэ. Над руу ирэх хүнийг Би хөөж гаргахгүй" (Иох 6:37). Энэ ишлэлийн эхний хэсэг нь Бурханы хэмжээлшгүй эрх мэдлийн сонголтыг тунхаглаж, сүүлийн хэсэг нь өршөөлийн гараа хүн бүхэнд сунгаж буй хэлжээ.

Үүнийг хүний ухаанаар ойлгоход хэцүү. Бурхан яаж заримыг нь сонгосон хэрнээ авралыг бүгдэд нь чөлөөтэй өгч чадах юм бэ? Шууд хэлэхэд, энэ бол нууц. Гэхдээ Бурханы хувьд биш бидний хувьд нууц. Библи хоёр сургаал зааж байгаагаас хойш бид хоёуланд нь итгэх хэрэгтэй. Үнэн бол Бурханы сонголт, хүний чөлөөт сонголт хоёрын дунд биш харин хоёр туйлд нь оршиж байна. В. Г. Блейки ийн дүгнэжээ:

Тэнгэрийн дээд эрх мэдэл, хүний үүрэг
хариуцлага, бүх нийтэд зориулсан чөлөөт
сонголт бүгд Бичээст байдаг бөгөөд бидний
логик сэтгэлгээ учрыг нь олж эвлүүлж чадахгүй
ч энэ бүгдийг оюун ухаандаа буулгаж авах
хэрэгтэй.³

[1:5]

Бурханы ивээлийн баялгаас гарах хоёр дахь
сүнслэг ивээл бол урьдаас тогтоохуй. Энэ нь
сонголттой тодорхой хэмжээнд холбоотой
боловч сонголт биш. Бурхан аврах хүмүүсээ
сонгож байгаа дүр зургийг сонголт гэж байгаа.
Харин аврагдах хүн бүрийг Бурхан хүүгээ
болгон үрчилж гэр бүлдээ авахыг шийдсэнийг
урьдаас тогтоохуй гэж нэрлэж байна. Тэр
биднийг аварсныхаа дараа Өөрийн хөвгүүд
болгох албагүй байсан. Гэвч Тэр хоёуланг нь
хийхээр сонгосон.

Библийн олон орчуулгад 4, 5-р ишлэлүүд
хайраараа биднийг урьдаас тогтоосон гэдэг
үгсээр холбогддог.

Энэ нь бидэнд ийм нигүүлсэнгүй хандахад
хүргэсэн Бурханы хайрыг сануулж байна.

Хөвгүүд болгон үрчлэн авахаар урьдаас тогтоосон гэдэг үгс бидний гайхалтай үрчлэлийн баримт нотолгоо юм. Итгэгч хүнийг Бурханы гэр бүлд бүх эрх үүргийг эдлэх төлөвшсөн насанд хүрсэн хүүгийн хувиар (Гал 4:4-7) оруулахыг ШГ-д **үрчлэл** гэж тодорхойлжээ. Үрчлэлийн Сүнс итгэгч хүнд Бурханыг Аав гэж дуудах сэтгэлийг төрүүлдэг (Ром 8:15).

Бид **Есүс Христээр дамжин хүү болж** үрчлэгддэг. Бид гэм нүгэл дотроо байсаар байсан цагт Бурхан биднийг **Өөртөө** ийм ойр халуун дотно байр сууринд тавьж чадахгүй. Тийм учраас Эзэн Есүс энэ дэлхийд буун ирж, үхэж оршуулагдаад, үхлээс амилан байж, бидний гэм нүглийн асуудлыг Бурханы таалалд нийцэхээр цэгцэлж өгсөн. Энэ бол Бурхан биднийг **хөвгүүдээ болгон** үрчилж авах зөвт байдлын үндэслэл буюу загалмай дээр өргөсөн тахилын хэмжээлшгүй үнэ цэнэ билээ.

Энэ бүгд нь **Түүний хүслийн сайн тааллын дагуу** болж байгаа. Биднийг урьдаас тогтооход хүргэсэн дээд хүсэл сэдэл энэ билээ. “Тэр яагаад ийм үйлдэл хийж байгаа юм бэ” гэдэг асуултын

хариу энэ. Тэр зүгээр л **сайн тааллынхаа** дагуу ийнхүү үйлдсэн билээ. Цорын ганц Хүүгийнх нь дүр төрхөд орсон, Түүнтэй хамт, Түүнтэй адил хөвгүүдээрээ хүрээлүүлэхээс нааш Түүний сэтгэл ханахгүй.

[1:6]

Энэ нь хайрлагдсан Түүний дотор бидэнд соёрхсон Түүний нигүүлслийн алдрыг магтуулахын тулд болой.

Паул эхлээд биднийг сонгосон, дараа нь Түүний хөвгүүд байх хувь заяаг урьдаас тогтоосон Бурханы нигүүлслийг эргэцүүлэн байгаад гайхан бахдаж, тайлбарлаж, сануулан уриалжээ. Ийм агуу нигүүлслийн давамгай сүр жавхланг бишрэн дуу алдахыг *гайхан бахдах* гэнэ. Бидэнд хандсан Бурханы нигүүлсэнгүй ажил, түүний үр дүн нь бүгд **Түүний** Өөрийн алдар болохыг *тайлбарлаж* байна. Юутай ч эгнүүлэшгүй тааллынх нь улмаас Түүнд мөнхийн алдар хүндлэл очно. Түүний **нигүүлслийн нөхцөлийг** бодоод үзэхэд Тэр (**үнэ төлбөргүйгээр**) **биднийг соёрхсон** байна. Түүний **нигүүлслийг** хүлээн авагчид нь **бид**.

Нигүүлслийн суваг нь **Хайрлагдсан Тэр**. Эцэст нь хэлэхэд энэ бол *сануулга уриа*. Паул “Агуу **нигүүлслийнх** төлөө Түүнийг **маггья**” гэж хэлж байна. Цааш явахын өмнө үүнийг нь биелүүлдгээ.

Гайхамшгийн Агуу Бурхан минь!

Таны зам мөр бүхэн

Таны тэнгэрлэг чанаруудыг илчилнэм

Таны нигүүлслийн яруу алдар

Таны бүхий л гайхамшгаас ялгарнам

Өршөөлт Бурхан тантай зэрэгцэх хэн байна вэ

Өөр хэн ийм өгөөмөр үнэгүй нигүүлсэлтэй вэ.

- *Самуел Дэйвийс*

[1:7]

Өөрийн хүмүүстээ зориулсан төлөвлөгөө нь хичнээн агуу болохыг харснаас хойш **ЗОЛИЛТЫН** асуудал сөхөгдөнө. Энэ нь Христийн хийсэн ажлыг гэм нүглийн хүлээс, шийтгэлийн ялаас биднийг чөлөөлж эрх чөлөөт амьдралд хөтлөн оруулсан талаас нь харуулна. Эзэн Есүс бол бидний Золигч (**Түүний дотор золилт бидэнд бий**). Бид бол золигдогсод. **Түүний цус** бидний

золионы үнэ, үүнээс бага юм төлж дийлэхгүй.

Золилтын нэг үр дүн бол **бидний нүглийн уучлал**. **Уучлал** гэдэг нь **золилт** биш харин үүнээс гарч байгаа нэг үр дүн юм. Нүглийг маань уучлуулахын тулд Христ хангалттай бүрэн тахил өргөх шаардлагатай байсан. Энэ ажил загалмай дээр хийгдсэн.

Тэгэхээр одоо –

Шударга ёс дахин нэхэл болохгүй

Өршөөлийн гар биднийг орхихгүй

Бидний авсан **уучлалын хэмжээг Түүний нигүүлслийн баялгийн дагуу** гэж тодорхойлжээ. Бид **Бурханы нигүүлслийн баялгийг** хэмжиж чадвал бидний нүглийг хэр хэмжээнд уучилсныг мэдэж авна. Түүний **нигүүлсэл** хязгааргүй! Түүний **уучлал** ч мөн адил!

[1:8]

Тэр биднийг нигүүлссэндээ сонгосон, урьдаас тогтоосон бас зольж авсан. Тэгээд зогссонгүй ээ. Бурхан тэр л нигүүлслээ бидэнд бүх **мэргэн ухаан болон гүнзгий мэдлэгээр** бялхуулан өгчээ. Энэ нь Түүнийг зорилго төлөвлөгөөгөө

бидэнтэй найр тавин хуваалцсаныг хэлж байна. Тэр биднийг Түүний чуулган болон дэлхий ертөнцөд зориулсан төлөвлөгөөг ухаарч, ойлгоосой гэж хүсдэг ажээ. Тиймээс Тэр бидэнд итгэл үзүүлэн хүн төрөлхтний хувь заяа хаашаа эргэж байгааг дэлгэн харуулжээ.

[1:9]

Бурхан бидэнд бүх мэргэн ухаан, гүн гүнзгий мэдлэгийг яг ямар байдлаар өгч байгааг Паул тайлбарлаж байна. Өөрөөр хэлбэл **хүслийнхээ нууцыг бидэнд мэдүүлсэн**. Христ болон чуулганы тухай алдарт үнэн бол Ефес номын үндсэн сэдэв. Энэ бол **нууц**. Зүгээр нууцлаг зүйл гэсэн утгаар биш харин өмнө нь мэдэгдээгүй байсан нандин нууц одоо ариун хүмүүст илчлэгдэж байна. Энэхүү сүр жавхлантай төлөвлөгөө нь гадны ямарваа нөлөөллөөс ангид Бурханы дээд эрх мэдэлт хүслээс эхтэй бөгөөд **Түүний сайн тааллын дагуу юм**. Уг төлөвлөгөөний агуу субъект Эзэн Есүс Христ гэдэг нь **Тэр Түүний дотор зорилго тавьсан** гэдэг хэсгээр илэрч байна.

[1:10]

Одоо Паул Бурханы төлөвлөгөөний нууцыг илүү нарийвчлан тайлбарлаж байгаа бөгөөд энэ бүлэгт нууцын хэтийн төлөвийг тухайлан бодож байна. 2-3-р бүлгүүдэд нууцын одоогийн байдлыг тодруулж өгнө.

Паулын ярьж байгаа цаг хугацаа буюу үе (гр. *ойкономиа*) нь **цагийн дүүрнийг гүйцэлдүүлэх** үе гэж тодорхойлогдож байна. Энэ нь Христ дэлхий дээр хаадын Хаан, эзэдийн Эзэний хувиар эргэн ирэх Мянган жилийн хаанчлалыг хэлж байгаа гэж бид ойлгодог. Хүн төрөлхтний энэ дэлхий дээрх сүүлийн цаг үед зориулсан Бурханы онцгой төлөвлөгөө байгаа.

Тэр төлөвлөгөө нь “бүх юмсыг Христээр тэргүүлүүлэх” явдал юм. Мянган жилийн хаанчлалын үед **тэнгэр дэх болон газар дээрх бүх юмсыг Христ дотор нэгтгэнэ**. Хүмүүст гадуурхагдаж, гологдсон Аврагч бүхнээс дээд Нэгэн буюу бүгдийн Эзэн, ертөнц дахины мөргөл хүндлэлийн төв болно. Христийг тэнгэр газар дахь **бүх юмсын** дээгүүр, хаанчлалын Тэргүүн байлгах нь Бурханы зорилго.

Христийн хаанчлалын цар хүрээ нь “тэнгэрт болон газарт байгаа юмс” гэдэг үгээр

тодорхойлогдож байна. Беллет ингэж бичжээ:

Энэ бол урьд дэлгэгдээгүй нууц. Эш үзүүлэгч Исаиагийн номонд газар дээрх Мянган жилийн хаанчлалын сайхан дүр зураг байдаг ч Христээр тэргүүлүүлсэн тэнгэрийн мянган жилийн хаанчлалын тухай сонсож байсан билүү? Тэнгэр газар дахь бүх юмсын дээгүүр алдаршсан Хүн тэргүүнээр заларна гэж Исаиа хэлсэн үү?⁴

10-р ишлэлийг заримдаа дэлхий нийт аврагдана гэдэг хуурамч онол сургаалыг дэмжихэд ашигладаг. Яваандаа бүх юмс, бүх хүн Христ дотор сэргэж эвлэрнэ гэж гуйвуулан номлодог. Гэхдээ энэ нь уг ишлэлд огт байхгүй санаа. Паул бүхнийг *захирах* тухай ярьж байгаагаас биш бүхнийг аврах тухай хэлээгүй!

[1:11]

Итгэгч иудейчүүд ба итгэгч харь үндэстнүүд Бурханы энэ агуу төлөвлөгөөнд өөр өөрийн хувьтай болох нь энэхүү нууцын нэг салшгүй хэсэг юм. Итгэгч иудейчүүдэд хамаатай хэсгийг нь 11, 12-р ишлэлүүдэд, итгэгч харь үндэстнүүдэд хамаатай хэсгийг нь 13-р ишлэлд дурдаад, 14-р

ишлэлд хоёуланг нь нэгтгэсэн байна.

Иудейн удмын христитгэгчдийн хувьд Паул **бид Түүний дотор өв залгамжлагчид болсон юм** гэж бичжээ. Тэд угсаа гарлынхаа улмаас биш Христтэй нэгдсэнийхээ улмаас ийнхүү хувь хүртэж байна. Тэрхүү **өв залгамжлал** нь тэднийг алмайран гайхах дэлхийн өмнө, бүх жинхэнэ итгэгчдийн хамт, Хурганы Сүйт бүсгүйн хувиар, сүр жавхлантайгаар өргөмжлөгдөх цаг уруу зааж байна. Эдгээр итгэгч иудейчүүд нь **бүх юмсыг хүслийнхээ зөвлөгөөгөөр үйлддэг Түүний зорилгын дагуу урьдаас тогтоогдсоноор** өнө мөнхөөс, Бурханы хэмжээлшгүй эрх мэдлээр энэхүү эрхийг авахаар онцлогдсон байжээ.

[1:12]

Ийнхүү урьдаас тогтоохын зорилго нь тэднээр **Түүний алдрыг магтуулахын тулд** ажээ. Өөрөөр хэлбэл тэр хүмүүс Бурхан ямар олиггүй түүхий эдээр юу хийж чадахыг харуулсан Өөрт нь **алдрыг** авч ирсэн Бурханы нигүүлслийн цомууд юм.

Элч өөрийгөө болон бусад итгэгч иудейчүүдийг **Христэд анхлан найдсан бид**

гэжээ. Тэрээр христитгэлийн эхэн үед сайн мэдээг хүлээн авсан цөөхөн бурханлаг иудейчүүдийг буюу үлдэгсдийг хэлж байна. Сайн мэдээ анх иудейчүүдэд тунхаглагдсан. Израиль үндэстний ихэнх нь шууд татгалзсан. Харин цөөхөн бурханлаг хүмүүс буюу үлдэгсэд Эзэн Есүст итгэсэн. Паул тэдний нэг мөн.

Аврагч энэ дэлхийд хоёр дахиа ирэхэд байдал өөр байх болно. Тэр цагт энэ үндэстэн өөрсдийн жадалсан Түүнийг харж, ганц Хүүгийнхээ төлөө гашуудах мэт болно (Зех 12:10). "Чөлөөлөгч Сионоос гарч ирнэ. Тэр Иаковаас бурханлаг бус байдлыг нь зайлуулна" гэж бичигдсэнчлэн "Бүх Израиль аврагдах болно" (Ром 11:26).

Паулын болон түүний үед амьдарч байсан иудей итгэгчид үндэстнээсээ түрүүлэн Мессиад итгэсэн. Тийм болохоор "Христэд анхлан найдсан бид" гэж тайлбарлажээ.

Мессиад "анхлан найдагсад" нь Түүнтэй хамт дэлхийг захирна. Тус үндэстнээс аврагдах бусад итгэгчид Түүний хаанчлалын газар дээрх албат болно.

[1:13]

Элч одоо "бид" гэхээс **та нар** гэж хэлснээр итгэгч иудейчүүдээс итгэгч харь үндэстнүүд рүү шилжиж байна. Үндэсний шүтлэгээсээ аврагдсан харь хүмүүс болон итгэсэн иудейчүүд Бурханы хүслийн нууцыг хамт хуваалцаж байна. Ефесчүүд болон бусад харь үндэстэн хэрхэн Христтэй нэгдэж байгаа алхмуудыг Паул элч дурджээ.

Тэд сайн мэдээг **сонссон,**

Тэд Христэд **итгэсэн,**

Тэд **амлалтын Ариун Сүнсээр тамгалагдсан.**

Эхлээд тэд **авралынхаа сайн мэдээ** болох **үнэний үгийг сонссон.** Энэ нь үндсэндээ Эзэн Есүст итгэснээр ирдэг **авралын сайн мэдээг** хэлж байна. Арай өргөн утгаар хэлбэл үүнд Христийн болон элч нарын бүх сургаал орно.

Тэд энэ мэдээг сонсоод итгэлийн шийдвэртэй алхам хийн Христийг дагах болсон. Эзэн Есүс бол жинхэнэ итгэж болох Нэгэн. **Аврал** зөвхөн Түүний дотор байдаг.

Тэд итгэмэгцээ амлалтын Ариун Сүнсээр тамгалагдсан. Энэ нь үнэхээр итгэсэн хүн бүр Бурханд харьяалагддагийг, алдаршсан биеэ

хүлээж авах хүртлээ Бурханаар хамгаалагдсаар байхын тэмдэг болгож Бурханы **Сүнсийг** хүлээж авдаг гэсэн үг. Лац тамга нь хууль эрх зүйн асуудалд өмчлөл, баталгааны тэмдэг болдогийн адил тэнгэрлэг асуудалд бас ийм байдаг ажээ. Бидний дотор оршигч Сүнс нь биднийг Бурханы өмч болгон тамгалдаг (1Ко 6:19, 20) бөгөөд биднийг зорилтын өдөр хүртэл хамгаалагдсаны баталгаа болдог юм (Еф 4:30).

Бидний тамгыг **амлалтын Ариун Сүнс** гэж нэрлэдэг. Нэгдүгээрт, Тэр бол *Ариун* Сүнс, энэ нь Түүний байгаа мөн чанар. Хоёрдугаарт, Тэр бол *амлалтын* Сүнс. Түүнийг өгнө гэж Эцэг (Иое 2:28; Үйл 1:4), мөн Эзэн Есүс амласан (Иох 16:7). Дээр нь Тэр бол итгэгчдэд өгсөн Бурханы бүх амлалтууд биелэгдэхийн баталгаа.

Энэ захидалд олонтаа дурдагддаг Гурвалын талаар 13-р ишлэлд хамгийн анх өгүүлдэг.

Бурхан Эцэг (ишлэл 3)

Бурхан Хүү (ишлэл 7)

Бурхан Сүнс (ишлэл 13)

[1:14]

Паул хэрэглэж байгаа биеийн төлөөний үгсээ дахиад өөрчиллөө. Тэр 11, 12-р ишлэлд хэрэглэсэн "бид", 13-р ишлэлд хэрэглэсэн "та нар" гэдэг биеийн төлөөний үгсээ 14-р ишлэлд нэгтгэн "бидний" болгов. Энэхүү чадамгай илэрхийллээр тэр 2, 3-р бүлэгт илүү дэлгэрэнгүй тайлбарлахаар зэхэж байгаа буюу итгэгч иудейчүүд итгэгч харь үндэстнүүд нэгдэн чуулган гэдэг шинэ биеийг бий болгох тухай зах зухаас нь харуулж байна.

Ариун Сүнс бол **бидний өвийн батлан даагч юм**. Энэ нь төлбөр бүтнээр хийгдэнэ гэсэн баталгаа болгож хийдэг урьдчилгаа төлбөр гэсэн үг. Энэ нь бүтэн төлбөртэй хэмжээний хувьд ялгаатай, харин төрлийн хувьд ижил.

Биднийг итгэсэн даруйд Ариун Сүнс бидэнд Христийн дотор биднийх болсон баялгуудын заримаас нь илчлэн харуулж эхэлдэг. Тэр бидэнд ирж буй алдрыг амтлуулдаг. Гэхдээ нэг өдөр өв залгамжлалаа бүтнээр нь авна гэдгээ бид яаж мэдэх юм бэ? Ариун Сүнс Өөрөө барьцаа буюу батлан даалт билээ.

Сүнс бол худалдаж авсан **эзэмшил чөлөөлөгдөх буюу золигдох хүртэл батлан**

даалт мөн. Анхны ургац нь ургац хураалтыг бэлгэдэж байдаг шиг **барьцаа** нь бүрэн төлөлт буюу **золилтыг** бэлгэдэж байдаг. Барьцаа болсон Сүнсний үүрэг нь **эзэмшил** Эзэндээ бүрэн шилжихэд зогсох болно. Гэвч Паул худалдаж авсан **эзэмшил** гэж юуг хэлээд байна вэ?

(1) Тэр бидний өвлөж авах **өвийг** хэлж байж болно. Бурханы бүх өмч Эзэн Есүсээр дамжин биднийх болсон, бид Бурханы өв залгамжлагчид, бид бас Христийн хамтран өвлөгчид (Ром 8:17; 1Ко 3:21-23). Гэм нүглээс болж дэлхий ертөнц бузартсан бөгөөд эвлэрч ариутгагдах учиртай (Кол 1:20, Евр 9:23). Энэхүү ёолон буй бүтээл Христ дэлхийд хаанчлахаар буцаж ирэхэд ялзралын хүлээснээс ангижирч Бурханы хүүхдүүдийн сүр жавхланта эрх чөлөөнд гарна (Ром 8:19-22).

(2) Худалдаж авсан **эзэмшил** гэж итгэгчдийн биеийг хэлж байж болно. Анх итгэх үед бидний сүнс, сэтгэл чөлөөлөгдсөн харин биеийн чөлөөлөлт хожим болно. Бид өвдөж, зовж, хөгширч үхдэг нь бидний бие чөлөөлөгдөөгүй, золигдоогүй байгааг харуулж байгаа бус уу?

Христ бидэн рүү буцаж ирэхэд бидний бие махбод Түүний цог жавхлант биетэй адил болохын тулд шинэчлэгдэнэ (Флп 3:21). Тэгсэн цагт тэд үүрд мөнх, бүрэн золигдоно (Ром 8:23).

(3) Худалдаж авсан **эзэмшил** гэж чуулганыг хэлж байж болох юм (1Пт 2:9 “Түүний эзэмшлийн ард түмэн”). Ингэж үзвэл үүний золилт мөн шүүрэлтийг буюу Есүс чуулганаа Өөрийнхөө өмнө ямар ч толбогүй, үрчлээсгүй буюу өөр ямар нэг тийм зүйлгүйгээр болгох цагийг зааж байна (Еф 5:27). Бурханы эзэмшил гэж ХГ-ний ариун хүмүүсийг хэлж байж болно гэж зарим нь итгэдэг.

Аль ч өнцөгөөс харсан бай эцсийн үр дүн нь адилхан л **Түүний алдрыг магтахад** оршино. Тэгвэл Өөрийн хүмүүст зориулсан Бурханы гайхамшигт төлөвлөгөө сүр жавхлантайгаар биеллээ олоход Тэр төгсөшгүй магтаалын эзэн болно. Паул энэ бүлэгт гурвантаа сануулан хэлсэн зүйл бол Бурханы хийж байгаа бүхний зорьсон зорилго, гарцаагүй гарах үр дүн нь Тэрээр дээдлэн хүндлэгдэж, алдаршихад оршино.

Түүний нигүүлслийн алдрыг магтуулахын

тулд (ишлэл 6)

Бид Түүний алдрын магтаалын төлөө байх юм (ишлэл 12)

Түүний алдрыг магтуулахын тулд (ишлэл 14)

3. Ариун хүмүүсийн төлөөх Паулын талархал ба залбирлууд (1:15-23)

[1:15]

Үүний өмнөх хэсэгт 3-аас 14-р ишлэл хүртэл (грек хэл дээр үргэлжилсэн ганц өгүүлбэр байдаг) өнө мөнхөөс эхлээд өнө мөнхөд үргэлжлэх Бурханы гайхамшигт төлөвлөгөөг харуулсан. Үүндээ тэр бидний оюун бодолд орж болох хамгийн агуу зүйлсийг дэлгэн өгүүлжээ. Үнэхээр агуу зүйлс тул Паул одоо уншигчдынхаа сүнсний гэгээрлийн төлөө нухацтай залбирлаа хуваалцаж байна. Тэрээр тэднийг Христийн доторх агуу хувь завшаан болон бүх бүтээлийн Тэргүүн болох Христэд зориулах учиртай хүч чадлынхаа төлөө талархаж яваасай гэж маш ихээр хүсэж байна.

Тиймээс гэсэн оршил нь Христийн биеийн гишүүдийн төлөө Бурханы хийсэн болон хийх гэж байгаа болгоныг буюу 3-14-р ишлэлд

дурдагдсан зүйлсийг эргэн харж байна.

Эзэн Есүст итгэх та нарын итгэл болон бүх ариун хүний төлөө гэсэн хайрыг чинь сонсоод гэжээ. Энэ мэдээллийн улмаас уншигчид нь саяхан дүрслэгдсэн сүнслэг ивээлүүдийг эзэмшигчид гэдэг баталгааг авч, Паул тэдний төлөө залбирах ажилдаа орсон байна. **Эзэн Есүст итгэх итгэл** нь тэдний амьдралд авралын гайхамшигийг авч иржээ. **Бүх ариун хүний төлөө гэсэн хайр** нь бодитоор итгэж өөрчлөгдсөнийг нь илэрхийлж байна.

Уг захидлыг онцгойлон Ефес хотынхонд бичээгүй гэж үздэг эрдэмтэд, судлаачид энэ ишлэлийг баримт болгодог. Энд Паул уншигчдынхаа итгэлийн тухай сонссон болохоос тэдэнтэй огт уулзаж байгаагүй мэтээр бичсэн байна. Гэтэл тэр Ефес хотод доод тал нь гурван жил болсон байна (Үйл 20:31). Тиймээс тэд энэ захидлыг Ефесийг оруулаад орон нутгийн хэд хэдэн чуулганд хандаж бичсэн гэж дүгнэдэг.

Аз болоход энэ асуудал бидний авч болох сургамжид огт нөлөөлөхгүй. Жишээ нь, **Эзэн** бол бидний жинхэнэ итгэж болох Нэгэн гэдгийг **Эзэн Есүст итгэх итгэл** гэснээс харж болно. Биднийг

ямар нэгэн хүний гаргасан тунхаг, чуулган эсвэл христчин хүнд итгэ гэж хэлээгүй. Аврах итгэл нь Бурханы баруун гарт өргөмжлөгдөн заларсан, үхэгсдээс амилсан Христэд байдаг.

Бидний авч болох бас нэг сургамж нь **бүх ариун хүний төлөө гэсэн хайр** гэдэг үгэнд агуулагдаж байна. Бид зөвхөн ойр тойрныхоо хэдэн итгэгчийг хайрлаад зогсохгүй, Христийн цусаар угаагдсан бүх хүнийг буюу итгэлийн гэр бүлийн бүх гишүүдийг хайрлах учиртай.

Гурав дахь сургамж нь **итгэл ба хайр** гэдэг үгийн холбоо байна. Зарим нь надад итгэл байгаа гэж хэлдэг ч, тэдний амьдралаас хайр харагддаггүй. Бусад нь агуу их хайрыг илэрхийлдэг боловч Христэд итгэх шаардлагыг төдийлөн ойшоодоггүй. Жинхэнэ христитгэл эрүүл сургаал, эрүүл амьдралын хослол юм.

[1:16]

Итгэгчдийн итгэл ба хайр нь Паулыг тэдний төлөө Эзэнийг магтаж, тэдний төлөө цөхрөлтгүй залбирахад хүргэжээ. Скрожи үүнийг ийнхүү яруу сайхнаар илэрхийлэв.

"Хэдийнээ тавигдсан суурийн төлөө талархал

өргөж, түүн дээр баригдах ер бусын барилгын төлөө зуучлан залбирчээ. Өнгөрсөн цагт хүрсэн амжилтын төлөө талархаж харин ирээдүйд хүрэх амжилтын төлөө зуучлан залбирч байна. Үзэж туулсан бүхнийх нь төлөө талархалаа өргөж, харин тэдэнд зориулсан Бурханы зорилгын дотор хүрч болох ирээдүйнх нь төлөө зуучлан залбирчээ."

[1:17]

Бурханы хүний залбирлын амьдрал уруу өнгийн харна гэдэг юутай их завшаан бэ. Энэ захидалд үүнээс гадна 3:14-21-д буюу нийтдээ хоёр удаа үүнийг дурдсан. Энд дурдсан нь сүнсний гэгээрлийн төлөө, хоёр дахь удаа нь сүнсний хүчний төлөө залбирал байна. Энд **Бурханд** хандан залбирч, дараа нь **Эцэгт** хандан залбирсан байна. Гэхдээ Паулын залбирал аль ч тохиолдолд зогсолтгүй, тодорхой, хүмүүсийн тухайн үеийн хэрэгцээнд нийцсэн залбирлууд байв. Энд **Бидний Эзэн Есүс Христийн Бурхан болох алдрын Эцэгт** хандсан залбирал байна. **Алдрын Эцэг** гэдэг нь:

(1) Бурхан бол бүх алдрын үүсгэгч буюу эх

үүсвэр.

(2) Бурхан бол бүх алдрыг эзэмшигч эсвэл

(3) Бурханы алдрын илрэл болсон Эзэн Есүсийн Эцэг гэсэн утгатай байж болно.

Тэр та нарт мэргэн ухаан хийгээд илчлэлийн сүнсийг өгч, Түүнийг бүрэн мэдүүлэг гэж залбирал цааш үргэлжилнэ. Ариун Сүнс бол мэргэн ухаан (Иса 11:2) ба илчлэлийн (1Ко 2:10) Сүнс. Гэвч итгэгч бүрийн дотор Ариун Сүнс оршин байгаа учраас Паул уншигчдаа Ариун Сүнсийг шинээр ав гэж залбирах боломжгүй. Харин Түүнээс онцгой хэмжээний гэгээрлийг авахыг хэлж байна.

Илчлэлт гэдэг нь мэдлэг мэдээллийг дамжуулахыг хэлдэг бол, **мэргэн ухаан** гэдэг нь тэр мэдлэг мэдээллээ амьдралдаа ухаалгаар хэрэглэхийг хэлдэг. Мэдлэг гэж ерөнхий мэдлэгийг биш харин **Түүний** тухай тодорхой **мэдлэгийг** (гр. *epignosis*) хэлж байна. Тэрээр итгэгчдийг хүний оюуны чадвараар олох боломжгүй, харин Сүнсний нигүүлсэлт үйлчлэлээр өгөгддөг **мэдлэг**, Бурханы тухай, гүн гүнзгий, сүнсний, биеэрээ амсаж мэдэрсэн

мэдлэгтэй болохыг хүсч байна.

Дейл ийнхүү тайлбарлажээ:

Ефес хотын энэ итгэгчид хэдийнээ тэнгэрлэг гэгээрлийг авсан байв. Тэгээгүйсэн бол итгэгч болохгүй байхсан. Гэхдээ Паул, тэдний дотор оршиж байгаа тэнгэрлэг Сүнс тэдний харааг улам тод, хурц, хүчтэй болгож тэнгэрлэг хүч, хайр ба сүр жавхлан нь тэдэнд илүү дүүрнээр илчлэгдээсэй гэж хүсч байна. Хүн төрөлхтөн сэтгэлгээний доод хүрээнд сэтгэл татсан, гайхан шагшруулсан олон нээлтийг маш богино хугацаанд хийж, итгэгч хүмүүсийн хүртэл сонирхлыг татаж, Христ доторх Бурханы илэрхийлэлтэй өрсөлдөж байгаа өнөө үед чуулган Бурханаас *"мэргэн ухаан хийгээд илчлэлийн сүнсийг"* өгөөч гэж гуйх нэн чухал шаардлага хэрэгцээ байгаа биз ээ. Энэхүү залбиралд Бурхан хариулбал бидэнд “нүдэнд үзэгдэх, түр зуурын юмс”-тэй холбоотой мэдлэгийг тэгтлээ бишрэхгүй, тэдгээр нь "үл үзэгдэх бөгөөд мөнхийн зүйлсийн" гэрэлд дарагдана.⁵

[1:18]

Сүнслэг гэгээрлийн эх сурвалж нь Бурхан, суваг нь Ариун Сүнс, туйлын зорилго нь Бурханы тухай бүрэн дүүрэн мэдлэг болохыг бид харлаа. Одоо бид ямар эрхтэн гэгээрэхийг харж байна. **Зүрхний мэлмийг гийгүүлэх болтугай** гэжээ.

Энэхүү зүйрлэлээс тэнгэрлэг үнэнийг зөвөөр ойлгох нь бидний оюуны чадвараас биш харин зөөлөн **зүрхнээс** хамаардаг гэж хэлж байна. Энэ бол бидний оюун ухаанаас гадна бидний зүрх сэтгэлээс хамаардаг зүйл байх нь. Бурханы илчлэлтүүд нь Түүнийг хайрладаг хүмүүст өгөгддөг. Энэ нь итгэгч хүн бүрд гайхамшигтай боломжуудыг нээн өгдөг. Учир нь бид бүгд оюуны өндөр чадамжтай байх боломжгүй ч бид бүгд хайрлах **зүрхтэй** байж болно.

Дараа нь Паул ариун хүмүүст байгаасай гэж хүсч байгаа тэнгэрлэг мэдлэгийн гурван тодорхой талбарын тухай өгүүлжээ:

- (1) **Түүний дуудлагын найдвар**
- (2) **Ариун хүмүүс дотор Түүний өв дэх алдрын баялаг**
- (3) **Итгэдэг бидэнд хандсан Түүний хүч чадлын хэмжээлшгүй сүр жавхлан**

Түүний дуудлагын найдвар нь ирээдүй рүү чиглэж байгаа буюу Тэрээр биднийг дуудахдаа бидний төлөө бодож байсан хэтийн хувь заяаг хэлж байна. Энэ нь бид Христтэй үүрд хамт байж, Түүнтэй адилхан болно гэсэн санааг агуулж байна. Биднийг орчлон ертөнцийн өмнө Бурханы хөвгүүд хэмээн тунхаглаж, бид Түүний өө сэвгүй сүйт бүсгүйн хувьд Түүнтэй хамт хаанчлах болно. Бид үүнд найдаж байгаа нь ийм зүйл болох эсэхэд эргэлзсэндээ биш, харин эдгээр нь бидний авралын ирээдүйд биелэх зүйл учраас найдан хүлээдэг.

Ариун хүмүүс дотор Түүний өв дэх алдрын баялаг нь итгэгч хүмүүсийн нээн илрүүлэх учиртай хоёр дахь асар өргөн ойлголт билээ. Үүний далайц хийгээд сүр жавхланг харуулахын тулд Паул хэрхэн үгэн дээр үг залгаж хэлснийг хар даа:

Түүний өв

Ариун хүмүүс доторх Түүний өв

Ариун хүмүүс доторх Түүний өв дэх алдар

Ариун хүмүүс доторх Түүний өв дэх алдрын баялаг

Үүнийг тайлбарлах хоёр арга байгаа бөгөөд

хоёулаа маш утга учиртай тул бид энд хоёуланг нь толилуулав. Эхний тайлбарын дагуу **ариун хүмүүс** нь **Түүний өв** бөгөөд Тэр тэднийг зүйрлэшгүй үнэтэй эрдэнэс гэж үздэг. Тит 2:14, 1Петр 2:9-г итгэгчдийг "Түүний эзэмшлийн тусгай ард түмэн " гэжээ. Хорон муу, ямар ч зохисгүй нүгэлтнүүд Христээр аврагдсанаар Бурханы зүрхэнд **Түүний өв** гэж хэлүүлэхээр байр суурийг эзэлнэ гэдэг нь үгээр хэлж барашгүй нигүүлсэл гарцаагүй мөн.

Нөгөө талаас *бидний* өвлөн авах бүхнийг ийнхүү **өв** гэж хэлсэн байж болно. Товчоор хэлбэл ертөнц бүхэлдээ Христийн захиргаан дор орох бөгөөд Түүний сүйт бүсгүй болсон бид Түүнтэй хамт түүнийг нь захирах юм. Түүний бидэнд зориулан хадгалсан алдрын баялгийг бид үнэхээр ойлгох аваас энэ дэлхийн нүд булаах таашаал тийм ч сонин сайхан санагдахаа болино.

[1:19]

Паулын залбиран гуйж байгаа гурав дахь зүйл нь итгэдэг бидэнд хандсан **Түүний хүч чадлын хэмжээлшгүй сүр жавхлан** буюу энэ бүхнийг биелүүлэх Бурханы хүчийг бид илүү ухааран

талархаасай гэдэг хүсэл.

Ф.Б. Мейер хэлэхдээ: "Энэ бол хүч. Энэ бол Түүний хүч. Энэ бол агуу хүч. Үүнээс өөр юу ч байсан багадна. Энэ нь бидний бодож, сэтгэж чадахаас хэмжээлшгүй агуу хүч" гэжээ.⁶

Бурхан энэ хүчээ биднийг золин авахдаа, мөн хадгалж авч үлдэхдээ хэрэглэсэн бөгөөд биднийг алдаршуулахдаа ч хэрэглэх юм. Луис Спери Чафер бичихдээ:

Бурханы Өөрийн сонголт, урьдаас хийсэн товлोलт болон дээд эрх мэдлээр хийсэн үрчлэлийн ажлаа гүйцэтгэхдээ ашигласан хүч ямар агуу болохыг Паул итгэгчдэд ойлгуулахыг хүсчээ.⁷

[1:20]

Түүний хүч чадал үлэмж агуу болохыг улам онцлон харуулахын тулд элч тэнгэрлэг **хүчийг** дэлхийд үзүүлсэн хамгийн агуу илрэлийг буюу Христийг **үхэгсдээс амилуулан** Бурханы **баруун гарт** залсан тэр хүчийг тайлбарлан өгүүлэв. Дэлхий ертөнцийг бүтээсэн нь Бурханы хүчний хамгийн дээд илрэл гэж бид бодож болох юм. Эсвэл Бурхан ард түмнээ Улаан Тэнгисээр

гатлуулсан гайхамшигт явдал гэж бодож байж ч болох. Гэвч тийм биш ээ! Христийг амилуулж, дээш авч одоход тэнгэрийн хүч хамгийн ихээр шаардагдсан гэж ШГ бидэнд сургаж байна.

Яагаад тэр вэ? Бурханы төлөвлөөг нураахын тулд Христийг булшнаас гаргахгүй гэж, нэгэнт амилчихсан хойно нь Түүнийг дээш одуулахгүй гэж бузар муу хүчнүүд тэр аяараа бүчин шавж байсан бололтой. Гэхдээ Бурхан бүх л төрлийн эсэргүүцлийг ялан дийлсэн. Христийн амилалт ба алдаршуулалт нь Сатан болон түүнийг дагагсдыг бут цохиж, ялгуусан хүчний сүр жавхланг үзүүлсэн явдал билээ.

Энэхүү хүчийг хэн ч хангалттай сайн дүрслэн өгүүлж чадахгүй. Тиймээс Паул бидний өмнөөс гаргаж байгаа тэрхүү хүчийг дүрслэхийн тулд динамик, эрч хүчийг илэрхийлсэн хэд хэдэн үг хэллэгийг зээлдсэн байна. Ингэхдээ: "Энэ хүч нь **Түүний чадлын хүчний нөлөө** билээ. **Тэрээр Христ дотор энэ л хүчээр нөлөөлж, Түүнийг үхэгсдээс амилуулаад**" гэжээ. Эдгээр үг тэр санааг илэрхийлэхэд багадаж байна уу гэлтэй. Энэ үгсийн утга санааг нарийн зөв салган ялгах нь тийм ч чухал биш, харин Бурханыхаа бүхнийг

чадагч мөн чанарыг гайхан бишрэхэд хангалттай.

Мейер ийнхүү дуу алджээ:

Ямар гайхалтай өргөмжлөл вэ! Үхэгсдийн булшнаас ганцаараа үхэшгүй мөнх Бурханы сэнтийд заларчээ. Харанхуй булшнаас сарнишгүй гэрэлд гарав. Энэхүү жижигхэн дэлхийгээс орчлон ертөнцийн төвд гарав. Итгэлийн луужингаа гаргаж оёоргүйн гүнийг хэмжигтүн. Тэгээд энэ замыг нэвт туулахад Эзэний авч явсан хүч чадлыг бишрэгтүн.⁸

Бичээст хэлснээр бол Христийн амилалт нь хүн төрөлхтний түүхэнд урьд өмнө болж байгаагүй гайхамшиг (1Ко 15:23). Үхлээс амилсан бусад нь эргээд үхсэн. Үхэшгүй мөнх амийн хүч чадлаар амилсан анхных нь Эзэн Есүс Христ юм. Христийг амилаад дээш одоход Бурхан **Түүнийг тэнгэрт Өөрийн баруун гарт залсан**. Бурханы **баруун гар** гэдэг нь онцгой эрх мэдлийн байр суурь (Евр 1:13), хүч чадал (Мт 26:64), хүндлэл (Евр 1:3), баяр жаргал (Дуу 16:11), ноёрхлыг (1Пт 3:22) илэрхийлнэ.

Түүний байршлыг **тэнгэр** гэж дүрсэлжээ. Үүнд Бурханы оршдог газрыг оруулан хэлж

байна. Эзэн Есүс өнөөдөр тэнд яс махнаас бүрдсэн бие махбодоор, дахиж үхэх боломжгүй алдаршуулагдсан бие дотроо байж байгаа. Түүний байгаа газарт бид удахгүй очно.

[1:21]

Бидний Аврагчийн алдаршууллыг **бүх засаг захиргаа, эрх мэдэл, хүч, ноёрхол төдийгүй зөвхөн энэ үед ч биш мөн ирээдүйд нэрлэгдэх аливаа нэрээс ч эрхэм** гэж тайлбарласан байна. Эзэн Есүс маань хүн төрөлхтөн хийгээд тэнгэр элч нарын одооноос эхлээд үүрд байх бүх захирагч, удирлагаас дээгүүр билээ.

Тэнгэрт байгаа хорон муу ба сайн тэнгэрлэг биес тодорхой шатлал зэрэгтэй билээ. Тэдний хүч чадал, эрх мэдэл харилцан адилгүй. Жишээ нь тэдний зарим нь биднийхээр ерөнхийлөгч, засаг дарга, хотын дарга эсвэл хотын зөвлөл буюу хурлын гишүүнтэй адил гэж хэлж болно. Тэдний засаг захиргааны эрх мэдэл, **хүч чадал, ноёрхол** ямар агуу байх нь хамаагүй Христ тэр бүгдээс хавьгүй **эрхэм** юм.

Энэ нь бидний амьдарч буй **энэ цаг үеэр зогсохгүй**, Христийн энэ дэлхий дээрх Мянган

жилийн хаанчлал буюу **ирээдүйд** ч үнэн байх болно. Тэгэхэд Тэр хаадын Хаан, эздийн Эзэн байх болно. Тэр бүх бүтээлийн дээгүүр өрөмжлөгдөнө. Үүнээс нэг ч бүтээл үлдэж хоцрохгүй.

[1:22]

Дээрээс нь Бурхан **бүх юмсыг хөл дор нь тавьжээ**. Энэ нь хүн болон тэнгэр элч нарын дээгүүр байгаад зогсохгүй бусад бүх амьд болон амьгүй бүтээлийн дээгүүрх ноёрхлыг илэрхийлж байна. Эдүгээ Түүний эрхэнд бүх юмс оруулагдсаныг хараахан үзээгүй л байна гэж Еврей номыг бичигч бидэнд сануулдаг (Евр 2:8). Тэр үнэн. Хэдийгээр орчлон ертөнцийг захирах эрх Христэд бий ч Тэрээр үүнийгээ хараахан хэрэгжүүлээгүй байна. Жишээ нь, хүн төрөлхтөн Түүний эсрэг тэрсэлж, Түүнийг үгүйсгэх буюу эсэргүүцээр байна. Гэвч Бурхан Хүүгээ орчлон ертөнцийг захирах очирт таягийг барина гэсэн зарилга гаргасан ба энэ нь яг одоо цагт биелсэнтэй адилхан гарцаагүй үнэн юм.

Үүний дараа бараг үнэмшмээргүй зүйл хэлэгдэж байна. Хадаасны сорвитой гараараа

ертөнцийг бүхэлд нь захирах алдарт Түүнийг Бурхан **чуулганд** өгчээ! Паул энд Бурханы хүслийн нууцын талаар биднийг цочоосон мэдээг илчилж байна. Тэрээр алхам алхмаар биднийг энэ оргил өөд хөтөлсөн байна. Тэрээр Христийн амилалт, алдаршуулалт, ноёрхлыг чадварлагаар дүрслэн харуулжээ. Энэхүү бүх алдрын Эзэнийг тунгаан алмайрч байхад маань Паул "Христийг **бүх юмсын дээрх Тэргүүн болгож** байж чуулганд өгсөн" гэж хэлж байна.

Энэ ишлэлийг бид хайнгадуухан уншвал Христ **чуулганы** Тэргүүн юм байна гэж харна. Энэ нь үнэн боловч энэхүү ишлэл үүнээс хавьгүй ихийг өгүүлж байна. **Чуулган** ертөнцийн ноёрхолыг гардан авсан Түүнтэй маш ойр холбоотой гэдгийг хэлж байна.

21-р ишлэлээс бид Христ бол энэ үед ба ирээдүйд тэнгэр болоод газарт орших бүх *бүтээлээс* эрхэм гэдгийг мэдсэн. Бид 22-р ишлэлийн эхний хэсгээс **бүх юмс** болон бүх бүтээл **Түүний хөлд**, эрхшээлд нь байна гэдгийг мэдсэн. Одоо бид **чуулган нь** Түүний хязгааргүй ноёрхолтой холбогдох онцгой дуудлагатай болохыг мэдлээ. **Чуулган** Түүний ноёрхлыг

хуваалцана. Бусад бүх бүтээл Түүний захиргаан дор байх болно.

[1:23]

1-р бүлгийн сүүлийн ишлэлээс бид Христ чуулган хоёрын харилцаа ямар ойр дотно болохыг сурна. Энд хоёр дүрслэл өгөгдсөн байна. Үүнд: (1) Чуулган **бол Түүний бие**, (2) **бүхний дотор бүгдийг Дүүргэгчийн дүүрэн байдал нь мөн**.

Толгой, **бие** хоёроос илүү ойрын холбоо гэж байдаггүй. Тэд амиараа холбоотой бөгөөд дотор нь нэг Сүнс оршдог. Чуулган бол Пентекостоос эхлээд Шүүрэн авалт хүртэл хугацаанд, дэлхийгээс дуудагдаж, гайхамшигт нигүүлслээр аврагдаад, Христийн **бие** байх онцгой завшаан соёрхогдсон бүлэг хүмүүс. Өөр ямар ч цаг үеийн итгэгчдэд ийм хүндэтгэл өгөгдөж байгаагүй, цаашид ч өгөгдөхгүй.

Чуулганы хоёр дахь тодорхойлолт нь **бүгдийг Дүүргэгчийн дүүрэн байдал**. Өөрөөр хэлбэл чуулган бол нэг цагт бүх газар зэрэг оршиж чаддаг Христийн бүрдэл хэсэг гэсэн үг. Бүрдэл хэсэг гэдэг бол аливааг дүүргэж, бүрэн гүйцэд

болгодог зүйл. Үүнд хоёр хэсэг нийлээд нэг цогц юмыг бий болгоно гэсэн санаа явж байна. Бие нь толгойг бүтэн болгодог шиг чуулган Христийг бүтэн болгоно.

Гэхдээ Христийг бүрэн гүйцэд биш, төгс биш юм байна гэж буруу ойлгохоос сэргийлэн Паул тэр даруй **бүхний дотор бүгдийг Дүүргэгчийн дүүрэн байдал** нь гэж хэлэв. Эзэн Есүс ямар нэгэн юмаар дутаж, түүгээр нөхөгдөхөөс нааш дүүрэн байж чаддаггүй Нэгэн огт биш, харин ч **Өөрөө бүхний дотор бүгдийг Дүүргэгч**, ертөнцийг дүүргэн хэрэгтэй бүхнээр нь Хангагч билээ.

Энэ бүгдийг ойлгоно гэдэг бидэн ахадсан хэрэг гэдгийг өчье. Бид Бурханы оюун хийгээд төлөвлөгөө ямар хязгааргүй уудам болохыг бишрэхийн сацуу бид үүнийг нь ойлгох чадвар дутуугаа хүлээн зөвшөөрөөд суух л үлдэж байна.

4. Бурханы хүч харь үндэстнүүд ба иудейчүүдийн авралаар дамжин илэрхийлэгдсэн нь (2:1-10)

[2:1]

Шинэ бүлэг эхэллээ гээд 1-р бүлгийн сүүлийн хэсэг, одоо үргэлжлэх ишлэлүүдийн амин чухал холбоог бүдэгрүүлэх учиргүй. Бид тэндээс Христийг булшнаас амилуулаад, Түүнд алдар ба хүндлэлийн титмийг өмсгөсөн Бурханы агуу хүч чадлыг харсан. Одоо бид тэр хүч биднийг сүнсний үхлээс босгож, Христтэй хамт тэнгэрт залан бидний амьдралд хэрхэн ажлаа хийснийг харна.

Энэ хэсэг Эхлэл номны эхний бүлгийг санагдуулдаг. Аль алинд нь (1) эзгүйрэл, эмх замбараагүй байдал, сүйрэл (Эх 1:2а; Еф 2:1-3), (2) тэнгэрлэг хүчний оролцоо (Эх 1:2б; Еф 2:4), (3) шинэ амьдрал бүтээж байгаа (Эх 1:3-31; Еф 2:5-22) тухай өгүүлж байна.

Ефес 2-р бүлэг эхлэхэд бид үхлийн хөндийд хөсөр хэвтэх сүнсний үхдэлүүд байна. Энэ бүлгийн төгсгөлд бид Христтэй хамт тэнгэрт залраад зогсохгүй, Сүнсээр дамжуулан Бурханы орших газар болно. Энэ хоёрын хооронд бид энэхүү гайхалтай өөрчлөлтийг бий болгож байгаа агуу гайхамшигийг харна.

Эхний арван ишлэлд харь үндэстнүүд болон иудейчүүдийг аварсан Бурханы хүчийг

дүрсэлжээ. Ямар ч үнсгэлжин ингэж суга дэвшээгүй билээ!

1-2-р ишлэлд Паул харь үндэстэн уншигчдадаа итгэж үнэмшихээсээ өмнө **үхсэн**, гажуудсан, чөтгөрийн, дуулгаваргүй хүмүүс **байсныг** нь сануулж байна. Тэд **нүгэл**, **хилэнцийнхээ** улмаас сүнсээрээ **үхмэл** байв. Энэ нь Бурханы хувьд тэд амьгүй байсан гэсэн үг. Тэд Түүнтэй ямар ч амьд холбоогүй байсан. Түүнийг оршин байдаггүй мэт тэд амьдарч байжээ. **Нүгэл болон хилэнцийн** урхаг нь үхэл болов. **Нүгэл** гэдэг нь санаатай болон санамсаргүй бодсон аливаа бодол, хэлсэн үг, үйлдсэн үйлдэл бөгөөд хүн эдгээрээс болж Бурханы төгс байдалд хүрч чадахгүй дутдаг. **Хилэнц** гэдэг нь мэдэгдэж байгаа хуулийг илт зөрчихийг хэлнэ. Өргөн утгаараа буруу алхам, бүдүүлэг алдааны алив хэлбэрийг ч хамарч болно.

[2:2]

Ефесчүүд гажуудсан мөн үхсэн байв. Тэд энэ **ертөнцийн заншлын дагуу явсан**. Тэд энэ цагийн сүнсийг дагасан. Энэ үеийн нүгэлд тэд

хутгалдав. Дэлхий өөрийн дагагсадыг шахаж хэлбэршүүлдэг хэвтэй ажээ. Тэр нь худал хуурмаг, ёс бус, бурхангүй, хувиа хичээх байдал, хүчирхийлэл, тэрслэлийн хэв болно. Нэг үгээр хэлбэл тэр нь гажуудлын хэв. Ефесчүүд ийм байж.

Үүгээр зогсохгүй тэдний зан авир нь чөтгөрийнх байж. Тэд **агаарын хүчний ноёрхогч** болох диаволын жишээг дагаж байв. Агаарын ноёрхогч, муу ёрын сүнснүүдийн удирдагчийн төөрүүлэгт тэд оржээ. Тэд энэ цаг үеийн бурханыг өөрсдийн хүслээр дуулгавартай дагаж байлаа. Аврагдаагүй хүмүүс яагаад адгууснаас дор аашлах явдал үе үе гаргадгийн шалтгаан энэ ажээ.

Эцэст нь хэлэхэд тэд дуулгаваргүй байж, эдүгээ **дуулгаваргүй хөвгүүд дотор ажиллаж буй сүнсийг** дагадаг байв. Аврагдаагүй хүн бүр, Бурханд **дуулгаваргүй тул дуулгаваргүй хөвгүүд** юм. Тэд Сатанаас хүчээ авдаг. Тиймээс ч Эзэнийг үл тоомсорлох, үл хүндлэх, дуулгаваргүй байх хандлагатай.

[2:3]

Паул *та нар* гэдэг биеийн төлөөний үгнээс *бид* гэдэг үг рүү шилжиж байгаа нь (итгэсэн хэн бүхний хувьд үнэн боловч) үндсэндээ иудей итгэгч нарт хандан ярьж байгааг илтгэж байна. Тэднийг дүрсэлсэн үгс: махан биеийн, ялзарсан, яллагдсан.

Тэдний дунд бид ч бас ... махан биеийнхээ хүсэл тачаалуудаар амьдарч байв. Шинээр төрөхөөсөө өмнө Паул болон бусад христитгэгчид дуулгаваргүй хөвгүүдийн эгнээнд алхаж явсан. Тэд зөвхөн махбодын хүсэл таашаалаа хангахын тулд амьдарч явсан учраас тэдний амьдрал *махан биеийн* байжээ. Паул өөрөө гаднаасаа ёс суртахуунтай мэт амьдарч байсан бөгөөд тэр одоо ямар хувиа хичээсэн амьдрал байсныг ойлгожээ. Түүний мөн чанар үйлдсэн бүх бузар муухайгаас нь дорд байв.

Итгэсэн иудейчүүд **махан бие болон санаа бодлын хүслүүдээ өөгшүүлснээрээ ялзарсан** байж. Энэ нь хүний жам ёсны төрөлх хүслүүдийг орхихыг хэлж байна. **Махан бие болон санаа бодлын хүслүүд** гэдэгт зүй ёсны хүслүүдээс авахуулаад ёс бус, гаж буруу хүслүүд хүртэл багтана. Энд ноцтой, бузар муу нүглүүдийг хэлж

байх шиг байна. Паул санаа бодлын нүглүүдийг нүгэлт үйлдлийн хамт дурдсан байгааг анзаарна уу.

Ф.Б Мейер анхааруулахдаа:

Санаа бодлын хүслээ өөгшүүлэх нь *махан биеийн* хүслээ өөгшүүлэхтэй адилхан хор хөнөөлтэй. Бид төсөөлөн бодох гэдэг гайхамшигт бэлгээ ашиглан ариун бус мөрөөдөлд живэн, хүсэл тачаалынхаа жолоог сул тавьж, үйлдэхийн даваан дээр өөрсдийгөө зогсоож явдаг. Хүний сэтгэл завхай эмтэй бүжихээр босохыг эсвэл хүсэл тачаалын арал дээрх төөрдөг байшингийн хаалгаар орж явахыг бусад хүний нүд даган харж чадахгүй. Хүний сэтгэл хажууд суугаа хүндээ ч мэдэгдэлгүй яваад ирж болдог. Цас шиг цагаан гэм зэмгүй гэсэн нэр хүнд нь үүнээс болж сэвтдэггүй. Болзоот залуугаа харан хүлээх онгон бүсгүйчүүлийн эгнээнд зогсох зөвшөөрөл нь байсаар байна. Гэвч энэ явдалдаа гэмшин улайхгүй байгаа бол үйлдэж байгаа хүн нь дуулгаваргүй хөвгүүн буюу уур хилэнгийн хүүхэд гэдгийг нь тодорхойлдог.⁹

Аврагдаагүй иудейчүүдийг Паул тэд бусдын адил төрөлхөөс уур хилэн хүртэх хүүхдүүд байсан гэж тодорхойлжээ. Энэ нь тэднийг төрөлхийн ууртай, хорлонтой, гомдомхой бөгөөд түргэн зантай гэж хэлж байгаа болно. Тэд бусад хүний л адил ийм мөн чанартай байв. Мэдээж тэд Бурханы уур хилэнгийн дор байлаа. Тэд үхэл болон шүүлтэд томилогдсон. 2-3-р ишлэлд хүний гурван дайсныг дурдсан байгааг анзаарна уу: (ишлэл 2) дэлхий, (ишлэл 2) диавол, (ишлэл 3) махан бие.

[2:4]

Харин Бурхан гэдэг нь аль ч ном зохиолд байдаггүй хамгийн ач холбогдолтой, уран яруу, сэтгэл сэргээсэн үгс юм. Асар том өөрчлөлт болсныг энэ нь илтгэж байна. Энэ нь үхлийн хөндийн ял, цөхрөлөөс Бурханы хайрт Хүүгийн хаанчлалын үгээр хэлшгүй жаргал уруу шилжсэн өөрчлөлт юм.

Энэхүү өөрчлөлтийн зохиогч нь **Бурхан** Өөрөө билээ. Өөр хэн ч үүнийг хийж чадахгүй бөгөөд *хийхгүй*.

Энэ ерөөгдсөн Нэгэний нэг мөн чанар нь

өршөөлөөр баян байх. Тэр бидэнд хандвал зохистой байдлаар хандахгүй байгаагаараа **өршөөлөө** харуулсан (Дуу 103:10). "Тэрээр үүнийг зургаан мянганы турш үзүүлсээр ирсэн бөгөөд тоолж тоомшгүй үй түмэн олон түүнээс нь хүртсэн боловч шавхагдашгүй баялгийн уурхай билээ" гэж Ийдий хэлжээ.¹⁰

Тэрээр ийнхүү оролцох болсон шалтгааныг **биднийг хайрласан Түүний агуу хайр** гэдэг үгс илэрхийлж байна. Тэр Өөрөө хайрын ундарга нь учраас Түүний хайр агуу байгаа юм. Бэлэг өгөгчийн чадал чансаа өгч байгаа бэлэгнээс нь харагддагийн адил Бурханы онц давуу байдал нь Түүний хайранд дээдийн гэрэл гэгээ нэмж байна. Өөрийн адил хүнээр хайрлуулснаас агуу хүчит Дээд Нэгэнээр хайрлуулсан нь хавьгүй дээр. Бурханы хайрын аугаа нь төлсөн төлөөсөндөө байгаа. Хайр Бурханы цорын ганц Хүү болох Эзэн Есүсийг бидний төлөө, Голготын толгой дээрх тарчлант үхэл рүү илгээсэн. Бурханы хайр хүлээн авагчид дээрээ тоолшгүй баялгийг цутгадгаараа аугаа билээ.

[2:5]

Нөгөө талаас хайрлагдаж байгаа хүмүүс нь үнэхээр олиггүй, дур гутаам учраас Бурханы хайрын аугааг харуулж байна. Бид **гэм нүгэл дотроо үхсэн** байв. Бид Бурханы дайсан байсан юм. Бид гачигдсан, гажсан хүмүүс байлаа. Тэрээр энэ бүгдийг үл хэрэгсэн биднийг хайрласан.

Биднийг гэсэн Бурханы хайр, Христийн хийсэн золилтын ажлын үр дүнд бид (1) **Христтэй хамт амьд болгогдсон**, (2) Түүнтэй хамт өргөгдсөн, (3) Түүнтэй хамт суусан.

Эдгээр үг Христтэй нэгдсэний үр дүнд хүлээн авсан бидний сүнсний байр суурийг илэрхийлж байна. Тэр зөвхөн бидний *өмнөөс* төлөөлөөд барахгүй бидний *оронд* төлөөлөгчөөр зогссон. Тиймээс Түүнийг үхэхэд бид үхсэн. Түүнийг булшлагдахад бид булшлагдсан.

Түүнийг **амилж**, дээш өргөгдөж, тэнгэрлэг газарт суухад *бид* мөн тэгсэн. Бид Түүнтэй холбогдсоныхоо ачаар Түүний Өөрийгөө золиослосон ажлын үр шимийг амсаж байна. **Түүнтэй хамт амьд болсон** гэдэг нь итгэсэн иудей болон итгэсэн харь үндэстнүүд Түүнтэй шинэ амьдрал дотор нэгдсэнийг илэрхийлнэ.

Түүнийг амилуулсан хүч бидэнд мөн үүнийг өгсөн.

Энэ үнэхээр гайхамшигтай тул Паул ярьж байсан зүйлээсээ түр хазайж, **та нар нигүүлслээр аврагдсан** гэж дуу алджээ. Яг эсрэгээр нь хандах учиртай байсан хүмүүст үзүүлсэн Бурханы тайлж ойлгошгүй, хэмжээлшгүй таалал түүнийг алмайруулжээ. Энэ бол **нигүүлсэл!**

Өршөөл нь хийсэн гэм хэргийнхээ шийтгэлийг авалгүй хэлтрэхийг хэлнэ гэдгийг бид өмнө үзсэн. Нигүүлсэл гэдэг нь бид хүртэх *зохисгүй* авралаа *хүртэхийг* хэлнэ. Энэ нь бидэнд өгөгдсөн бэлэг болохоос бидний авах ёстой шан хөлс биш. Түүнчлэн үүнийг өгсөн Нэгэн нь үүнийг албан шахалтаар хийгээгүй. А.Т Пийрсон хэлэхдээ:

Үүнийг Тэр хийх шаардлага байгаагүй ч хайрын улмаас, сайн дураараа хийсэн. Нигүүлслийн яруу алдар нь юундаа оршино вэ гэвэл дорой нүгэлтнүүдийг гэсэн Бурханы хайр ямар ч саадгүй, шахалтгүйгээр гарсанд байгаа юм гэжээ.¹¹

[2:6]

Бид Христтэй хамт амьд болгогдсон төдийгүй, Түүнтэй хамт өргөгдсөн. Үхэл ба шүүлт Түүний ард хоцорсны адил бид бас тэдгээрийн ард гарсан. Бид булшны амилалтын тал дээр нь зогсож байна. Энэ бол бидний Христтэй нэгдсэний үр дүнд бидэнд өгөгдсөн сүр жавхлант байр суурь билээ. Бид ийм байр суурь эзлэх болсон нь үнэнээс хойш бид үхлээс амилсан хүмүүс шиг амьдрах учиртай.

Бидний байр суурийн нөгөө тал бол **тэнгэрлэг газарт Христ Есүс дотор суусан** нь байгаа юм. Түүнтэй нэгдсэн холбооны улмаас биднийг нүгэлт энэ орчлонг гэтэлж **Христийн дотор** алдаршин суусан гэдэг. Бурхан биднийг ингэж үздэг. Бид үүнийг итгэлээрээ өөртөө хамааруулбал бидний амьдралын хэв маяг, хандлагыг өөрчилнө. Түр зуурын, жижиг сажиг дэлхийн энэ амьдралдаа бид хорогдон зууралдахгүй. Бид Христийн Бурханы баруун гарт заларч байгаа дээгүүрх зүйлсийг хайх болно (Кол 3:1).

5-6-р ишлэлийн түлхүүр нь **Христ Есүс дотор** гэдэг үг. Бид Түүний дотор амьд болгогдож,

өргөгдөж, суулгагдсан. Тэр бидний Төлөөлөгч, тиймээс Түүний ялалт, Түүний байр суурь нь биднийх. Жорж Виллиямс: "Магдалын Мариа, цовдлогдсон хулгайч хоёр Бурханы Хүүгийн алдрыг хуваалцана гэдэг ямар аугаа санаа вэ!" гэж дуу алдсан байдаг.

[2:7]

Энэхүү нигүүлсэлт өөрчлөлтийн гайхамшиг нь мөнхөд илчлэгдэх сэдэв билээ. Өөрийн Хүүг нүглийн энэ ширэнгэн ой уруу илгээхэд Түүний хувьд ямар золиос байсан, загалмай дээр бидний гэм нүглийг үүрэх нь Эзэн Есүс минь хувьд ямар золиос байсан гэдгийг Бурхан тэнгэрт цугласан олонд, үеийн үед илчилсээр байх болно. Энэ бол хэзээ ч ярьж барахгүй сэдэв. Үүний агуу цар хүрээг харуулан ойлгуулахын тулд Паул дахиад үгэн дээр үг өрдөг аргаа хэрэглэж байна:

Бидэнд хандсан энэрлээр

Бидэнд хандсан энэрлээр Түүний нигүүлсэл

Бидэнд хандсан энэрлээр Түүний нигүүлслийн баялаг

Бидэнд хандсан энэрлээр Түүний нигүүлслийн хэмжээлшгүй баялаг

Бурхан үүнийгээ мөнхөд илчилсээр байх юм бол бид мөнх сурсаар байна гэсэн утга харагдаж байна. Тэнгэр бидний сургууль болох нь. Багш нь Бурхан. Хичээлийн сэдэв нь Түүний нигүүлсэл. Бид сурагчид нь байх болно. Хичээлийн жил нь мөнх үргэлжилнэ.

Ингэхээр бид тэнгэрт очоод бүгдийг мэдчихнэ гэдэг бодлоо хаях хэрэгтэй байна. Зөвхөн Бурхан л бүхнийг мэдэх бөгөөд бид Түүнтэй хэзээ ч эн зэрэгцэхгүй.¹²

Бид тэнгэрт очихоороо хэр ихийг мэдэж авах вэ гэдэг сонирхолтой асуулт гарч ирнэ. Түүнчлэн Тэнгэрийн Их сургуульд орох бэлтгэлээ одооноос базааж, энэ дэлхий дээр байхдаа Библиэр мэргэшиж эхэлсэн нь дээр гэдэг нь харагдаж байна.

[2:8]

Дараагийн гурван ишлэл Библид өгүүлсэн авралын төлөвлөгөөг хамгийн ойлгомжтой, тодорхой харуулж байна.

Энэ бүхэн Бурханы **нигүүлслээс** эхтэй: Тэр Өөрөө үүнийг өгөхийг санаачилсан. Авах огт зохисгүй хүмүүст Эзэн Есүсийн мөн чанар,

хийсэн ажлын үндсэн дээр авралыг өгсөн юм.

Үүнийг бидэнд одоо эзэмшил болгон өгсөн. Аврагдсан хүн үүнийг мэдэх боломжтой. Паул Ефес хотынхонд **та нар аврагдсан** гэж бичиж байна. Тэр ч, тэд ч үүнийг мэдэж байж.

Мөнх амийн бэлгийг **итгэлээр** хүлээн авдаг. **Итгэл** гэдэг нь хүн өөрийгөө төөрсөн, гэмт нүгэлтэн гэдгийг хүлээн зөвшөөрөн Эзэн Есүсийг аврагдах цорын ганц гарц найдвар гэж хүлээж авахыг хэлнэ. Хүн Эзэн Есүст бүх найдвараа өгөх нь жинхэнэ авралд хүргэх итгэл юм.

Авралыг бид өөрсдөөсөө төлбөр төлөөд эсвэл сайн үйл үйлдээд авч болно гэх санаархал болгоныг **энэ нь та нараас биш** гэдэг үг няцааж байна. Үхсэн хүн юу ч *хийж* чаддаггүй, гэмт хэрэгтэн ялаас өөр юу ч авах *зохисгүй*.

Энэ нь Бурханы бэлэг. Бэлэг бол мэдээж ямар ч болзолгүй, үнэ төлбөргүй өгөгддөг зүйл. Бурхан зөвхөн ийм болзлоор л авралыг санал болгодог. **Бурханы бэлэг бол нигүүлслээр** өгөгдсөн, **итгэлээрээ** авдаг *аврал*. Үүнийг хаа сайгүй хүн бүрд санал болгосон.

[2:9]

Энэ нь **үйлсээр биш** гэдэг нь хэн нэгэн хүн ямар нэг гавьяа байгуулаад авчихаж болдоггүй гэсэн үг. Тухайлбал, дараах зүйлсийг хийснээр аврагдах боломжгүй:

- (1) Цуглаанаас аврагдсан гэх баталгаа авах
- (2) Баптисм хүртэх
- (3) Чуулганд гишүүнээр элсэх
- (4) Цуглаанд явах
- (5) Хайрын зоог барих
- (6) Арван хуулийг дагахыг хичээх
- (7) Уулан дээрх номлолын дагуу амьдрах
- (8) Өглөг өгөх
- (9) Сайн хөрш байх
- (10) Ёс суртахуунтай, хүндэтгэлтэй амьдралаар амьдрах

Хүн **үйлсээрээ** аврагдахгүй. Мөн **итгэл дээрээ үйлсээ нэмж** аврагддаггүй. Тэд **зөвхөн итгэлээр аврагддаг**. Мөнх амийг хүлээн авахын тулд ямар нэгэн үйлсийг ямар ч хэмжээгээр хамаагүй хийх ёстой болбол аврал нь нигүүлслээр өгөгдөх боломжгүй болно (Ром 11:6). **Үйлсийг** үүнд оролцуулахгүй байгаагийн нэг учир нь хүнийг

үйлсээрээ бардамнахаас сэргийлсэн хэрэг. Хүн **үйлсийнхээ** үр дүнд аврагддаг байсан бол тэр Бурханы өмнө бардамнах шалтгаантай болно. Ийм юм байх боломжгүй (Ром 3:27).

Хүн үйлсээрээ аврагдчихдаг байсан бол Христ үхэх шаардлагагүй байв (Гал 2:22). Гэвч нүгэлт хүнд аврагдаж болох өөр зам байгаагүй учраас Есүс үхсэн гэдгийг бид мэднэ.

Хэн нэгэн өөрийн хийсэн үйлсээр аврагдаж болдог байсан бол тэр хүн өөрөө өөрийнхөө аврагч болж өөрийгөө магтан хүндэлж болох байсан. Гэвч ингэвэл энэ нь шүтээн шүтэх явдал болох бөгөөд Бурхан үүнийг хориглосон (Ег 20:3).

Христэд итгэх итгэл болон өөрийн үйлсээр аврагддаг байвал Есүс ба нүгэлтэн гэсэн хоёр аврагч гарч ирэх буюу ингэх боломжгүй. Тэгвэл Христ аврагчийн алдраа өөр хэн нэгэнтэй хуваалцах хэрэг гарах бөгөөд Тэр тэгэхгүй (Иса 42:8).

Эцэст нь хэлэхэд, хэрэв хэн нэгэн авралдаа үйлсээ нэмэр болговол Бурхан түүнд өртэй болно. Ийм зүйл бас л боломжгүй юм. Бурхан хэнд ч өртөн болох боломжгүй (Ром 11:35).

Итгэл нь ямар нэг гавьяа биш учраас бардамнан сайрхаад байх юмгүйгээрээ үйлсээс ялгаатай (Ром 3:27). Би Бурханд итгэсэн гэж бардамнах шалтгаан хүнд байхгүй. Түүнд итгэнэ гэдэг бол хүний хийж чадах хамгийн ухаалаг, зохистой, мэдрэмжтэй алхам. Бүтээгч ба Аврагчдаа найдна гэдэг бол цорын ганц утга учиртай хэрэг мөн. Бид Түүнд итгэж чадахгүй бол өөр хэнд итгэх вэ?

[2:10]

Бид авралын үр дүнд **Түүний бүтээл** болсон. Бид өөрсдийнхөө ажлын үр дүн биш, харин Бурханы бүтээл. Дахин төрсөн итгэгч хүн бол Бурханы уран бүтээл. Бүтээлээ урлахдаа ямар түүхий эдийг хэрэглэснийг бодолцвол Тэр үнэхээр амжилттай ажилласныг харах болно. Түүний уран бүтээл нь Христтэй холбон бий болгосон цоо **шинэ бүтээл** байсан юм. "Хэрэв хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. Хуучин юмс нь өнгөрчээ. Харагтун, шинэ болсон байна" (2Ко 5:17).

Энэхүү шинэ бүтээлийн зорилго зориулалтыг **сайн үйлсийн төлөө** гэдэг хэсгээс харж болно.

Бид **сайн үйлсээрээ** аврагдаагүй нь үнэн гэдэгтэй адил бид сайн үйлсийн **төлөө** аврагдсан нь үнэн. **Сайн үйлс** бол *үндэс* нь биш, харин *үр жимс* нь мөн. Бид *аврагдахын төлөө* ажилладаггүй, харин *аврагдсаныхаа улмаас* ажилладаг.

Иаков 2:14-26-д энэ үнэнийг онцлон хэлсэн. Иаков "үйлсгүй итгэл үхмэл" гэж хэлэхдээ аврагдахын тулд итгэл дээрээ ажил үйлсийг нэмэх ёстой гэсэн санааг хэлээгүй, харин **сайн үйлс** бүхий амьдралд хүргэдэг итгэл байх хэрэгтэй гэжээ. Бидний итгэл жинхэнэ бодит эсэхийг **үйлс** маань харуулдаг. Паул "**бид сайн үйлсийн төлөө бүтээгдсэн Түүний бүтээл**" гэж бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрсөн.

Бурханы ийм дэс дарааллыг тогтоожээ:

Итгэл → Аврал → Сайн үйлс → Шагнал

Итгэл нь авралд хүргэдэг. Аврал нь **сайн үйлсийг** төрүүлнэ. Сайн үйлс нь Түүгээр шагнагдана.

Тэгэхээр би ямар **сайн үйлс** хийх ёстой вэ гэдэг асуулт гарч ирнэ. **Бурхан биднийг тэдгээрийн дотор яваасай** гэж урьдаас бэлтгэсэн **сайн үйлс** гэж Паул хариулжээ.

Өөрөөр хэлбэл, Бурхан хүн нэг бүрийн амьдралд зориулан төлөвлөгөө бэлдсэн байдаг. Тэр биднийг аврагдахаас өмнө бидний сүнсний өсөлт дэвшлийг төлөвлөчихсөн байсан. Түүний бидэнд зориулсан хүсэл төлөвлөгөөг таньж, түүнийг нь дуулгавартай дагах нь бидний үүрэг хариуцлага. Бид өөрсдөө төлөвлөгөө зохиох шаардлагагүй, зөвхөн Түүний чиглүүлэн хөтлөх төлөвлөгөөг нь дагахад болно. Энэ нь биднийг уурлаж цухалдах, яаруу буруу гишгэхээс гэтэлгэх бөгөөд бидний амьдрал Түүнийг хамгийн дээдээр алдаршуулж, бусдыг хамгийн ихээр ивээж, өөрт хамгийн аугаа шагналыг хүртээнэ.

Хувь амьдралд зориулан төлөвлөсөн Түүний **сайн үйлсийг** таньж мэдэхийн тулд бид дараах зүйлсийг хийх ёстой: (1) нүгэл хийснээ ухаарсан даруйдаа гэмшиж орхих, (2) Түүнд огт болзолгүйгээр, тасралтгүй бууж өгч байх, (3) Түүний хүслийг ялгаж танихын тулд Бурханы үгийг судлах, тэгээд хий гэснийг нь хийх, (4) залбирах цагийг өдөр бүр гаргах, (5) үйлчлэх боломж гармагц ашиглах, (6) христитгэлт хүмүүстэй нөхөрлөлөө гүнзгийрүүлж, зөвлөгөө авч байх. Бурхан биднийг **сайн үйлст** зориулан

бэлддэг. Тэр биднээр гүйцэтгүүлэх **сайн үйлсийг** бэлдэж өгдөг. Тэгээд тэдгээрийг нь биелүүлэхээр Тэр биднийг шагнадаг. Түүний нигүүлсэл ийм ажээ!

5. Итгэгч иудейчүүд, итгэгч харь үндэстнүүдийн Христ доторх нэгдэл (2:11-22)

Паул 2-р бүлгийн эхний хагаст итгэгч харь үндэстнүүд болон иудейчүүдийн тус тусын авралын тухай бичсэн. Одоо тэр үүнийг ахиулан тэдний үндэс угсааны ялгаа арилж, Христ дотор нэгдэн чуулган буюу Эзэний орших ариун сүм дуган болж хэлбэрших тухай өгүүлж байна.

[2:11]

Харь үндэстнүүд Христэд итгэхээсээ өмнө төрөлхөөсөө иудейчүүдийн хувьд гадуурхагдсан харь хүмүүс байсан тухай 11-12-р ишлэлд Паул дурдаж байна. Нэгдүгээрт тэднийг дорд үздэг байв. Иудейчүүд тэднийг **хөвч хөндүүлээгүй гэж нэрлэж** байсан. Энэ нь израильчуудыг Бурханы гэрээний ард түмэн болохыг харуулсан тэмдэг шиг мэсний ором тэдний биед байхгүйг хэлж байна. "Хөвч

хөндүүлээгүй" гэдэг үг нь өнөөгийн хүмүүс адлагдсан улс үндэстнийг нэрлэдэг шиг угсаатнаар нь доромжилсон үг байж. Энэ үгийн утга санаа Давидын хэлсэн үгнээс анзаарагддаг. Тэрээр "Хөвч хөндүүлээгүй энэ филист хүн амьд Бурханы цэргийг доромжлохоор хэн юм бэ?" гэсэн (1См 17:26).

Иудейчүүд өөрсдийгөө онцлон ялгаж **Хөвч хөндүүлэгсэд** гэж нэрлэдэг байв. Тэд энэ нэрээрээ ихэд бахархдаг байлаа. Энэ нь Бурхан тэднийг бусад үндэстнүүдээс тусгайлан сонгосон ард түмэн гэж тодорхойлдог байсан. Паул тэдний сайрхлыг энэ бол зөвхөн **махан биед хүний гараар хийгдсэн** хөвч хөндөлт гэж тайлбарлаж байна. Энэ нь махан биеийн хэрэг төдий юм. Тэд Бурханы гэрээний ард түмэн гэсэн гадаад тэмдэгтэй байсан болохоос дотроо Эзэнд үнэнээсээ итгэх итгэлгүй байлаа. “Учир нь гаднах байдлаараа иудей нь иудей хүн биш бөгөөд махан биеийн гаднах хөвч хөндөлт нь ч хөвч хөндөлт биш. Харин доторх байдлаараа иудей нь иудей хүн мөн. Үсгээр бус, Сүнсээр хийлгэсэн зүрх сэтгэлийн хөвч хөндөлт нь хөвч хөндөлт мөн. Тэр хүний магтаал нь хүнээс бус,

харин Бурханаас ирдэг юм” (Ром 2:28, 29).

Иудейчүүд зүрхэндээ хөвч хөндүүлсэн эсэх нь хамаагүй 11-р ишлэлд хэлж байгаа зүйл нь тэд өөрсдийнхөө нүдэнд *тусгай* ард түмэн ба харь үндэстнүүдийг гадуурхдаг байв. Иудейчүүд болон харь үндэстнүүдийн хоорондын дайсагнал нь хүн төрөлхтний харсан хамгийн том яс үндэс, шашны ялгаа байсан юм. Иудей хүн Бурханы өмнө аугаа хувь завшаантай байр суурийг эзэлж байв (Ром 9:4, 5). Харь үндэстэн бол иудейчүүдийн хувьд гадаад хүн байлаа. Үнэн Бурханыг тогтоосон ёсоор нь хүндэлж мөргөхийг хүсвэл тэр иудей хүн болох ёстой байв (Рахаб, Рутыг харьцуулна уу). Иерусалимд байдаг иудейн сүм нь Бурханы нэрээ тавьсан, дэлхий дээрх цорын ганц газар байсан бөгөөд хүн зөвхөн тэнд л Түүнд ойртон очиж болдог байв. Сүмийн дотор хэсэгт харь үндэстнүүд орж болдоггүй, орвол үхэх аюултай байжээ.

Есүс Тир, Сидон нутгийн харь үндэстэн эмэгтэйн итгэлийг сорихдоо иудейчүүдийг гэртээ байгаа хүүхдүүдтэй, харин харь үндэстнүүдийг ширээн доорх ноходтой зүйрлэсэн. Тэр эмэгтэй нохойноос өөрцгүй

гэдгээ хүлээн зөвшөөрч, гэхдээ хүүхдүүдийн унагах талхны үйрмэг гуйсан. Түүний итгэл шагналаа авсныг та хэлүүлэлтгүй мэдэж байгаа (Мк 7:24-30). Ефес 2:11-т элч уншигчдаа өмнө нь харь үндэстнүүд байсан, тиймээс ч гадуурхагдаж байсныг сануулж байна.

[2:12]

Харь үндэстнүүд ч Христгүй байв: тэдэнд Мессиа байгаагүй. Тэрээр Израиль үндэстэнд өгөгдсөн амлалт байв. Мессиагийн үйлчлэлээр үндэстнүүд ерөөл хүртэнэ гэж урьдаас хэлэгдсэн байсан ч (Иса 11:10; 60:3), Тэрээр иудей хүн болж төрөх, голлон "Израилийн гэрийн алдагдсан хонинууд"-д үйлчлэх ёстой байв (Мт 15:24).

Харь үндэстнүүд Мессиагүй байснаас гадна **Израилийн нийгмээс гадна, харь хүмүүс** байв. Харь хүн гэж тухайн улсад "харьяалалгүй" нэгнийг хэлдэг. Тэрээр иргэншлийн эрх, давуу талгүй, гадны, үл таних хүн. **Израилийн** нийгмийн хувьд харь үндэстнүүд нь гадна байгсад, гаднаас нь харагсад байв.

Тэд амлалтын гэрээнүүдийн хувьд ч харь

хүмүүс байсан. Бурхан **Израиль** үндэстэнтэй Абрахам, Исаак, Иаков, Мосе, Давид мөн Соломон зэрэг хүнээр дамжуулан **гэрээнүүдийг** байгуулсан. Энэ **гэрээнүүд** нь иудейчүүдэд ивээл ерөөлийг амласан. Харь үндэстнүүд эдгээрийн гадна байсан. Тэд үндэстнээрээ ч, хувь хүний хувьд ч **ямар ч найдваргүй** байв.

Үндэстний хувьд тэдний газар нутаг, засаг төр, ард түмэн тогтож хоцрох баталгаа байхгүй. Хувь хүмүүсийн хувьд ч ирээдүй бүрхэг байсан: тэдэнд үхлээс цааш харах **найдвар байгаагүй**. Тэдний ирээдүй саргүй шөнө шиг байсан гэж нэгэн хүн хэлжээ.

Эцэст нь хэлэхэд, тэд **ертөнцөд Бурхангүй байлаа**. Энэ нь тэднийг атейст (бурхангүй үзэлтнүүд) байсан гэсэн үг биш. Тэдэнд өөрсдийнх нь шүтэж мөргөдөг мод, чулуугаар хийсэн бурхан шүтээнүүд байсан. Гэхдээ тэд цорын ганц үнэн Бурханыг таньдаггүй байв. Бурхангүй, хатуу хахир ертөнцөд тэд Бурхангүй байв.

[2:13]

Харин гэдэг үг бас нэг огцом шилжилтийн

дохио болж байна (2:4-тэй адил). Ефес хотын харь үндэстнүүд алслагдсан, гадуурхагдсан газраасаа аврагдаж, Бурханд ойр байх байр сууринд өргөмжлөгджээ. Тэднийг итгэх үед ийм явдал болсон. Тэднийг Аврагчид итгэхэд, Бурхан тэднийг **Христ Есүс дотор** оруулж, хайрлагдсан Түүний дотор хүлээн авсан. Тэр цагаас хойш, тэд **Есүс Христийн дотор** байгаа учраас Бурханд Есүсийн адил ойртсон. Энэхүү гайхалтай өөрчлөлтийг бий болгохын тулд төлсөн төлбөр нь **Христийн цус** байсан. Харь үндэстнүүд Бурханд ойртон очих эрхийг эдлэхийн тулд эхлээд гэм нүглээсээ цэвэрлэгдэх шаардлагатай. Үүнийг зөвхөн загалмай дээр урссан **Христийн цус** л хийж чадна. Тэд Эзэн Есүсийг итгэлийн тодорхой үйлдлээр хүлээж авсан цагт Түүний үнэт цусаар хийгдсэн цэвэрлэгээ тэдний хувьд хүчин төгөлдөр болсон.

Есүс тэдэнд зөвхөн **ойртоод** зогсоогүй, иудейчүүд ба харь үндэстнүүдийн хоорондох эртнээс улбаатай дайсагналыг үүрд үгүй хийсэн шинэ нийгмийг бий болгосон. ШГ-ний цаг үеийг хүртэл дэлхий иудейчүүд, харь үндэстэн гэсэн хоёр бүлэгт хуваагдсан байв. Чуулган нэртэй

гурав дахь бүлгийг бидний Аврагч бий болгов (1Ко 10:32). Дараагийн ишлэлүүдэд, итгэгч иудей хүн итгэгч харь үндэстэн хоёр хэрхэн Христийн дотор нэг болж, иудей, харь үндэстэн гэж байхгүй энэхүү шинэ нийгэм рүү орж байгааг харуулна.

[2:14]

Учир нь Тэр Өөрөө бидний энх тайван мөн.

"Тэр энх тайвныг тогтоосон" гэж хэлээгүйг анзаараарай. Тэгж хэлсэн бол бас л үнэн байх байсан. Үүнийг бид дараагийн ишлэлээс харах болно. Энд **Тэр Өөрөө** бидний энх тайван гэжээ. Гэхдээ хүн яаж энх тайван *байж* болох вэ?

Ингэдэг ажээ: иудей хүн Эзэн Есүст итгэсэн цагаас үндэснийхээ иргэншлийг алддаг байна. Тэр цагаас эхлээд уг хүн "Христ дотор" байгаа болно. Мөн харь үндэстэн Аврагчийг хүлээн авсан цагаасаа эхлээд харь хүн байхаа больж "Христ дотор" байгаа болно. Өөрөөр хэлбэл, итгэгч иудей болон итгэгч харь үндэстэн дайсагналцан хуваагдсан байсан бол одоо Христ дотор **хоёр хэсэг нэг болжээ**. Христтэй нэгдсэн холбоо нь тэднийг нэг нэгэнтэй нь зайлшгүй

нэгтгэж байна. Иймээс Микагийн зөгнөн хэлсэнчлэн Хүн энх тайван болж байна (Мик 5:5).

Бидний энх тайван байх Түүний ажлын цар хүрээг 14-18-р ишлэлүүдэд нарийвчлан дурджээ.

Эхлээд, бидний сая өгүүлсэн эв нэгдлийн ажил байна. Тэр **хоёр хэсгийг нэг болгосон** гэдэг нь итгэгч иудей, итгэгч харь хүнийг нэгтгэсэн тухай хэлж байна. Одоо тэд иудей эсвэл харь үндэстэн байхаа больж, зөвхөн христитгэгчид болжээ. Нарийн яривал, христитгэлт иудей эсвэл христитгэлт харь үндэстэн гэж ярих нь ч буруу. Үндэс угсаа гэх мэт махан биеийн ялгаанууд бүгд загалмайд хадагдсан.

Христийн ажлын хоёр дахь хэсгийг устгал гэж нэрлэж болно. **Тэр ... хуваагдлын ханыг устгасан.** Мэдээж энэ нь мод юмуу чулуун хана биш, харин Мосегийн тушаалуудын Хууль өгөгдсөнөөр Израилийг бусад үндэстнээс тусгаарласан үл харагдах саад тотгорыг хэлж байна. Үүнийг дүрслэхэд сүмийн хашаан доторх иудейчүүдийн хэсгийг харь үндэстнүүдийн хэсгээс заагласан ханыг олонтаа хэрэглэж ирсэн. Тэр ханан дээр "Бусад үндэстнээс хэн нэгэн

Ариун газрын эргэн тойрны хашаа хамгаалалтыг давж орж болохгүй. Үйлдэл дээрээ баригдсан ийм хүн амиа алдвал хариуцлагаа өөрөө үүрнэ" гэж бичсэн байдаг байж.

[2:15]

Христийн ажлын гурав дахь тал нь иудей ба харь үндэстнүүдийн хооронд, мөн хүн Бурхан хоёрын хооронд байсан урт хугацааны **дайсагналыг** устгасан явдал мөн. Хууль буюу **зарлиг доторх тушаалуудын Хууль** нь энэхүү дайсагналын гэмгүй шалтгаан гэж Паул тодорхойлжээ. Мосегийн Хууль нь нэг цогц хууль байсан атлаа албан ёсны салангид тушаалуудаас бүрдэж байсан. Тэдгээр нь амьдралын ихэнх талбарыг биш юм гэхэд маш олон талбарыг хамарсан сургаалаас бүрдэж байв. Хууль нь өөрөө ариун, шударга, сайн (Ром 7:12). Гэвч хүний нүгэлт мөн чанар үүнийг үзэн ядалт жигшлийн шалтаг болгожээ. Хууль үнэхээр Израилийг дэлхий дээрх Бурханы тусгаарлан сонгосон ард түмэн болгосон учир иудейчүүд ихэрхэг болж, харь үндэстнүүдийг дорд үзэв. Харь үндэстнүүд үүнд гүнээ эгдүүцэн

дайсагнасан тул бидний хэтэрхий сайн мэддэг анти-Семитизм буюу еврейчүүдийг үзэн ядах үзэл бий болсон. Гэхдээ Христ яаж тэрхүү **дайсагналын** шалтгаан болсон хуулийг зайлуулав аа? Нэгдүгээрт, Тэр хууль зөрчсөний төлөөсийг төлөхийн тулд үхсэн. Ингэснээр Тэр Бурханы зүй ёсны шаардлагыг бүрэн гүйцэд хангасан. Одоо хууль "Христ дотор" байгаа нэгнээс юу ч нэхэж чадахгүй боллоо. Түүний шийтгэлийн төлбөр бүрэн төлөгдсөн. Итгэгчид хуулийн дор биш, нигүүлслийн дор байгаа. Гэхдээ энэ нь тэднийг өөрсдийн хүслээр амьдрах эрхтэй гэсэн үг биш, харин хуулийн дагуу Христэд харьяалагдах болсон тул Түүний хүссэнээр амьдрах ёстой болсон гэсэн үг.

Хуулиас үүдэлтэй дайсагналыг үгүй болгосны үр дүнд Эзэн шинэ бүтээл хийх боломжтой болов. Тэр Өөрийн дотор **мөнөөх хоёрыг** буюу итгэгч иудей ба итгэгч харь үндэстнийг чуулган хэмээх **нэг шинэ хүн** болгосон. Түүнтэй нэгдсэнээрээ дамжуулан дайснууд байсан талууд бие биетэйгээ энэхүү шинэ нөхөрлөлөөр нэгдсэн. Чуулган нь урьд өмнө байгаагүй организм учраас **шинэ юм**. Үүнийг ойлгох нь маш чухал. ШГ-ний

чуулган нь ХГ-ний Израилийн үргэлжлэл биш. Энэ бол урьд өмнө байсан мөн хожим ирэх бүхнээс ялгаатай онцлог зүйл. Энэ нь дараах зүйлсээс илэрхий байна:

1. Харь үндэстэн иудей хүний адил эрх эдлэх учраас энэ нь **шинэ**.
2. Христигэлт болсноороо иудей, харь үндэстэн ялгаагүй иргэншлээ алдаж байгаа учраас энэ нь **шинэ**.
3. Иудейчүүд, харь үндэстнүүд Христийн биеийн эрхтнүүд болж байгаа учраас энэ нь **шинэ**.
4. Иудей хүн Христийн хаанчлалын албат болох биш, Христтэй хамт хаанчлах найдвар өгөгдсөн учраас энэ нь **шинэ**.
5. Иудей хүн цаашид хуулийн дор байхгүй учраас энэ нь **шинэ**.

Чуулган өөрийн онцгой дуудлагатай, онцгой хувь тавилантай, Бурханы зорилгод онцгой байр суурьтай гарцаагүй **шинэ** бүтээл мөн. Гэхдээ Христийн ажлын цар хүрээ ингээд зогсохгүй. Түүнчлэн Тэр иудей ба харь үндэстнүүдийн хооронд **энх тайвныг** тогтоосон. Тэрээр үүнийг хийхийн тулд дайсагналын шалтгааныг

зайлуулж, шинэ мөн чанарыг бий болгож, шинэ нэгдлийг бүтээсэн. Загалмай бол арьс өнгө, анги давхрагаар ялгаварлан гадуурхах, еврейчүүдийн эсрэг үзэл, мухар сүсэг болоод хүн хоорондын элдэв тэмцэл мөргөлдөөнд өгөх Бурханы хариу юм.

[2:16]

Христ иудейчүүд болоод харь үндэстнийг бие биетэй нь эвлэрүүлээд зогсохгүй тэдний **аль алийг Бурхантай** эвлэрүүлсэн. Израиль болон бусад улс үндэстнүүд хоорондоо дайсагналцдаг байсан ч бүгд Бурханы эсрэг дайсагнах тал дээр санаа сэтгэл нэгддэг байжээ. Энэ дайсагналыг үүсгэгч шалтгаан нь нүгэл. Эзэн Есүс загалмай дээрх үхлээрээ дайсагналын шалтгааныг зайлуулснаараа **дайсагналыг хөнөөсөн**. Түүнийг хүлээж авсан хүнийг зөвт, уучлагдсан, золигдсон, өршөөгдсөн, нүглийн хүчнээс ангижирсан гэж тооцдог. Дайсагнал арилж, одоо тэдэнд **Бурхантай энх тайван тогтсон**. Эзэн Есүс итгэгч иудей болон харь үндэстнийг чуулган хэмээх **нэг бие дотор** нэгтгэж, бүх дайсагнал арилсан энэ биеийг **Бурханд**

толилуулж байна.

Бидэнтэй эвлэрэх хэрэг Бурханд байхгүй. Тэр хэзээ ч биднийг үзэн ядаж байгаагүй. Харин бид Түүнтэй эвлэрэх хэрэгтэй байсан. Бидний Эзэний загалмай дээр гүйцэтгэсэн ажил биднийг Түүн рүү дайсан биш, харин найзын хувиар очих зөвт үндэслэл болж өгсөн.

[2:17]

14-р ишлэлд Христ *бол* бидний энх тайван гэсэн. 15-р ишлэлд Түүнийг энх тайвныг *тогтоосон* гэжээ. Одоо бид **Тэр ирж, энх тайвныг тунхагласныг** мэдэж авна. Тэр хэзээ, яаж ирсэн юм бэ? Эхлээд, Тэр амилахдаа биеэрээ ирсэн. Дараа нь, Ариун Сүнс гэдэг төлөөлөгчөөрөө ирсэн. Тэр амилахдаа **энх тайвныг тунхагласан**. Үнэндээ үхлээс амилсныхаа дараа хэлсэн Түүний анхны үг нь **амар тайван** гэдэг үг байсан (Лк 24:36, Иох 20:19, 21, 26). Улмаар Тэр элч нараа Ариун Сүнсний хүч дотор илгээж, тэднээр дамжуулан **энх тайвныг тунхагласан** (Үйл 10:36). Энх тайвны сайн мэдээ нь **алс хол байсан та нарт** (харь үндсэтнүүд) **болон ойр байгсдад**

(иудейчүүдэд) тунхаглагдан Исаиа 57:19-д бичигдсэн Бурханы амлалт нигүүлсэнгүйгээр биелсэн.

[2:18]

Бурхан болон нэг биеийн гишүүн эрхтнүүдийн хооронд энх тайван байгаагийн бодит баталгаа нь тэд Бурханы өмнө хэдийд ч **очих замтай болсон** явдал мөн. Энэ нь Бурханы оршихуй болох ариунаас ариун газар уруу зөвхөн тэргүүн тахилч жилд нэг удаа орж болдог байсан ХГ-ний үетэй харьцуулбал эрс ялгаатай байна. Энэ ялгааг Ийдий ийн хэлжээ:

Зөвхөн тэр нэг үндэстний, тэр нэг овгийн, тэр нэг хүн, жилийн тэр нэг өдөр, зөвхөн хэлбэр төдий, тун хязгаартай эдэлдэг байсан сүнсний тэнгэрлэг эрхийг хамгийн алс суух харь үндэстэн Христ дотор орсноор тасралтгүй эдлэх болжээ.¹³

Итгэгч хүн бүр залбирлаараа тэнгэрийн сэнтийн өмнө очиж, ертөнцийн Хамгийн Дээд Нэгэнд сөгдөн Түүнийг **Эцэг** гэж дуудаж болохоор болов.

Залбиралд мөрдөгдөх дарааллыг энд өгчээ.

Нэгд, **Түүгээр** (Эзэн Есүс) дамжуулна. Тэрээр Бурхан, хүний хоорондын цорын ганц Зууч. Түүний үхэл, оршуулга, амилалт нь Бурханы оршихуйд очиход саад болж байсан бүх хуулийн хоригийг зайлуулсан. Тэр Зуучийн хувьд одоо биднийг Эцэгтэйгээ байнгын нөхөрлөлтэй байлгах зорилгоор дээр байгаа. Бид Бурханд Түүний нэрээр ханддаг. Бидэнд өөрсдөөсөө хандах зохистой юм юу ч байхгүй тул бид Түүний чанараар гуйн ойртдог. Залбиралд оролцож байгаа талууд нь **бид цөмөөрөө** буюу итгэгч иудей, итгэгч харь үндэстэн аль аль нь юм. Бид **очих замтай болсон** нь бидний давуу эрх билээ. **Нэг Сүнсээр** – бидний залбиралд Ариун Сүнс тусалдаг.

“Үүнчлэн мөн Сүнс бидний сул дорой байдалд тусалдаг. Учир нь яаж залбирах ёстойгоо бид мэддэггүй. Харин Сүнс Өөрөө үгээр илэрхийлшгүйгээр ёолон байж бидний төлөө зуучлан гуйдаг” (Ром 8:26).

Бидний хандах Нэгэн нь **Эцэг** билээ. ХГ-ний нэг ч итгэгч Бурханыг Эцгийн ёсоор мэддэггүй байсан. Христ амилахаас өмнө хүмүүс Бурхантай Бүтээгчийн өмнөх бүтээлийн хувиар

харилцдаг байж. Тэр амилсныхаа дараа “...харин Миний ах дүү нар уруу очиж, тэдэнд “Би Миний Эцэг ба та нарын Эцэгт, Миний Бурхан ба та нарын Бурханд очно” гэдгийг хэл гэлээ” (Иох 20:17). Түүний гүйцэтгэсэн золилтын ажлын үр дүнд итгэгчид анх удаа Бурханыг **Эцэг** гэж дуудах боломжтой болов. 18-р ишлэлд хамгийн энгийн итгэгчийн залбиралд хүртэл Гурвал бүхлээрээ оролцож байгааг харуулжээ: тэрээр Эзэн Есүс Христээр **дамжуулан**, Ариун **Сүнсний** хүчээр, Бурхан **Эцэгт** хандан залбирдаг.

[2:19]

Энэ бүлгийн сүүлийн дөрвөн ишлэлд элч Паул итгэгч харь үндэстнүүдийн эдлэх шинэ, гайхалтай хувь завшаануудыг тоочсон. Тэд **цаашид харь хүмүүс болон гаднын хүмүүс биш**. Тэд дахин хэзээ ч харийнхан, ноход, хөвч хөндүүлээгүй, гадны хүмүүс гэгдэхгүй. Тэд одоо ШГ-ний **ариун хүмүүсийн адил нутгийн иргэд** болсон. Иудей гаралтай итгэгчид тэднээс юугаараа ч дээрдэхгүй. Христигэлт хүн бүр тэнгэрийн улсын нэгдүгээр зэрэглэлийн иргэд

мөн (Флп 3:20, 21). Мөн тэд **Бурханы гэр бүлийн** гишүүд юм. Тэд тэнгэрийн хаанчлалд “ер бусаар ороод” зогсоогүй тэнгэрийн гэр бүлд үрчлэгдсэн.

[2:20]

Эцэст нь, тэд чуулганы гишүүд болсон буюу Паулын энд хэлснээр тэд ариун сүмийг барих чулуу болцгоов. Энэ **сүмийн суурь, булангийн чулуу**, наалдуулах зуурмаг, эв нэгдэл, тэгш хэм, өсөлт болон бусад онцлогуудыг элч нарийвчлан дэлгэрэнгүй тайлбарлажээ.

Энэ сүм элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байгаа. Энэ нь ШГ-ний элч нар болон эш үзүүлэгчдийг хэлж байна. ХГ-ний эш үзүүлэгчид чуулганы тухай юу ч мэдэхгүй байсан тул тэдний тухай яриагүй юм. Мөн элч нар болон эш үзүүлэгчид өөрсдөө чуулганы суурь гэсэн үг биш. Христ **суурь** нь юм (1Ко 3:11). Гэхдээ тэд Эзэн Есүсийн тухай болон Түүний хийсэн ажлын талаар зааж сургаснаараа суурийг тавьсан. **Элч нар болон эш үзүүлэгчид** гэрчлэл, сургаалиараа Христийг илчилж, тийнхүү Христ дээр чуулган суурилсан. Петр

Түүнийг Христ мөн, амьд Бурханы Хүү гэж хүлээн зөвшөөрөхөд Христ Өөрийнх нь чуулган тэрхүү хадан суурин дээр буюу Тэрээр Бурханаар тослогдсон, Бурханы цорын ганц онцгой Хүү гэдэг бат үнэн дээр суурилахыг хэлсэн (Мт 16:18).

Илчлэлт 21:14-т элч нарыг ариун Иерусалимын арван хоёр суурьтай холбожээ. Тэд суурь нь биш боловч суурьтай холбоотой, яагаад гэвэл тэд Христ болоод чуулганы тухай агуу үнэнийг анх сурган заасан хүмүүс юм. Аливаа байшингийн **суурийг** нэг л удаа тавьдаг. **Элч нар болон эш үзүүлэгчид** энэ ажлыг нэг удаа бүх байшинд зориулан хийсэн. Тэд одоо бидэнтэй хамт байхгүй байгаа ч тэдний тавьсан **суурь** ШГ-нд бичигдэн үлдсэн. Хоёрдогч утгаар авч үзвэл үе болгонд элчийн, эш үзүүлэгчийн үйлчлэлтэй хүмүүс байдаг. Илгээлтийн ажилчид, чуулган таригчид элчийн үүрэгтэй гэж үзэж болно. Ариусгаж өсгөхийн тулд үгийг тунхаглагчид нь эш үзүүлэгчид юм. Гэвч тэд үндсэн утгаар элч, эш үзүүлэгчид биш.

Христ Есүс сүмийн **сууриас** гадна бас **булангийн** тулгуур **чулуу** мөн. Түүний арвин их

яруу алдар, төрөл бүрийн үйлчлэлийг нэг жишээгээр хангалттай гаргах боломжгүй. **Булангийн** тулгуур **чулуу** гэдэг үгийг дор хаяж гурван янзаар тайлбарлаж болно. Тэд бүгд Эзэн Есүс Христийг чуулганы өвөрмөц, бүхнээс дээгүүр, салшгүй тэргүүн болохыг харуулах юм.

(1) **Булангийн** тулгуур **чулуу** гэж бид ихэвчлэн байшингийн нүүрний доод буланд байдаг чулууг хэлдэг. Барилгын бусад хэсгүүд бүгд үүн дээр суурилдаг учраас үүнийг үндсэн чухал үүргийг гүйцэтгэдэг зүйл гэж хэлж болно. Энэ утгаар Эзэнийг үнэхээр илэрхийлж байна. Дээр нь хоёр ханыг холбон нийлүүлж байгаа нь итгэгч иудей, итгэгч харь үндэстэн Түүгээр дамжуулан чуулган дотор нэгдэж байгаагийн илрэл гэж болно.

(2) Библийн зарим судлаачид **булангийн** тулгуур **чулуу** гэдэг нь нуман хаалганы голын чулууг хэлж байна гэж үздэг. Тэр чулуу бусдаасаа хамгийн дээр байрладаг бөгөөд бусад чулуугаа тулдаг. Тэгэхээр Христ бол чуулганы бүхнээс дээгүүрх Нэгэн. Тэр мөн чуулганы салшгүй хэсэг мөн. Түүнийг авч хаявал бусад нь бүгд нурна.

(3) Байж болох гурав дахь тайлбар нь цац суварга буюу пирамидын оройн дээд чулуу. Энэ чулуу байгууламжийн хамгийн дээр нь байрладаг. Ийм хэлбэр хэмжээтэй ганцхан чулуу нь тэр. Энэ чулууны зүсэгдсэн өнцөг, хэмжээ нь пирамидын хэлбэрийг тодорхойлдог. Тэгэхээр Христ бол чуулганы Тэргүүн. Тэр Өөрөө ч, Түүний үйлчлэл ч өвөрмөц ажээ. Чуулганы өвөрмөц онцлогийг тодорхойлогч нь Тэр билээ. Юуны өмнө түүний **суурь**:

[2:21]

Түүний дотор гэдэг нь Христийн дотор гэсэн үг. Тэр бол чуулганы амьдрал, өсөлтийн эх сурвалж. Блейки хэлэхдээ:

Түүгээр бид чуулган уруу орж ирсэн,
Түүгээр бид чуулган дотор өсдөг,
'Нигүүлсэл, нигүүлсэл нь үүнд оршиг' гэх
уухайн түрлэгээр дээд чулууг ил гаргах
эцсийн оргил цэг хүртэл чуулган бүхэлдээ
Түүний дотор өсдөг.¹⁴

Сүмийн эв нэгдэл, тэгш тэнцвэрийг **бүх барилга холбогдон** гэж илэрхийлжээ. Энэ нь

маш олон хувь хүний хамтдаа цогцлоох эв нэгдэл юм. Гишүүн бүр эмэгтэй эрэгтэй ялгаагүй тухайн **барилгад** өөрсдөд нь таарсан онцгой байр суурь бий. Үхлийн хөндийгөөс Бурханы нигүүлслээр ухаж гаргасан чулуунууд хоорондоо төгс зохицох ажээ. Энэ барилга нь **өсдөгөөрөө** өвөрмөц, онцлог ажээ. Гэхдээ бусад байшин барилга шиг тоосго чулуу нэмж өсдөггүй. Харин хүний бие махбод шиг өсдөг гэж хэлж болно. Эцсийн эцэст чуулган бол амьгүй байшин биш ээ. Байгууллага ч биш. Энэ бол Христ Тэргүүнтэй, бүх итгэгчдээс бүрдсэн Биетэй амьд нэгдэл юм. Тэрээр Пентекостын өдөр мэндэлж, тэр цагаас хойш Шүүрэн авалтыг хүртэл өссөөр байна.

Амьд материалаар хийсэн энэхүү өсдөг барилгыг **Эзэн доторх ариун сүм** гэжээ. Паулын хэрэглэсэн **сүм** гэдэг үг нь сүмийн гаднах хашааг биш доторх (гр. *naos*) ариун газрыг хэлсэн үг байна. Тэр сүмийн Ариунаас ариун газар байрладаг хэсгийг хэлж байна.

Бурхан тэнд оршиж, Өөрийгөө хурц гэрэлтсэн үүлээр тунхаглан илэрхийлж байсан.

Бид эндээс хэд хэдэн сургамж авч болно. Үүнд:

(1) Бурхан чуулган дотор оршдог. Түүний дотор нь оршиж, Өөрийн яруу алдрыг илчилдэг амьд сүмийг аврагдсан иудейчүүд болон харь үндэстнүүд хамтдаа бүрдүүлдэг.

(2) Энэ **сүм** бол **ариун**. Энэ нь Түүний ариун зорилгын төлөө дэлхийгээс тусгаарлагдсан.

(3) Чуулган нь **ариун сүм** болохынхоо хувьд магтаал, хүндэтгэл болон хайр бишрэл нь Эзэн Есүс Христээр дамжин Бурханд хүрдэг төв юм.

Цааш нь Паул **ариун сүмийг Эзэн дотор** оршдог гэж дүрсэлжээ. Өөрөөр хэлбэл Эзэн Есүс бол түүний ариун байдлын эх сурвалж юм. Гишүүд нь Түүнтэй нэгдсэн нэгдлээрээ ариун гэдэг байр суурьтай болсон бөгөөд Түүнийг хайрлах хайрынхаа улмаас ч ариун байх учиртай.

[2:22]

Энэ гайхамшигтай сүмд итгэгч харь үндэстнүүд итгэгч иудейчүүдтэй ижил байр суурь эзэлж байна. Үүнийг уншихад анх Ефес хотынхон болон бусдыг гайхашруулсан шигээ биднийг ч гайхашруулах учиртай. Итгэгчдийн байр суурь ямар асар өндөр болсныг **Бурханы Сүнс дотор орших газар** гэдгээс харж болно.

Бурхан Өөрийн хүмүүстэй нөхөрлөж амьдрах газрыг бий болгох нь сүмийн зорилго буюу зориулалт. Чуулган бол тэр газар. Үүнийг ХГ дэх харь үндэстнүүдийн байр суурьтай харьцуулна уу. Тэр цагт тэд Бурханы оршихуйд байгаа газар уруу дөхөж ч болдоггүй байв. Одоо тэд үүний нэг хэсгийг бүрдүүлж байна!

Бурханы Гурвал гурвуулаа чуулгантай холбоотой үйлчлэл хийдгийг анхаарна уу:

(1) **Түүний дотор** гэдэг нь Христийн дотор гэсэн үг. Түүнтэй нэгдсэн нэгдлээрээ бид сүм болон баригддаг.

(2) **Бурханы орших газар.** Энэ сүм бол Бурхан Эцгийн энэ дэлхий дээр орших гэр.

(3) **Сүнс дотор.** Ариун **Сүнсээр** дамжуулан Бурхан чуулган дотор оршдог (1Ко 3:16).

Энэ бүлэг харь үндэстнүүдийг үхсэн, гажсан, чөтгөрийн, дуулгаваргүй байсан гэж эхэлсэн бол төгсөхдөө харь үндэстнүүдийг бүх гэм буруу, бузраасаа цэвэрлэгдэж, **Сүнс дотор Бурханы орших газрыг** бүрдүүлж байна гэжээ.

6. Ярианы завсар нууцын тухай өгүүлсэн нь (3:1-13)

[3:1]

Паул санаагаа 1-р ишлэлд эхлээд 2-р ишлэлээр таслаад 14-р ишлэлийг хүртэл дахин сөхөлгүй явжээ. Хөндлөнгөөс орж ирсэн буюу яригдаж байсан санааг таслан орж ирсэн ишлэлүүд нь Христ ба чуулганы тухай нууцыг өгүүлэх завсар хэсэг юм.

Өнөөгийн энэ Чуулганы үе өөрөө Бурханы ажил хэргийн завсар орж ирсэн үе учраас энэ бүхэн их сонирхолтой болж байна. Үүнийг ингэж тайлбарлаж болох юм: ХГ-нд бичигдсэн түүхийн ихэнх цаг үед Бурхан үндсэндээ иудей хүмүүстэй ажиллаж байсан. Эхлэл 12-оос эхлээд Малахи 4 хүртэл бараг зөвхөн Абрахам болон түүний үр удмын тухай бичигдсэн. Эзэн Есүс дэлхий дээр ирэхэд Израиль Түүнийг хүлээн авахаас татгалзсан. Үүний улмаас Бурхан Өөрийн сонгосон дэлхий дээрх ард түмэн болох тэр үндэстнийг түр хажуу тийш нь тавьсан. Бид өнөөдөр иудей ба харь үндэстнүүд Бурханы хувьд нэг түвшинд үзэгдэж байгаа Чуулганы үед амьдарч байна. Чуулган бүрэн болоод тэнгэр дэх гэр лүүгээ авагдсаны дараа Бурхан Израиль үндэстэнд хандсан төлөвлөгөөгөө үргэлжлүүлнэ.

Эш үзүүлэгийн цагийн зүү дахин явж эхэлнэ. Тэгэхээр өнөө үе бол Бурханы израильчуудтай харьцах хөтөлбөрийн өнгөрсөн ба ирээдүйн завсар үе. Энэ бол тэнгэрлэг хөтөлбөрт урьд нь байсан ба хожим ирэх бүхнээс ялгаатай өвөрмөц шинэ үе юм.

2-13-р ишлэлд Паул энэхүү завсар үеийн тухай нэлээд дэлгэрэнгүй тайлбарлажээ. Цаг үеийн завсрын тухай тайлбарлахдаа бодитоор яриандаа завсар оруулсан нь санаандгүй хэрэг гэж үү?

Элч энэ хэсгийг **Үүний улмаас Паул би бол харь үндэстнүүд болох та нарын төлөөх Христ Есүсийн хоригдол** гэж эхэлжээ. Үүний улмаас гэдэг нь түрүүхэн дурдсан сэдэв буюу итгэгч харь үндэстнүүд Христтэй нэгдсэн нэгдлийнхээ ачаар хүртсэн хувь завшаан буюу байр суурийг хэлж байна.

Энэ захидлыг Паул Ромд анх баривчлагдан хоригдож байх үедээ бичсэн гэж үздэг. Гэвч тэр өөрийгөө Ромын хоригдол гэж нэрлэсэнгүй. Тэгсэн бол ялагдсан, өөрийгөө хөөрхийлсэн эсвэл өрөвдүүлэх гэсэн санаа гарна. Паул өөрийгөө **Христ Есүсийн хоригдол** гэж нэрлэсэн нь байдлаа хүлээн зөвшөөрсөн, нэр

хүнд, ялалтыг илэрхийлж байна. Рут Паксон үүнийг:

Паулын сүнс хоригдоогүй тул Ефес номонд шоронгийн үнэр ч үнэртэхгүй байна. Ромын хоригдол атлаа тэгж хэлэлгүй, харин Есүс Христийн хоригдол гэж хэлжээ. Энэхүү өөр ертөнцийн гэмээр ялалтын нууц юундаа байна вэ? Паулын бие нь шоронд хатаж байгаа ч сүнс нь Христтэй хамт тэнгэрлэг оршихуйд дүүлнэ гэж оновчтой өгүүлжээ.¹⁵

Тэр яах аргагүй **харь үндэстнүүдийн** өмнөөс хоригдсон. Тэр үйлчилж явах бүх цаг хугацааныхаа турш итгэгч харь үндэстэн Христийн чуулганд итгэгч иудейчүүдийн адил хувь завшаан, эрхийг эдэлнэ гэж номлосноороо ширүүн эсэргүүцэлтэй байнга тулгардаг байсан. Эцэст нь түүнийг Ефес хотын Трофим нэртэй харь хүнийг сүмийн харь үндэстэнд хориотой хэсэг рүү дагуулж орсон гэж гүтгэн баривчлуулж, Цезарийн өмнө шүүлгэсэн (Үйл 21:29). Гэхдээ энэ ялын цаана шашны удирдагчдын заналтай дайсагнал байлаа.

[3:2]

Одоо Паул санаагаа тасалж, нууцын талаар тайлбарлаж эхэлнэ. Ингэхдээ бид цагийн завсар үеийн тухай өгүүлэхийн тулд бодитоор завсар оруулан тайлбарласан гэж бид өмнө нь хэлсэн. “... **Та нар сонссон**” гэсэн нь тэд энэхүү онцгой үйлчлэл түүнд өгөгдсөнийг гарцаагүй мэдэж байсан гэсэн үг. Тэрхүү үйлчлэлийг **Бурханы нигүүлслийн нярвын үүрэг** гэж дүрсэлжээ. **Нярав** гэж өөр хүний ажил хэргийг авч явах үүргийг хүлээсэн хүнийг хэлнэ. Паул ШГ-ний чуулганы тухай агуу үнэнийг өгүүлэх үүрэгтэй **Бурханы нярав** байсан. Энэ нь дор хаяж гурван янзын утгаар **Бурханы нигүүлслийн нярвын үүрэг** байв:

- (1) Сонгогдсон хүний хувьд. Ийм өндөр нэр хүндтэй үүрэгт сонгогдох зохисгүй Паул энэ тааллыг хүртсэн.
- (2) Мэдээний агуулгын хувьд. Бурхан үнэ төлбөргүй сайхан сэтгэлээр тааллаа хүртээсэн тухай мэдээ байсан.
- (3) Хүлээн авагчдын хувьд. Харь үндэстнүүд ийм таалал хүртэх нэлээд зохисгүй хүмүүс байсан.

Гэхдээ харь үндэстнүүдэд хүртээхийн тулд

нигүүлслийн нярвын үүргийг Паулд өгчээ.

[3:3]

Тэр энэ нууцыг хэн нэгэн хүнээс сонсоогүй, өөрийн мэдлэг ухаанаар ч ойлгож аваагүй. Энэ нууц Бурханы шууд **илчлэлтээр** түүнд мэдэгдсэн. Энэ явдал хаана, хэрхэн болсныг бидэнд хэлээгүй. Бурхан итгэсэн иудей болоод итгэсэн харь үндэстнүүдээс бүрдсэн чуулганы тухай төлөвлөгөөгөө Паулд ямар нэгэн гайхамшигт арга замаар харуулсан гэдгийг л бид мэдэж байгаа. **Нууц** гэдэг нь энэ мөчийг хүртэл нууцлагдаж ирсэн, хүний мэдэх аргагүй, тэнгэрийн илчлэлтээр эдүгээ илэрсэн ариун нууц зүйлийг хэлнэ гэж бид өмнө нь ярьсан. Элч энэ **нууцын** тухай 1:9-14, 22, 23; 2:11-22-д цухас дурдаад өнгөрсөн.

[3:4]

Энэ сэдвээр бичсэн зүйлс нь **Христийн нууцын** талаар Бурханы өгсөн ойлголт түүнд байгааг уншигчдадаа харуулахад хангалттай байв. Блейки энэ хэсгийг ийнхүү найруулан илэрхийлжээ:

Би өмнө нь бичсэнээ улам ойлгомжтой болгохын тулд одоо илүү дэлгэрэнгүй тайлбарлаж байгаа нь та нарт зааварлагч энэ нууцын талаар бүрэн мэдээлэлтэйг харуулах гэсэн юм.¹⁶

Дарбигийн орчуулгад хэлснээр “өнөөх Христийн нууц” гэсэн нь энд Тэргүүн бөгөөд Бие болох нууцлаг Христийн тухай авч үзэж байгааг хэлж байна. (Христ гэдэг нэр нь Эзэн Есүс ба Түүний хүмүүсийг хамтад нь хэлж байгаа санааг мөн 1Ко 12:12-аас үзнэ үү.)

[3:5]

5-6-р ишлэл тэр нууцын тухай бидэнд байгаа хамгийн бүрэн тодорхойлолт юм. Паул бидэнд нууц гэж юу болохыг тайлбарлаад Христийн нууц гэж юу болохыг тайлбарлаж байна.

Нэгдүгээрт, энэ бол **өөр үеийнхэнд хүний хөвгүүдэд мэдэгдээгүй байсан** үнэн юм. Үүнийг ХГ-нээс хайгаад нэмэргүй гэсэн үг. Үүний бүдэг дүрслэл, цухас санаа байж болох ч энэ үнэн өөрөө тэр цагт мэдэгдээгүй байв.

Хоёрдугаарт, энэ бол Бурханы **ариун элч нар болон эш үзүүлэгчдэд, Ариун Сүнсээр**

илчлэгдэж байгаа үнэн. Илчлэгч нь Бурхан, элч нар болон эш үзүүлэгчид нь илчлэлтийг авахаар тусгаарлагдагсад, Ариун Сүнс нь тэдэнд үнэнийг илчлэх суваг юм.

Элч нар болон эш үзүүлэгчид нь ХГ-нийх биш, ШГ-нийх гэдгийг харахгүй бол энэ ишлэл зөрчилтэй болно. Ишлэлийн эхний хэсэгт энэ үнэн нь бусад цаг үеийнхэнд мэдэгдээгүй гэж байна. Тэгэхээр ХГ-ний эш үзүүлэгчдэд мэдэгдээгүй гэсэн үг. Тиймээс Паулын цаг үед үхээд хэдэн зуун болчихсон байсан хүмүүс үүнийг хэрхэн мэдэгдэх вэ? Христ ба чуулганы тухай аугаа нууц нь Амилсан Эзэний дуу хоолой болох тусгай даалгавар авсан, Чуулганы үеийн Паул мэтийн хүмүүст мэдэгдсэн нь тодорхой байна. (Паул өөрийгөө энэхүү ариун нууц илчлэгдсэн **цорын ганц** хүн гэж хэлээгүй. Тэрээр амьдарч байсан цаг үедээ энэ үнэнийг харь үндэстнүүдэд болон хойш үеийнхэнд захидлуудаараа тунхаглах хамгийн эхний хүн байсан ч илчлэлт авсан олон хүний нэг нь байсан.)

Христэд итгэдэг олон хүн дээр дурдсанаас тэс өөр байр суурьтай болохыг дурдах нь зохистой.

Тэд чуулган ХГ-ний үед байсан, тэр чуулган нь Израиль байсан гэж үздэг. Харин эдүгээ чуулганы тухай үнэн улам бүрэн дүүрнээр илчлэгдсэн гэдэг. Тэд "Энэ нууцыг одоо илчилсэн шиг бусад үеүдэд мэдэгдээгүй. Мэдэгдэж байсан, *гэхдээ одоогийнх шиг хэмжээнд биш*" гэж тайлбарладаг. Бидэнд *арай бүрэн илчлэлт* өгөгдсөн ч бид Бурханы Израиль буюу Бурханы ард түмний үргэлжлэл гэж тэд хэлдэг. Үүнийгээ батлах гэж тэд 1611 оны Жеймс хааны орчуулгын Үйлс 7:38-ыг иш татдаг. Энэ номонд Израиль үндэстнийг “цөл дэх чуулган” гэж нэрлэсэн байдаг. Бурханаар сонгогдсон хүмүүс цөл дэх чуулган гэдэг нь үнэн боловч тэд *Христийн* чуулгантай холбоотой гэсэн үг биш. Грек хэлний *ekklessia* гэдэг үг нь чуулган, цуглаан, дуудагдан гарсан бүлэг гэсэн ерөнхий утгатай. Энэ үг ганц Үйлс 7:38-д израильчуудыг хэлээд зогсоогүй Үйлс 19:32, 41-д энэ үгээр үймэн цугласан үл итгэгчдийг хэлжээ. Чухам *аль* “чуулганыг” хэлж байгааг хам сэдэв нь тодорхойлно.

5-р ишлэлд ХГ-ний үед одоогийнх шиг бүрэн илчлээгүй ч чуулган оршин байсан гэж хэлж

байна хэмээх маргааныг яах вэ? Үүний хариу Колоссай 1:26-д байна. Тэнд тэрхүү нууц “өнгөрсөн үеүдээс, үр удмуудаас нууцлагдаж байсан боловч одоо Өөрийнх нь ариун хүмүүст илэрхийлэгджээ” гэж шууд хэлсэн. Энд нууцыг ямар зэрэглэлд илчилсэн бэ гэдэг талаар хэлээгүй харин илчилсэн тухай ярьж байна.

[3:6]

Одоо бид тэрхүү нууцын гол үнэнийг харж байна. Тэр нь Эзэн Есүс Христийн чуулганд итгэгч **харь үндэстнүүд хамтран өв залгамжлагч**, нэг л биеийн эрхтнүүд, **сайн мэдээгээр дамжуулан Христ Есүс дотор амлалтыг хамтран хуваалцагчид болжээ**. Өөрөөр хэлбэл, итгэсэн **харь үндэстнүүд** одоо итгэгч иудейчүүдтэй адил нэртэй, адил эрхтэй болсон гэжээ.

Нэгдүгээрт, тэд **хамтран өв залгамжлагчид**. Өвийн хувьд тэд аврагдсан иудейчүүдтэй адил өвийг өвлөнө. Тэд бол Бурханы өв залгамжлагчид, Есүс Христтэй хамт өв залгамжлах ба бүх аврагдсан хүнтэй **хамтран өв залгамжлагчид** мөн.

Мөн тэд нэг **биеийн** эрхтнүүд юм. Одоо тэд алс хол ч биш, хувь дутуу ч биш, харин чуулганд аврагдсан иудейчүүдтэй ижил байр суурьтай болов.

Эцэст нь, тэд **сайн мэдээгээр дамжуулан Христ Есүс дотор амлалтыг хамтран хуваалцагчид** билээ. Энд гарч байгаа **амлалт** нь Ариун Сүнсийг хэлж байж болно (Үйл 15:8, Гал 3:14). Эсвэл энэ нь **Христ Есүсийн дотор** байгч хэн бүхэнд хандан **сайн мэдээнд** амласан бүхнийг хэлж байж болно. **Харь үндэстнүүд** нь иудейчүүдтэй хамтрагсад болно.

ХГ-ний үед ийм зүйл болоогүй бөгөөд ирж байгаа Христийн хаанчлалын үед ч ийм зүйл болохгүй.

ХГ-нд Израиль Бурханы өмнө онцгой байр суурьтай байв. Харь хүн Бурханы амлалтаас өөртэй нь адил хувь эдэлнэ гэвэл израиль хүний хөх инээд хүрэх байв. Ийм юм огт байхгүй байв. Харь үндэстнүүд дуудагдах тухай эш үзүүлэгчид урьдаас зөгнөн хэлж байсан (Иса 49:6, 56:6, 7), гэхдээ тэд иудейчүүд юугаар ч илүү байр суурь эзлэхгүй нэгэн бие дотор харь үндэстнүүд адил тэгш эрхтэй эрхтнүүд болох тухай санааг огт

цухуйлгаагүй.

Бидний Эзэний ирж буй хаанчлалд Израиль үндэстнүүдийн тэргүүн болно (Иса 60:12). Харь үндэстнүүд ивээгдэнэ, гэхдээ Израилаар дамжин ивээгдэнэ (Иса 60:3, 61:6, Зех 8:23).

Израилийг газар дээрх ерөөлүүд уруу голлон дуудсан (Дх 28, Амо 9:13-15). Чуулганы дуудлага нь голлон тэнгэрлэг оршихуйн сүнслэг ерөөлүүд юм (Еф 1:3). Израиль Бурханы дуудсан газрын ард түмэн байсан. Чуулган нь Христийн тэнгэрлэг Сүйт бүсгүй байхаар дуудагдсан (Илч 21:2, 9). Мянган жилийн хаанчлалд Израиль Христийн захиргаан дор ивээгдэнэ (Хос 3:5). Чуулган Түүнтэй хамт ертөнцийг бүхэлд нь захирч, Түүний алдрыг хуваалцана (Еф 1:22, 23).

Тэгэхээр чуулган бол Израиль эсвэл хаанчлал биш гэдэг нь тодорхой болох учиртай. Энэ бол шинэ нийгэм, онцгой нөхөрлөл, бидний Библиэс олж мэдэх итгэгчдийн хамгийн завшаантай бие болж байна. Христ дээш одож, Ариун Сүнс бууж ирснээр чуулган бий болсон (Үйл 2). Чуулган Ариун Сүнсний баптисмаар хэлбэршсэн (1Ко 12:13). Чуулган Христэд харьяалагдах бүхэн тэнгэр дэх гэр лүүгээ аваачигдахад буюу

Шүүрэгдэхдээ бүрэн болно (1Тс 4:13-18, 1Ко 15:23, 51-58).

[3:7]

Чуулганд харь үндэстнүүд болон иудейчүүд тэгш эрхтэй хамтрагчид болохыг цохон тэмдэглэсний дараа Паул өөрөө үүнд ямар үүрэг, үйлчлэлтэй болохоо тайлбарлаж эхэлжээ (ишлэл 7-9).

Нэгдүгээрт, тэр сайн мэдээний **үйлчлэгч болсон юм**. Энэ үгийг үндсэн утга нь *зарц*. Паул өөрийгөө зүгээр л энэхүү нууцтай холбоотойгоор Эзэнд үйлчилж байсан гэж хэлжээ.

Тэр үйлчлэл нь түүний хүртэх зохисгүй бэлэг буюу **Түүний нигүүлслийн бэлэг болж** өгөгдсөн байжээ. Ингэхдээ зөвхөн **нигүүлслийг** харуулаад зогсохгүй бардам, өөрийгөө зөвт хэмээн тооцдог байсан фарисай хүнд үр дүнтэй хүрч, сүнснийг нь авраад, түүнийг элчээр томилж, илчлэлт авах чадварыг олгон ажил үүргээ гүйцэтгэх хүчийг өгсөн Бурханы **хүчийг** харуулав. Тиймээс Паул тэрхүү **бэлгийг Бурханы хүчний үйлчлэлийн дагуу надад өгсөн** гэж хэлжээ.

[3:8]

Элч өөрийгөө **ариун хүмүүсээс хамгийн өчүүхэн нь** гэжээ. Зарим хүнд энэ нь хуурамч даруу зан шиг санагдаж болох юм. Үнэндээ Ариун Сүнсээр дүүрсэн хүн өөрийгөө ингэж үнэн зөвөөр дүгнэдэг. Христийг алдар дотор нь харсан хүн өөрийгөө хичнээн гэм нүгэлтэй, хэрэггүй болохоо ухаардаг. Паулын хувьд үүний дээр өмнө нь Бурханы чуулганыг хавчиснаараа (Гал 1:13, Флп 3:6) Эзэн Есүсийг хавчиж байсан түүх бий (Үйл 9:4). Бурхан үүнийг нь үл хэрэгсэн түүнийг **харь үндэстнүүдэд** сайн мэдээг хүргэх элч болгон онцгой байдлаар томилжээ (Үйл 9:15, 13:47, 22:21, Гал 2:2, 8). Иудейчүүдэд хүрэх элч нь Петр байсанчлан **харь үндэстнүүдэд** хүрэх элч нь Паул байв. Түүний үйлчлэл сайн мэдээ, чуулган гэсэн хоёр хэсэгтэй байлаа. Тэр эхлээд хүмүүст хэрхэн аврагдах вэ гэдгийг хэлж өгдөг, тэгээд ШГ-ний чуулганы үнэн рүү хөтөлдөг байжээ. Түүний хувьд сайн мэдээг өгөх нь эцсийн зорилго биш, харин ШГ-ний орон нутгийн чуулганыг байгуулан

хүчирхэгжүүлэхийн өмнөх алхам ажээ.

Энэхүү үйлчлэлийн эхний алхам нь **Христийн нэвтэршгүй баялгийг харь үндэстэнд тунхаглах** ажил юм. Үүнийг Блейки:

"Баялаг, нэвтэршгүй гэдэг хоёр сайхан үгээр тэрхүү туйлын нандин зүйл ямар хязгааргүй элбэг болохыг илэрхийлжээ. Нандин зүйлс ихэвчлэн ховор байдаг. Ховор хомс чанар нь тэдний үнэ цэнийг улам өсгөдөг. Гэтэл энд тэрхүү нандин зүйл нь зах хязгааргүй байгаа ажээ. Өрөвч сэтгэл, хайр, гавьяа, ариусгал, тайвшрал болон өөрчлөлтийн хүч нь бүгд ямар ч хязгааргүй байгаа бөгөөд бүх хэрэгцээ, хүсэл эрмэлзэл, зүрхний тэмүүллийг одоогоос өнө мөнхөд хангаж чадах юм" гэж илэрхийлжээ.¹⁷

Хүн Эзэн Есүст итгэсэн мөчдөө сүнсний тэрбумтан болж, Христийн дотор шавхагдашгүй эрдэнэсийг эзэмшдэг.

[3:9]

Паулын үйлчлэлийн хоёр дахь хэсэг нь **нууцын үйлчлэлийн үүрэг нь юу болохыг бүгдэд мэдүүлэх хэрэг болно. Өөрөөр хэлбэл,**

нууц нь амьдрал дээр хэрхэн үйлчлэхийг ойлгуулах явдал байв. Бурхан Өөрийнхөө нэрийн төлөөх ард түмнийг (Үйл 15:14) буюу Хүүгийнхээ Сүйт бүсгүйг харь үндэстнээс дуудан гаргах нь энэ үеийнхэнд зориулсан төлөвлөгөө байв. Энэ төлөвлөгөө нь бүхэлдээ **нууцын** үйлчлэл билээ. **Бүгдэд** гэдэг нь **бүх итгэгчдийг** хэлж байна. Аврагдаагүй хүмүүс тэр нууцын гүн гүнзгий юмсыг ойлгоно гэж харалтгүй (1Ко 2:14). Паул тэгэхээр **бүгд** гэж **бүх төрлийн** итгэгчдийг буюу итгэсэн иудей болон харь үндэстэн, боол хийгээд чөлөөт хүмүүсийг хэлж байна.

Энэхүү **нууц нь Бурханы дотор үеэс үед нууцлагдаж байв.** Энэ төлөвлөгөө Бурханы санаанд өнө мөнхөд байсан авч, энд Бурхан үүнийгээ хүн төрөлхтний түүхийн **үеүдийн турш** нууцалсаар ирсэн гэдэг санаа байна. Цуглаан буюу даяар чуулган нь цоо шинэ, өвөрмөц, жиших зүйлгүй гэдгийг харуулахын тулд Ариун Сүнс хичнээн чармайж байгаа нь дахин анзаарагдаж байна. Үүнийг өмнө нь Бурханаас өөр хэн ч мэддэггүй байсан. Энэхүү нууц **бүхнийг бүтээсэн Бурхан дотор**

нууцлагдаж байв. Тэр биет ертөнцийг **бүтээсэн,** Тэр цаг үеүдийг **бүтээсэн** ба Тэр чуулганыг **бүтээсэн,** гэхдээ Тэр мэргэн ухаандаа энэ шинэ бүтээлээ Христийг дэлхий дээр эхний удаа иртэл мэдүүлэхгүй байхаар шийджээ.

[3:10]

Энэхүү нууцтай холбоотой Бурханы одоогийн зорилго нь Өөрийн **олон янзын мэргэн ухааныг** тэнгэр элч нарт илчлэх явдал болно. Паул дахиад л сургуулийн жишээг хэрэглэж байна. Багш нь Бурхан. Анги танхим нь дэлхий ертөнц. Тэнгэр элч нар сурагчид. Хичээлийн сэдэв нь **“Бурханы олон янзын мэргэн ухаан”**. Чуулган бол үзүүлэн хичээл. Тэнгэрээс тэнгэр элч нар Түүний тайлагдашгүй шүүлт болон юмсын гүнд нэвтрэн орох чадварыг гайхан биширч байдаг. Бурхан хэрхэн Өөрийн алдрын төлөө нүглийг ялан дийлснийг тэд хардаг. Тэд Түүнийг хэрхэн дэлхийн хог шаарнуудын төлөө тэнгэрийн Сорыг илгээснийг хардаг. Тэр хэрхэн дайснуудаа асар их үнээр худалдан авч, хайраараа байлдан дагуулаад тэднийг Хүүдээ Сүйт бүсгүй болгон бэлтгэснийг тэд хардаг. Тэр тэдэнд хэрхэн

тэнгэрлэг газар дахь сүнслэг ивээл ерөөл өгснийг харж байна. Мөн Эзэн Есүсийн загалмай дээр хийсэн ажил дэлхий ертөнцөд гэм нүгэл орж ирээгүй байснаас илүү их алдрыг Бурханд авчирж, итгэгч иудейчүүд хийгээд харь үндэстнүүдэд ямар их ивээлийг өгч байгааг тэд харж байна. Бурхан зөвт болохоо баталж, Христ өргөмжлөгдөж, Сатан ялагдаж, чуулган Христийн яруу алдрыг хуваалцахаар хаан сэнтийд залрав.

[3:11]

Нууц өөрөө, нууцын битүүмжлэл, хэтийн илчлэлт нь, Бурханы мэргэн ухааныг толилуульж байгаа байдал нь бүгд **бидний Эзэн Христ Есүсийн дотор үйлдсэн мөнхийн зорилгын дагуу хийгдсэн** ажээ. Дэлхий ертөнц бүтээгдэхээс өмнө Сатан буруу эргэж, хүн түүнийг дагаж нүгэлд унахыг Бурхан мэдэж байв. Тэгээд Тэр хариу стратеги, мастер төлөвлөгөөгөө хэдийнээ бэлдсэн байв. Энэ төлөвлөгөө нь Христ мэндэлж, үхэж, амилж, дээш одож, тэгээд алдаршиснаар биеллээ олжээ. Төлөвлөгөө бүхэлдээ Христэд төвлөрч, Түүгээр биелэв.

Бурхан одоо бурхангүй иудейчүүд болон харь үндэстнүүдийг аварч, тэднийг Христийн Биений эрхтэн болгож, тэднийг Хүүгийнхээ дүр төрхөөр хэлбэршүүлээд, өвөрмөц замаар Хурганы Сүйт бүсгүйн хувьд үүрд мөнх хүндлэгдэхээр болголоо.

[3:12]

Христийн хийсэн ажил болон Түүнтэй нэгдсэнийхээ үр дүнд бид хэдийд ч Бурханы оршихуй уруу, биднийг сонсоно гэдэг бүрэн итгэлтэйгээр зэмлүүлэх айдасгүйгээр орох, үгээр хэлшгүй хувь заяаг хүртэв (Иак 1:5). Бидний **зоримог байдал** нь хүүхэд аавдаа хүндэтгэлтэй боловч айх айдасгүйгээр харьцдагтай адил юм. Бурханд хандан ярих эрх чөлөө маань бидний **очих** үүд хаалга. Биднийг хүлээн авч, сонсож бас ухаалаг, хайрын хариу өгөх баталгаанд бидний **бат итгэл** оршино. Энэ бүгд Эзэн Есүс **Христэд итгэх** бидний **итгэлээр** байх юм.

[3:13]

Түүний үйлчлэлийн нэр хүнд, түүнээс гарсан гайхалтай үр дүнг бодож, түүний зовлонгоос

болж зүрх алдахгүй байхыг Паул ариун хүмүүст уриалан зоригжуулж байна. Тэрээр харь үндэстнүүдэд үйлчлэхдээ **зовлон шаналлыг** тэсвэрлэн туулсандаа баяртай байна. Зовлон бэрхшээлээсээ болж шантарч урам хугарахын оронд харин ч түүнийг Эзэн Есүсийн төлөө зовох зохистой байгаагаараа бахархах учиртайг хэлжээ. Тэд болон бусад харь үндэстнүүд түүний **зовсны** ашиг тусыг харж баярлах учиртай аж. Түүний шоронд хоригдсоныг тэд ичгүүр биш, **алдар** гэж харах хэрэгтэй гэсэн байна.

7. Ариун хүмүүсийн төлөөх Паулын залбирал (3:14-19)

[3:14]

Элч одоо 1-р ишлэлд өгүүлж эхэлсэн боловч нууцын тухай сэдэвт түрэгдэн саатсан санаагаа сөхөж байна. **Иймд** гэдэг үг тэгэхээр 2-р бүлэгт хамаарч байгаа буюу харь үндэстнүүд төрөлхөөсөө хэн байж байгаад, Христтэй нэгдсэнээрээ хэн болсныг өгүүлж байна. Тэднийг ядуурал болон үхлээс баялаг ба яруу алдар уруу шилжүүлсэн гайхалтай өргөмжлөлөөс болж Паул тэднийг үргэлж

үүнийгээ бодитойгоор мэдэрч, энэхүү өргөмжлөгдсөн байр сууриндаа баярлан баясаж яваасай гэж залбирч байна.

Түүний залбирч байгаа байдал нь **би өвдөг сөгдөн** залбирч байна гэж илэрхийлэгджээ. Сөгдөх гэдэг нь заавал бие махбодын байрлалыг хэлсэн байх албагүй, гэхдээ сэтгэл байнга ийм байх учиртай. Бид залбирахдаа алхаж, сууж эсвэл бүр хэвтэж болно, гэхдээ бидний сүнс үргэлж даруу бөгөөд хүндэтгэлтэйгээр өвдөг сөгдөж байх ёстой.

Залбирал нь **Эцэгт** хандсан байна. Ер нь Бурхан бол хүн төрөлхтний Эцэг, буюу Тэр тэднийг Бүтээгч (Үйл 17:28, 29). Арай нарийвчлан хэлбэл, Тэр бол бүх итгэгчдийн Эцэг, Тэр тэднийг бүгдийг нь сүнслэг гэр бүлдээ төрүүлсэн гэдэг санаа байна (Гал 4:6). Өвөрмөц утгаараа Тэр бол **бидний Эзэн Есүс Христийн Эцэг** буюу тэд адил тэнцүү гэсэн үг (Иох 5:18).

[3:15]

Энд гарч байгаа Эцэгийг Паул **тэнгэр болон газар дахь бүхэл гэр бүлийг нэрлэдэг** Нэгэн гэж тодорхойлжээ. Энэ нь дараах утгуудыг

илэрхийлж байж болно:

- (1) Тэнгэр болоод газар дээр байгаа аврагдсан бүхэн Түүнийг өрхийн Тэргүүн гэж үздэг.
- (2) Тэнгэр элч, хүн гээд бүх бүтээл хувьчлан болон бүлээрээ Түүний улмаас оршин байгаа. Тэнгэрт орших гэр бүл гэдэгт янз бүрийн зэрэглэлийн тэнгэр элч нар хамрагдана. Газарт орших гэр бүлүүд гэдэг нь Ноагийн удмаас салбарлан гарсан, эдүгээ үндэстэн болон хуваагдсан угсаатнууд юм.
- (3) Энэ дэлхий дээрх бүх эцгүүд Түүнээс гаралтай. Бурхан Эцэг хамгийн анхдагч ба хамгийн төгс нь юм, Тэрээр бүх эцэг, үрийн харилцааны төгс жишээ. Өөр нэг орчуулгад “тэнгэр хийгээд дэлхийн бүх эцэгийн үүдэл болсон Түүнээс” гэжээ.

[3:16]

Тэр Өөрийн алдрын баялгийн дагуу соёрхох болтугай гэснээс Паул ямар өргөн цар хүрээтэй зүйл гуйгаа вэ хэмээн гайхшрахаар байна. Тэрээр ариун хүмүүсийг сүнсээр **хүчтэй болгох болтугай** гэж гуйж байна. Гэхдээ ямар хэмжээнд

вэ? Жемисон, Фоссет, Браун нар: “бидний ахархан бодлоор биш, харин Түүний алдрын баялгийн энгээр, бялхам дүүрнээр” гэж хариулжээ.¹⁸ “Баялгаас”, **баялгийн дагуу** гэдэг хоёр үг ялгаатай гэж номлогчид онцлон хэлдэг. Баян хүн хөрөнгөнөөсөө багахан хэсгийг өгч болно, энэ нь баялгаасаа өгч байгаа хэрэг болно, харин баялгийнхаа дагуу биш юм! Паул Бурханаас Өөрийн төгс байдлын баялгийн дагуу хүчирхэгжүүлж өгөхийг гуйж байна. Эзэний алдар хязгааргүй баян учраас ариун хүмүүс тэрхүү арвин хурд бэлэн байг! Ийм аугаа Хаанаас тийм өчүүхнийг гуйх гэж үү? Наполеоноос асар том тусламж хүссэн нэгний хүсэлтийг даруй ёсоор болго гээд “Хүсэлтийн чинь хэмжээ намайг хэр хүндэлж байгааг чинь харууллаа” гэсэн гэдэг.

Аугаа Хаанд бараалхан ирэхдээ чи

Асар том гуйлтаа өргөөрэй

Хүч болоод нигүүлсэл нь их тул

Хүч мөхөсдөж биелүүлшгүй хүсэл гэж үгүй билээ

Жон Ньютон

Одоо бид Паулын залбирсан тодорхой

хүсэлтүүд рүү ирлээ. Тэдгээрийг тус тусдаа тавьсан гуйлт гэж үзэхийн оронд дараа дараагийнхаа хүсэлтийн суурь болон тавигдаж байгаа залбирлын пирамид гэж үзэх хэрэгтэй. Эхний гуйлт нь суурь болж байна. Дараа дараагийн гуйлтаар Паул алдарт оргил уруу өгсөж байна.

Эхний гуйлт Түүний **Сүнсээр дамжуулан хүч чадлаар** тэдний **доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай** гэдэг хүсэлт. Гуйж байгаа ерөөл нь *сүнсний* хүч байна. Ер бусын гайхамшиг үйлдэх хүч биш, харин төлөвшсөн, буйртай, ухаалаг христитгэлт хүн болоход хэрэгтэй сүнслэг хүч ажээ. Энэ хүчийг Өгөгч нь Ариун **Сүнс**. Мэдээж бид Бурханы үгээр хооллож, залбирлын цэвэр агаарыг амьсгалж, өдөр бүр Эзэнд үйлчлэн дасгал хийснээр л Тэр бидэнд энэ хүчийг өгөх боломжтой болно.

Энэ хүчийг бид **доторх хүн** буюу өөрсдийн мөн чарын сүнслэг хэсгээр мэдэрдэг байна. Бурханы хуульд баярладаг нь тэр **доторх хүн** (Ром 7:22). Гаднах хүн маань мөхөж яваа ч өдрөөс өдөрт шинэчлэгдэж байгаа нь бидний **доторх хүн** (2Ко 4:16). **Доторх хүн** маань

Бурханаас ирсэн хэдий ч түүнд хүч чадал, өсөлт, хөгжил хэрэгтэй.

[3:17]

Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглах нь хоёрдугаар алхам. Энэ бол Сүнсний өгч байгаа хүчний үр дүн: **Христ бидний зүрхэнд нутаглахын** тулд бид хүчийг авдаг. Хүн Христэд итгэхэд Эзэн Есүс даруй тэр хүний дотор амьдарч эхэлдэг (Иох 14:23, Илч 3:20). Гэхдээ уг залбирал тэр тухай биш байна. Энд Христийг итгэгч хүний *дотор* оруулах тухай яриагүй, харин тэр хүний дотор *гэртээ байгаа юм шиг* байх тухай ярьж байна! Тэрээр аврагдсан хүн бүрийн дотор байнга оршин суугч мөн. Гэхдээ энд Түүнийг бүх өрөө, өнцөг булан бүрд нь орж, хүрч чаддаг байх тухай, нүгэлт үг, бодол, сэдэл, үйлсээс нь болж гашуудахааргүй байх тухай, Эзэн тухайн итгэгчтэй тасралтгүй нөхөрлөх тухай хүссэн гуйлт байна. Ийнхүү христитгэгчийн зүрх сэтгэл Христийн байх дуртай байсан Бетан дахь Мариа, Марта, Лазар нарын орон гэр шиг болно. Зүрх гэдэг нь мэдээж бидний сүнсний амьдралын төв, бидний зан

үйлийг удирддаг газрыг хэлж байна. Энд Паул бидний унших ном, хийх ажил, идэх хоол, зарцуулах мөнгө, хэлэх үг бүр – товчхон хэлбэл амьдралын алхам бүр Эзэн Есүсийн удирдлаган дор байгаасай гэж залбирч байна.

Бид Ариун Сүнсээр хүчирхэгжихийн хэрээр Эзэн Есүстэй улам адилхан болно. Бид Түүнтэй адилхан болохын хэрээр Тэр бидний зүрх сэтгэлд суурьшиж, гэртээ байгаа мэт байх болно.

Бид **итгэлээрээ** Түүний оршихуйд баярлаж чадна. Үүнийн тулд Түүнээс байнгын хамааралтай байх, Түүнд байнга бууж өгөх, Түүнийг “гэртээ байгааг” байнга санах хэрэгтэй. Лоренс бид **итгэлээрээ** “Түүний оршихуйг мэдэрч” болно гэж хэлсэн.

Өдий хүртэл Паулын залбиралд Гурвалын гишүүн нэг бүр орсоор ирлээ. **Христийг** (ишлэл 17) итгэгчдийн **зүрхэнд** гэртээ байгаа юм шиг байлгахын тулд тэднийг Ариун Сүнсээрээ (ишлэл 16) хүчирхэгжүүлээч гэж Эцэгээс (ишлэл 14) гуйсан байна. Залбирлаар дамжуулан өөрсдийхөө болон бусдын өмнөөс мөнх оршигч Бурханы Гурвалыг татан оролцуулж, ажиллуулж болох том давуу тал бидэнд байна.

Христэд ямар ч хаалтгүйгээр хүрэх боломжтой учраас Христэд итгэгч **хайр дотор үндэслэж суурилдаг**. Энд Паул барилгын болон ботаникийн нэр томъёог зээлдэн хэрэглэжээ. Ургамлын үндэс нь тэжээл дамжуулах, түшиг тулгуур болох үүрэгтэй. Барилгын суурь яаж тавигдахаас барилга ямар байх нь шалтгаална. Скрожийн хэлснээр “Бидний амьдралын үндэсийг тэтгэх хөрс нь хайр. Хайр бидний итгэлийн үүрд суурилах хадан суурь” ажээ.¹⁹ **Хайр дотор үндэслэн суурилах** гэдэг нь хайрыг амьдралынхаа хэв маяг болгохыг хэлнэ. **Хайрын** амьдрал гэдэг нь элэгсэг, амиа боддоггүй, гэмшилтэй, даруу амьдралыг хэлдэг. Итгэгчийн амьдралд Христийн дүр төрх бий болж байгаа хэрэг шүү дээ (1Ко 13:4-7).

[3:18]

Өмнөх хүсэлтүүд нь Бурханы хүүхдэд **ариун хүмүүсийн хамт тэр хайрын ямар өргөн, урт, өндөр хийгээд гүн болохыг** бүрэн ойлгоход хүргэх сүнсний өсөлт, хөгжлийн хөтөлбөрийг гаргасан.

Хэмжээсүүдийн тухай авч үзэхээсээ өмнө

ариун хүмүүсийн хамт гэдэг үгийг бодоцгооё. Энэ санаа асар өргөн учраас итгэгч тус бүр өчүүхэн хэсгийг л ойлгож чадна. Тиймээс энэ зүйлийг бусадтай хамт судлах, ярилцах, хуваалцах хэрэг гарна. Ариун Сүнс дасгалжсан хэсэг бүлэг итгэгчдийн хамтдаа тунгаан бодох үйлийг ашиглан Бичээсийг илүү гэрэлтүүлдэг.

Хэмжээсүүд нь Христийн хайрын цар хүрээг ярьж байгаа нь тодорхой байна. Христийн хайр гэдэг үг дараагийн ишлэлд дурдагдсан. Христийн хайрыг хэлж байгаа бол үүнийг ингэж холбон тайлбарлаж болох юм.

Өргөн – дэлхий (Иох 3:16)

Урт – үүрд мөнх (1Ко 13:8)

Гүн – загалмай дээрх үхэл хүртэл (Флп 2:8)

Өндөр – тэнгэр (1Иох 3:1-2)

Ф.Б. Мейер үүнийг маш сайн илэрхийлжээ:

Бидний өмнө ч, ард ч ялгаагүй өргөн уудам байх болно. Тэгээд Есүсийн нүүрийг мянга мянган жилийн турш ширтлээ ч Түүний үзэсгэлэн гоо анх диваажингийн үүдээр ороод харахад ямар шинэхэн, бишрэм, яндашгүй байсан тэр хэвээрээ байх болно.²⁰

Эдгээр хэмжээс нь Ефес номонд онцгой чухал байр суурьтай байгаа тэрхүү нууцад хамааралтай байж болно. Эдгээр хэмжээсийг ишлэлүүдээс хялбархан олж болно:

- (1) **Өргөнийг** 2:11-18-д дүрсэлсэн байна. Энд иудейчүүд болон харь үндэстнүүдийг аварч, улмаар тэднийг нэгтгэн чуулган болгосон Бурханы нигүүлслийн **өргөнийг** хэлжээ. Тэрхүү нууц нь хүн төрөлхтний энэ хоёр хэсгийг хоёуланг багтаажээ.
- (2) **Урт** нь мөнхөөс мөнхөд үргэлжилж байна. Өнгөрсөнд гэвэл итгэгчид ертөнцийн сууриас өмнө Христ дотор сонгогдсон байв (1:4). Ирээдүйн хувьд, бидэнд Христ Есүсээр дамжуулан (2:7) үзүүлсэн энэрлээр Өөрийн нигүүлслийн давамгайл баялгийг тасралтгүй дэлгэсээр байх болно.
- (3) **Гүн** нь 2:1-3-д тодорхой дүрслэгджээ. Бид үгээр хэлж баршгүй гэм нүгэлд живж, доройтсон байв. Бидний өмнөөс үхэх гэж Христ бузар булайн ялзарсан ширэнгэн ойн гүнд ирсэн.
- (4) **Өндөр** нь 2:6-д гарч байна. Бид Христтэй хамт амилуулагдаад зогсоогүй, Түүний

алдрыг хуваалцахаар Түүнтэй хамт
тэнгэрлэг оршихуйд, хаан ширээнээ залрав.

Тэгэхээр эдгээр хэмжээс нь өргөн далайцтай
бөгөөд хязгааргүй ажээ. Эдгээрийг бодохоор бид
Скрожийн хэлснээр “энэ ариун үгсийн нүргээн
дотроос дэс дарааллыг нь гаргахаас өөр юм хийж
чадахгүй”.

[3:19]

Элчийн удаах хүсэлт нь ариун хүмүүс
мэдлэгийг давдаг **Христийн хайрыг** өөрийн бие
болон амьдралаар мэдрэх болтугай гэдэг хүсэлт
байна. Тэд үүнийг хэзээ ч бүхлээр нь таньж
мэдэж чадахгүй. Яагаад гэвэл энэ бол зах
хязгааргүй далай. Гэхдээ тэд өдрөөс өдөрт улам
ихээр мэдэж авч болно. Тиймээс тэр гайхамшигт
Эзэний гайхамшигт **хайрыг** бие болон
амьдралаар гүн гүнзгий мэдрэн баярлах болтугай
гэж залбирч байна.

Энэхүү аугаа залбирал нь Паулыг **та нар**
Бурханы бүх дүүрэнд (гр. *eis* буюу *уруу*)
бялхсан байх болтугай гэхүйд оргилдоо хүрч
байна. Бурханы **бүх дүүрэн** Эзэн Есүс дотор

оршдог (Кол 2:9). Тэр бидний зүрхэнд итгэлээр орших тусам бид **Бурханы бүх дүүрнээр** улам **дүүрнэ**. Бид хэзээ ч Бурханы бүх дүүрэнд хүртэл дүүрэхгүй. Гэвч энэ бол бидний зорих зорилт.

Ийнхүү тайлбарлахын сацуу бидний ухаагүй гүн гүнзгий утга санаа бас байгааг хэлэх нь зүйтэй. Бичээс судлахдаа бид өөрсдийн ойлгох, тайлбарлах чадвараас давсан үнэнүүдтэй харьцаж байгаагаа санах хэрэгтэй. Энэ ишлэлийг ойлгоход дөхөм болгох үүднээс жишээ ашиглаж болно. Далайгаас шанагаар утгахад шанага дүүрэн устай ч, шанаганд байгаа далайн ус ямар өчүүхэн бэ! Ингээд бодохоор нууц нь нууц хэвээрээ үлдэх бөгөөд бид Бурханы үгийн хичнээн хязгааргүй уудам болохыг харж алмайрахаас өөр яах билээ!

8. Паулын магтаал (3:20, 21)

[3:20]

Энэ залбирал сүнсийг сэргээсэн магтаалаар төгсөж байна. Өмнө нь маш том, аюумшиггүй, бараг үл гүйцэлдэх хүсэлтүүд гарсан. Гэхдээ Бурхан **бидний гуйж, бодох бүхнээс** илүүг

биелүүлэх **чадвартай**. Түүний чадлын хэр хэмжээг Паул бялхсан ивээл ерөөлүүдийг нь суваргалан босгох аргаараа харуулж байна:

Чадвартай

Үйлдэх чадвартай

Бидний гуйсныг үйлдэх чадвартай

Бидний бодсоныг үйлдэх чадвартай

**Бидний гуйж, бодсоныг үйлдэх
чадвартай**

**Бидний гуйж, бодох бүхнийг үйлдэх
чадвартай**

**Бидний гуйж, бодох бүхнээс минь илүү
үйлдэх чадвартай**

**Бидний гуйж, бодох бүхнээс минь илүү
хэмжээлшгүй үйлдэх чадвартай**

**Бидний гуйж, бодох бүхнээс минь илүү
хэмжээлшгүй бялхлаар үйлдэх
чадвартай**

Залбиралд Бурхан юугаар дамжуулж хариулдагийг **бидний дотор ажилладаг хүчний дагуу** гэж илэрхийлжээ. Энэ нь бидний гэм нүглийг зэмлэж, залбирлыг чиглүүлж, бишрэл мөргөлд сэдээдэг, үйлчлэлд удирдан христитгэлт

зан чанарын үр жимсийг гаргахаар бидний амьдралд тасралтгүй ажиллаж байдаг Ариун Сүнснийг хэлж байна. Бид Түүнд дуулгавартай байх тусам биднийг Христтэй адил болгон хэлбэршүүлэх ажил амжилттай байх болно.

[3:21]

Түүнд алдар нь чуулган дотор, Христ Есүс дотор бүх үеийнхэнд үеийн үед байх болтугай. Амен. Мөнх магтуулах зохистой нь Бурхан билээ. Түүний мэргэн ухаан, хүч чадал нь тэнгэр элч, нар, сар, одод, амьтад, шувууд, загас жараахай, гал, мөндөр, цас мөс, манан будан, салхи, уул толгод, ой модод, хаад ноёд, харц ард, хөгшин залуу, Израиль болоод бусад үндэстнүүдээр дамжин илэрхийлэгддэг (Дуу 148).

Дуусашгүй **алдрыг** Бурханд өргөх бас нэг бүлэг буюу Христ Тэргүүнтэй, итгэгчид гэдэг Биетэй **чуулган** байна. Энэхүү солигдон авагдсан хам нийт нь Түүний зүйрлэшгүй гайхамшигт нигүүлслийн мөнхийн гэрч байх болно. Виллиямс:

Бурхан бөгөөд Эцэгийн хувьд Бурханы мөнх алдар нь чуулган болоод Христ Есүсийн

дотор үеийн үед харагдах болно. Гайхалтай зүйл! Христ ба чуулган нь нэг Биеийн хувьд тэрхүү мөнхийн үзүүлэнгийн самбар нь болно гэж бичжээ.²¹

Чуулган одоо ч “магтаалын үйлчлэл, гишүүдийнхээ ариун амьдрал, дэлхий дахинаа тунхаглах сайн мэдээ, хүнийг гачигдал зовлонтой байх үед хүрэх үйлчлэлээрээ” дамжуулан Түүний нэрд алдрыг өгч байх учиртай (Эрдман).

Энэхүү магтаал нь **бүх үеийнхэнд үеийн үед** үргэлжилнэ. Бурханыг чуулган болон Есүс Христийн дотор мөнхөд магтая гэсэн Паулын уриаг сонссон бид сэтгэлийн гүнээс **Амен!** гэж түрлэг өргөнө.

II. ИТГЭГЧДИЙН ЭЗЭНТЭЙ АЛХАХ АМЬДРАЛ (бүлэг 4-6)

1. Христигэлт нөхөрлөлийн эв нэгдлийн төлөөх уриа (4:1-6)

[4:1]

Ефес номын энэ хэсгээс тэс өөр зүйл яригдаж эхэлнэ. Өмнөх бүлгүүдэд Христигэлт хүмүүст өгөгдсөн дуудлагыг авч үзсэн. Сүүлийн гурван бүлэгт дуудагдсан тэрхүү дуудлагадаа зүй зохистой явахыг уриалжээ. Нигүүлсэл биднийг ямар байр сууринд залсан болох нь өнөөг хүртэл яригдсан үндсэн сэдэв байлаа. Одооноос эхлээд тэрхүү байр суурь амьдралд хэрхэн нөлөөлөх учиртайг үзэх болно. Христ доторх өргөмжлөгдсөн байр суурь биднээс үүнд тохирсон бурханлаг аж амьдралыг шаарддаг. Тэгэхээр Ефес ном 1-3-р бүлэгт тэнгэрлэг оршихуйгаас 4-6-р бүлэгт орон нутгийн чуулган,

гэр, нийгэм уруу шилждэг нь үнэн. Стоттын тун онож хэлснээр бид “чуулган дотроо эв нэгдлийг, хувийн амьдралдаа ариун байдлыг, гэр дотроо эе эвийг, бузар хүчний эсрэг тэмцэлдээ баттай зогсохыг хичээх учиртай”.

Паул хоёр дахь удаагаа өөрийгөө **хоригдол** гэж нэрлэж байна. Энэ удаад тэрээр өөрийгөө **Эзний хоригдол** гэжээ. Теодорет үүнийг: “Дэлхийн доромжлол гэж үздэг зүйлийг тэр хамгийн дээд зэргийн хүндэтгэл гэж тооцон, Христтэй холбогдсон холбоогоор хаан хүн титмээрээ сайрхдагаас илүү сайрхаж байна” гэж илэрхийлсэн.

Паул Эзэнд дуулгавартай, итгэмжтэй байсныхаа төлөө хоригдсоны хувьд уншигчдадаа **дуудлагадаа зүй зохистой явахыг** уриалжээ. Тэрээр тэдэнд захиран тушаагаагүй. Тэр эелдэг дөлгөөхнөөр уриалан, нигүүлслийн үгээр хэлж байна.

Энэ захидалд долоонтаа гарч байгаа **явах** (2:2, 10; 4:1, 17; 5:2, 8, 15) гэдэг үг нь хүний амьдралыг бүхэлд нь хэлж байгаа. Зохистой явах нь Христийн Биеийн нэг эрхтэн болох итгэгч хүний өндөр байр сууринд тохирно.

[4:2]

Амьдралын талбар бүрд Христтэй адил сэтгэлээр хандах нь маш чухал. Үүнд:

Төлөв даруу байдал – Эзэн Есүстэй холбогдсоны улмаас гарах жинхэнэ даруу байдал. **Даруу байдал** өөрөө хэн ч биш болохыг мэдүүлэхийн зэрэгцээ бусдыг өөрөөсөө дээдлэх боломжийг өгдөг. Энэ нь бардам сагсуу, хямсгар их зангийн эсрэг чанар болно.

Дөлгөөн сэтгэл – Бурханы хийж байгаа зүйлийн эсрэг тэрслэлгүй дуулгавартай үгэнд орох, хүний найрсаг бус үйлдэлд өс санаж хонзогнолгүй хандах. Энэ байдал “Би сэтгэлдээ дөлгөөн, зүрхэндээ даруу” гэж хэлсэн Түүний амьдралаас харагддаг. Вraith хэлэхдээ:

Ямар гайхшруулсан ер бусын үг вэ! Дэлхий ертөнцийг бүтээгч, огторгуйд оддыг цацаж, нэрийг нь оноож дууддаг, тоо томшгүй ордуудыг тойрог замд нь тогтоон баригч, уул толгодыг дэнслэгч, аралыг цэг гэж үздэг, алгандаа далай тэнгисийг багтаагч Түүний өмнө дэлхийн оршин суугчид дэвхрэг царцаа мэт байтал Тэрээр хүн болж ирэхдээ

Өөрийгөө даруу дөлгөөн гэсэн. Тэр хүний төгс гэж үздэг бүхнийг бүрдүүлж тэр дүрээр ирсэн юм биш, харин Өөрөө тэр төгс төгөлдөр нь *байсан* гэжээ.²²

Тэвчих – байнгын өдөөн хатгалгыг тэвчээртэй, тогтуунаар туулах. Үүнийг ийм жишээгээр дүрслэн илэрхийлж болно: нас бие гүйцсэн том нохой жижигхэн гөлөг хоёр байна гэж бодъё. Тэр гөлөг нохой уруу хуцаж, дайрч, элдэвээр аяглахад гөлгийг ганцхан ухасхийгээд тас татаж чадах тэр нохой гөлөгний энэ эрээ цээргүй аашийг тэвчин тэсэж сууна.

Бие биенээ хайр дотор хүлцэх – бусдын алдаа дутагдал, доголдол, хувь хүний зан араншин, чадвар, ааш өөр өөр байдгийг хүлээн зөвшөөрөх. Дотроо бухимдан буцалж байгаа атлаа гаднаа найрсаг дүр эсгэхийг хэлэхгүй. Дургүй хүргэж байгаа, төвөг садаа учруулж байгаа, ичгүүр төрүүлж байгаа хүмүүсийг хайрлахыг хэлнэ.

[4:3]

Амар тайвны холбоос дотор Сүнсний нэгдлийг хадгалахыг хичээгтүн. Бурхан

чуулганыг бий болгосноороо хүн төрөлхтний түүхэнд байсан хамгийн том хагарал буюу иудей ба харь хүмүүс гэдэг хуваагдлыг үгүй хийсэн. Энэ ялгаа Христ Есүсийн дотор үгүй болсон. Гэхдээ энэ нь тэдний амьдрал дээр хэрхэн хэрэгжих вэ? Дайсагналын манан татсаар байх уу? “Христийн иудей чуулган” ба “Христийн харь үндэстнүүдийн чуулган” барих чиглэл байх болов уу? Аливаа хагарал, дайсагналын жавар хургахаас сэргийлэхийн тулд Паул христитгэгчдээс эв эеэ хичээхийг хүсэн гуйж байна.

Тэд **Сүнсний эв нэгдлийг хадгалахыг** хичээх ёстой. Ариун Сүнс үнэнээр итгэгч бүрийг Христийн дотор нэг болгосон. Тэр Бие дотор нэг Сүнс оршиж байна. Энэ бол юу ч бусниулж эс чадах эв **нэгдэл**. Гэхдээ итгэгчид маргалдаж, гомдоллосноороо ийм юм байдаггүй мэт аашилж мэдэх юм. **Сүнсний нэгдлийг хадгалах** гэдэг нь бие биетэйгээ амар тайван, эв найрамдалтай амьдрахыг хэлнэ. Бие биенээсээ төрөлхөөс ихээхэн ялгаатай эрхтнүүдийг холбож байдаг шандас шөрмөс нь **амар тайван** юм. Ялгаа, зөрөө гарсан тохиолдолд хүмүүс ер нь хуваагдаж,

нам бүлэг болон талцдаг. Сүнс "нэн тэргүүнд эв нэгдэл. Эргэлзээтэй тохиолдолд эрх чөлөө. Бүх зүйлд хайр" гэж хариулдаг. Ямар ч орон нутгийн чуулганыг эсвэл Бурханы ажлыг нурааж чадах махан биеийн гэмт чанар бидний хэн хэнд хангалттай бий. Тиймээс бид өөрсдийн өчүүхэн хувийн ааш хандлагаа дарж, Бурханы алдар болон нийтийн ивээл ерөөлийн төлөө хамтдаа **амар тайван** дотор ажиллах учиртай.

[4:4]

Ялгаатай талуудаа дөвийлгөхийн оронд бид христигэлийн жинхэнэ эв нэгдлийг бий болгодог бодит байдлын долоон эерэг шинжийг бодож үзэх ёстой.

Нэг бие. Арьс өнгө, үндэс угсаа, ахуй соёл, хэл яриа, ааш зангаараа ялгаатай боловч Пентекостоос эхлээд Шүүрэлт хүртэл итгэгчдээс бүрдсэн **нэг л бие** байна. Урсгал, чиглэл, салбар, бүлэг энэ үнэнийг бодит илрэл болоход саад болж байна. Аврагч эргэн ирэхэд ийнхүү хүний бий болгосон ялгаа зааг нь арчигдан алга болно. Тиймээс бидний энэ үед баримтлах уриа: "Урсгал чиглэл, салбар бүлэг, нэр хаяг сөнөж,

Есүс Христ бүгдийн дотор байтугай" гэж байх ёстой.

Нэг Сүнс. Итгэгч бүрийн дотор байдаг нэг л Ариун Сүнс (1 Ко 6:19) Христийн Бие дотор оршдог (1 Ко 3:16).

Нэг найдвар. Чуулганы гишүүн нэг бүр Христтэй хамт байх, Түүнтэй адил байх, Түүний алдрыг үеийн үед хуваалцах нэг ижил хувь заяатай. Ариун хүн бүрд оногдсон **нэг итгэл найдвар** гэдэгт Эзэн Есүсийн эргэн ирэхэд болон түүнээс цааш болох зүйлс багтаж байгаа.

[4:5]

Нэг Эзэн. “Хэдийгээр тэнгэрт болон газарт бурхад хэмээгдэгчид нь байдаг (тиймээс олон бурхад ба олон эзэд байдаг хэмээсэн) ч, бидний хувьд ганц Бурхан, Эцэг байна. Бүх юм Түүнээс гарсан бөгөөд бид Түүний төлөө юм. Мөн ганц Эзэн Есүс Христ байна. Бүх юм Түүгээр бөгөөд, бид ч Түүгээр байгаа юм” (1 Ко 8:5, 6, мөн 1 Ко 1:2-ыг үзнэ үү).

Нэг итгэл. Энэ бол "ариун хүмүүст нэгэнт бүрмөсөн тушаагдсан" (Иуд 3), бидний төлөө ШГ-нд хадгалагдсан сургаал болох Христитгэл

юм.

Нэг баптисм. Үүнийг хоёр утгаар ойлгож болно. Эхнийх нь, Христэд итгэсэн хүн бүрийг бие рүү оруулдаг Сүнсний **нэг баптисм** (1Ко 12:13). Дараа нь, итгэсэн хүмүүс Христийн үхэл, оршуулга, амилалттай нэгдсэн гэдгээ тунхагладаг **нэг баптисм** байна. Өнөө үед баптисмыг янз бүрийн хэлбэрээр хийж байгаа ч ШГ-нд итгэгч хүмүүс Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр хийлгэх нэг л баптисм байгаа гэдэг. Дагалдагчид баптисм хүртсэнээр хуучин хүнээ булшлаад, шинэ амьдралаар амьдарна гэж Христэд ам өгч байгаа хэрэг.

[4:6]

Нэг Бурхан. Золигдсон **бүгдийн Эцэг бөгөөд нэг Бурханыг** Бурханы хүүхэд бүр хүлээн зөвшөөрдөг. Тэрээр:

Бүгдийн дээр - Тэр бол орчлон ертөнцийн хамгийн Дээд эрх мэдэл.

Бүгдээр дамжуулан - Тэр зорилгоо биелүүлэхийн тулд бүгдээр дамжуулан бүх зүйлийг ашиглан ажилладаг.

Бүгдийн дотор - Тэр итгэгч нэг бүрийн дотор

оршдог бөгөөд нэгэн зэрэг бүх газар оршдог.

2. Биеийн гишүүдийн зохистой ажиллагааны хөтөлбөр (4:7-16)

[4:7]

Христийн Биеийн эв нэгдэл нь ихэр мэт үнэнийг агуулдаг. Өөрөөр хэлбэл, гишүүдийнх нь ялгаатай байдал. Гишүүн нэг бүрд тодорхой үүрэг оногдсон болно. Хоёр ижил гишүүн гэж үгүй, мөн яг ижилхэн үүрэгтэй хоёр гишүүн байхгүй. Хэсэг нэг бүрийн гүйцэтгэх үүрэг нь **Христийн бэлгийн хэмжээгээр** өгөгдөх бөгөөд ингэхдээ Тэр Өөрийн хүслээр энэхүү хэмжээг тодорхойлдог ажээ. **Христийн бэлэг** гэж Ариун Сүнсийг хэлж байгаа бол (Иох 14:16, 17, Үйл 2:38, 39) Ариун Сүнс ариун хүн нэг бүрд бэлгийг, мөн тэрхүү бэлгийг ашиглах чадварыг өгдөг гэсэн санаа байна. Гишүүн нэг бүр оногдсон ажил үүргээ биелүүлэхэд Христийн Бие сүнсээрээ ч, тоогоороо ч өсч байдаг.

[4:8]

Бурханы хүүхэд нэг бүрд үүргээ таньж, биелүүлэхэд нь туслахын тулд Эзэн чуулганд

үйлчлэх тусгай **бэлгүүдийг** өгчээ. Эдгээрийг өмнөх ишлэлд дурдсан бэлгүүдтэй андуурч болохгүй. Итгэгч бүрд ямар нэгэн бэлэг байгаа (ишлэл 7), гэхдээ хүн бүр 11-р ишлэлд дурдсан бэлэг биш, эдгээр нь чуулганы өсөлтөд зориулсан онцгой бэлгүүд болно.

[4:9]

Гэтэл үүнд нэг асуудал үүслээ! Мессиа хэрхэн тэнгэр өөд одох юм бэ? Тэр тэнд өнө мөнхөөс Бурхан Эцэгтэй амьдарч байгаагүй билүү? Тэр тэнгэр өөд гарсан юм бол эхлээд мэдээж хэрэг тэнгэрээс бууж ирсэн байх ёстой. Түүний дээш одох тухай Дуулал 68:18-д байгаа эш үзүүллэг, түүний цаана Түүний дээрээс бууж ирэх тухай санаа байна. Тэгэхээр бид 9-р ишлэлийг ингэж уншиж болно. "**Дуулал 68-д 'Тэр дээш одсон' гэдэг нь Тэр бас газрын доод хэсэгт буусан гэдгээс өөр ямар утгатай вэ?**". Яг ийм юм болсныг бид мэднэ. Эзэн Есүс Бетлехемд малын тэжээлийн тэвшинд, загалмайн үхэл рүү, тэр байтугай булш уруу **доош буусан. Газрын доод хэсэг** гэж заримдаа Үхэгсдийн орон буюу там хэмээн тайлбарладаг. Гэхдээ ингэж

тайлбарлавал зөрчил үүсэхээр байна. Тэр дээш одохын тул доош газар уруу бууж ирэх хэрэгтэй болно. Гэхдээ заавал там байх албагүй. Дээр нь Түүнийг үхэхэд Сүнс нь там уруу биш, тэнгэр өөд одсон гэж Бичээс хэлдэг (Лк 23:43, 46). Библийн өөр нэг орчуулгад энэ ишлэлийг "Дээш гарсан гэдэг үг нь Түүнийг хамгийн доод түвшин уруу, дэлхий рүү бууж ирсэн гэдэг санааг илэрхийлж байна" - гэж орчуулсан байдаг.

[4:10]

Дуулал 68:18-д байгаа эш үзүүллэг болон үүний цаадах доош бууж ирнэ гэсэн санаа нь Эзэн Есүсийн хүн болж төрсөн, үхсэн, оршуулагдсанаар биелсэн. Тэнгэрээс **доош буусан** Нэгэн нь нүгэл, Сатан, чөтгөрүүд болон үхлийг ялаад, **бүх юмсыг дүүргэхийн тулд** агаар мандалаас гарч огторгуйн чанадах **тэнгэрүүд** рүү одсон.

Тэр ивээл ерөөлийн эх сурвалж, бүх сайн сайхны нийлбэр, Хамгийн дээд эрх мэдэл гэдэг утгаараа **бүх юмсыг дүүргэдэг** нь үнэн. “Загалмайн гүн, алдрын оргилын хооронд Түүний эзлээгүй орон зай гэж үгүй” гэж

Ф.В.Грант бичсэн.²³

8-10-р ишлэл бэлгүүдийг Өгөгч нь дээш гарсан Христ гэж хэлж байна. Түүнийг тэнгэр өөд одохоос өмнө ийм бэлгүүд огт байгаагүй. Энэ нь ХГ-д чуулган байсан бол огт бэлэггүй чуулган байсан байж таарах тул тэр үед байгаагүй гэдэг санааг лавшруулж байна.

[4:11]

Одоо бэлгүүдийг нэрлэж байна. Гайхалтай нь, тэр бэлгүүд төрөлх авьяас биш, харин хүмүүс гэж байна. **Тэр заримыг нь элч, заримыг нь эш үзүүлэгч, заримыг нь сайн мэдээ тунхаглагч, заримыг нь хоньчин ба багш болгожээ.**

Элч гэдэг нь үгийг номлох, чуулган тарих тушаал даалгаврыг шууд Эзэнээс хүлээн авсан хүмүүс. Тэд Христийн амилалтыг харсан хүмүүс байв (Үйл 1:22). Тэдэнд номлосон үгээ батлан (Евр 2:4) гайхамшгийг үйлдэх (2Ко 12:12) хүч байв. Тэд ШГ-ний эш үзүүлэгчдийн хамт чуулганы суурь байх үндсэн үйлчлэлтэй байв (Еф 2:20). Энэ ишлэлд гарч байгаа элч гэдэг үг Христийг дээш гарсны *дараах* элч нарыг хэлж байна.

Эш үзүүлэгчид - Бурханы дуу хоолой буюу ам нь болсон хүмүүс. Тэд Бурханаас шууд илчлэлтүүдийг авч тэднийгээ чуулганд дамжуулж байв. Тэдний Ариун Сүнсээр хэлсэн үгс нь Бурханы үг байв.

Үндсэн утгаар нь авч үзвэл бидэнд өнөөдөр элч юмуу эш үзүүлэгчид байхгүй. Чуулганы суурь тавигдаж, ШГ бичигдэж дууссанаар тэдний үйлчлэл төгссөн. Паул энд ШГ-ний **эш үзүүлэгч** нарын тухай ярьж байгааг бид өмнө нь онцлон хэлсэн. Тэд Христийг дээш гарсны дараа өгөгдсөн. Тэднийг ХГ-ний эш үзүүлэгчид гэж үзвэл энэ хэсэг маш төвөгтэй, утгагүй болно.

Сайн мэдээг тунхаглагчид нь авралын сайн мэдээг тунхаглан номлогсод. Тэд алдагдагсдыг Христ уруу авч ирэхээр тэнгэрээс бэлэг авсан хүмүүс. Тэд гэм нүгэлтний нөхцөл байдлыг оношлох, мөс чанарыг тонших, эсэргүүцлийг няцаах, Христийг хүлээж авах шийдвэрийг дэмжих, шинэхэн итгэгчийг үгээр зоригжин баталгаа авахад нь туслах онцгой чадвартай хүмүүс байдаг. Сайн мэдээг тунхаглагчид орон нутгийн чуулганаас гарч дэлхийд номлоод аврагдсан хүмүүсийг тэжээл, урам авах орон

нутгийн чуулганд дагуулан ирдэг.

Хоньчид Христийн хонин сүргийн туслах хоньчины хувиар үйлчилдэг хүмүүс. Тэд сүргийг хариулж, тэжээдэг. Мэргэн ухаанаар зөвлөх, засаж залруулах, урам зориг өгөх, тайтгаруулах нь тэдний үйлчлэл.

Хоньчны ажил орон нутгийн чуулганы ахлагчийн ажилтай нягт холбоотой. Гол ялгаа нь хоньчин бол бэлэг, харин ахлагч бол албан үүрэг. Орон нутгийн чуулганд ганц юмуу тэргүүн пастор биш хэд хэдэн хоньчид, ахлагчид байсан гэж ШГ-д гардаг (Үйл 20:17, 28, 1Пт 5:1, 2).

Багш Библийг тайлбарлаж, утгыг нь хөрвүүлж, тэр үгсийг ариун хүмүүсийн зүрх сэтгэл, мөс чанарт хамаатуулах тэнгэрлэг хүчийг авсан хүмүүс болно. Сайн мэдээг тунхаглагч Бичээсээс үгийг салган авч номлодог бол багш тэр үгийг хам сэдэвтэй ямар холбоотойг ойлгуулахыг эрэлхийлдэг.

Хоньчин ба багш гэж холбож бичсэнийг зарим нь нэг бэлэг гэж үзээд, уг нь үүнийг “хоньчин-багш” гэж ойлговол зохилтой гэдэг. Гэхдээ ийм байх албагүй. Багш боловч хоньчлох зүрх сэтгэлгүй хүн байж болно. Хоньчин хүн

үгийг заах тусгай бэлэггүй атлаа үгийг хэрэглэж чаддаг байж болно. 11-р ишлэлд байгаа хоньчин ба багш гэдэг бэлгийг нэг гэж үзвэл хэл зүйн ижил дүрмийн²⁴ дагуу 2:20-д байгаа элч ба эш үзүүлэгч гэдэг бэлэг ч мөн нэг бэлэг болно.

Эцэст нь хэлэхэд, бид төрөлх авьяас, тэнгэрлэг бэлгийг ялгаж салгах хэрэгтэй. Аврагдаагүй хүн хичнээн авьяастай байгаад ШГ-нд хэлээд байгаа сайн мэдээг тунхаглагч, хоньчин эсвэл багш байж таарахгүй. Тухайн бэлгийг хүлээн аваагүй л бол Христэд итгэсэн хүн ч тэгж чадахгүй. Сүнсний бэлгүүд нь ер бусын зүйлс мөн. Тэдгээр нь хүний хүчээр хийх боломжгүй зүйлсийг хийх чадвар өгдөг.

[4:12]

Бид одоо бэлгүүдийн үйл ажиллагаа буюу зорилго зориулалтыг үзнэ. Энэ нь **ариун хүмүүсийг үйлчлэлийн ажилд бэлтгэж, Христийн биеийг байгуулахын тулд юм. Үйл явц нь ийм болно:**

- (1) Бэлгүүд **ариун хүмүүсийг** бэлтгэнэ.
- (2) Тэгээд **ариун хүмүүс** үйлчилнэ.
- (3) Тэгэхээр **бие** босгон байгуулагдана.


Үйлчлэл гэдэг бол зөвхөн мэргэжлийн түвшинд бэлтгэсэн хэдэн хүний хийдэг үүрэгт ажил биш. Үүнийг зүгээр л *үйлчлэл* гэж ойлгох хэрэгтэй. Үүнд бүх л төрлийн сүнслэг үйлчлэл багтана. Энэ ишлэл итгэгч бүрийг "үйлчлэлд" байх ёстой гэж байна.

Бэлгүүд нь итгэгч нэг бүрийг төгс болгох буюу Эзэнд үйлчлэхэд бэлтгэхийн тулд өгөгдөж, ингэснээр **Христийн бие** барьж босгогдох юм. Ванц Хавнер үүнийг:

Итгэгч нэг бүр илгээлтийн эзэн учраас итгэгч бүр захирамж авсан. Сайн мэдээ гэдэг чинь чуулганд ирж сонсдог зүйл биш, харин чуулганаас хэлэх учиртай зүйл бөгөөд энэ үүрэг бид бүгдэд оногдсон. “Христитгэл анх энгийн гэрч нарын ажил байсан, одоо энгийн үзэгчдийн санхүүжилтээр хийгддэг мэргэжлийн ажил болжээ” гэж нэг нь хэлсэн байдаг. Бид өнөөдөр үйлчлэл хийлгэх гэж 'сүмийн бүтэн цагийн ажилчдыг' хөлслөөд ням гариг бүр тэдний тоглолтыг харж суудаг болж. Христэд итгэгч бүр Христийн бүтэн цагийн үйлчлэгч байх учиртай... Хоньчид, багш нар, сайн мэдээ тунхаглагчдын тусгай

үйлчлэл байгаа. Юуны тулд тэр вэ? ... Ариун хүмүүсийг үйлчлэлд бэлтгэх гэж тэр.²⁵

Тэнгэрээс өгөгдсөн энэ хүмүүс бусдыг өөрсдөөсөө байнгын хамааралтай болгохоор ажиллаж болохгүй. Харин ч тэд ариун хүмүүс нэгэн цагт өөрсдөө үйлчлэлээ залгамжлан авч



явах хэмжээнд хүргэхийн тулд ажиллах учиртай. Бид үүнийг ийм маягаар дүрсэлж болох юм.

Зургийн төвд байгаа цэгийг багшийн бэлэг авьяас гэж үзье. Тэр эргэн тойрныхондоо үйлчилж тэднийгээ бэлтгэж, итгэлээр босгон байгуулна. Тэд цааш нь явж, Бурханы өгсөн бэлгийн дагуу бусдад үйлчилнэ. Ингэж чуулган өсөж өргөжинө. Энэ бол **Христийн биеийг** сүнсний хувьд өсгөх тэнгэрийн арга.

Христчин үйлчлэлийг сонгомол бүлэг хүмүүсийн хүрээнд хязгаарлавал Бурханы хүмүүсийн хөгжилд саад болж, дэлхий дахинд сайн мэдээг хүргэх ажлыг гацааж, чуулганы

өсөлтийг зогсооно. Санваартан, энгийн хүн гэх ялгаа зааг Бичээст байдаггүй бөгөөд сайн мэдээ түгээхэд саад болж байдаг хамгийн том ганц шалтгаан ч байж мэднэ.

[4:13]

13-р ишлэл "Энэ өсөх явц хэр удаан үргэлжлэх вэ?" гэдэг асуултад хариулж байна. **Бид бүгд** төлөвшиж, хэлбэршиж, **нэгдэл хүртэл** гэж хариулжээ.

Нэгдэл. Эзэн чуулганаа тэнгэр өөд авахад бид **итгэлийн нэгдэлд** хүрнэ. Бид одоохондоо олон зүйлийн “зөвхөн толинд туссан бүдэг дүрсийг” харж байна. Бид олон зүйлийн талаар өөр өөр бодолтой байна. Тэр цаг ирэхэд бид бүгд санал нэгтэй болно. Бид **Бурханы Хүүг мэдэх мэдлэгийн нэгдэлд** хүрнэ. Одоо бид Эзэнийг, Тэр ямар болох, Түүний сургаалын утга учрын талаар дор бүрнээ өөр өөрийнхөөрөө төсөөлж байна. Тэр цагт бид Түүнийг байгаагаар нь харж, биднийг хэрхэн мэддэг шиг бид мэдэх болно.

Төлөвшил. Шүүрэлт болоход бид төлөвшиж гүйцнэ. Бид хувь хүний хувьд ч, Христийн Биеийн хувьд ч сүнсээр төгс боловсорно.

Хэлбэршил. Бид Түүний дүрээр хэлбэршинэ.

Хүн бүр **Христийн** адил ёс суртахуунтай болно. Даяар чуулган алдарт Тэргүүндээ нийцсэн, нас биед хүрсэн Бие болно. “Чуулган өөрөө Христийн дүүрэн байдал, бүхний дотор бүхнийг дүүргэгч нь Түүний дүүрэн байдал.” Чуулганы **чанарын хэмжээ** гэдэг нь бүрэн хөгжил буюу түүнийг өсгөх Бурханы төлөвлөгөө биелэхийг хэлж байна.

[4:14]

Бэлгүүдийг Бурханы өгсөн зориулалтаар хэрэглэж, ариун хүмүүс Эзэнд идэвхтэй үйлчилж байхад төлөвшилгүй, тогтворгүй, гэнэн байх аюулаас хол байна.

Төлөвшилгүй. Үйлчлэлд идэвхтэй ордоггүй итгэгчид сүнсний хувьд **хүүхэд** хэвээрээ үлддэг. Тэд дасгал хийдэггүй учир хөгждөггүй. Еврей номд ийм хүмүүст хандан “энэ цагт та нар багш байх ёстой боловч дахин та нарт хэн нэг нь хэрэгтэй болсон байна” (Евр 5:12) гэж бичсэн байна.

Тогтворгүй. Сүнсний хувирамтгай байдал гэдэг бас нэг аюул байна. Төлөвшөөгүй христитгэгчид утгагүй хоосон маяг, мэргэжлийн

луйварчдын ов мэхэнд автах эрсдэлтэй байдаг. Тэд аятайхан санагдсан нэгнээс нөгөө рүү энд тэнд үсчсэн шашны тэнүүлчид болдог.

Гэнэн. Энэ бүгдээс хамгийн ноцтой нь хууртагдах аюул. Нялхас зөвт үгэнд дадлагажаагүй, мэдрэмж нь сайн мууг ялгаж салгахад суралцаагүй байдаг (Евр 5:13, 14). Эрч хүчтэй, өнгөн дээрээ үнэмшилтэй санагдах буруу урсгалынхан ийм хүмүүсийн сэтгэлийг татна. Тэд ижил нэр томъёог хэрэглэж байвал христитгэл мөн гэж боддог. Тэд Библийг бие даан судалдаг байсан бол тэр зальтай үгсийг нь нэвт харж чадахсан. Гэтэл тэд одоо хуурамч **номлолын салхинд туугдан тэдний башир аргаар** системтэй алдаанд унадаг.

[4:15]

Энэ хэсгийн сүүлийн хоёр ишлэлд Христийн Бие зохистой өсөх үйл явцыг тайлбарлан дүрсэлжээ. Нэгдүгээрт, сургаал дагах шаардлагатай: **харин үнэнийг ярин ...** . Итгэлийн суурин дээрээ эргэлзэн буулт хийж болохгүй. Хоёрдугаарт, зөв хандлагатай байх ёстой: **харин хайр дотор үнэнийг ярин.** Үүнийг

өөр хандлагаар яривал үр дүн нь өрөөсгөл болно.

Блейки хэлэхдээ:

Бидний амьдрах, хөдлөх, орших хүртэл үнэн дотор байх ёстой. Гэхдээ тэр үнэнийг хайраас салгаж болохгүй. Хатуу ширүүнээр хэлсэн сайн зүйл сайн юм болдоггүй. Дуулах мэдээний сайхан нь дуулгах элчийн муухай аашинд балардаг гэжээ.²⁶

Бэлэг ариун хүмүүсийг бэлтгэж, ариун хүмүүс идэвхтэй үйлчилж эхэлсэн бол тэд **Христ уруу бүх талаар өсдөг**. Христ бол тэдний өсөлтийн зорилго зорилт нь бөгөөд тэд **бүх талаар өсөх** ёстой. Амьдралын талбар бүрдээ тэд **Түүнтэй** улам адилхан болж өсөх учиртай. Тэргүүн нь чуулганаа Өөрийнхөөр удирдах тусам Түүний Бие Түүнийг дэлхийд улам үнэн зөв төлөөлж чадна!

[4:16]

Эзэн Есүс бол өсөлтийн зорилго төдийгүй өсөлтийн эх үүсвэр нь болно. **Бүхэл бие** нь Түүнээс үндэслэн **өсөж** ургадаг. Биеийн эрхтнүүдийн нэгдлийг **хамтдаа холбогдон нийлж** гэжээ. Энэ нь эрхтэн нэг бүр яг байх

ёстой байр, хийх үүрэг дээрээ байж, бусад эрхтнүүдтэйгээ төгс **холбогдсоноор** тэд хамтдаа нэг бүтэн амьд организмыг бий болгож байгааг хэлж байна. Дараа нь эрхтэн нэг бүрийн ямар салгашгүй чухал болохыг: **холбоос бүрийн хангаж байдаг зүйлээр хамтдаа холбогдон нийлж** гэж илэрхийлжээ. Хүний бие үндсэндээ яс, булчин, эрхтэнгүүдээс бүрддэг. Яснууд хоорондоо үеэр, шандасаар холбогддог. Эрхтнүүд ч мөн шөрмөсөөр холбогддог. Үе, шандас бүр биеийн өсөлтөд оролцож, үүрэг гүйцэтгэдэг. Христийн **бие** мөн үүнтэй ижил. Аль ч эрхтэн орхигддоггүй. Хамгийн дорд итгэгч хүртэл заавал шаардлагатай.

Итгэгч бүр өөрт оногдсон үүргээ биелүүлж байгаа цагт **бие нь** эв найртай, зөв ажиллагаатай нэгдэл болон өсдөг. **Бие нь биеийн өсөлтийг бий болгодог** гэх нь этгээд сонсогдож байгаа ч үнэхээр ийм байдаг. Энгийн үгээр хэлбэл итгэгчид Библиэс тэжээлээ авч, залбирч, магтаж, Христийг гэрчилж байгаа цагт бие **өсөж** байдаг. Чаферын хэлснээр: “Чуулган нь хүний биеийн нэгэн адил өөрөө өөрийгөө өсгөн хөгждөг”. Тоо хэмжээгээр өсөхийн зэрэгцээ **хайр дотор**

өөрийгөө босгон барьдаг. Энэ нь гишүүд бие биеэ харилцан халамжлах, санаа тавихыг хэлж байна. Хрититгэгчид Христийн дотор байж, чуулган дахь зүй зохистой үүргээ биелүүлж байхад тэд бие биетэйгээ **хайр** ба эв нэгдэл дотор дотносдог.

3. Шинэ ёс суртахууны төлөөх уриа (4:17-5:21)

[4:17]

Энд шинэ ёс суртахууны төлөөх элчийн уран ятгалга эхэлж байна. Энэ ятгалга 5:21 хүртэл үргэлжилнэ. Тэрээр **Эзний дотор гэрчлэн Эзний** эрх мэдэл, тэнгэрээс өгсөн илчлэлтээр Христэд итгэгчдийг өнгөрсөн амьдралаа бохир дээл мэт тайлж, Эзэн Есүс Христийн онц ёс суртахууныг өмсөхийг уриалж байна. **Харь үндэстнүүд ... шиг та нар цаашид тэгж явж болохгүй.** Тэд одоо харь үндэстэн биш, харин хрититгэгчид болсон. Үүнд нийцсэн өөрчлөлт амьдралд нь байх ёстой. Христгүй ертөнцийн үндэстнүүд Түүнийг мэдэхгүй, доройтож байгааг Паул харсан. Үүнийг тодорхойлох долоон муухай шинж байна:

Зорилгогүй: Тэд **оюун санааны хоосрол дотроо** явдаг. Тэдний амьдрал зорилгогүй, үр дүнгүй, хоосон байсан. Маш их ажил хийгээд байгаа боловч ахиц дэвшилгүй байв. Тэд амьдралын үнэн бодит байдлыг орхигдуулж, салхины хойноос хөөцөлддөг байв.

[4:18]

Сохор. “Тэд дэлхийн хуурмаг төсөөллөөр сохлогдсон байв” (JBП). Тэд **оюун ухаандаа харанхуй болж**. Нэгдүгээрт, тэд эхнээсээ сүнслэг үнэнийг ойлгох чадваргүй байсан, дээр нь үнэн Бурханыг мэдэх мэдлэгээс татгалзсаны улмаас Эзэнээс оноосон сохор байх шийтгэлийг эдэлж явна.

Бурхангүй. Тэд **Бурханы амиас хөндийрсөн** буюу Түүнээс алс хол байв. Энэ нь тэдний сонголт, гүн суусан мэдлэггүй байдал, зүрхний хатуурлаас болсон. Тэд бүтээл, мөс чанарт нь байгаа Бурханы гэрлийг үгүйсгэж, шүтээн шүтэхийг сонгосон. Тиймээс тэд Бурханаас улам бүр холдсоор байв.

[4:19]

Ичгүүргүй. Тэд мэдрэмжгүй болж.

У.Ц.Врайтын тайлбар:

“Маул үүнийг “өвдөхөөс өнгөрсөн” гэж орчуулжээ. Ямар оновчтой үгс вэ! Мөс чанарыг анх үгүйсгэхэд өвдөлт, эсэргүүцэл мэдрэгддэг. Гэвч энэ дуу хоолойн амыг барьчихвал намссаар улам бүдэг болно. Эсэргүүцэл хүлэгдэж, өвдөлт нь мохож, эцэст нь “өвдөхөөс өнгөрдөг”²⁷

Бузар булай. Тэд өөрсдийгөө санаатайгаар тачаангуй байдалд буюу хорон муу зан үйлд тушаадаг. Харь үндэстнүүдийн үндсэн том гэм нүгэл нь бэлгийн ёс бус байдал байсаар ирсэн, одоо ч тийм байна. Тэд гаж явдалд юутай ч зүйрлэшгүй гүн хутгалдсан. Помпей хотын ханын зургууд ёс журамаа алдсан, ичгүүр сонжуургүй байдлыг харуулдаг. Өнөөдөр харь үндэстнүүдийн ертөнц үүний ижил гэм нүглээр тодорхойлогддог.

Ёс журамгүй. Бэлгийн гэм нүгэлдээ тэд зүсэн бүрийн бузар булайг үйлддэг. Энд тэднийг тачаангуй байдлын худалдаа, бизнес эрхэлж байсан мэт өөрсдийгөө бүх төрлийн бузар булай байдалд тушаасан гэдэг санаа байна.

Ханаж цаддаггүй. Шунахайран. Тэдний сэтгэл ханадаггүй байв. Тэдэнд юу ч хангалтгүй байв. Тэдний гэм нүгэл яг тэр муу зүйлээ улам ихээр хийх шуналыг төрүүлдэг.

[4:20]

Энэ бүхэн ефесчүүдийн мэддэг, хайрладаг болсон **Христээс** хичнээн өөр байна вэ! Тэр бол цэвэр агаад ариун байдлын биелэл байсан. Тэр нүгэл гэдгийг мэддэггүй, Тэр нүгэл үйлддэггүй, Түүнд нүгэл байгаагүй.

[4:21]

Та нар үнэхээр Түүнийг сонсож, Түүгээр сургагдсан юм бол гэдгийн **юм бол** гэсэн нь ефесчүүд итгэсэн эсэхэд эргэлзэж байна гэсэн үг биш. Энэ нь зүгээр Христийг **сонссон** бөгөөд **Түүгээр сургагдсан** хэн боловч Түүнийг ариун бөгөөд бурханлаг болохыг мэднэ гэдэг санааг хэлж байна. Христийг сонссон гэдэг нь **Түүнийг** итгэлээр **сонсож**, Түүнийг Эзэн ба Аврагч гэж хүлээж авахыг хэлнэ. **Түүгээр сургагдсан** гэдэг нь ефесчүүд итгэснийхээ улмаас Христтэй нөхөрлөж явсныхаа үр дүнд хүлээж авсан сургаалыг хэлж байна. Блейки үүнийг:

“Христтэй хувьчлан холбоотой байхад бүх үнэн өөр өнгөтэй, өөр онцлогтой болдог. Христгүй үнэн хүч муутай байдаг” гэж хэлжээ.²⁸ **Есүс дотор үнэн байгаачлан** Тэр үнэнийг заагаад зогсохгүй, Тэр өөрөө биежсэн үнэн юм (Иох 14:6). Энэ дэлхий дээр төрөхдөө **Есүс** гэдэг нэр авсан тул энэ нэр Түүний энэ дэлхий дээрх амьдралыг сануулж байна. Энэ дэлхий дээр Хүний биеэр ямар ч толбогүй амьдарсан амьдрал нь харь үндэстнүүдийн амьдралаас эрс ялгаатай байгааг Паул дүрслэн хэлэв.

[4:22]

Бид Христэд итгэх мөчдөө **заль мэхийн тачаалын** улмаас **ялзарч буй хуучин хүнээ тайлж** хаядаг болохоо Христийн сургуулиас мэдэж авдаг. **Хуучин хүн** гэдэг нь хүн итгэж аврагдахаасаа өмнө буюу Адамын хүүхэд байхдаа хэн байсан тэр бүгдийг хэлж байна. Бид эхэндээ тааламжтай санагдаж, найдвар төрүүлэвч эцэстээ жигшүүртэй муухай, урам хугалдаг заль мэхтэй хорон муу хүсэл шуналд автсанаасаа болж ялзардаг. Итгэгч хүний Христ доторх байр суурийн хувьд энэ **хуучин хүн**

Христтэй хамт цовдлогдож оршуулагдсан. Амьдрал дээр итгэгч хүн хуучин хүнээ үхсэн гэж тооцох учиртай. Паул энэ үнэний байр суурийг бид **хуучин хүнийг** бүрмөсөн тайлж хаясан гэж онцолж байна.

[4:23] Ефесчүүд Есүсийн хөлд сурсан хоёр дахь зүйл нь тэд **оюун санааныхаа сүнс дотор шинэчлэгдэж** байгаа аж. Энэ нь тэдний бодол санаа бузар байснаа ариун болж эрс өөрчлөгдсөнийг харуулж байна. Бурханы Сүнс тэднийг аврагдаагүй хүний бус, харин Бурханы байр сууринаас боддог болоход нөлөөлдөг.

[4:24]

Гурав дахь сургамж бол тэд нэгэнтээ **шинэ хүнийг өмссөн** явдал байна. **Шинэ хүн** гэдэг нь итгэгч хүн Христийн дотор хэн болохыг хэлнэ. Энэ бол хуучин юмс нь өнгөрөн одоод, бүх юмс нь шинэ болсон шинэ бүтээл (2Ко 5:17). Энэхүү **шинэ төрлийн хүн нь Бурханы дагуу буюу Түүнтэй ижил төстэйгээр бүтээгдсэн** ажээ. Тэр нь өөрийгөө **зөвт байдал болон үнэний ариун байдал дотор** илэрхийлэн харуулдаг. **Зөвт**

байдал гэдэг нь бусдад зөв хандаж харьцахыг хэлнэ. **Ариун байдал** гэдэг нь “Бурханыг байх ёстой байранд нь тавьж үзэх”-ийг хэлнэ гэж Ф.В.Грант тодорхойлсон.²⁹

[4:25]

Паул итгэгчдийг байр сууринаас тэдний байдал уруу орж байна. Тэд Христтэй нэгдсэн холбоогоороо дамжуулан хуучин хүнээ тайлан хаяад шинэ хүнийг өмссөн болохоор энэ гайхалтай өөрчлөлтөө өдөр бүр, алхам тутамдаа харуулж амьдрах учиртай.

Тэд эхний ээлжинд **худал хуурмагийг хойш тавьж**, үнэнийг өмссөнөөрөө ингэж чадна. Худал хуурмаг гэдэгт үнэнийг бүрхэгдүүлэх, хэтрүүлэг, булхай, амласнаа биелүүлэхгүй байх, нууцыг задруулах, зулгуйдах, татвараа төлөхөөс зайлсхийх зэрэг бүх л хэлбэрийн шударга бус явдал багтана. Христитгэгчийн үг бат байх ёстой. Тэр за гэвэл за, үгүй гэсэн бол үгүй байх ёстой. Христитгэгч шударга үнэнийг ямар нэг хэлбэрээр гажуудуулахад түүний амьдрал Библи гэхээсээ илүү нэр хугалагч болдог.

Бид хүн бүрд үнэний өртэй. Паул **хорш** гэдэг үгээр бусад итгэгчдийг хэлж байна. **Бид бие**

биедээ эрхтнүүд юм гэдэг үгнээс цаад шалтгаан харагдаж байна (Ром 12:52, 1Ко 12:12-27-г үзнэ үү). Нэг итгэгч нөгөөдөө худал хэлнэ гэдэг биеийн нэг мэдрэл тархи уруу худал мэдээ дамжуулах эсвэл аюул тулгарсан цагт нүд нь биеийн бусад хэсгээ хуурахтай адилхан гээд бодохоор төсөөлөхөд ч бэрх.

[4:26]

Амьдралд гарах дараагийн өөрчлөлт нь нүгэлт **уур хилэн**, зөвт ууртай холбоотой. Жишээ нь Бурханы мөн чанарыг доромжлоход итгэгч хүн зөвтөөр **уурлах** явдал гардаг. Хорон муугийн эсрэг уурлах нь зөв байж болно. Гэхдээ бусад тохиолдолд уур хилэн нь нүгэл. Өөрийн буруугаас болж, хорон муу санаа, атаархал, дургүйцэл, өс хонзон эсвэл үзэн ядалтын улмаас уурлахыг хориглосон. “Хэний ч уур хүрдэг. Энэ нь амархан. Гэхдээ зөв хүнд, зөв хэмжээгээр, зөв цагт, зөв зорилгоор, зөв арга замаар уурлана гэдэг *амаргүй*” гэж Аристотель хэлжээ.

Итгэгч хүн зөвт бус **уур** гаргасан бол даруй гэмшиж, уурлахаа болих ёстой. Гэмшихдээ Бурханы болон уурласан хүнийхээ өмнө гэмшин

улайх ёстой. Өс хонзон, хорсол, бухимдлыг хадгалж өөгшүүлэх учиргүй. **Та нарын уур хилэн дээр нар бүү жаргаг.** Бурхан болон бусад итгэгчидтэйгээ харьцах харилцааг минь сэвтээж байгаа аливаа асуудлыг дор нь шийдэж зүй зохистой болгож байх учиртай.

[4:27]

Уур уцаараас үүдэлтэй гэм нүглээ улайхгүй бол **диаволд** ажлаа хийх суурь тавьж өгдөг. Ийм зүйлсийг бидний туслалцаагүйгээр олох чадвар түүнд хангалттай бий. Тийм учраас бид хорон санаа, уур уцаар, атаа хорсол, үзэн ядалт болон шуналаа шалтаг тоочин халхалж болохгүй. Ийм гэм нүглүүд нь христитгэгчийн гэрчлэлийг үнэ цэнэгүй болгож, аврагдаагүй байгаа хүмүүсийг бүдрүүлж, итгэгчдийг хохироож, бидний өөрсдийн бие болон сүнснийг гэмтээдэг.

[4:28]

Одоо Паул хулгайлах хуваалцах гэдэг эрс ялгаатай хоёр зүйлд анхаарлаа хандуулж байна. Хуучин хүн хулгайлдаг, шинэ хүн хуваалцдаг. Хуучин хүнээ тайлж хая, шинэ хүнээ өмс!

“Хулгайч хүн цаашид хулгай бүү хий” гэдэг зааврыг итгэгч хүмүүст өгснөөр итгэгч гэхээрээ л огт гэм нүгэлгүй төгс хүн гэсэн үг биш гэдгийг харуулж байна. Өдөр тутам үхсэн гэж тооцож байх учиртай амиа бодсон, хуучин, муу чанар нь байсаар л байна. Хулгай гэдэг нь том хулгай хийхээс авахуулаад өрөө төлөхгүй байх, ажлын цагаараа Христийг гэрчлэх, хүний зохиолоос хулгайлах, буруу хэмжүүр хэрэглэх, төлбөрийн баримтыг хуурамчаар үйлдэх гээд маш олон хэлбэртэй. Хулгай хийхийг хориглосон энэ заалт цоо шинэ юм биш ээ. Мосегийн хуульд хулгай хийхийг хориглож байсан (Ег 20:15). Үүний араас гарч байгаа зүйл уг ишлэлийг жинхэнэ христитгэгч болгож байна. Бид зөвхөн хулгайлахгүй байгаад зогсохгүй ядруу нэгэнтэйгээ хуваалцах юмтай байхын тулд шударгаар **хөдөлмөрлөх** ёстой. Хууль биш, харин нигүүлсэл ариун байх хүч чадал болдог. Зөвхөн нигүүлслийн хүч л хулгайчийг өглөгийн эзэн болгож чадна.

Энэ бол үндсэн эргэлт. Өөрийн хэрэгцээ, хүсэл сонирхлоо биелүүлэхийн төлөө ажилладаг нь хүний төрөлх чанар. Тэдний орлого өсөхөд

амьдралын түвшин ахидаг. Тэдний амьдралын бүх зүйл өөрсдийг нь тойрон эргэлддэг. Энэ ишлэл ажил эрхлэгчийг илүү өгөөмөр, нэр төртэй байхыг санал болгож байна. Энэ нь өөрийн гэр бүлийг даруухнаар тэжээхийн сацуу гэрийнхнийхээ болон бусад хүний **гачигдалд** тус дэм болж бай гэдэг санааг хэлжээ. Тэр **гачигдал** ямар их вэ!

[4:29]

Элч одоо хэл ярианы сэдэв рүү орж, үр ашиггүй яриа болон хүнийг босгон байгуулдаг үг хэлийг харьцуулж байна. **Ялзарсан** хэл яриа гэдэг нь ерөнхийдөө цаагуураа олиггүй утга агуулсан яриаг хэлж байна. Үүнд: завхай марзан яриа, доромжлол, бохир наргиа зэрэг нь багтана. Гэхдээ энд хөнгөмсөг, утгагүй хоосон, дэл сул, үнэ цэнэгүй үг яриаг бас хамаатуулж байна. Паул 5:4-д садар, жигшүүртэй яриаг дурдсан. Энд биднийг үр ашиггүй үгсээ орхин, хүнийг босгон байгуулах үг яриагаар орлуул гэдгийг хэлж байна. Христитгэгчийн үг яриа нь:

Сургаж босгосон. Сонсож байгаа хүмүүсээ босгон байгуулдаг.

Зөв зүйтэй. Тухайн нөхцөл байдалд тохирсон.
Нигүүлсэнгүй. Энэ нь **сонсож буй хүнд**
нигүүлслийг өгөх учиртай.

[4:30]

Бурханы Ариун Сүнснийг бүү гомдоо.
Золилтын өдрийн төлөө та нар Түүгээр
тамгалуулсан билээ. Энэ нь өмнөх ишлэлтэйгээ
холбоотой гэж үзвэл ашиггүй хоосон яриа Ариун
Сүнснийг гашуудуулдаг байх нь. Үүнийг 25-28-
тай холбож болох бөгөөд худал ярих, зөв бусаар
уурлах, хулгай хийх нь Түүнийг мөн шаналгадаг
байна. Ерөнхийдөө биднийг Түүнийг
гашуудуулдаг бүхнээс зайгаа ав гэж хэлж байна.

Үүнд гурван том шалтгаан байна:

- (1) Тэр бол *Ариун* Сүнс. Тэрээр ариун бус
бүхнийг үзэн ядна.
- (2) Тэр бол **Бурханы** Ариун Сүнс, ерөөлт
Гурвалын нэг.
- (3) Бид **золилтын өдрийн төлөө Түүгээр**
тамгалуулсан. Тамга нь эзэмшил,
баталгааг илэрхийлдэг гэж өмнө нь хэлж
байсан. Тэр бол Христ эргэн ирж, бидний
аврал бүрэн төгс болтол биднийг хадгалах

баталгааны тамга. Паул энд итгэгч мөнхийн баталгаатай болсныг нүгэл үйлдэхгүй байх хамгийн хүчирхэг шалтгаан болгон авсан нь сонирхолтой юм.

Гашууддаг гэдэг нь Ариун Сүнс нь зүгээр нөлөө төдий зүйл биш харин Бодгаль болохыг харуулж байна. Үүнээс Тэр биднийг хайрладаг гэдэг нь харагдаж байна. Яагаад гэвэл хайрладаг хүн л гашууддаг. Бурханы Сүнсний хийх дуртай үйлчлэл нь Христийг алдаршуулах бөгөөд итгэгчдийг Түүнтэй улам бүр адилхан болгож өөрчлөх ажил (2Ко 3:18). Христитгэгч нүгэл үйлдэхэд энэ үйлчлэл тухайн хүнийг сэргээн барьж босгох үйлчлэлээр солигддог. Итгэгчийн сүнсний ахиц дэвшилд нүгэл саад болохыг харахаараа Ариун Сүнс гашууддаг. Ингээд Тэр итгэгчийг гэмшүүлэх, улайлгах ажил хийх хэрэгтэй болдог.

[4:31]

Үг яриа, ааш зангийн нүгэл бүрийг зайлуулж хаявал зохино. Тэдгээрийн заримыг энд дурджээ. Тэдгээрийг нарийн ялгаж салгах хэцүү ч ерөнхий утга нь тодорхой байна. Үүнд:

Хорсол – Дургүйцэх, уучлахгүй зуух, хахир хатуу хандлага

Хилэн – Бухимдлаа барьж дийлэхгүй тэсрэх, хэрцгий түрэмгий уур, муухай ааш гаргах

Уур – Яншин үглэх, дайсагнах, зэвүүрхэх

Хашгираан – Уур бухимдлаа чангаар илэрхийлэх, орилох, хэрэлдэх, сөргөлдөгчөө загнаж хашгичих

Хорон муу яриа – Доромжилсон үг хэллэг, гүтгэлэг, доош нь хийсэн яриа

Хорон санаа – Бусдад мууг хүсэх, хонзогнох, хорон байх

[4:32]

Ааш зангаас гарах нүглийг устгаж, өөрийн савыг Христийнх шиг чанараар дүүргэх учиртай. Өмнө нь төрөлхийн хорон муугийн тухай дурдсан бол одоо ер бусын ёс суртахууны тухай өгүүлнэ:

Энэрэл – Өөрөөс ямар ч золиос гарах байсан бусдыг гэх тусч сэтгэл.

Уян зөөлөн сэтгэл – Бусдыг ойлгох, өрөвдөн хайрлах нинжин сэтгэл. Тэдний зовлонг үүрэхэд бэлэн байдал.

Уучлал – Өөрийг нь гомдоож, хохироосон нэгнийг өршөөхөд бэлэн байх, хариу нэхэхгүй байх.

Бурхан Өөрөө уучлагчийн агуу жишээ. Уучлах үндэслэл нь загалмай дээр хийсэн Христийн ажил. Энэ бүхнийг уучлал авах зохисгүй бидний төлөө хийжээ. Зохистой нөхөн төлбөр хийгдэхээс нааш Бурхан уучилж чадахгүй байв. Тэрээр хайрынхаа улмаас зөвт байдлынхаа шаардсан зүйлийг хангаж өгсөн. **Христ дотор** гэдэг нь Түүний мөн чанар болон хийсэн ажилд Бурхан биднийг уучлах үндэслэлийг олсон.

Тэр биднийг “сая сая төгрөгийн” өртэй байхад уучилсан учраас бид өөртөө “хэдхэн төгрөгийн” өртэй нэгнээ уучлах учиртай (Мт 18:23-28).

Ленски зөвлөхдөө ингэж хэлжээ:

Хүн надад мууг үйлдвэл би тэр л мөчид уучлах ёстой. Тэгвэл сүнс минь чөлөөлөгдөнө. Тэгэхгүйгээр түүнийг буруутгасаар байвал би Бурханы болон түүний эсрэг нүгэл үйлдэж тэр нь Бурханы уучлалд саад учруулдаг. Тэр хүн гэмшиж, нөхөн төлбөр хийж, надаас уучлалт гуйсан эсэх нь хамаагүй. Би түүнийг шууд уучилсан.

Тэр хийсэн буруугаа Бурханы өмнө хүлээх учиртай. Гэхдээ энэ бол Бурхан, тэр хоёрын хэрэг, минийх биш. Харин би Матай 18:15-д хэлсэн ёсоор түүнд туслах ёстой. Гэхдээ энэ нь бүтэмжтэй болсон эсэхээс үл хамааран би энэ бүхнийг эхлэхээс ч өмнө түүнийг уучлах учиртай.³⁰

[5:1]

4:32-т дурдсан Бурханы уучлалын жишээ нь Паулын уриалгын үндэс суурь болж байна. Уялдаа холбоо нь гэвэл Бурхан чамайг Христ дотор уучилсан. Тэгэхээр одоо **Бурханыг дуурайгчид болж**, бусдыг уучил гэдэгт оршино. **Хайрлагдсан хүүхдүүдийн** хувьд гэдэг чухал шалтгааныг хавсаргажээ. Хүүхдүүд эцэг эхээ дуурайдаг, удам судрынхаа нэрийг өргөхийг хичээх ёстой нь жам. Сүнсний хувьд ч бид Эцгийгээ дэлхийд таниулж, Түүний **хайрлагдсан хүүхдүүд** гэсэн нэр хүндэд тохирсон байдлаар амьдрахыг хичээх нь зүйн хэрэг.

[5:2]

Эзэнтэй адилхан байх ёстой бас нэг зам нь **хайр дотор явах. Хайр дотор явах** гэдэг нь өөрийгөө бусдад зориулахыг хэлнэ гэж энэ ишлэл тайлбарлажээ. Бидний төгс үлгэр жишээ болох Христ ийнхүү үйлдсэн. Гайхалтай! Тэр биднийг хайрласан. Хайраа нотлон бидний төлөө загалмай дээр Өөрийгөө үхэлд тушаасан.

Түүний бэлгийг Бурханд өгсөн **өргөл бөгөөд тахил** гэжээ. Бурханд өгч байгаа юм бүхэн **өргөл. Тахил** нь үхэл учирсан гэдгийг нэмж хэлж байна. Тэр бол загалмайн үхэлд хүртэл дуулгавартайгаар Бурханы хүслийг биелүүлэхэд Өөрийгөө бүрэн зориулсан жинхэнэ шатаалт **тахил** байв. Түүний үгээр илэрхийлэшгүй зориулалт гарган өргөсөн **тахил анхилам үнэрт** гэж уран яруу илэрхийлжээ. Ф.Б.Мейер: “Хэмжээлшгүй хайр, харамгүй төлөөсийг, тэр хайрыг хүртэх ийм зохисгүй хүмүүст зориулан өгөхөд тэнгэрийг дүүргэсэн анхилам үнэр түгэж, Бурханы зүрхийг баяр хөөрөөр дүүргэсэн” гэжээ.³¹

Эзэн Есүс өөрийгөө бусдын төлөө өгснөөр Эцгээ баярлуулсан. Бид ч гэсэн өөрсдийгөө бусдын төлөө өгснөөр Бурханыг баярлуулж

болно гэсэн сургамж энд байна.

Бусад хүн, Эзэн минь, бусад хүн!

Барих уриа лоозон минь ийм байг

Бусдын төлөө амьдарснаар

Бурхан тань шиг болоход минь туслаач

-Чарльз Д. Мейгс

[5:3]

Гурав, дөрөвдүгээр ишлэлд элч бэлгийн гэм нүглийн тухай сэдэв рүү шилжиж, түүнээс салж, ариун амьдралаар амьдрах тухай шийдэмгий уриалж байна. Эхлээд тэр энэ нүглийн хэлбэрүүдийг дурджээ.

Садар самуун. Энэ үг завхайрал гэдэг үгтэй хамт дурдагдах бүрдээ *гэрлээгүй* хүн бэлгийн харьцаанд орохыг хэлдэг. Харин энэ тохиолдолд завхайрал гэдэг үгнээс ялгаж бичээгүй байгаа болохоор ерөнхийдөө бэлгийн харьцааны *бүх* ёс бус хэлбэрийг хэлж байна.

Бузар булай. Энэ нь ёс суртахуунгүй үйлдэл гэдэг утгыг агуулж байж болно, мөн цэвэр бус зураг дүрс, ном хэвлэл, сонин сэтгүүл зэрэг ёс бус амьдралд байдаг, хүний хуял тачаалыг өдөөж хөдөлгөх зүйлсийг хэлнэ.

Шунал. Бид ерөнхийдөө мөнгөнд шунах гэж ойлгодог ч энд хүн хуял тачаалаа гэрлэлтийн хязгаараас гадуур хангах гэсэн ханашгүй шуналыг хэлж байна (Ег 20:17-г үзнэ үү: “Чи бүү шунахайр... хөршийнхөө эхнэрт...”).

Эдгээр нь христитгэгчдийн **дунд дурсагдах** ч учиргүй. Итгэгч хүн *эдгээрийг үйлдлээ* гэж сонсогдох ч учиргүй гэдгийг хэлүүлэлтгүй ойлгох учиртай. Эдгээр зүйлийн уг ичгүүрт, нүгэлт мөн чанарыг зөөлрүүлэхээр *ярих* ч хэрэг байхгүй. Эдгээрийг ноцтой гэж үзэхгүй байх, зөвтгөх шалтаг тоочих, тэр ч бүү хэл байдаг л зүйл шиг байнга авч үзэх, ярих нь маш том аюулыг дагуулж байдаг. Паул уриагаа **ариун хүмүүст үл нийцэх** гэдэг үгээр хүч оруулан тунхаглаж байна. Итгэгчид дэлхийн ялзралаас тусгаарлагдсан, тиймээс одоо үг болоод үйлсээрээ харанхуйд дурлахгүй, тусгаар байх ёстой.

[5:4]

Тэдний үг хэл нь дараах зүйлсээс ангид байх учиртай:

Бузар булай. Энэ бол эр эмийн явдлыг оролцуулсан бохир наргиа, яриа бөгөөд

ичгүүргүй, зүй бусын бүх төрөл.

Мунхаг яриа. Тэнэг хүнд л тохирсон утгагүй дэмий хоосон яриаг хэлнэ. Үүнд бүдүүлэг хэл яриа орж байж болох юм.

Тоглоом тохуу. Энэ нь далд, зохисгүй, тохиромжгүй утгатай наргианууд. Ямар нэг зүйлийн тухай ярьж, наргиа болгон хэлж, тэр сэдвийг ойр ойрхон дурссаар эцэстээ түүнийгээ үйлдэхэд хүргэх.

Гэм нүглийн талаар наргиа хийх нь үргэлж аюултай байдаг. Ийм зохисгүй, дэмий хоосон юм ярьж байхын оронд христитгэгч амьдралдаа авч байгаа бүх ивээл өршөөлийн төлөө Бурханд **талархах** учиртай. Энэ нь Эзэний таалалд нийцэж, бусдад үлгэр дууриал болж, өөрийнх нь сүнсэнд ашиг тусыг өгдөг.

[5:5]

Ёс суртахуунгүй хүнд Бурхан хэрхэн ханддаг тухай эргэлзэх зүйл үгүй. Тэдэнд **Христийн болон Бурханы хаанчлалд өв байхгүй**. Хүн төрөлхтөн бэлгийн гэмт хэрэг үйлдэгчдийг өвчтэй гэж үзэн сэтгэцийн эмчилгээ хэрэгтэй гэдэг. Ёс суртахуунгүй байдлыг ертөнц өвчин

гэж үздэг. Бурхан үүнийг нүгэл гэж үздэг. Хүмүүс үүнийг өнгөрөөдөг. Харин Бурхан ялладаг. Хүний шийдэл нь сэтгэлзүйн эмчилгээ хийх. Бурханы шийдэл нь шинээр төрүүлэх.

Гуравдугаар ишлэлд гарсан гурван төрлийн гэмтнийг энд онцлон хэлсэн: **садар самуун, бузар булайг үйлдэгч, шунахай хүн. Шунахай хүн** бол **шүтээн шүтэгч** гэж үзэж байна. Түүнийг **шүтээн шүтэгч** гэж нэрлэх шалтгаанууд байна. Нэгдүгээрт, тэр Бурханы мөн чанарыг буруугаар ойлгодог. Тэрээр Бурханыг хүний тачаангуй шуналыг дэмжигч гэж үздэг. Тэгээгүйсэн бол тэр шунахайрч зүрхлэхгүй байсан. Хоёрдугаарт, тэр хүн өөрийн хүслийг Бурханы хүслээс дээгүүр тавьдаг тул шунахайрлыг шүтээн шүтэх гэж байна. Гуравдугаарт, тэр Бүтээгчийг биш, бүтээлийг шүтэж байна (Ром 1:25).

Паул **хаанчлалд өв байхгүй** гэж шууд утгаар нь хэлж байна. Эдгээр гэм нүглийг үйлдэгчид төөрсөн, нүгэлтэй, там уруу орох замдаа яваа ажээ. Одоогийн байдлаар тэд үл үзэгдэх **хаанчлалд** ороогүй, тэд Христийг эргэн ирж захирах **хаанчлалд** ч байхгүй, тэнгэрт мөнхөд

байх **хаанчлалын** хаалга ч тэдний хувьд үүрд хаалттай байх болно. Паул **хаанчлалд** хамрагдаж байгаа ч Христийн Шүүлтийн сэнтийний өмнө шагналаа алдах хүмүүс гэж хэлээгүй байна. Энд шагналын тухай биш, харин авралын тухай ярьж байна. Тэд өөрсдийгөө итгэгчид гэж тунхаглаж болох ч амьдрал нь тэдний аврагдаагүй болохыг харуулдаг. Тэд гэмшиж, Эзэн Есүст итгэвэл аврагдаж *болно*. Гэхдээ тэд үнэнээсээ итгэвэл эдгээр гэм нүглүүдийг хийхээ болино.

Христ Бурхан гэдгийг **Христ болон Бурханы хаанчлал** гэдэг үгс илэрхийлж байгааг анзаарна уу. **Христийг хаанчлалын** захирагчийн хувьд Бурхан Эцэгтэй нэг түвшинд тавьсан байна.

[5:6]

Бэлгийн ёс суртахуунгүй байдлыг хүлээн зөвшөөрөх хүмүүсийн тоо өдрөөс өдөрт олширсоор байна. Тэд бие махбодын таашаалыг хангах нь хэрэгцээ бөгөөд ашигтай зүйл, түүнийг нь нухчин дарвал хүний сэтгэлгээ гаж, явцуу болно гэж хэлдэг. Тэд ёс суртахууныг хүний амьдарч буй ахуй соёл нь тодорхойлно,

тиймээс “гэрлэхийн өмнөх”, “гэрлэлтээс гадуур”, “ижил хүйстний” (Бурханы үг тэдгээрийг садар, завхай, гаж гэж яллаж байгаа) бэлгийн харьцааг манай ахуй соёл зөвшөөрч байгаа тул хуулиар батлан албан ёсны эрх болгох хэрэгтэй гэдэг. Ингээд зогсохгүй ижил хүйстний бэлгийн харьцааг дэмжин дуу хоолойгоо өргөж байгаа хүмүүсийн манлайлагчдын дунд чуулганд өндөр албан тушаал бүхий итгэсэн гэдэг үйлчлэгчид байгаа нь гайхширмаар. Ёс бус гэж жирийн хүмүүсийн ойлгосоор ирсэн бэлгийн ёс суртахуунгүй байдлыг одоо чуулганы нэртэй үйлчлэгчид байх л зүйл гэж тунхаглах болжээ.

Христитгэгчид ийм утгагүй ярианд хууртагдаж болохгүй. **Эдгээрээс болж Бурханы уур хилэн дуулгаваргүй хөвгүүд дээр буудаг юм.** Садарлах, завхайрах зэрэг гэм нүглийг Бурхан юу гэж үзэн ямар хариу барьдгийг Тооллого 25:1-9-д харуулсан. Моабын эмэгтэйчүүдтэй нүгэл үйлдсэний улмаас хорин дөрвөн мянган израиль хүн алуулсан. Ижил хүйстний бэлгийн ёс бус харьцааг Эзэн юу гэж үздэгийг тэнгэрээс буулгасан хүхэр галаар сүйтгэгдсэн Содом, Гоморра хотуудын жишээ

харуулж байна (Эх 19:24-28).

Бурханы **уур хилэн** нь зөвхөн ер бусын шийтгэлийн үзэгдлээр илэрхийлэгдээд зогсдоггүй. Бэлгийн гэм нүгэл үйлдсэн хүмүүс Түүний шийтгэлийн бусад хэлбэрээр бас авдаг. Бэлгийн замын халдвар, ДОХ зэрэг бие махбодод тусах нөлөө байна. Гэм буруутайгаа мэдрэхээс үүдэн сэтгэцийн, мэдрэлийн, сэтгэл санааны өвчин эмгэгүүдтэй болдог. Хүний зан чанар ч өөрчлөгддөг байна. Эмэгтэйлэг шинж нь улам нэмэгддэг (Ром. 1:27). Садарлагч, завхайрагчид дээр Бурханы эцсийн мөнхийн шийтгэл ирэх нь мэдээж (Евр 13:4). Дуулгаваргүй Адамаас төрж, санаатай Бурханд дуулгаваргүй хандан түүнийг дагаж буй **дуулгаваргүй хөвгүүдэд** өршөөл үзүүлэхгүй (Илч 21:8).

[5:7]

Итгэгчдийг ийм бурхангүй үйлд бүү оролц гэж чухалчлан сануулсан. Үүнийг үл хэрэгсвэл Христийн нэрийг хүндлээгүй, бусдын амьдралыг нураасан, гэрчлэлээ алдсан, шийтгэлийн шуургыг урин дуудсан хэрэг болно.

[5:8]

Долдугаар ишлэлд байгаа чухал тушаалдаа хүч нэмэхийн тулд **гэрэл, харанхуй** хоёрыг оновчтой тодорхойлж байна (ишлэл 8-14). Нэгэн цагт ефесчүүд **харанхуй байсан, харин одоо тэд Эзэн дотор гэрэл ажээ**. Паул тэднийг харанхуйд байв гээгүй харин тэд өөрсдөө **харанхуй** байв гэжээ. Одоо Эзэнтэй холбогдсон нэгдлээрээ дамжуулаад тэд **гэрэл** болцгоов. Тэр бол гэрэл, тэд Түүний дотор байгаа, тэд **одоо** тэгэхээр **Эзэний дотор гэрэл** юм. Тэдний байдал тэдний байр суурьтай таарч байх учиртай. Тэд **гэрлийн хүүхдүүд шиг явах ёстой**.

[5:9]

Энд гэрэлд алхагчдын ургуулах учиртай **үр жимсийг** тайлбарлаж байна. **Сүнсний үр жимс** нь **алив сайн, зөвт байдал ба үнэнээс** бүрддэг. **Сайн** гэдэг нь ёс суртахууны бүх өндөр дээд хэм хэмжээг хэлнэ. **Зөвт** гэдэг нь Бурхан болоод хүнтэй харьцах бүрдээ шударга байхыг хэлнэ. **Үнэн** гэдэг нь шударга, тэгш, бодит байхыг хэлнэ. Энэ бүгд нийлэхээрээ түнэр харанхуйг

гийгүүлэх Христээр дүүрэн амьдралын гэрлийг бий болгоно.

[5:10]

Гэрэлд алхагсад нь өмнөх ишлэлд дурдсан үр жимсийг гаргаад зогсохгүй **Эзэнд таалагдах юманд суралцдаг**. Тэд бодол, үг хэл, үйлдэл бүрээ шалгаж цэгнэдэг. **Эзэн** үүнийг юу гэж үзэх бол? Энэ Түүнд ямар харагдах бол? Тэд хүнтэй ярих яриа, амьжиргааны түвшин, хувцас хунар, ном зохиол, ажил төрөл, амралт зугаалга, наргиан цэнгээн, тавилга хогшил, найз нөхөд, унаа машин, спорт гээд амьдралынхаа бүх зүйлийг шүүлтүүрээр оруулдаг.

[5:11]

Итгэгч хүн **харанхуй, үр жимсгүй ажлуудад оролцох ёсгүйн** дээр тэдгээрийг хүлээн зөвшөөрөх хандлага ч гаргах ёсгүй. Бурхан болоод хүмүүсийн хувьд тэрхүү **харанхуйн ажлууд нь үр жимсгүй** болно. Ийнхүү хоосон байдлаас болж Паул Ром хотын итгэгч нараас “Тэгэхэд та нар одоо ичиж байгаа зүйлсээс ямар

үр жимс авсан бэ?” (Ром 6:21) гэж асуусан. Нөгөө талаас тэдгээр нь **харанхуйн үйлс** шүү дээ. Тэд бүдэг гэрэл, халхавч нөмрөг, цоожтой хаалга, нууц өрөөний ертөнцөд хамаардаг. Энэ нь хүн хорон мууг үйлдэхээрээ гэрлээс дайжин **харанхуй уруу** зүтгэдэг (Иох 3:19) төрөлх шинжийг харуулж байна. Итгэгчдийг **харанхуйн ажлуудаас** зайлсхийгээд зогсохгүй **тэдгээрийг илчил** гэжээ. Үүнийг бид нэгдүгээрт ариун амьдралаар, хоёрдугаарт Ариун Сүнсний чиглүүлгээр хэлэх залруулгын үгсээр хийнэ.

[5:12]

Одоо элч христитгэлт хүн яагаад ёс суртахууны ялзралтай эвлэрч болохгүй, зэмлэх ёстойн учрыг тайлбарлаж байна. Хүний нууцаар үйлддэг бузар гэмүүд үнэхээр гутамшигтай тул тэдгээрийг үйлдэх нь битгий хэл тэр тухай **ярихад ч ичмээр юм**. Хүний бодож олсон ёс бусын гэм нүглүүдийг дүрсэлж дурсахад хүртэл сонсогчийн оюун бодлыг бузарлах урхагтай. Тийм болохоор христитгэгчид эдгээрийг дурсахаас ч зайлсхий гэж сургажээ.

[5:13]

Харанхуйд байгаа бүхнийг **гэрэл илчлэн харуулдаг**. Тиймээс христитгэгчийн ариун амьдрал аврагдаагүй хүмүүсийн гэм нүгэлт байдлыг тод томруун ялгаруулж илчилдэг. Зохистой зэмлэл ч гэм нүглийн жинхэнэ мөн чанарыг илчилдэг. Блейки хэлэхдээ:

Фарисайчуудын хоёр нүүрт байдлыг Эзэн буруушаахаас өмнө тэдгээрийн үйлс дагалдагч нарт тийм ч буруу санагддаггүй байв. Гэтэл Христ үнэний ариун гэрлийг тусгахад тэдний үнэн царай илчлэгдэж одоо ч тэр жигшмээр байдал нь ил хэвээр байгаа.³²

13-р ишлэлийн сүүлийн хэсгийг **харагддаг бүхэн нь гэрэл** гэж уншвал зохино. Энэ нь христитгэгчид үйлчлэлээ хийж, гэрлээ тусгахад бусад хүн гэрэлд гарч ирдэг гэсэн үг. **Гэрлийн** зэмлэлийн үйлчлэлээр бузар муу хүмүүс гэрлийн хүүхдүүд болон өөрчлөгддөг.

Мэдээж энэ бол гажилтгүй дүрэм биш. Гэрэлд гарсан бүхэн христитгэгч болдоггүй. Гэхдээ гэрэл гэрлийг төрүүлдэг нь сүнсний ертөнцийн ерөнхий зүй тогтол мөн. Энэ зарчим 1Петр 3:1-д

дүрслэгдсэн байгаа. Энд итгэгч эхнэр үл итгэгч нөхөртөө амьдралаараа үлгэрлэн тэднийг байлдан дагуул гэжээ. Ингэхдээ: “Түүнчлэн эхнэрүүд ээ, та нар нөхөртөө захирагд. Ингэх нь нөхрүүдийн чинь зарим нь үгийг дагахгүй байгаа ч гэсэн, тэд эхнэрүүдийнхээ үтгүйгээр, биеэ авч явах байдлаар аврагдана.” Ингэж христитгэлт эхнэрүүдийн гэрэл үл итгэгч нөхрүүдийн харанхуйг ялж нөхрүүд нь гэрэл болцгооно.

[5:14]

Итгэгч хүний амьдралд үргэлж сургаал номлож, эргэн тойрныхоо харанхуйг илчилж, үл итгэгчдийг үргэлж ийнхүү урин дуудсан байх учиртай:

“Нойрсогч оо, сэр Үхэгсдээс бос,

Христ чиний дээр гэрэлтэх болно.”

Энэ бол харанхуйд унтагч, сүнсээрээ үхмэл хүмүүсийг дуудсан гэрлийн дуу хоолой. Гэрэл тэднийг амь уруу, гэгээрэл рүү дуудаж байна. Тэд энэ урилгыг хүлээн авч, хариу өгвөл **Христ** тэдний дээр гэрэлтэх болно.

[5:15]

Дараагийн долоон ишлэлд Паул тэнэг алхамуудыг бодлоготой үйлдэлтэй эсрэгцүүлэн харьцуулахдаа хэд хэдэн сургамж болон зэмлэлийг ашиглажээ. Юуны өмнө уншигчдадаа **мэргэн бус хүмүүс шиг биш, харин мэргэн хүмүүсийн адилаар алхахыг** хүссэн байна. **Алхах** гэдэг үг бол Ефес номд гарч байгаа бас нэг түлхүүр үг бөгөөд “хувь хүний амьдралын бүх үйл хэрэг” гэсэн утгаар долоон удаа хэрэглэгджээ. **Хянамгай алхах** гэдэг нь Бурханы хүүхдүүдийн байр сууринаас амьдрахыг хэлнэ. **Мэргэн бус хүн шиг алхах** гэдэг нь тэр өндөрлөгөөс бууж, дэлхийн хүн шиг авирлахыг хэлнэ.

[5:16]

Мэргэн ухааны алхмууд нь биднийг **цагийг аврах** буюу боломжуудыг ашигла гэж байна. Өдөр бүр өргөн их боломжууд үүд хаалгаа нээж байдаг. **Цагийг аварна** гэдэг ариун амьдралтай, өршөөлийн үйлстэй, тусламжийн үгстэй байхыг хэлнэ. Бидний амьдарч буй **өдрүүд бузар булай** учир энэ нь тулгамдсан асуудал болж байна. Энэ нь бидэнд Бурхан хүмүүстэй мөнхөд тэмцэхгүй,

нигүүлслийн өдрүүд удахгүй төгсгөл болж, энэ дэлхий дээр магтан хүндлэх, гэрчлэх, үйлчлэх боломжууд үүрд хаагдана гэдгийг сануулж байна.

[5:17]

Тиймээс бид **мунхаг байлгүй, Эзэний хүсэл юу болохыг ухаарах ёстой**. Энэ бол амин чухал зүйл. Бузар муу дэндүү их бөгөөд цаг хугацаа охор тул бид өөрсдийн сонгосон яаруу тэвдүү үйл хэрэгт өдрүүдээ зарцуулж дуусгах сорилттой тулгардаг. Ингэснээр хүчээ дэмий барна. Тухайн өдөрт бидэнд зориулсан Бурханы **хүсэл юу болохыг мэдэж аваад түүнийг үйлдэх нь чухал**. Энэ бол үр нөлөөтэй, ашиг тустай байх цорын ганц зам. Бид христитгэлийн ажлыг **Эзэний хүслээс** ангид, өөрийн санаа, хүч, хүслээр хийж байж мэднэ. Бидэнд хувьчлан зориулсан Бурханы **хүслийг** ялган таньж аваад түүнээс хазайлгүй дагах нь мэргэн ухааны зам болой.

[5:18]

Дарсанд бүү согтуур. Ингэвэл дураараа дургих байдалд автагдана. Олон христитгэгч

огт амсдаггүй болохоор Хойд Америкийн соёлд энэ тушаалыг өгөх шаардлагагүй санагдаж, ингэж хэлсэнд цочирдож болох юм. Гэхдээ Библийг бүх ахуй соёлд хандан өгсөн бөгөөд олон оронд дарс хоолны ширээн дээрх түгээмэл унд. Дарс хэрэглэхийг Бичээс буруутгаагүй, харин хэтрүүлэн хэрэглэхийг буруу гэдэг. Дарсыг эм гэж хэлсэн тохиолдол ч байна (Сур 31:6, 1Тм 5:23). Эзэн Есүс Галилын Кана хотод болсон хуримд зориулан дарс өгсөн (Иох 2:1-11).

Гэхдээ дараах нөхцөл дарсыг хэтрүүлсэн хэрэг болох бөгөөд үүнийг хоригложээ:

- (1) Хэмжээнээс хэтрээд ирэхээр (Сур 23:29-35)
- (2) Зуршил болоод ирвэл (1Ко 6:12б)
- (3) Сул дорой итгэгчийг бүдрүүлэх шалтгаан болвол (Ром 14:13, 1Ко 8:9)
- (4) Христитгэгчийн гэрчлэлийг сэвтээж, Бурханы алдрыг гутааж байвал (1Кор. 10:31)
- (5) Христитгэгч үүний тухай эргэлзэж байгаа тохиолдолд (Ром 14:23)

Дарсанд согтуурахын оронд Ариун Сүнсээр дүүрэн байх сонголтыг Паул санал болгож байна. Энэ хоёрыг хамтад нь авч үзэхээр бидэнд эхлээд

хачирхалтай санагдаж болно, гэвч лавшруулаад энэ хоёр байдлыг харьцуулаад харвал яагаад ингэснийг нь бид харах болно.

Нэгдүгээрт, энд хэд хэдэн төстэй тал байна.

Үүнд:

- (1) Аль аль тохиолдолд тухайн хүн гадны хүчний удирдлага нөлөөн дор байна. Нэг нь согтууруулах ундаа, нөгөө нь **Сүнсний** хүч.
- (2) Аль аль нөхцөлд хүн дүрэлзсэн байдалтай байна. Пентекостын өдөр **Сүнсний** улмаас бий болсон гал дөлтэй байдлыг дарсанд согтуурснаас боллоо гэж андуурцгаасан (Үйл 2:13).
- (3) Аль алинд нь хүний алхаа амьдралд нөлөө орж байна. Согтуу хүний алхаа гишгээнд, нөгөө тохиолдолд ёс суртахуунд нөлөө орж байна.

Гэхдээ энэ хоёр тохиолдол хоёр том ялгаатай.

Үүнд:

- (1) Архинд согтвол дураараа дургиж, замбараагүй байдалд хүргэдэг. Сүнс хэзээ ч ийм байдалд хүргэдэггүй.

(2) Архинд согтсон хүн биеэ хянаж чаддаггүй. Харин Сүнсний үр жимс нь бие захирах байдал гэдэг (Гал 5:23). **Сүнсээр** дүүрсэн итгэгч хүн хэзээ ч үйлдлээ хянаж чадахгүй байдалд ордоггүй. Эш үзүүлэгчийн сүнс үргэлж эш үзүүлэгчдээ захирагддаг (1Ко 14:32).

Сүнсээр дүүрэх нь Бурханы өгсөн бэлэг мэт Библид дүрслэгдсэн тохиолдлууд бий. Жишээ нь: Иохан баптист эхийн хэвлийд байхаасаа Ариун **Сүнсээр дүүрсэн** байв (Лк 1:15). Ийм тохиолдолд тухайн хүн ямар нэгэн болзол хангалгүйгээр хүлээн авдаг ба түүний ажил үйлс эсвэл залбирлаас үл хамааран гагцхүү Эзэний хүслээр өгөгддөг ажээ. Ефес 5:18-д итгэгчдийг **Сүнсээр дүүрэн байхыг тушаажээ**. Энэ нь хүнээс өөрөөс нь хамаарах зүйл байна гэсэн үг. Тэр тодорхой шаардлагыг хангах ёстой. Энэ нь өөрөө бий болдоггүй, дуулгавартай байдлын үр дүн болно.

Тийм болохоор Сүнсний дүүргэлтийг Түүний бусад үйлчлэлүүдээс ялгаатай авч үздэг. Энэ нь дараах үйлтэй ижилгүй.

(1) Ариун Сүнсний *баптисм*. Энэ нь

итгэгчийг Христийн биед нэгтгэж өгдөг
Сүнсний ажил (1Ко 12:13).

(2) *Дотор нутаглах.* Энэ үйлчлэлээр
Тайвшруулагч христитгэгчийн бие дотор
нутаглаж, түүнийг ариун байдал, магтаал
хүндлэл, үйлчлэлд зориулан
хүчирхэгжүүлдэг (Иох 14:16).

(3) *Тосолгоо.* Бурханы хүүхдэд Эзэний юмсыг
зааж өгдөг тосолгоо бол Сүнс Өөрөө (1Иох
2:27).

(4) *Барьцаа болон тамга.* Ариун Сүнс бол
ариун хүний өвийг баталгаажуулдаг
барьцаа буюу ариун хүн өв хүлээн авах
тамга гэдгийг бид өмнө нь үзсэн (Еф 1:13,
14).

Эдгээр нь хүнийг аврагдсан даруйд хийгддэг
Сүнсний зарим үйлчлэл байна. Христийн дотор
орсон хүн бүр хэдийнээ баптисм хүртэж, дотроо
нутаглуулж, тосолгоо, барьцаа ба тамгыг хүлээн
авдаг.

Харин дүүргэлт бол өөр зүйл. Энэ нь дагалдагч
хүн амьдралдаа нэг удаа үзээд болчихдог үйл
явдал биш, харин тасралтгүй үргэлжлэх үйл явц
юм. Энэ тушаал шууд утгаараа “Сүнсээр дүүрэн

бай” гэжээ. Үүний эхлэл нь тодорхой нэг үйл явдал байж болно, гэхдээ үргэлжлэл нь цаг тутам хийгдэх үйл болой. Өнөөдрийн дүүргэлт маргаашийнхыг орлохгүй. Тэгээд ч энэ бол их хүсүүштэй байдал. Үнэндээ энэ бол итгэгч хүний энэ дэлхий дээр байх хамгийн төгс нөхцөл билээ. Ийм үед Ариун Сүнс итгэгчийн амьдралыг гашуудах юм багатай удирдах бөгөөд ингэснээр итгэгч хүн тухайн цаг үед Бурханы өөрт нь өгсөн төлөвлөгөөг биелүүлж байна гэсэн үг.

Тэгвэл итгэгч хүн яаж **Сүнсээр дүүрэх** вэ? Яаж гэдгийг нь Паул энд хэлээгүй, **дүүрэн бай** гэдэг тушаалыг өгөөд л орхиж. Гэхдээ бид Библийн бусад хэсгүүдээс хүн **Сүнсээр дүүрэн байхын** тулд дараах зүйлсийг хийх ёстойг мэднэ. Үүнд:

- (1) Өөрт мэдэгдсэн гэм нүгэл бүрийг гэмшин улайгаад, түүнээсээ холдох (1Иох 1:5-9). Ийм ариун Бодгаль нүглийг өөгшүүлсэн биед чөлөөтэй ажиллаж чадахгүй нь ойлгомжтой.
- (2) Бид өөрсдийгөө Түүний удирдлагад бүрэн тушааж өгөх (Ром 12:1, 2). Энэ нь бидний хүсэл сонирхол, ухаан бодол, бие махбод,

цаг хугацаа, авьяас чадвар болон эрхэмлэн нандигнадаг бүхнийг хэлж байна. Бид амьдралынхаа талбар бүрийг Түүний удирдлагад нээлттэй тавьж өгөх ёстой.

(3) Христийн үгийг бидний дотор бялхам оршихыг зөвшөөр (Кол 3:16). Энэ нь үгийг уншиж, судлаж, дуулгавартай дагахыг хэлнэ. Христийн үг бидний дотор бялхам байхад **Сүнсээр** дүүрдэгтэй (Еф 5:19) ижил үр дүн гарна (Кол 3:16).

(4) Эцэст нь бид өөрийгөө хоослох учиртай (Гал 2:20). Аягыг шинэ юмаар дүүргэхийн тулд хуучныг нь асгах шаардлагатай. Түүгээр **дүүрэхийн** тулд бид өөрсдийгөө асгах шаардлагатай. Нэр нь үл мэдэгдэх хүн ийнхүү бичжээ:

Нүглийн ачаагаа хаяж Христийн гүйцэтгэсэн ажилд найдан амарсан шигээ амьдрал үйлчлэлийн ачаагаа Ариун Сүнсэнд даатган амар. Өглөө бүр өөрийгөө Сүнсээр удирдуулахаар тавьж өгөөд магтаал, амар тайван дотор амьдар. Түүнд өөрийгөө болон өдрөө зохицуулуулахаар тушаа. Өдрийн турш Түүн дотор баясан, Түүнээс хамааран дуулгавартай байж хэвш. Тэр удирдан

чиглүүлж, гэгээрүүлж, зэмлэн, зааж сурган, хэрэглэнэ, бас чиний дотор ба гадна хүссэнээ хийнэ гэж найд. Үзэгдэж мэдрэгдэж байгаагаас үл хамааран Тэр ажиллаж байгааг үнэн баримт гэж тооц. Ариун Сүнс бол бидний амьдралын Эзэн гэж итгэж, дуулгавартай даган өөрсдөө болгох гэж матийн зүтгэхээ больё. Тэгвэл Ариун Сүнсний хүсдэгчлэн Түүний үр жимс бидний амьдралд ургах болно.

Хүн **Сүнсээр дүүрсэн** эсэхээ мэддэг үү? Хүн Бурханд ойр байх тусмаа өөрөө ямар ч зохисгүй, нүгэлтэй болохоо маш тодорхой мэдэрдэг (Иса 6:1-5). Түүний оршихуйд бид өөрөөрөө бахархаад байх юм юу ч олохгүй (Лк 5:8). Бид бусдаас сүнсээрээ илүү байна, одоо боллоо гэсэн юм мэдрэхгүй. **Сүнсээр дүүрсэн** итгэгч хүн өөрөөрөө биш, Христээр дүүрэн байдаг.

Үүний зэрэгцээ тэр Бурхан амьдралд нь болон амьдралаар нь дамжуулаад ажлаа хийж байгааг мэдэрч болно. Ер бусын арга замаар юм бүтэхийг харна. Нөхцөл байдал гайхамшигтайгаар тохирон бүрдэхийг харна. Хүмүүсийн амьдралд Бурханы гар хүрнэ. Юмс тэнгэрийн цагийн хуваариар явна. Байгалийн хүч хүртэл түүний

талд үйлчилж, тэд Эзэний тэргэнд хөллөгдсөн мэт санагдана. Тэр энэ бүгдийг харж, Бурхан өөрийнх нь төлөө, өөрөөр нь дамжуулан ажиллаж байгааг ойлгоно. Тэгсэн хэрнээ энэ бүгдээс ирэх сайшаал магтаал нь түүнд хамаагүй мэт санагдана. Энэ бүгд Эзэнд хамаарна гэдгийг тэр дотроо ойлгож байгаа.

[5:19]

Одоо элч Сүнсээр дүүрснээр хүрдэг дөрвөн үр дүнг энд дурдаж байна. Нэгдүгээрт, Сүнсээр дүүрсэн христитгэгчид **дуулал, магтуу, сүнслэг дуунуудаар нэг нэгэнтэйгээ ярилцдаг**. Тэнгэрээс дүүргэлт авсан хүн Эзэний юмсыг ярихаар ам нээж, тэдгээрийг бусадтай хуваалцах сэтгэлтэй байдаг. Дээрх гурван зүйлийг зарим хүн бүгдээрээ Дуулал номын хэсгүүд гэж үздэг боловч бид **дуулал** гэж зөвхөн Давид, Асаф болон бусдын Сүнсээр бичсэнийг гэж ойлгож байна. **Магтуу** гэдэг нь Ариун Бичээс биш ч хүмүүс шууд Бурханд өргөж байгаа хүндэтгэл магтаал болно. **Сүнслэг дуунууд** гэдэг нь шууд Бурханд хандаагүй ч, сүнсний сэдэвтэй бусад дуунууд болно.

Сүнсээр дүүрсний хоёр дахь нотолгоо нь дотоод баяр баясгалан ба Бурханыг магтах сэтгэл: **Эзэнд хандаж, зүрхэндээ дуулж, ая дуу зохиогтун.** Сүнсээр дүүрсэн амьдрал бол баяр хөөрөөр оргилсон булаг (Үйл 13:52). Үүний нэг жишээ бол Зехариа. Тэр Ариун Сүнсээр дүүрээд Эзэнд хандан сэтгэл зүрхнээсээ дуулсан (Лк 1:67-79).

[5:20]

Гурав дахь үр дүн нь талархал: **Бурхан болон Эцэгт бүхний төлөө бидний Эзэн Есүс Христийн нэрээр үргэлж талархал өргө.** Сүнс удирдаж байгаа газар **Бурханд** талархал байдаг. Чин сэтгэлийн гүнээс өөрийн эрхгүй ундрэн гарах талархал байдаг. Хааяа нэг биш, харин үргэлж гарах талархал. Зөвхөн таатай сайхан зүйлсийн төлөө биш, харин бүх юмсын төлөөх талархал. Нартай сайхан өдрийн төлөө хэн ч талархаж чадна, харин амьдралын шуурганы төлөө талархахад Сүнсний хүч хэрэгтэй.

Аз жаргалд хүрэх хамгийн дөт, хамгийн баталгаатай зам бол:

Өөртөө тохиолдож байгаа бүхний төлөө

Бурханд талархан магтахыг дүрэм болго. Яагаад гэвэл гамшиг мэт харагдаж байгаа нөхцөл байдлынхаа төлөө талархан Бурханыг магтсанаар та үүнийгээ ивээл болгодог. Та гайхамшигийг үйлдэж чаддаг бол өөрийнхөө төлөө хийх гайхамшиг бол энэ талархах сэтгэл юм. Яагаад гэвэл ийм сэтгэл үггүйгээр хүрсэн бүхнээ аз жаргал болгон хувиргадаг. (Сонгон авав.)

[5:21]

Сүнсээр дүүрсний дөрөв дэх шалгуур нь Бурханаас эмээн нэг нэгэндээ захирагдах явдал мөн. Эрдман ийнхүү сануулав:

Үүнийг хэтэрхий их үгүйсгэдэг... Христитгэгчид хэтэрхий бага хэрэгжүүлдэг сүнслэг байдлын шалгуур... Халлелүяа хашхирч, магтаалын дуу дуулж, “харь хэл”-ээр ярихыг "сүнсээр дүүрэх" хэмээгсэд олон байна. Энэ бүгд хиймэл, хуурмаг, утга учиргүй ч байж мэднэ. Христитгэлт ахан дүүстээ захирагдаж, биеэ төвшин авч яван, даруу байх, маргахаас зайлсхийж, тэсвэрлэх, эелдэг зөөлөн байх нь Сүнсний хүчний

баталгаа гарцаагүй мөн... Христитгэгчид ийнхүү харилцан захирагдахдаа бүхний Эзэн хийгээд Захирагч Түүнээс буюу "Христээс эмээх" учиртай.³³

Сүнсээр дүүрэхэд гардаг дөрвөн үр дүн ярих, дуулах, талархах болон захирагдах болно. Гэхдээ цаана нь дахиад доод тал нь дөрөв байгаа:

- (1) Нүглийг зоригтой зэмлэх (Үйл 13:9-12),
Эзэнийг гэрчлэх (Үйл 4:8-12, 31, 13:52-14:3) зүрх зориг
- (2) Үйлчлэх хүч чадал (Үйл 1:8, 6:3, 8, 11:24)
- (3) Хувиа хичээх биш, харин өгөөмөр байх (Үйл 4:31, 32)
- (4) Христийг (Үйл 9:17, 20) болон Бурханыг (Үйл 2:4, 10:44, 46) магтан өргөмжлөх.

Бид Сүнсээр дүүрэхийг чин сэтгэлээсээ хүсэх ёстой. Гэхдээ өөрсдийнхөө алдрын төлөө биш, зөвхөн Бурханы алдрын төлөө хүсэх учиртай.

4. Христитгэлт гэр бүлд хүн бүр ариун байх тухай уриа (5:22-6:9)

[5:22]

Эндээс шинэ сэдэв эхэлж байгаа ч өмнөх

ишлэлтэйгээ нягт холбоотой. Өмнө нь Паул бие биедээ захирагдах нь тэнгэрлэг дүүргэлтийн нэг илрэл гэж бичсэн. 5:22-6:9-д тэрээр христитгэлт гэр бүлийн хувьд бие биедээ захирагдах нь Бурханы хүсэл болохыг харуулсан гурван тодорхой зүйлийг дурдсан байна:

Эхнэр хүн нөхөртөө захирагдах ёстой.

Хүүхдүүд эцэг эхдээ захирагдах ёстой.

Боолууд эзэддээ захирагдах ёстой.

Итгэгчид бүгд Есүс Христийн дотор нэг гэхээрээ энэ дэлхий дээрх харилцаануудыг үгүйсгэж болно гэсэн үг биш. Бид Бурханы тогтоосон аливаа удирдлага, төр засгийг хүндэтгэх ёстой хэвээрээ байгаа. Зохион байгуулалт сайтай нийгэм бүр удирдах ба удирдуулах ёсон гэсэн хоёр багана дээр тогтдог. Нэг хэсэг нь эрх мэдлийг хэрэгжүүлж, нөгөө хэсэг нь тэрхүү эрх мэдэлд захирагдах үүрэг хүлээж байдаг. Энэ бол Бурханы Гурвалд ч үйлчилдэг үндсэн зарчим билээ. "Бурхан бол Христийн тэргүүн мөн гэдгийг та нар ойлгоосой гэж би хүсэж байна" (1Ко 11:3). Хүний төр засгийг Бурхан томилсон. Төр засаг хичнээн хорон муу байсан ч огт төр засаггүй байснаас

дээр гэж Бурхан үзжээ. Бурханд дуулгаваргүй хандах эсвэл Түүнийг үгүйсгэхээс бусад тохиолдолд бид түүнд захирагдах учиртай. Засаг захиргаа байхгүй бол эмх замбараагүй байдал үүсэх бөгөөд аль ч нийгэм ийм нөхцөлд оршин тогтнож чадахгүй.

Гэрт ч мөн ижил. Өрхийн тэргүүн гэж байх ёстой, тэрхүү тэргүүнд захирагдах учиртай. Өрхийн тэргүүний байр суурийг Бурхан эр хүнд өгчээ. Үүнийгээ Тэр эр хүнийг түрүүнд, эм хүнийг дараа нь бүтээснээрээ илэрхийлжээ. Ийнхүү бүтээлийн дэс дараанд ч, зорилгод ч Тэрээр эр хүнийг удирдлагаар, эм хүнийг захирагдахаар тавьжээ.

Захирагдахаар арай муу, дорд гэсэн санаа огт биш. Эзэн Есүс Бурхан Эцэгт захирагддаг ч Эцгээсээ доогуур гэсэн үг биш. Тэгэхээр эм хүн эр хүнээс дор биш. Харин ч зориулалт, хайр халамж, хичээнгүй байдал, баатарлаг тэсвэр тэвчээрээр эр хүнээс илүү ч байж болно. Гэхдээ **эхнэр** хүнийг **Эзэнд захирагддаг шиг нөхөртөө захирагд** гэсэн. Нөхрийн эрх мэдэлд захирагдах нь Эзний эрх мэдэлд захирагдаж байгаа хэрэг. Иймээс аливаа дургүйцэх эсвэл тэрслэх хандлага

байх ёсгүй.

Хүн төрөлхтний түүх Бурханы бий болгосон захирагдах ёсыг зөрчсөнөөс үүдсэн хямралуудаар дүүрэн байдаг. Удирдлагыг гартаа авч нөхрийнхөө өмнөөс шийдвэр гаргаснаараа Ева хүн төрөлхтөнд бүх гай гамшгийг дагуулсан гэм нүглийг авч ирсэн. Сүүлийн үед Бурханы байлгахыг хүсээгүй байран дээр гарсан эмэгтэйчүүд шашны олон гаж урсгал үүсгэсэн байна. Эмэгтэй хүн Бурханы зааж өгсөн байрыг орхисноор нутгийн чуулганыг сүйрүүлж, гэр бүлийг тарааж, орон гэрийг бусниулдаг.

Нөгөө талаас Бурханы өгсөн байранд үүргээ гүйцэтгэж байгаа эмэгтэй хүнээс илүү нүд булаам зүйл байдаггүй. Ийм эмэгтэй хүний бүрэн хөрөг зургийг Сургаалт үгс номын 31-р бүлэгт дүрсэлжээ. Энэ бол Бурханы тааллыг олсон эх хүн, эмэгтэй хүний дүр.

[5:23]

Эхнэр хүн нөхөртөө захирагдахын шалтгаан нь гэвэл **нөхөр эхнэрийнхээ тэргүүн юм**. Христ чуулганы хооронд байдаг шиг харилцаа холбоо нөхөр, эхнэрийн хооронд байдаг. **Христ**

чуулганы тэргүүн бөгөөд Тэр биеийн Аврагч (Аврагч гэдэг нь 1Тм 4:10-д хэлсэн Хамгаалагч гэсэн утгатай. JND). Тэгэхээр **нөхөр** бол **эхнэрийн тэргүүн** бөгөөд түүний хамгаалагч нь юм. **Тэргүүний** хувьд тэр түүнийг хайрлаж, тэргүүлж, чиглүүлнэ, хамгаалагчийн хувьд хангаж, хамгаалж бас арчлан санаа тавина.

Өнөө цагт энэ сургаал маш хүчтэй эсэргүүцэлтэй тулж байгааг бид бүгд мэднэ. Хүмүүс Паулыг туйлширсан гоонь эр, эцгийн эрхт ёсыг баримтлагч, эмэгтэй хүнийг үзэн ядагч гэх зэргээр буруутгадаг. Эсвэл түүний хэлж байсан бүхэн тухайн нийгмийн зан заншлыг илэрхийлж байсан өнөөгийн нийгэмд таарахгүй гэж хэлдэг. Эдгээр үзэл Бичээс Бурханы амьсгалснаар байгаа гэдгийн эсрэг довтолж байгаа хэрэг. Эдгээр нь зөвхөн Паулын үгс биш, Бурханы үг. Үүнийг эсэргүүцэж үгүйсгэнэ гэдэг Бурханыг үгүйсгэж байгаа бөгөөд зовлон бэрхшээл, гай гамшгийг урин дуудаж байгаа хэрэг мөн.

[5:24]

Эхнэрийн үүргийг **Христийн** сүйт бүсгүй

болох **чуулгантай** зүйрлэхээс илүү дээгүүр алдаршуулах боломжгүй. Чуулган захирагдах нь эхнэр хүнд үлгэр дуурайл болдог. **Бүх талаараа захирагдах** гэдэг нь Бурханы хүслийн дагуух **бүх зүйлийг** хэлнэ. Нөхөр нь эхнэрээ Эзэнд үнэнч байхыг хориглож байгаа бол дуулгавартай байх албагүй. Амьдралын бусад бүх энгийн харилцаанд эхнэр нь нөхрөө итгэгч биш байсан ч дагах үүрэгтэй.

[5:25]

Эхнэрүүдэд өгсөн дээрх заавар дангаараа байсан бол, **нөхрүүдэд** адилхан өндөр заавар өгөөгүй бол энэ нь өрөөсгөл, шударга бус байхсан. Гэхдээ Бичээс дэх үнэний гайхалтай тэнцвэр, **нөхрүүдэд** олон адилхан заавар буйг анзаарна уу. Нөхрүүдэд эхнэрээ захир гэж тушаагаагүй, харин **Христ чуулганыг хайрласны адил эхнэрээ хайрла** гэж хэлжээ. Нөхөр эхнэрээ **Христ чуулганыг** хайрласан шиг хайрладаг бол эхнэр хүн нөхөртөө захирагдахаас татгалзахгүй гэж хэлсэн байна.

Эхнэрээ хэтэрхий хайрласнаараа Бурханд таалагдахгүй байх вий гэж санаа зовдог нэг

эрийн тухай бичжээ. Түүнээс нэгэн итгэгч та эхнэрээ Христ чуулганыг хайрласан шиг хайрладаг юм уу гэж асуухад "Үгүй" гэжээ. Тэгсэн тэр асуугч "Тэр хэмжээнээс хэтэрвэл л та хэт их хайрлаж байгаа хэрэг" гэж тайлбарлажээ. **Чуулганыг** хайрласан Христийн хайр өнгөрсөн, одоо, ирээдүйг гурван аугаа замаар хамарчээ.

Өнгөрсөнд Тэр чуулганыг хайрлах хайраа **түүний төлөө Өөрийгөө өгч** харуулсан. Энэ нь Түүний загалмай дээр амиа тахил болгон өргөснийг хэлж байна. Тэр Өөртөө Сүйт бүсгүйгээ олж авахын тулд асар их үнэ төлсөн. Еваг Адамын хажуунаас гаргаж авсны адил **чуулган** нь Аврагчийн шархадсан хажуунаас төрсөн.

[5:26]

Өнөөдөр чуулганыг хайрлах Түүний хайр Түүний ариусгалын ажлаас харагддаг. **Тэрээр чуулганыг үгээр дамжуулан усанд угааж цэвэрлэн, ариусгасан. Ариусгах** гэдэг нь тусгаарлах гэсэн утгатай. Чуулган байр суурийн хувьд хэдийнээ ариуссан, бодит байдал дээр тэр өдрөөс өдөрт тусгаарлагдаж байгаа. Тэрээр

Естер хатан Ахашверош хаанд бараалхахын өмнө нэг жил гоо сайхны бэлтгэл хийж байсан шиг ёс суртахуун, сүнсний бэлтгэлийг хийж байна (Ест 2:12-16). Ариусгах үйл явц нь **үгээр дамжуулан усанд угааснаар хийгддэг**. Энгийн үгээр хэлбэл итгэгч хүн Христийн үгийг сонсож дагаснаар амьдрал нь цэвэрлэгддэг. Ийнхүү Есүс дагалдагчиддаа "Миний та нарт хэлсэн үгнээс болж та нар хэдийнээ цэвэр болсон" (Иох 15:3) гэж хэлсэн. Тэгээд Тэр ариусгахыг Өөрийн тэргүүн тахилчийн залбиралд үгтэй холбосон байна: "Тэднийг Өөрийн үнэнээр ариусгаач. Таны үг бол үнэн" (Иох 17:17). Христийн цус бүхнийг бүх гэм нүглээс нэг удаа бүрмөсөн цэвэрлэдгийн адил Бурханы үг нүглийн бузраас тасралтгүй цэвэрлэдэг. Энэ ишлэл чуулганыг цэвэрлэж байгаа ус нь Бурханы үг гэж хэлж байна.

[5:27]

Өнгөрсөнд Христийн хайр бидний *золилтоор* харагдсан. Одоо цагт энэ нь бидний *ариушлаар* харагдаж байна. Ирээдүйд энэ нь бидний *алдаршууллаар* илрэх болно. **Тэрээр түүнийг**

ямар ч толбогүй, ямар ч үрчлээсгүй бөгөөд тиймэрхүү ямар ч зүйлгүй, харин ариун, гэм зэмгүй байлган Өөрийнхөө өмнө алдарт чуулган болгох гэсэн ажээ. Тэр цагт тэр туйлын үзэсгэлэн гоо, төгс сүнслэг болно.

А.Т Пийрсон ийнхүү дуу алджээ:

Эцсийн эцэст бүхнийг мэдэгч мэлмий биднийг харахад Түүний туйлын ариун байдалд үл нийцэх нэг ч батга, нэг ч мэнгэ хүний нүүрнээс олж харахгүй гээд бодоод үз дээ. Ямар итгэмээргүй гайхамшигтай хэрэг вэ!³⁴

Ф.В. Грант үүнтэй санал нийлэн хэлэхдээ:

Түүнд ямар ч хөгшрөлтийн шинж, ямар ч согог байхгүй. Түүнд гагцхүү мөнхийн залуу насны бөхөшгүй цог, ялзаршгүй гал халуун хайр нийцнэ. Тэгэхэд чуулган ариун бөгөөд гэм зэмгүй болно. Бурхан нүгэл болоод хорон мууг ялан дийлсэн ялалтаа хэрхэн хадгалдгийг мэддэггүй байсан бид чуулганы түүхийн талаар мэддэг бүхний дараа үүнийг уншихад хачин санагдана.³⁵

[5:28]

Христ чуулганыг хайрласан тухай уран яруу, сүр жавхлант илэрхийллийн араас Паул нөхрүүдэд хандан энэ бол тэдний үлгэрлэн дуурайх жишээ гэж сануулж байна. **Тиймээс нөхрүүд ч эхнэрүүдээ өөрийн бие адил хайрлах ёстой.** Христийн хайрыг дуурайн тэд **эхнэрүүдээ** үнэхээр өөрийн бие мэт **хайрлах** ёстой.

Грек хэлээр "өөрийн" гэдэг үг 22-23-р ишлэлд зургаан удаа гарч байна. "Өөрийн" гэдэг үгээр Бурхан хүнийг ганц эхнэртэй байлгахыг хүсдэгийг онцлон харуулна. ХГ-ний үед олон эхнэртэй байхыг Бурхан зөвшөөрсөн боловч хэзээ ч сайшааж байгаагүй.

Үүний зэрэгцээ Паул эхнэр нөхөр хоёрын дотно харилцааг янз бүрээр илэрхийлсэн нь сонирхолтой. Эр хүн эхнэрээ хайрлана гэдэг өөрийн биеийг (28а), өөрийгөө (28б, 30) болон "өөрийн махан биеийг" хайрлахтай адил гэжээ. Гэрлэлтээр хоёр хүн үнэхээр нэгдэж, нэг махан бие болдог учраас **эхнэрээ хайрлана** гэдэг **өөрийгөө** хайрлаж байгаа хэрэг мөн.

[5:29]

Хүн төрөлхөөс биеэ арчлах зөнтэй байдаг. Тэр өөрийгөө хооллож, хувцаслаж, угааж цэвэрлэж, өвчин аюул ослоос хамгаалж, тав тухаа хангадаг. Тэр өөрийгөө хэр зэрэг арчлахаас түүний амьд орших эсэх нь хамаарна. Ийнхүү хүний өөртөө санаа тавьдаг чанар нь **Эзэн чуулгандаа** санаа тавьдагтай харьцуулбал юу ч биш.

[5:30]

Яагаад гэвэл бид Түүний биеийн эрхтнүүд юм. Бурханы нигүүлсэл гайхамшигтай! Нигүүлсэл биднийг нүгэл болон тамаас авраад зогсохгүй, биднийг Христтэй нэгтгэн **Түүний** нууцлаг **Биеийн эрхтнүүд** болгосон. Тэрээр бидэнд хэр хайртайгаа илэрхийлжээ: биднийг **Өөрийн Бие** мэт хайрлан энхрийлдэг гэнэ. Хэрхэн санаа тавьдаг вэ гэвэл Тэр биднийг тэтгэж, ариусгаж, сургадаг гэнэ. Ямар баталгаа байгаа вэ гэвэл Тэр биеийнхээ эрхтнүүдгүйгээр тэнгэрт оршихгүй гэжээ. Бид Түүнтэй амин холбоотой. Биед нөлөөлөх зүйл Тэргүүнд ч нөлөөлнө.

[5:31]

Элч одоо Эхлэл 2:24-ийг гэр бүлийн харилцааг бий болгохдоо Бурханы тогтоосон анхдагч тодорхойлолт гэж дурдаж байна. Юуны өмнө эр хүний эцэг эхтэйгээ харьцах харьцаанаас тэргүүнд тавигдах өөр нэг харилцаа буюу эхнэртээ үнэнч байх харилцаа орж ирж байна. Гэр бүлийн энэхүү эрхэм тэргүүнд харилцаанд орохын тулд эр хүн эцэг эхээ **орхиж, эхнэртэйгээ нийлдэг**. Хоёр дахь зүйл нь гэвэл эхнэр нөхөр хоёр **нэг махан бие болж байгаа** явдал: Хоёр хүн жинхэнээр нэг бие болно. Энэ хоёр энгийн үнэнийг бодож баримталбал хадмын асуудал, гэр бүл доторх зөрчлийг шийдэж чадна.

[5:32]

Энэ нууц бол агуу билээ. Гэвч би Христ болон чуулганы тухай хэлж байна. Паул одоо гэр бүлийн харилцааны тухай ярианыхаа оргил цэгт нөхрийн хувьд эхнэр хэн билээ, **Христийн** хувьд **чуулган** нь тийм байдаг гэж өмнө нь мэдэгдээгүй байсан гайхамшигт үнэнийг тунхаглажээ. **Энэ нууц бол агуу** гэснээрээ Паул энэ бол маш нууцлаг гэх гээгүй. Харин энэ үнэний хэлж байгаа зүйл агуу гэжээ. Өмнө нь

Бурхан дотор нууцлагдаж байгаад одоо илчлэгдэж байгаа зорилго бол тэр нууц юм. Тэр зорилго нь үндэстнүүд дотроос Өөрийн яруу алдарт Хүүгийн Бие бөгөөд Сүйт бүсгүй болох ард түмнийг дуудан гаргахад оршжээ. Тиймээс **Христ ба чуулганы** харилцаа нь гэрлэлтийн төгс дүр зураг болж байна.

Эзэн дотор нэг сүнс:

Алдаршсан Есүс

Түүний бие, Түүний Сүйт бүсгүй

Чуулганы төлөө цусаа урсгасан

- Мери Баули Петрс

[5:33]

Сүүлийн энэ өгүүлбэр элчийн эхнэр нөхрүүдэд хэлсэн санааг дүгнэсэн ажээ. Нөхрүүдэд **та нарын нэг бүр чинь өөрийгөө хайрладгийн адил эхнэрээ хайрла** гэжээ. Энэ бол нөхөр бүрд хамаатай. Чи эхнэрээ хайрлаж болох юм гээгүй, харин эхнэр чинь чиний бие мөн тул түүнийг хайрла гэжээ. Эхнэрүүдэд, **нөхрөө үргэлж эмээн хүндэтгэж, дуулгавартай бай** гэжээ. За одоо жаахан бодоод үзье! Тэнгэрийн энэ зааврыг христитгэгчид өргөнөөр

сахин биелүүлбэл юу болох бол? Хариулт нь тодорхой. Зөрчил тэмцэл, хуваагдал, салалт гэж үгүй болно. Бидний гэр орон тэнгэрийн улстай улам л төстэй болохсон.

[6:1]

Тавдугаар бүлэгт бид Сүнсээр дүүрэхийн нэг үр дүн нь нэг нэгэндээ захирагдах гэж үзсэн. Жишээ нь Сүнсээр дүүрсэн эхнэр нөхөртөө захирагддаг. Одоо бид Сүнсээр дүүрсэн **хүүхдүүд** сайн дураараа эцэг эхийнхээ удирдлага захиргаанд ордог тухай үзнэ. Хүүхэд бүрийн үндсэн үүрэг хариуцлага бол **Эзэн дотор эцэг эхээ дагах** явдал билээ. Эцэг эх нь ч, хүүхдүүд нь ч Христэд итгэдэг эсэх нь хамаагүй. Эцэг эх, үрийн холбоо нь зөвхөн итгэгчдэд биш, бүх хүн төрөлхтөнд өгөгдсөн зүйл. **Эзэн дотор ... дага** гэдэг тушаал нь нэгдүгээрт, хүүхэд **Эзэнд** дуулгавартай хандлагаар эцэг эхээ **дагахыг** хэлж байна. Тэд Түүнийг дагах мэт дуулгавартай байх ёстой. Хоёрдугаарт, тэд Бурханы хүсэлд нийцсэн бүх зүйл дээр дагах ёстой гэсэн утга байна. Эцэг эх нь тэднийг нүгэл үйлдэхийг тушаавал тэд дагах учиргүй. Ийм тохиолдолд тэд эелдэгээр

татгалзаад ямар ч үр дагавар ирсэн хариу эсэргүүцэлгүй даруугаар үүрнэ. Харин бусад тохиолдолд тэд дуулгавартай байх учиртай.

Дуулгавартай байх ёстой дөрвөн шалтгаан дурджээ. Нэгдүгээрт, **ЭНЭ НЬ ЗӨВ ЮМ**. Төлөвшөөгүй, сэтгэлийн хөдөлгөөнтэй, туршлагагүй хүмүүс өөрсдөөсөө ахмад, ухаалаг эцэг эхийнхээ эрх мэдэлд захирагдах ёстой гэдэг нь гэр бүлийн амьдралын үндсэн зарчим.

[6:2]

Энэ нь Бичээсийн дагуу юм гэдэг нь хоёр дахь шалтгаан. Паул энд Египетээс гарсан нь 20:12-оос иш татан **Эцэг эхээ хүндэл** гэжээ (мөн Дх 5:16-г үзнэ үү). Энэ тушаал бол Арван хууль дотроос тодорхой **амлалтыг** хамт дурдсан **эхний тушаал** ажээ. Хүүхдүүдийг эцэг эхээ хүндэл, хайрла бас дуулгавартай дага гэж уриалж байна.

[6:3]

Гурав дахь шалтгаан нь хүүхдүүдийн сайн сайхны төлөө юм: **ЭНЭ НЬ ЧАМД САЙН** гэсэн байна. Хүүхэд эцэг эхээсээ ямар ч заавар, залруулга авдаггүй бол юу болох вэ? Ийм хүүхэд аз

жаргалгүй, нийгэмтэйгээ ч нийцэж чадахгүй болно.

Дөрөв дэх шалтгаан нь гэвэл дуулгавартай байдал бүрэн дүүрэн амьдралыг өгнө: **чи дэлхий дээр урт наслах болно**. ХГ-ний цаг үед эцэг эхдээ дуулгавартай еврей хүүхэд урт насалж байсан. Сайн мэдээний эрин үед ийм байж ч болно, үгүй ч байж болно. Эцэг эхдээ дуулгавартай байх нь үргэлж урт насыг өгөхгүй. Дуулгавартай журамт хүү эрт нас барж болно. Гэхдээ ерөнхийдөө тэрслүү, хэнэггүй хүн эрт өнгөрч, харин сахилга баттай, дуулгавартай амьдрал эрүүл энх, урт насыг авчирдаг.

[6:4]

Хүүхдүүдэд өгсөн зааврыг **эцгүүдэд** зөвлөгөө өгч тэнцвэржүүлжээ. Тэд хүүхдээ утгагүй шаардлага тавих, хэтэрхий догшрон ширүүлэх, байнга үглэснээр **уурлуулж** болохгүй. Ингэхийн оронд хүүхдүүдээ **Эзний дэг журам болон сургамж дотор хүмүүжүүлэх** ёстой. **Дэг журам** гэдэг нь сахилгажуулах, бурууг нь үгээр ба үйлсээр засаж залруулахыг хэлж байна. **Сургамж** гэдэг нь анхааруулах, зэмлэх,

залруулахыг хэлж байна. Хүүхдийг дэг журамтай болгох ажлыг "Эзэн дотор" буюу Библид илэрхийлсэн Түүний хүслийн дагуу Түүний төлөөлөгчийн хувьд хийхийг хэлж байна.

Жон, Чарльз зэрэг 16 хүүхдийн эх Сюзанна Вэсли нэгэнтээ ингэж бичжээ:

Хүүхдийнхээ эрх дураараа занг ялахаар судалдаг эцэг эх сүнсийг нь авран шинэчлэх гэж Бурхантай хамтран ажилладаг. Ийм бус эцэг эхчүүд хүүхдийнхээ дураараа занг өөгшүүлдэг чөтгөрийн ажлыг гүйцэтгэж, сүсэглэлийг амьдралгүй, авралыг биелэгдэшгүй болгож, хүүхдийнхээ сүнс хийгээд сэтгэлийг үүрдийн хараал зэмлэлд тушаадаг.³⁶

[6:5]

Христитгэлийн гэр бүл дотор захирагдах гурав дахь буюу сүүлийн талбар нь **эзэн** ба зарцын харилцаа юм. Паул **боол** гэдэг үг хэрэглэсэн нь үндсэндээ аливаа зарц, үйлчлэгч, ажилтныг хамруулж байна.

Ажилтны нэн түрүүний үүрэг бол **махан биений дагуу эздэд дуулгавартай байх** явдал.

Махан биеийн дагуу эзэд гэдэг үг ажил олгогч нь ажилтнаараа биеийн хүчний эсвэл оюуны хөдөлмөр хийлгэх эрхтэй харин сүнсний асуудал буюу мөс чанарыг захирах мэдэлгүй гэдэг санааг илэрхийлж байна.

Хоёрдугаарт, боолууд хүндэтгэлтэй хандах ёстой. **Айдас ба чичрэл** гэдэг нь дагжин бээцийж, арчаагүйтэн агшихыг хэлээгүй. Харин Эзэн болоод ажил олгогчоо хохироохоос болгоомжлон хүндэтгэлтэй хандахыг хэлнэ.

Гуравдугаарт, үйлчлэлийг хүний мөс чанараар буюу **чин сэтгэлээс** хийх ёстой. Бидэнд цалин олгож байгаа цаг бүрд жаран минутын ажлыг хийж гүйцэтгэхийн төлөө явах учиртай.

Дараа нь, бид **Христэд** хийж өгч байгаа гэсэн сэтгэлээр ажиллах ёстой. Эдгээр үг дэлхийн, итгэлийн гэж ялгаварлах учиргүйг хэлж байна. Бидний үйлс бүхэн Түүнд таалагдах, Түүнийг хүндлэх, бусдыг Түүн рүү дагуулах зорилготой байх ёстой. Амьдралын хамгийн энгийн, хар ажлыг ч Бурханы алдрын төлөө хийж байгаа тохиолдолд хүндтэй, нэр төртэй ажил болж хувирдаг. Аяга таваг угаах ажил ч үүнд орно. Тиймээс ч зарим христитгэлт эзэгтэй гал

тогооны угаалтуурынхаа дээр "Энд тэнгэрлэг үйлчлэл өдөрт гурван удаа хийгддэг" гэж бичсэн байдаг юм.

[6:6]

Бид зөвхөн даргыгаа харж байхад биш, харин цаг үргэлж Эзэн биднийг харж байгааг санаж хичээнгүйлэн ажиллах хэрэгтэй. Дарга байхгүй үед назгайрах хандлага угаасаа байдаг. Гэхдээ энэ бол шударга бус байдлын нэг хэлбэр. Христитгэлт хүний ажлын гүйцэтгэлийн стандарт хэм хэмжээ даргын байршлаас хамаарч өөрчлөгдөх учиргүй. Нэгэн итгэгч худалдагчаас үйлчлүүлэгч нь “дарга чинь хараагүй байна” гээд “төлснөөс арай ахиухныг өгчих” гэж гуйжээ. Худалдагч хариуд нь "Миний Эзэн намайг үргэлж харж байдаг" гэсэн гэдэг. Христийн зарцын хувьд бид **Бурханы хүслийг** Бурханы тааллыг олох чин хүслээр **зүрх сэтгэлээсээ үйлдэх** ёстой. Эрдман ингэж хэлжээ:

Хөдөлмөр нь ийм замаар хэмжээлшгүй нэр хүндтэй болно. Хамгийн даруу зарцын ажил ч Христийн тааллыг олохын тулд Бурханд сайшаагдахаар сайн эрмэлзэл, зүрхний бэлэн

байдал, тэмүүллээр хийгдвэл агуу болно.³⁷

[6:7]

Дээрээс нь бид **сайн хүслээр** үйлчлэх учиртай. Дотроо дургүйцэн эгдүүцэж байгаа атлаа гаднаа дуулгавартай дүр эсгэх биш, харин баяр хөөртэй, уриалгахан сэтгэлээр үйлчилнэ. Дарга чинь тэсэхэд бэрх, түрэмгий, бодлогогүй байлаа ч та ажлаа **хүмүүст биш Эзэнд мэт** хандлагаар хийж болно. Бидний амьдарч буй энэ дэлхий дээр ийм ер бусын хандлага, үйлс хамгийн чанга дуу хоолой болдог.

[6:8]

Ийм сайн ажил бүрийг Христ шагнана гэсэн баталгаа байгаа нь бүх зүйлийг Түүний төлөө хийх урам өгдөг. **Боол, эсвэл чөлөөт байх нь ялгаагүй.** Түүний төлөө хийгдсэн таатай, таагүй бүх ажлыг Эзэн анзаардаг ба Тэр ажилчин бүрд шагналыг нь өгнө.

Боолуудын тухай энэ хэсгээ өндөрлөхөөс өмнө хэлэх хэдэн зүйл байна:

- (1) ШГ боолчлолыг буруутгадаггүй. Тэр ч бүү хэл жинхэнэ итгэгчийг Христийн боол гэж

- зүйрлэсэн байна (ишлэл 6). Гэхдээ сайн мэдээ хүрсэн газар бүрд, голлон ёс суртахууны шинэчлэлийн улмаас боолыг хэтрүүлэн дарлах явдал устаж алга болсон.
- (2) ШГ хаадууд гэхээсээ боолуудад хандан ихийг хэлдэг. Энэ нь ухаалаг, хүчирхэг, язгууртан хүмүүсээс тийм ч олныг дуудаагүйг тусгаж байж болно (1Ко 1:26). Ихэнх христитгэгчид нийгэм, эдийн засгийн доод давхрагаас гаралтай байсан болов уу. Боолууд гэж онцлон хэлснээр хамгийн дорд боол ч христитгэлийн шилдэг ивээл ерөөлийг хүртэх боломжтойг харуулж байна.
- (3) Христитгэлийн эхэн үед зах дээр христитгэлт боол Бурханыг дагадаггүй боолуудаас хавьгүй өндөр үнэлэгддэг байсан нь энэхүү заавар үр дүнтэй болохыг харуулж байна. Өнөөдөр ч ажил олгогчийн хувьд христитгэлт ажилтан хүн Бурханы нигүүлслийг огт мэдэхгүй ажилтнаас илүү үнэ цэнэтэй байх учиртай.

[6:9]

Эзэд мөн боолуудтайгаа **адил** зарчмыг чигээ болгоно. Тэд шударга, элэгсэг, үнэнч байх ёстой. Ялангуяа түрэмгийлж, **сүрдүүлсэн** үг хэллэг хэрэглэхээс сэрэмжилж явах ёстой. Хэрэв тэд энэ зүйлийг сахиж чадвал зарц дээрээ хэзээ ч хүч хэрэглэх шаардлагагүй болно. Түүнчлэн тэд ямагт тэдний ч **Эзэн**, боолуудын ч **Эзэн тэнгэрт байгаа** гэдгийг санаж явах хэрэгтэй. Дэлхий дээрх эзэн, боолын ялгаа Эзэний өмнө үгүй болдог. Эзэд ч, боолууд ч ялгаагүй нэг өдөр Түүнд тайлагнах болно.

5. Христигэлийн тулааны тухай сэрэмжлүүлэг-ятгалга (6:10-20)

[6:10]

Паул захидлаа өндөрлөх дөхөж байна. Тэрээр Бурханы гэр бүлийн бүх гишүүдэд хандан тэднийг Христийн цэрэг болохынх нь хувьд уриалан дуудсан байна. Христигэлийн амьдрал бол тулаан юм гэдгийг Бурханы жинхэнэ хүүхэд бологсад нэг их удалгүй ухаардаг. Сатаны цэргүүд Христийн ажилд саад болж, цэргүүдийг нэг нэгээр нь тулааны талбараас унагахаар тууштай зүтгэдэг. Итгэгч хүн Эзэнд үр нөлөөтэй

байх тусам Сатаны зэрлэг довтолгооны бай болж байдаг: дайсан нэр төдий христитгэгчид дээр сумаа гарзддаггүй. Бид өөрсдийн хүчээр чөтгөртэй тулж чадахгүй. Тэгэхээр юуны түрүүнд бид **Эзэн дотор** буюу **Түүний чадлын** шавхагдашгүй нөөц дотор тасралтгүй хүчирхэгжих ёстой гэсэн тушаал өгчээ. Өөрийн сул тал, арчгүй доройгоо мэддэг, Түүнд бүрэн найдаж Түүнээс хамааралтай байдаг хүмүүс Бурханы хамгийн сайн цэрэг байдаг. "Бурхан ... хүчит юмсыг ичээхийн тулд ертөнцийн мөхөс юмсыг сонгожээ" (1Ко 1:276). Бидний сул дорой нь **Түүний чадлын агуу хүчийг** харуулдаг.

[6:11]

Хоёр дахь тушаал нь тэнгэрийн хуяг дуулгыг авах тухай байна. Итгэгч хүн **диаволын арга мэхний эсрэг зогсох чадвартай байхын тулд Бурханы бүрэн хуяг дуулгыг өмсөх** ёстой. Бүрэн зэвсэглэсэн байх нь зайлшгүй шаардлагатай. Ганц хоёр зэвсэг хангалтгүй. Бурханы хангаж өгсөн өвч зэвсгээс өөр юу ч биднийг ялагдашгүй болгохгүй. Диавол урам хугалах, бухимдуулах, төөрөлдүүлэх, ёс

суртахууны алдаа, сургаалын алдаа гаргуулах гэх мэт янз бүрийн арга мэхтэй. Тэр бидний хамгийн сул талыг мэддэг бөгөөд түүгээр довтолдог. Хэрэв нэг арга нь бүтэхгүй бол өөр нэг арга хэрэглэн биднийг унагаж авахыг боддог.

[6:12]

Бид бурхангүй үзэлт философчид, башир санваартнууд, Христийг үгүйсгэгч гаж урсгалынхан эсвэл ялзарсан удирдагч нарын эсрэг дайтдаггүй. Харин чөтгөрийн хүч, буруудаж унасан тэнгэр элч нар, асар их хүчтэй муу сүнснүүдийн эсрэг тулалддаг. Бид тэднийг нүдээрээ харж чаддаггүй ч бидний эргэн тойрон муу ёрын сүнснүүд үргэлж байдаг. Тэд жинхэнэ итгэгчийн дотор орж чадахгүй нь үнэн ч тэднийг дарамталж, сүрдүүлж чадна. Христитгэгчид чөтгөрийн тухай сэдвээр “өвчилж” болохгүй, мөн чөтгөрөөс айж амьдрах ёсгүй. Бурханы өвч зэвсэгтэй байхад тэдний дайралт довтолгооны эсрэг бат зогсож чадах бүхэн түүнд байгаа. Паул унасан тэнгэр элч нарыг **захирагчид ба эрх мэдэл, энэхүү харанхуй ертөнцийн хүчнүүд, тэнгэр дэх бузар муугийн сүнслэг хүч** гэж нэрлэж байна. Бидэнд эдгээрийг ялгаж салгах

хангалттай мэдлэг байхгүй. Эдгээр нь хүний амьдралд байдаг ерөнхийлөгч, засаг дарга, хотын дарга, ахлагчид гэдэг шиг эрх мэдлийн дэв зиндаа ялгаатай сүнслэг хүчнүүдийг хэлж байж болно.

[6:13]

Паул энэ захидлыг бичиж суухад бүрэн зэвсгэлсэн Ром цэрэг түүнийг манаж харгалзаж байсан болов уу. Амьдралаас сүнсний сургамж гярхай олж хардаг тэрээр ийнхүү бичжээ: догшин дайсан дайрч байна. Зөрчил тэмцэл туйлдаа хүрэхэд дайны утаа замхартал **эсэргүүцэн бат зогсох чадвартай байхын тулд бид Бурханы бүрэн зэвсгийг авах ёстой**. Тэр **бузар муу өдөр** гэж дайсан бидний эсрэг үер мэт дайран ирэх аливаа цагийг хэлж байгаа болов уу. Сатаны дайралт яг далайн давалгаа шиг нэг түрж нэг татарч байдаг. Бидний Эзнийг хүртэл цөлд сорьсныхоо дараа чөтгөр түүнийг хэсэг хугацаагаар орхиж байсан (Лк 4:13).

[6:14]

Өвч зэвсгийн эхний хэсэг нь **үнэний бүс**. Мэдээж бид Бурханы үгийн **үнэнээс** итгэмжтэй

барьж байх ёстой, гэхдээ **үнэн** биднийг бас барьж байх ёстой ажээ. Бид үүнийг өдөр тутмын амьдралдаа хамааруулах ёстой. Бүхнийг **үнэнээр** шалгаж байгаа цагт бид тулаанд хүч ба хамгаалалтыг олно.

Хоёр дахь хэсэг нь **зөвт байдлын хуяг**. Итгэгч хүн бүр Бурханы зөвт байдлыг өмссөн (2Кор 5:21), гэхдээ тэд мөн үнэн шударга, зөвт амьдрах учиртай. Нэг хүн: "Хүн зөвт амьдарч байгаа цагт гуйвшгүй байдаг. Үгс биш үйлс л гүтгэлгийг сөрөх хамгаалалт болж чаддаг" гэж хэлсэн. Бидний мөс чанарт Бурхан болоод хүний эсрэг хийсэн гэм буруу байхгүй цагт чөтгөр биднийг чичлэх газар олохгүй. Дуулал 7:3-5-д Давид **зөвт байдлын хуягийг** өмсөж байна. Эзэн Есүс үүнийг үргэлж өмсөж явсан (Иса 59:17).

[6:15]

Цэрэг хүн **хөлдөө амар тайвны сайн мэдээний бэлэн байдлыг өмсөх** ёстой. Энэ нь **амар тайвны сайн мэдээг** авч явах **бэлэн байдал** буюу дайсны газар нутаг уруу дайрахыг хэлж байна. Бид майхандаа тайвшраад суухдаа үхлийн аюулд ордог. Аврагчийнхаа үзэсгэлэнт

хөлийг даган уулан дээгүүр баярын мэдээг түгээж, амар тайвныг тунхаглаж явахдаа бид аюулгүй байна (Иса 52:7, Ром 10:15).

Хөлийг минь Та авч Өөрийнхөө төлөө

Хөнгөн ба үзэсгэлэнтэй болгооч

-Францис Ридли Хавергал

[6:16]

Тэгээд **муу нэгний галт сум** исгэрэн орж ирээд **бамбай мөргөж**, хор хөнөөлгүй унахын тулд цэрэг хүн бас **итгэлийн бамбайг** авах ёстой. Энд гарч байгаа **итгэл** бол Эзэнд болон Түүний үгэнд найдах бат итгэл. Уруу татлага тулгарч, нөхцөл байдал таагүй болон эргэлзээ төрж, онгоц сүйрэх аюул нөмрөхөд **итгэл** дээш харж, "Би Бурханд итгэдэг" гэж хэлдэг.

[6:17]

Бурханы хангаж өгдөг **дуулга** бол **аврал** (Иса 59:17). Эцэстээ ялалт ирэх нь гарцаагүй тул тулаан хичнээн ширүүн байсан ч христитгэгч сандрахгүй. Эцэст нь аврагдана гэдэг баталгаа

түүнийг эргэж буцах юмуу бууж өгөхөөс сэргийлдэг. "Бурхан бидний талд юм бол, хэн биднийг эсэргүүцэх вэ?" (Ром 8:31).

Эцэст нь, цэрэг **Сүнсний сэлэм буюу Бурханы үгийг авна**. Эзэн Сатантай тулахдаа энэ **сэлмийг** хэрэглэх сонгодог жишээг харуулсан. Тэр гурван удаа Бурханы үгийг иш татсан. Тэгэхдээ ямар ч хамаагүй үгсийг биш харин тухайн нөхцөлд тохирсон, Ариун Сүнсний хэлж өгсөн үгсийг хэлсэн (Лк 4:1-13). **Бурханы үг**³⁸ гэж Библийг бүхэлд нь хэлээгүй, харин тухайн нөхцөлд хамгийн тохиромжтой, Библийн тодорхой хэсгийг хэлж байна.

Давид Ватсон хэлэхдээ:

Бурхан бидэнд хэрэгтэй хамгаалалт бүрийг өгдөг. Бид Эзэнтэй үнэн дотор алхах, бидний амьдрал Бурхантай болон бусадтай зөв байх, хаа ч явсан амар тайвныг тогтоохыг эрхэмлэх, муу нэгний галт сумыг унтраахаар итгэлийн бамбайгаа хамтдаа өргөх, оюун бодлоо амархан төрдөг санаа зовнил болон айдсаас хамгаалах, Бурханы үгийг Сүнсний хүч дотор үр дүнтэй хэрэглэхийг хичээх ёстой. Есүс Бурханы үгээр дахин давтан сэлэмдсэнээр цөлд дайснаа ялсныг санаарай.³⁹

[6:18]

Залбирлыг хуяг дуулгын нэг хэсэг гэж дурдаагүй байна. Гэхдээ, залбирал бол цэрэг хүний амьдарч амьсгалах орчин нь гэж хэлбэл давсалсан хэрэг болохгүй гэж бодож байна. Ийм л уур амьсгалаар хуяг дуулгаа өмсөж, дайсантайгаа тулах ёстой. **Залбирал** мэр сэр биш харин тасралтгүй, хааяа нэг хийдэг үйлдэл биш харин хэвшил байх ёстой. Цэрэг хүн нийтийн болон хувийн, бодож цэгнэсэн болон санаандгүй, гуйлт болон зуучлал, улайх болон даруусах, магтаал болон талархлын гээд төрөл бүрийн **залбирал** хэрэглэж байх хэрэгтэй.

Залбирал Сүнс дотор буюу Түүгээр удирдуулж, амилж байх учиртай. Амны уншлага болсон залбирал тамын цэргүүдтэй тэмцэхэд яаж туслах вэ? **Залбирлыг** сонор сэрэмжтэй хийх ёстой буюу **үүний тулд ... сэргэг байх** хэрэгтэй. Бид үүрэглэх, бодлоороо тэнүүчлэх, бусад зүйл рүү сатаарахаас болгоомжлох ёстой. **Залбирахад** сүнсний эрмэлзэл, сэрэмж, төвлөрөл шаардагдана. Залбирал **цөхрөлтгүй** байх хэрэгтэй. Бид гуйж, хайж, тогшсоор байх ёстой

(Лк 11:9). **Ариун хүмүүсийн төлөө гуйх** хэрэгтэй. Тэд ч тэмцэл дунд байгаа тул цэрэг нөхдийнхөө дэмжлэгийн **залбирлыг** авах хэрэгтэй.

[6:19]

Паулын **миний төлөө** гэсэн хувийн гуйлтын талаар Блейки ингэж хэлжээ:

Тахилчаас гарахааргүй санаа биш үү!
Ефесийнхэнд бүгдэд нь хүрэх нигүүлсэл бүхий Паулд тэдний залбирал хэрэг болжээ. Тэдний залбирлаар өөрт нь хэрэгтэй нигүүлсэл өгөгдөөсэй гэсэн байна.⁴⁰

Паул энэ захидлыг шоронгоос бичсэн. Тэгсэн хэрнээ эрт суллагдахын төлөө залбираач гэж гуйсангүй. Харин **сайн мэдээний нууцыг зоригтойгоор мэдүүлэхээр ам ангайхад үг өгөгдөхийн** төлөө залбируулжээ. Паул энд **нууцын** тухай сүүлийн удаа дурсаж байна. Энд үүнээс болж хүлээстэй байгаа гэж тайлбарлажээ. Гэсэн ч тэр харамсахгүй байна. Харин ч эсрэгээрээ! Тэр үүнийг улам ихээр түгээхийг хүсэж байна.

[6:20]

Элчин сайд нар ер нь баривчлагдах, хоригдохоос хамгаалагдсан дархан эрхтэй байдаг. Гэвч хүмүүс сайн мэдээ л биш бол ямар л бол ямар зүйлийг тэвчдэг. Өөр ямар ч сэдэв сэтгэлийг ингэж хөдөлгөж, ийм их дайсагнал, сэжиг төрүүлж, ийм ихээр хавчигдаж байсангүй. Тэгэхээр энэхүү Христийн төлөөлөгч хүлээсэнд байгаа элчин сайд байх нь. Ийдий үүнийг оновчтой хэлжээ:

Хамгийн дээд эрх мэдэлт улсын төлөөлөгчийг эгнэшгүй эрхэм дээд, нэн чухал яаралтай үүргийг андуурах боломжгүй итгэмжлэлээр хийхээр явж байхад баривчлан хорьжээ.⁴¹

Итгэгч иудей болон харь үндэстнүүд ижил тэгш эрхтэй, Христийг Тэргүүнээ гэж хүлээн зөвшөөрсөн нэгдмэл шинэ нийгэм болж байна гэж тунхагласнаар шашны явцуу үзэлтнүүдийн дайсагналыг төрүүлжээ.

6. Паулын хувийн мэндчилгээ (6:21-24)

[6:21, 22]

Паул өөрийнхөө байдлыг ариун хүмүүст мэдүүлэхийн тулд **Тухикийг** Ромоос Ефес рүү

илгээжээ. Тэрээр **Тухикийг Эзэн дотор хайрт дүү, итгэлт үйлчлэгч** гэж магтав. Энэ хүний тухай ШГ-д таван удаа л гардаг. Тэрээр Паултай хамт Грекээс Ази уруу явсан багийн гишүүн (Үйл 20:4). Тэр Колоссай (Кол 4:7), Ефес (Ефес 6:21-ийг 2Тм 4:12-той харьцуулна уу), магадгүй Критэд байсан Тит (Тит 3:12) рүү Паулын явуулсан зарлага байлаа. Тэрээр Паул шоронд ямар байдалтай байгааг ариун хүмүүст мэдэгдэх, мөн тэднийг шаардлагагүй айдсаас чөлөөлж, **зүрхийг** нь урамшуулах давхар зорилготой явсан.

[6:23]

Төгсгөлийн ишлэлүүдээс бид Паулын хэрэглэдэг *амар тайван* ба *нигүүлсэл* гэдэг мэндчилгээг харж байна. Энэ хоёрыг хослуулснаар уншигчдадаа бүх нигүүлслийг бялхуулахыг хүсчээ. Мөн иудей ба харь үндэстний мэндийн үгийг хамтад нь хэрэглэснээрээ иудей ба харь үндэстнүүд Христийн дотор нэг болсон гэдэг сайн мэдээний нууцыг далдуур сануулсан биз ээ. 23-р ишлэлд тэр уншигчдадаа **амар амгалан** болон **хайрыг**

итгэлийн хамт хүсэн ерөөжээ. **Амар амгалан** амьдралын бүх нөхцөл байдалд тэдний зүрх сэтгэлийг хамгаална. **Хайр** тэдэнд Бурханыг дээдлэн хүндлэх, бие биетэйгээ хамтран ажиллах чадварыг өгнө. **Итгэл** тэдэнд христитгэлийн тулаанд олзтой явах хүчийг өгнө. Энэ бүх ивээл **Бурхан Эцэг бөгөөд Эзэн Есүс Христээс** ирдэг. Энэ хоёр эн тэнцүү байгаагүй бол ийм ивээл ирэх боломжгүй байсан.

[6:24]

Эцэст нь элч **бидний Эзэн Есүс Христийг хувиршгүй чин үнэнч хайраар хайрлагч бүх хүнд нигүүлсэл** байхыг ерөөв. Жинхэнэ христитгэлт хайр байнгын юм. Тэр хайрын дөл заримдаа багасч болох ч хэзээ ч бөхөж алга болдоггүй.

Ромын шоронд хоригдож байсан эрхэм хүн тэндээс хэдийнээ алга болжээ. Аугаа элч шагналаа авч, Хайртынхаа царайг харсан. Харин бидэнд түүний захидал байгаа. Яг л анх түүний зүрх, үзэгнээс гарсан шигээ шинэхэн бөгөөд амьд хэвээрээ байна. Хорьдугаар зуун гарчихаад байсан ч бидэнд заавар, урам, ятгалга ба уриалга

өгсөөр байна.

Ефес номын тайлбараа бид Х. В. Вэбб-Пеплогийн хэлсэн үгийг чин зүрхнээсээ хүлээн зөвшөөрөн өндөрлөе:

Бурханы Номонд ийм сүрлэг, ийм гайхамшигтай бичээс өөр байхгүй биз ээ. Тиймээс ямар ч хүн, тэр байтугай Бурханы элч төлөөлөгч хүртэл бидэнд ногдсон орон зайд зохих ёсоор үнэлж чадах уу? Бид бүгд үүнд ойртон очиж, ариун амьдралын тухай сургаалыг хайгаасай гэж би хүсэж байна. Эдгээр сургаалаар бид одоо байгаагаасаа улам ариун, дээгүүр амьдарч, түүгээрээ Бурханыг алдаршуулах юм.⁴²

ФИЛИПШОЙН ЧУУЛГАНД БИЧСЭН ЗАХИДАЛ

Оршил

*“Нигүүлслийн хавтсанд үдсэн энэрлийн бяцхан
боть” –Ж.Х.Жовет*

I. БИЧЭЭСТ ЭЗЛЭХ ОНЦГОЙ БАЙР СУУРЬ

Аливаа урсгал чиглэлийн “анхны чуулган” нь тухайн хот тосгонд, дагагчдынхаа хувьд онцгой хүндтэй байдаг. Аль нэг хотод байтугай Европ тив дахинаа чуулган огт байгаагүй үед бидний мэдэх анхны чуулган гээд төсөөл дөө! Тэр нь эртний Македонийн (хойд Грек) Филиппой хотын чуулган байв. Барууны христитгэгчид, (христитгэлийн үр жимсийг амсан байгаагаа мэдсэн бол үл итгэгчид ч ялгаагүй) Паул “Македоний дуудлага”-ыг дагаж, Ромын Эзэнт гүрэнд сайн мэдээ тунхаглахдаа зүүн зүг биш харин баруун тийш явсанд баярлан баясах учиртай. Сайн мэдээ эхлээд Европт түгээгүй байсан бол өнөөдөр Ази тив христитгэгч илгээлтийн эздийг Европ болон Умард Америк уруу илгээж байх байсан биз ээ.

Филиппойн чуулган Паулд дахин дахин тусламж илгээдэг өгөөмөр чуулган байв. Хүний нүдээр харахад энэхүү “талархлын захидал” -ыг илгээх шалтгаан болсон гэж хэлж болох юм.

Гэхдээ Филиппой ном талархлын захидлаас хавьгүй илүү агуу зүйл билээ. Энэ нь жинхэнэ баяр хөөрийн захидал бөгөөд –“баяр хөөр”, “баярлах” гэдэг үг энэ дөрвөн бүлэгт 12 удаа гардаг. Паул амар сайхан цагт ч, хэцүү бэрх үед ч баяр хөөртэй байхад суралцсан (4:11). Энэ “бялхсан баяр хөөрийн” захидалд бяцхан зөрчил, анхааруулга бас бий.

Христитгэгчдийн баярлан хөөрөх гол шалтгаан нь Бурханы Хүү энэ дэлхийд хүн болж ирсэнд, тэр ч бүү хэл боолын дүрийг авсанд оршино! Тэрээр эдгээх, заах ажил хийгээд зогссонгүй үхэх хүртлээ, тэгэхдээ загалмайн үхэл хүртэл явсан. Энэ аугаа үнэнийг Филиппой 2:5-11-д сайхан илэрхийлжээ. Үүнийг Паулын иш татсан эсвэл өөрөө зохиосон эртний магтуу гэж олон хүн үздэг. Төлөв даруу болсноор эв нэгдэлтэй байх тухай энэ ишлэл сургаж байна. ШГ-нд сургаал хэзээ ч үүрэг хариуцлагаас салангид байгаагүй, харин сүүлийн үеийн

чуулганы хүмүүс ийм болж, харамсмаар үр дагавар гарсан.

Филиппой бол Бурханы бүх үгэн дотроос хамгийн баяр хөөртэй, сэтгэл татсан номуудын нэг.

II. ЗОХИОГЧ

Ихэнх судлаачид Филиппой номыг маргаангүй Паул бичсэн гэж үздэг тул бидэнд бүрэн нотолгоо бий гэж үзэж байна. Зарим судлаач Филиппой номыг *хоёр* захидлын нийлбэр эсвэл ядаж л боолын тухай хэсгийг (2:5-11) нэмж оруулсан гэдэг. Эдгээр үзэл онолыг нотлох эх бичээс байдаггүй.

Гадаад нотолгоо их байна. Захидлыг нэлээд эрт иш татан Паул бичсэн гэж үздэг зарим хүн гэвэл Игнатиус, Ромын Клемент, Поликарп, Иренаеус, Александрын Клемент болон Тертуллиан нар юм. Марсионы “бичээс” ба Мураторийн бичээсийн хоёуланд энэ номыг Паул бичсэн гэдэг.

Паул, 1:1-д тодорхой хэлснээс гадна найрлага, үг хэллэг тэр чигээрээ Паулынхтай тохирч байна.

Паулыг бичээгүй гэх маргаан үндэслэл тун багатай. Тухайлбал 1:1-д дурддаг “харгалзагчид болон үйлчлэгчид” Паулын цаг үеэс хойш гарч ирсэн нэр цол гэдэг. Хэрэв бид хожим гарсан санааг 1-р зуун уруу оруулах гэвэл үнэхээр тийм болно. Гэхдээ Паул *харгалзагчид (епископой: гр. “удирдагч, захирагчийн ажил” гэснээс гаралтай)* гэдэг үг Пасторын буюу Хоньчны захидлууд болон Үйлс 20:28-д хэрэглэсэн *ахлагч* гэдэг үгтэй ижил утгатай юм. Мөн ганц чуулганд *олон тооны* харгалзагчидтай байсныг тэмдэглэн хэлэх учиртай.

Х.А.А Кеннеди *дотоод нотолгоог* гайхалтай дүгнэн хэлжээ:

Паулын захидал дотроос үүн шиг түүний тамгаар тамгалагдсан нь ховор. Энд хуулбарлахын аргагүй нээлттэй байдал, торгон мэдрэмж, чин сэтгэлээ дэлгэснийг харж болно.¹

Ш. БИЧИГДСЭН ОГНОО

Ефес, Колоссай, Филемон номуудын нэгэн адил Филиппой номыг шоронд байхдаа бичсэн тул энэ ном “Шоронгоос бичсэн захидал”-д багтдаг. Гэхдээ бусад гурван захидлыг бараг нэг цаг үед (МЭ 60 он) бичиж илгээсэн боловч Филиппой номыг жаахан хожуу бичсэн нь тодорхой байна. Марсион Паулыг филиппойчуудад Ром хотоос бичсэн гэж тодорхой хэлдэг бөгөөд энэ нь Паул Ромд байсан гэдэг 1:13, 4:22 ишлэлтэй таарч байна. Паул Ромд хоёр жил хоригдсон бөгөөд Филиппой номыг дээрх цаг үеийн төгсгөлөөр бичсэн гэсэн санаа энд тэнд цухуйдаг. Жишээ нь, 1:12-18 ишлэлд Паул ирээд Мөнхийн хотод тодорхой хугацаагаар номлож байсан мэтээр бичжээ. Паулын хэрэг шийдэгдэх дөхөж байгаа нь (эерэгээр буюу суллагдаж мэдэх) 1:12, 13, 19, 23-26 ишлэлээс харагдаж байна.

Эдгээр баталгаа, мөн захидал бичих цаг хугацаа, уулзалт, элчид илгээсэн мөнгөн тусламж өгсөн хугацаа зэргээс харахад уг захидлыг МЭ 61 оны сүүлээр бичсэн байхаар байна.

IV. ТҮҮХЭН НӨХЦӨЛ, ХӨНДСӨН СЭДЭВ

Элч Паул хоёр дахь илгээлтийн аянаараа Трой хүртэл явж ирсэн нь христитгэлийн үйлчлэлийн түүхэнд дурсгалт өдөр байв. Трой хот нь Бага Азийн баруун хойд эрэгт, Грекийн тушаа Эгейн тэнгисийн эрэг дээр байдаг байв. Нэгэн шөнө Паулд үзэгдэл үзэгдэж Македонийн нэгэн эр өөрөөс нь “Македонид ирж бидэнд туслаач” (Үйл 16:9) гэж гуйжээ. Тэр даруй Паул Тимот, Лук болон Силас нарын хамт Македони уруу явахаар далайд гарчээ. Тэд Неаполд ирснээр анх удаагаа *Европд* хөл тавьж тэндээсээ Филиппой уруу газраар аялжээ. Филиппой хот тэр үед Ромын колони байсан бөгөөд Ромын захирагчид эрх барьж, тэндхийн оршин суугчдад Ромын иргэний эрх ямбыг олгож байв.

Амралтын өдөр сайн мэдээ тунхаглагчид гол уруудан явж байгаад, тэнд тогтмол залбирахаар цугладаг хэсэг эмэгтэйчүүдтэй таарав (Үйл 16:13). Тэдний дунд Туатэйр хотоос ирсэн, нил ягаан өнгийн бөс даавуу худалддаг Лудиа гэгч эмэгтэй байлаа. Тэрээр сайн мэдээ сонсоод

хүлээн авч, даруй Европ тивийн хамгийн анхны христитгэгч болов.

Гэвч Паул Филиппойд үргэлж амар тайван байсангүй. Төлөгчийн (ирээдүйд болох зүйлийг урьдчилан хэлдэг) муу сүнсэнд эзэмдүүлсэн нэгэн бүсгүй Эзэний зарц нартай тааралдаж хэсэг хугацаанд тэднийг дагаж: “Эдгээр хүмүүс бол Хамгийн дээд Нэгэний үйлчлэгчид бөгөөд бидэнд авралын замыг тунхаглахаар ирсэн юм” гэж чанга хашхирсаар явав (Үйл 16:17). Муу сүнсэнд эзэмдүүлсэн хүнээр гэрчлүүлэн зарлуулахыг хүсээгүй тул элч муу сүнсийг тэр эмэгтэйгээс гар гэж тушаав. Тэгэхэд тэр эмэгтэйн мэргэ төлгөөр ашиг олдог байсан эзэд нь болсон явдлыг хараад Паулд асар ихээр уурласан. Тэд Паул Силас хоёрыг Ромын эрх баригч нарт хүргэхээр олон хөлийн газар уруу чирч аваачжээ. Эрх баригчид тэднийг зодож жанчаад шоронд хорь гэж тушаав.

Филиппойн шоронд юу тохиолдсоныг бид бүгд мэднэ. Шөнө дунд Паул Силас хоёр Эзэнд хандан залбирч, магтан дуулж байтал гэнэт хүчтэй газар хөдлөлт болж, шоронгийн бүх хаалга нээгдэж, шоронгийн хоригдлуудын гав

дөнгө нь суларсан. Хуяг хоригдлуудыг оргожээ гэж бодоод амиа хорлохыг завдтал Паул түүнд хоригдол оргоогүйг хэлжээ. Тэгтэл хуяг “Ноёд оо, аврагдахын тулд би юу хийх ёстой вэ?” хэмээн хашхирчээ. “Эзэн Есүс Христэд итгэгтүн. Чи болон гэрийнхэн чинь ч аврагдана” (Үйл 16:31) гэж сэтгэлд хоногшсон хариу өглөө. Бурханы нигүүлслээр Филиппой хотод бас нэг шагнал гардах үйл явдал боллоо. Өглөө нь, орон нутгийн эрх баригчид Паул болон түүний хамтрагчийг хотоос аль болох хурдан гарч явахыг шаарджээ. Паул татгалзав. Тэрээр тэдэнд Ромын иргэнийг шударга шүүхээр оруулалгүй занчиж шоронд хорьсоныг нь сануулсан. Эрх баригчид хотоос гарч явахыг удаа дараа ятгасны эцэст Паул Силас нар эхлээд Лудиагийн гэрт очиж, тэндээсээ замаа хөөжээ (Үйл 16:40).

Арваад жилийн дараа Паул филиппойчуудад захидал бичсэн юм. Тэр дахиад шоронд хоригдсон байв. Филиппойчууд Паулыг шоронд байгааг сонсоод түүнд мөнгөн тусламж илгээжээ. Энэхүү бэлгийг Паулд хүргэх үүргийг Епафродитод оноов. Үүнийг хүргэж өгсний дараа тэрээр элчид зовлон зүдгүүртэй үед нь

туслая гэж тэнд хэсэг хугацаагаар үлдсэн байдаг. Энэ үүргээ биелүүлж яваад Епафродит өөрөө өвдөж, үхлийн ирмэгт ирсэн юм. Гэвч Бурхан түүнийг өршөөж, эрүүл болгон босгожээ. Тэр одоо Филиппой уруу, өөрийн гэр чуулганд буцахад бэлэн болж элч түүгээр энэхүү талархлын захидлыг өгүүлж байна.

Филиппой ном бол Паулын захидлуудаас хамгийн хувьчилсан, дотно сэтгэлээ илэрхийлсэн захидлуудын нэг юм. Энэ чуулган түүний сэтгэлд маш онцгой байр суурь эзэлж байгаа нь энэ захидлаас тодорхой харагддаг. Бид үүнийг уншаад элч болон түүний үүсгэсэн чуулганы хооронд маш дотно холбоо байгааг олж мэднэ.

ТОЙМ

- I. Паулын мэндчилгээ, магтаал болон залбирал (1:1-11)
- II. Паулын шорон дахь нөхцөл байдал, ирээдүйн төлөв, тэсвэрлэн туулахыг гуйсан хүсэлт (1:12-30)
- III. Христийн даруу байдал болон золиосын үлгэр дууриаллаар нэгдэх тухай уриа (2:1-16)

- IV. Паул, Тимот, Епафродит гурвын христэд үлгэр жишээ (2:17-30)
- V. Хуурамч багш нарын эсрэг сануулга (3:1-3)
- VI. Паул Христийн төлөө өв залгамжлалаасаа татгалзаж, хувийн ололт амжилтаа үгүйсгэв (3:4-14)
- VII. Элчийн үлгэр жишээгээр тэнгэрлэг алхаанд дуудсан уриа (3:15-21)
- VIII. Эв эе, харилцан туслалцаа, баяр хөөр, тэвчээр, залбирал ба оюун бодолдоо сахилга баттай байх тухай уриалга (4:1-9)
- IX. Ариун хүмүүсийн өгсөн мөнгөн тусламжийн төлөөх Паулын талархал (4:10-20)
- X. Төгсгөлийн мэндчилгээ (4:21-23)

I. Паулын мэндчилгээ, магтаал болон залбирал (1:1-11)

[1:1]

Энэ захидлын эхэнд Паул Тимот нар хамт байна. Гэхдээ Тимот захидлыг бичихэд нь

тусалсан гэсэн үг биш. Тимот анх Филиппой хотод Паулыг дагаж очсоноор тэндхийн ариун хүмүүс түүнийг таньдаг болжээ. Элч **Паул** уг захидлыг бичиж эхлэхэд **Тимот** түүнтэй хамт байна.

Одоо Паул хөгширч, (Флм 9) харин Тимот идэр насанд хүрчээ. Тиймээс хөгшин залуу хоёр Хамгийн шилдэг Эзэнд үйлчлэх буулганд нэгдэн оржээ. Жовет үүнийг “Энэ бол эрч хүч хийгээд туршлага, тэмүүлэл хийгээд мэргэн ухаан, хайрын найдвар болоод чимээгүйхэн боловч арвин баталгаа бүхий хавар намрын нэгдэл юм.” гэж сайхан хэлжээ.²

Хоёуланг нь **Есүс Христийн боол** гэж тодорхойлжээ. Хоёулаа Эзэндээ хайртай байлаа. Загалмайн хүлээс тэднийг, Аврагчдаа мөнхөд үйлчлэхээр уяжээ. Энэ захидал **Филиппойд байгаа Христ Есүс доторх бүх ариун хүмүүст болон харгалзагчид, үйлчлэгч нарт** ханджээ. *Бүх* гэдэг үг энэ захидалд ойр ойрхон давтагддаг. Паулын хайрын сэтгэл Эзэний хүмүүст хандаж байлаа.

Филиппойд байгаа Христ Есүс доторх ариун хүмүүс гэдэг нь итгэгчдийн давхар байр

суурийг хэлжээ. Тэд сүнсний хувьд **Христ Есүсийн** дотор Бурханаар тусгаарлагдсан байв. Харин газарзүйн байршлын хувьд **Филиппой** хотод байлаа. Тэд нэг цагт хоёр газар байна!

Тэгээд элч **харгалзагчид болон үйлчлэгч нарт** ханджээ. **Харгалзагчид** гэж, Бурханы хонин сүргийг хоньчилдог, бурханлаг үлгэр дууриаллаар удирдан дагуулагсад болох ахлагчид. **Үйлчлэгч нар** гэж чуулганы санхүү мөнгө зэрэг материаллаг ажил хэрэгт голлон санаа тавьдаг үйлчлэгч нарыг хэлж байна. Чуулганд –**ариун хүмүүс, харгалзагчид болон үйлчлэгч нар** гэсэн 3 бүлэг л байжээ. Хэрэв удирдах санваартан хүн байсан бол Паул түүнийг дурьдах байсан. Тэрээр зөвхөн **харгалзагчид** (олон тоо) болон **үйлчлэгч нар** (мөн олон тоо) гэж хэлсэн байна.

Эндээс бид эхэн үеийн чуулганы амьдралын гайхалтай энгийн байдлыг харж байна. Эхлээд **ариун хүмүүсийг**, дараа нь тэдний *сүнсний чиглүүлэгчдийг*, хамгийн сүүлд тэдний *түр хугацааны үйлчлэгч* нарыг хэлжээ. Тэгээд л боллоо!

[1:2]

Паулын мэндчилгээ ариун хүмүүст **нигүүлсэл...болон амар тайвныг** ерөөдөг онцлогтой. Нигүүлсэл гэдэг нь аврагдах үед нүгэлтэнд өгөгддөг нигүүлслийг биш харин нигүүлслийн хаан ширээнээс хэрэгцээтэй цагт туслуулахаар олдог нигүүлслийг хэлж байна (Евр 4:16). Түүнчлэн Паулын тэдэнд хүсч байгаа **амар тайван** нь аль хэдийнээ тэднийх болсон амар тайвныг биш харин залбирал болон талархал гуйлтаар хүлээж авдаг Бурханы **амар тайвныг** хэлж байна (4:6, 7).

Энэ хоёр ерөөл хоёулаа **бидний Эцэг Бурхан хийгээд Эзэн Есүс Христээс** ирдэг. Элч Хүүг Эцэгийнх нь нэгэн адил хүндэлж байна (Иох 5:23). Паулын хувьд Есүс Христ Бурхан гэдэгт эргэлзэх аргагүй.

[1:3]

Одоо Паул талархлын дуу дуулж байна. Элчийн хувьд энэ бол шинэ зүйл биш. Паул Силас хоёр анх тэнд очоод хоригдож байхдаа тэдний дуу Филиппойн шоронд цуурайтаж байсан. Түүний бие эдгээр үгсийг бичиж байхдаа Ромд хоригдож байсан болов уу. Тэгсэн ч

“шөнөөр магтаал өргөсөн” хэвээр байна. Мятаршгүй Паул! Филиппойчуудын талаарх **бүх дурсамжиндаа** түүний зүрх талархлаар дүүрч байв. Тэд түүний итгэлийн хүүхдүүд байгаад зогсохгүй үлгэр жишээ чуулган болохоо олон талаар баталсан.

[1:4]

Тэрээр филиппойчуудын талаар **залбирах бүрдээ** үргэлж **баяр хөөртэйгөөр гуйлтаа өргөдөг** байлаа. Тэдний төлөө залбирах нь түүний хувьд уйтгартай хоосон ажил биш харин туйлын их баяр хөөр байв. Паул залбирлын хүн байсан нь эндээс болон Паулын захидлуудад гардаг үүнтэй төстэй олон ишлэлээс харагддаг. Түүнийг Бурханд гайхамшигтайгаар ашиглагдсаны учрыг олохын тулд үүнээс цаадахыг хайх хэрэггүй. Түүний аяллын цар хүрээ, түүний таньдаг христитгэгчдийг бодохоор тэд бүгдэд ямар ойр дотно, хувьчилсан анхаарал тавьдаг байсан нь гайхмаар.

[1:5]

Талархах тодорхой шалтгаан нь тэд **сайн мэдээг сонссон анхны өдрөөс өнөөг хүртэл** үүн дотор **хамтран зүтгэж** байгаад оршино. **Хамтран зүтгэнэ** гэдэг нь санхүүгээр туслахыг хэлж байж болох юм. Гэхдээ цаашлаад залбирлаар дэмжих болон сайн мэдээг тараахад бүх зүрхээ зориулахыг бас хэлж байгаа. Паул **анхны өдөр** гэхээр Филиппойн чуулганд энэхүү захидлыг уншихад нөгөө шоронгийн хуяг амьд байсан болов уу гэж бодогдуулж байна. Тэгвэл, Паулын Филиппойн итгэгчдэд өгсөн энэ танилцуулга нь түүний зүрхний утсыг хөндсөн байж таарна.

[1:6]

Христитгэлийн амьдралынх нь гараа сайн байсныг элч бодохдоо энэхүү **сайн үйлийг эхлүүлсэн** Бурхан үүнийгээ төгс төгөлдөр болгож төгсгөнө гэдэгт **бат итгэж** байна.

Түүний эхлүүлсэн сайн ажлыг

Түүний хүчит мутар төгсгөх болно

Түүний амлалт хэзээд биелдэг, Амен.

–Август М.Топлади

Сайн үйл гэдэг нь тэдний авралыг эсвэл сайн мэдээг дэлгэрүүлэх ажилд санхүү мөнгөөр идэвхтэй туслахыг хэлсэн байж болох юм. **Христ Есүсийн өдөр** гэдэг нь Түүний дахин ирж Өөрийн хүмүүсийг тэнгэрийн улс дахь гэр рүүгээ авч явах цагийг мөн Христийн шүүлтийн сэнтийг буюу Түүний төлөө хийсэн ажил шалгагдаж, шагнагдахыг хэлсэн байж болох юм.

[1:7]

Паул филиппойчуудын төлөө талархаж байгаагаа зөв гэж үзэв. Филиппойчууд түүнийг шүүхдэж байхад ч, хоригдож байхад ч, сайн мэдээг **батлан хамгаалан** аялж явахад нь ч хамт үнэнчээр бат зогссоныг Паул **зүрхэндээ** нандигнан хадгалдаг байжээ. **Сайн мэдээг хамгаалах** гэдэг нь шүүмжлэгчдэд хариу өгөхийг, **сайн мэдээг батлах** гэдэг нь итгэсэн хүмүүсийн зүрхэнд үгийг улам бат суурилуулахыг хэлж байна. В. Е. Ваин хэлэхдээ: “Сайн мэдээ нь дайснаа түлхэн унагаж, найз нөхөртөө хүч өгдөг”³ гэжээ. **Нигүүлсэл** гэдэг нь ширүүн эсэргүүцлийг сөрөн Эзэний ажлыг хийж

явахад бидний авах зохисгүй хүч Бурханаас өгөгдөхийг хэлж байна.

[1:8]

Тэдний итгэмжтэй хамтран ажилласныг нь бодохдоо элч тэднийг **үгүйлж** байна. Тэднийг **Христ Есүсийн сэтгэлээр хэрхэн** санаж байгааг **Бурхан гэрчилнэ** гэжээ. Паул еврей хүн атлаа харь үндэстнүүдэд бичиж байгаа гэж бодохоор энэхүү хайрын илэрхийлэл ер бусын аж. Эртнээс улбаатай үзэн ядалтыг Бурханы нигүүлсэл үгүй хийж, одоо тэд бүгд Христ дотор нэг болов.

[1:9]

Талархал нь одоо залбирал уруу хөтөлж байна. Паул тэдэнд эд баялаг, ая тух, эсвэл зовлон бэрхшээлээс ангид байдлыг гуйх болов уу? Үгүй ээ, харин тэдний **хайр** жинхэнэ мэдлэг **ба бүх ойлгоцоор** тасралтгүй нэмэгдэхийн төлөө гуйсан. Христитгэлийн амьдралын үндсэн зорилго нь Бурханыг **хайрлах** болон бусдыг **хайрлах** юм. Гэвч хайр нь сэтгэл хөдлөл төдий зүйл биш. Эзэндээ үр дүнтэй үйлчлэхийн тулд бид оюун ухаанаа ашиглан **ойлгоцоо**

дасгалжуулах хэрэгтэй. Эс бөгөөс бидний хүчин зүтгэл үр дүнгүй болно. Тиймээс Паул энд филиппойчууд зөвхөн христитгэлт хайрыг харуулсаар байхын төлөө залбираад зогсохгүй, тэдний **хайр** бүрэн дүүрэн **мэдлэг** болон **бүрэн ойлгоцоор** дасгалжихын төлөө залбирч байна.

[1:10]

Ийнхүү гэгээрсэн хайр нь **аль нь сайн болохыг** ялган таних чадвартай болно. Амьдралд зарим зүйл нь сайн байхад зарим нь илүү сайн байдаг. Сайн нь онцын дайсан болдог тал бий. Илүү үр нөлөөтэй үйлчлэхийн тулд эдгээрийг ялгаж салгадаг байх хэрэгтэй.

Ийнхүү гэгээрсэн хайр нь эргэлзээтэй болон илт буруу зүйлээс зайлсхийх боломжтой болгоно. Паул тэднийг **Христийн өдрийг хүртэл цэвэр**⁴ буюу ил тод, буруутгах юмгүй байхыг хүсэн ерөөж байна. **Гэм зэмгүй** байна гэдэг огт нүгэлгүй байхыг хэлээгүй. Бид бүгдээрээ нүгэл үйлддэг боловч буруутгах юмгүй хүн гэж гэмээ улайж, болиод, хохироосон хүмүүсээсээ уучлалт гуйж, шаардлагатай бол нөхөн төлбөр хийдэг хүнийг хэлнэ. Зургадугаар ишлэлд мөн дурьдсан

Христийн өдөр гэдэг нь шүүрэлт болон дараа нь итгэгчдийн ажлыг шүүх, өдрийг хэлж байна.

[1:11]

Элчийн өргөсөн залбиралд гарч байгаа сүүлчийн гуйлт нь христитгэгчид **зөвт байдлын үр жимсээр** буюу зөвт байдлаас гардаг **үр жимсээр дүүрэн** байх, өөрөөр хэлбэл зөвт амьдралыг бүрдүүлж байдаг бүх христчин чанаруудаар дүүрэн байхыг хүсчээ. Эдгээр чанарын эх үндэс нь **Есүс Христ** бөгөөд зорилго нь Бурханы **магтаал болоод алдрын төлөө юм**. Паулын энэхүү гуйлт Исаиа 61:3-р ишлэлтэй яг адилхан байна: тэднийг “**(Бурханы магтаал болоод алдрын төлөө)** Түүнийг алдаршуулахын тулд, **Эзэний (Есүс Христээр)** суулгац, **(зөвт байдлын үр жимсээр дүүрэн)** үнэн зөвийн царснууд гэж нэрлэх болно” хэмээсэн.

Лейман Штрауссын бичсэнээр ‘үр жимс’ гэдэг үг бидний Христтэй харилцах харилцаа болон Түүний биднээс харж хүлээдэг зүйлтэй ойр холбоотой. Усан үзмийн мөчрүүд үр жимс ургуулах жамтай.”⁵

II. Паулын шорон дахь нөхцөл байдал, ирээдүйн төлөв, гэсвэрлэн туулахыг гуйсан хүсэлт (1:12-30)

[1:12]

Залбирал дууслаа. Дараа нь Паул ивээлээ буюу хоригдсоны улмаас гарсан ашгуудыг тоочиж байна. Энэ хэсгийг Жовет “Сохорсон биш завшив” гэж нэрлэжээ.

Түүний шоронд хоригдсон нь хүмүүсийн боддог шиг саад бэрхшээл бус харин ч **сайн мэдээг** дэлгэрүүлэх **үлэмж ахиц дэвшил** болсныг тэрээр **ах дүү нараа мэдээсэй гэж хүссэн**. Бурхан чөтгөрийн болон хүмүүсийн хорон муу төлөвлөгөөг хэрхэн дарж, харахад эмгэнэлтэй зүйлийг ялалт болгож үнс нурмаас ч гоо үзэсгэлэнг бий болгож чаддагийг харуулсан бас нэгэн гайхалтай жишээ энэ байна. “Хүн хорон муу боловч Бурханд арга зам байдаг.”

[1:13]

Юуны өмнө Паулын **хүлээс Христийн төлөө** гэдэг нь бүгдэд **илэрхий** болжээ. Тэр ямар нэгэн гэмт хэрэг юмуу хорон мууг хийснээсээ биш

харин Христийг гэрчилснээсээ болж хоригдсон нь олонд илт болсон гэсэн үг.

Түүний **хүлээсний** жинхэнэ шалтгаан **захирагчийн бүхэл ордон** болон бусад газар илэрхий болсон байна. **Захирагчийн ордон** гэдэг нь нэг бол (1) Эзэн хааны амьдарч байгаа **ордныг** хамгаалдаг Ромын цэргүүдийг хэлж байж болно. Эсвэл (2) **Ордныг** бүхэлд нь хэлж байж болох юм. **Ордон** гэж ордны бүх оршин суугчдыг хэлнэ. Аль нь ч бай, Паул шоронд хоригдсон нь Ромын эзэнт гүрний төлөөлөгчдөд гэрчлэл болсон гэж хэлж байна.

Т.В.Друри:

Хоригдлын гарт зүүсэн Ромын шоронгийн хүлээс нь Христийн төлөө тэвчээртэй цөхрөлтгүй зовсон түүний түүхийг маргааш нь Нерод шадарлах хүнд ярьж өгөх сонсогчийг дэргэд нь заавал байлгаж байв.⁶ гэж бичжээ.

[1:14]

Шоронд хоригдсоноос болж гарсан хоёр дахь үр ашиг нь бусад христитгэгчид Эзэн Есүсийг гэрчлэхдээ айж шантрахгүй байх зүрх зориг

нэмэгдсэнд оршино. Хавчлага ихэнхдээ дуугүй ноомой хүмүүсийг зоригт гэрчлэгчид болгон өөрчлөгдөхөд хүргэдэг.

[1:15]

Зарим нь атаархал, өрсөлдөх сэтгэлээр хийж байжээ. Тэд **Христийг атаархал** болон өрсөлдөөний улмаас тунхаглаж байв.

Бусад нь элчид туслах гэсэн чин ариун сэтгэл, **сайн санаанаасаа** Христийг тунхаглаж байв.

[1:16]

Атаархуу тунхаглагчид үүнийг хийснээрээ шоронд байгаа Паулыг илүү зовооно гэж бодож байв. Тэдний тунхаглаж буй мэдээ нь сайн боловч санаа нь муухай байжээ. Христигэлийн үйлчлэлийг махан биеийнхээ хүч чадалд түшиглэж хомхой сэтгэл, өрсөлдөөн, бардам зан болон атаархах сэдлээр хийж байсан нь харамсалтай юм. Үүгээр бидэнд Эзэнд үйлчлэхдээ сэдлээ шалгаж байх нь чухал гэдгийг харуулж байна. Бид үүнийг өөрсдийгөө дөвийлгөн харуулах, эсвэл шашны бүлэглэлийн

төлөө, эсвэл бусад христитгэгчдийг ялан дийлэхийн тулд хийх учиргүй.

Энэ бол бидний хайр, мэдлэг ба ойлгоцоор дасгалжихын чухлыг сануулсан сайн жишээ байна.

[1:17]

Бусад нь Паул сайн мэдээг хамгаалахаар зогсож байгааг мэдэн сайн мэдээг цэвэр бөгөөд чин сэтгэлийн **хайраар** тунхаглаж байлаа. Тэдний үйлчлэлд ямар ч хувиа хичээх, урсгал чиглэлээ дөвийлгөх, харгислах явдал байгаагүй. Тэд Паулыг **сайн мэдээний** төлөө бат зогссоноосоо болж хоригдож байгааг сайн мэдэж байв. Тиймээс тэд түүнийг хоригдож байх үед энэ ажлыг үргэлжлүүлэхээр шийджээ.

[1:18]

Паул зарим хүний буруу хандлагаас болж гутрахгүй гэж шийджээ. **Христ** аль ч замаар **тунхаглагдаж байгаа нь** түүний хувьд баярлан баясах шалтгаан болсон.

Ийм хэцүү нөхцөл байдалтай байсан ч Паул өөрийгөө өрөвдөж бусдаас анхаарал халамж, хөөрхийлөл хайгаагүй. Харин ч тэрээр Эзэний баяр хөөрөөр дүүрч, уншигчидаа ч баярлан баясахыг уриалсан.

[1:19]

Түүний ирээдүйн төлөв өөдрөг байна. Элч энэ бүхэн эцэстээ түүнийг **суллахад** хүргэхийг мэдэж байв. Бурхан түүнийг филиппойчуудын залбирал болон **Есүс Христийн Сүнсний туслалцааны үйлчлэлээр** чөлөөлнө гэсэн утгатай байна. Паул хэдхэн итгэгчдийн залбиралд ач холбогдол өгч найдвар тавьж байгаа нь гайхалтай. Тэрээр тэднийг Ромын зорилго, эрх баригч хүчийг ч няцаах чадалтай гэж үзэж байна. Үнэхээр тийм. Христитгэгчид залбирлаар улс үндэстний хувь заяанд нөлөөлж, түүхийг өөрчилж чадна. **Есүс Христийн Сүнсний туслалцаагаар** гэдэг нь Ариун Сүнс хүчээ хангаж өгөхийг хэлж байна. Ер нь, “нөхцөл байдал ямар ч байсан, итгэгчдийг тууштай бат зогсоох Сүнсний хүчний эх үүсвэрийг” хэлжээ.

[1:20]

Тэрээр христигэгчдийн залбирал болон Ариун Сүнсний туслалцааг бодохдоо өөрөө хэзээ ч **ичихгүй** харин ч Христийг үргэлж айдасгүйгээр, яруу тодоор гэрчлэх хүсэл **найдвараа** илэрхийлж байна.

Шүүхийн үйл явц яаж ч эргэсэн, өөрөөр хэлбэл суллагдах хийгээд **үхэлд** тушаагдахын аль нь ч бай **түүний бие дотор Христ өргөмжлөгдөх** нь түүний хүсэл байна. **Өргөмжлөгдөнө** гэдэг нь Христийг илүү агуу болгоно гэсэн үг биш юм. Тэрээр аль хэдийн агуу бөгөөд бид юу ч хийсэн Түүнийг илүү агуу болгож чадахгүй. Харин өргөмжилнө гэдэг нь бусад хүнийг Христийг хүндэлдэг буюу магтдаг болгохыг хэлж байна. Христ хэрхэн бидний биеэр дамжин өргөмжлөгдөж болохыг Гаи Кинг ингэж илэрхийлжээ:

... Түүнийг баяр хөөртэйгөөр гэрчлэх уруул,
Түүнд баяр хөөртэйгөөр үйлчлэх гар,
Түүний аянд баяртай нь аргагүй явах хөл,
Түүний хаанчлалын төлөө залбирахаар
баяртайгаар сөгдөх өвдөг, бие биенийхээ

ачаанаас баяртайгаар үүрэлцэх мөрөөр өргөмжлөгдөнө.⁷

Христ бас бидний махбодын **үхлээр дамжин өргөмжлөгдөж болно**. Түүнд үйлчилсээр элэгдэх бие, хэрцгий жаданд сүлбэгдэж, чулуугаар шидүүлж, модонд өлгөгдөн шатсан биеэр өргөмжлөгдөж болох юм.

[1:21]

Энд Паулын амьдралыг үзэх үзэл товч гарч байна. Тэрээр мөнгө, алдар нэр эсвэл өөрийн таашаалын төлөө амьдраагүй. Түүний амьдралын зорилго нь Эзэн Есүсийг хайрлаж, Түүнд мөргөн үйлчлэх байв. Тэрээр **Христийн** амьдралаар амьдрахыг хүссэн. Тэрээр Аврагчийг амьдралаараа дамжуулан амьдруулахыг хүссэн.

Үхэх нь ололт юм. Үхэх гэдэг бол Христтэй мөнхөд хамт байж Түүнтэй адил болохыг хэлнэ. Энэ нь Түүнд нүгэлгүй зүрх, хэзээ ч буруу зам уруу орохгүй хөлөөр үйлчлэхийг хэлнэ. Бид ер нь бол үхлийг ололт гэж хардаггүй. Харамсалтай нь өнөө үед хүмүүс “дэлхийн ололтын төлөө амьдарч, үхэл нь ололт амжилтын төгсгөл” гэж боддог мэт. Жовет хэлэхдээ: “Элч Паулын хувьд

үхэл гэдэг бол бүх баялаг нь үтэр түргэн ялзарч алга болдог харанхуй харгуй байгаагүй. Харин энэ бол нигүүлсэнгүй шилжилт буюу гэрэл уруу дагуулах далд зам байсан”⁸ гэжээ.

[1:22]

Хэрэв Бурхан Паулыг махбодод нь амьдруулахыг хүсэж байвал түүний хувьд энэ нь **үр жимстэй ажиллах** боломж ажээ. Тэрээр Эзэний хүмүүст үргэлжлүүлэн туслах боломжтой болно. Гэвч Аврагч уруугаа явах уу эсвэл мөн л багагүй сэтгэл хорогдох хүмүүстэйгээ хамт дэлхий дээр үлдэж Эзэндээ үйлчлэх үү гэдгээ шийдэхэд хэцүү байв. Тэрээр алийг нь **сонгохоо** мэдэхгүй байлаа.

[1:23]

Хоёр талаас шахагдаж байна гэдэг нь тэнгэрийн улсын гэр рүүгээ явах эсвэл дэлхий дээр Христ Есүсийн элчээр үлдэх **хоёрын** нэгийг сонгох шаардлага тулгараад байгаагаа хэлж байна.

Тэрээр **одож, Христтэй хамт байхыг** хүсэн тэмүүлж **үүнийг илүү дээр** гэж үзэж байв.

Зөвхөн өөрийн хүсэл сонирхлыг бодвол эргэлзээгүй энэ замыг сонгох байв.

Паул сүнс унтдаг гэдэг онолд итгэдэггүй байсныг анзаараарай. Тэрээр христитгэгчид үхээд **Христтэй хамт байхаар оддог**, Эзэний оршихуйг ухамсартайгаар мэдрэн баясан баярладаг гэдэгт итгэдэг байв. Тэрээр өнөөдрийн зарим нэгний ярьдаг шиг: “Амьдрах нь Христ, нойрсох нь ололт юм” эсвэл “Эндээс одож, нойрсох нь илүү дээр юм” гэж хэлсэн бол ямар утгагүй байх байсан бол. “Нойрсох” гэдэг үгийг ШГ-нд итгэгчдийн *бие* үхэхийг хэлэхэд хэрэглэдэг (1Тс 4:14) бөгөөд сүнсний талаар хэлээгүй. Сүнс нойрсох гэдэг бол үлгэр домог.

Үхлийг Аврагч ирэх үетэй андуурч болохгүйг мөн анхаараарай. Үхэх үед бид **Түүнтэй хамт байхаар** явна. Шүүрэлтийн үед Тэрээр бидэн рүү ирнэ.

[1:24]

Филиппойчуудын **тусын тулд** Паул дэлхий дээр дахиад хэсэг байх нь **илүү чухал байв**. Энэхүү өгөөмөр сэтгэлтэй хүний хувиа хичээдэггүй зан чанар хүний сэтгэлд хүрэхгүй

байхын аргагүй. Тэр өөрийн ая тух, биеийн амрыг харалгүй, харин Христийн ажлыг бүхнээс дээгүүр тавьж, Түүний хүмүүсийн сайн сайхныг бодсон.

[1:25]

Тэрээр дэлхийд үлдэж ариун хүмүүст зааж, тайвшруулж, урамшуулах хэрэгцээ байгаад **итгэлтэй байна** гээд Паул энэ удаад үхэлд тушаагдахгүй гэдгээ мэдэж байжээ. Тэр яаж мэдэв? Тэрээр Эзэнтэй маш ойр амьдарч байсан тул Ариун Сүнс түүнд үүнийг мэдүүлэх боломжтой байсан гэж бид итгэдэг. “Эзэний нууц Өөрөөс нь эмээгчдийн төлөө байдаг” (Дуу 25:14). Бурхантай гүн гүнзгий харьцаж, чимээгүй тунгаан бясалгаж буй хүмүүс энэ дэлхийн дуу чимээ, хөл үймээнд дарагддаг нууцуудыг сонсдог. Та сонсоё гэвэл ойртож очих хэрэгтэй. Паул ойрхон байсан.

Паул махбоддоо үлдсэнээр тэдний сүнсний **ахиц дэвшилд** нэмэр болж, Эзэнд итгэж найдсанаар авсан **баяр хөөрийг** нэмэгдүүлэх аж.

[1:26]

Тэрээр өршөөгдөж дэлхий дээр илүү урт насалж, үйлчлэх болоод филиппойчууд дээр эргэж очвол тэдэнд Эзэн дотор **сайрхах** шалтгаан нэмэгдэх байв. Паулыг Филиппойд ирвэл тэд түүнийг яаж тэврэн үнсэж асар их баяр хөөрөөр Эзэнийг магтах байсан бол гэж төсөөлөгдөхгүй байна уу? Магадгүй тэд “Паул аа, бид таны төлөө залбирсан боловч үнэндээ дахин харна гэж бодож ч байсангүй. Таныг бидэн рүү дахин авчирсан Эзэнд ямар их баярлаж байна аа!” гэх байсан биз.

[1:27]

Одоо Паул: **“Өөрсдийгөө зөвхөн Христийн сайн мэдээнд зохистойгоор авч явагтун”** гэж сэрэмжлүүлэв. Христитгэгчид Христ шиг байх ёстой. Тэнгэрийн улсын иргэд ямар байх ёстой тийнхүү үйлдэх хэрэгтэй. Бид байр суурийн хувьд өөрийн болсон зүйлээ бодит байдал дээр хэрэгжүүлэх учиртай.

Элч биднийг зохистойгоос гадна тууштай байхыг уриалж байна. Тухайлбал, тэрээр очоод тэднийг харахад эсвэл байхгүй байлаа ч тэд христитгэл буюу **сайн мэдээний итгэлийн**

төлөө нэг сэтгэлээр хамтран зүтгэж, нэг сүнс дотор бат зогсоцгоож байна гэж сонсохыг хүсжээ. Христитгэгчид ижил дайсантай тул өөр хоорондоо тэмцэлдэх бус харин дайсныхаа эсрэг нэгдэх хэрэгтэй.

[1:28]

Тэд мөн сайн мэдээний дайснуудаас **айх** хэрэггүй. Хавчлага тулахад айхгүй байх гэдэг нь хоёр утгатай. Нэгдүгээрт, энэ бол Бурханыг эсэргүүцэгчид сүйрэхийн тэмдэг. Хоёрдугаарт, дайсны уур хилэнгийн өмнө зоригтой байгаа нь **авралын** тэмдэг. **Аврал** гэдэг үгийг энд ирээдүй цаг дээр хэрэглэн ариун хүмүүс хожим зовлонгоос чөлөөлөгдөж, түүний махбодь, сэтгэл болон сүнс аврагдахыг (*аврагдан Христтэй нэгдмэл болохыг*) хэлж байж болно.

[1:29]

Христэд итгэх хийгээд Түүний төлөө зовох нь аугаа завшаан болохыг филиппойчууд санах хэрэгтэй.

Доктор Грифит Жоныг нэг удаа хэрцгий балмад харь хүмүүс бүчин дайрсан бөгөөд

нүүрээ алгаараа хамгаалж байгаад эргүүлээд авахад гар нүүр нь цусанд будагдсан байлаа. “Тэрээр ер бусын байдлаар сэтгэл хөөрч, Түүний Нэрийн төлөө зовох зохистой гэж тооцогдсондоо баярлажээ”. Христигэлийн төлөөх зовлон ийм өндөрт өргөмжлөгдөж байгаа нь гайхалтай хэрэг биш үү? Хэмжээлшгүй нэгэнтэй нэгдсэн бол ялихгүй жижигхэн зүйл ч унтрашгүй галаар шатаж байдаг.” Загалмай өргөмжлөл хүндэтгэлийг өгдөг.

[1:30]

Энэ ишлэлд “Та нар ч оролцож байгаа учир” гэдэг үгс нэмбэл өмнөх ишлэлтэй ямар холбоотой нь улам тод болно:

Та нар намайг Филиппойд байхад болон одоо хүртэл **та нар миний дотор харсан, миний дотор байгаа гэж сонсож байгаатай адил тэмцэлд та нар ч оролцож байгаа учир** Христийн төлөө зовох нь та нарт соёрхогдсон.

Ш. Христийн даруу байдал болон золиосын үлгэр дууриаллаар нэгдэх тухай уриа (2:1-16)

Филиппой хотын чуулган олон талаар үлгэр жишээ, Паулаар үе үе халуунаар сайшаалгасан чуулган байсан боловч дотроо далд зөрчилтэй байв. Юодиа, Сунтухе гэгч эмэгтэйчүүд санал зөрдөг байжээ (4:2). Элч 2-р бүлэгт Бурханы хүмүүсийн хооронд гарах зөрчлийн шалтгаан ба үүнийг хэрхэн арилгах тухай ярих учир үүнийг санаж байхад хэрэг болно.

[2:1]

Энэ ишлэл дэх **хэрэв** гэдэг үгийг эргэлзсэндээ бус тодруулга хийхийн тулд хэлж байна. Энэхүү ишлэлд итгэгч хүмүүс эвтэй, хамтран ажиллахад хүргэх дөрвөн агуу зүйлийг жагсаажээ. Элч нэг ёсондоо: “Бидэнд **Христ доторх** ийм их дэмжлэг байгаа, Түүний **хайр** асар том ятгалга болж байгаа, Түүний Ариун Сүнс бид бүхнийг хамтад нь гайхалтай **нөхөрлүүлж**, христитгэлийн дотор бидэнд ийм их **энэрэнгүй болоод өрөвчхөн сэтгэл** байгаагаас хойш бид бүгд өөр хоорондоо

баяр хөөртэйгээр нэгдэн амьдрах боломжтой” гэж хэлжээ.

Ф.Б.Мейер энэ дөрвөн сэдлийг ийнхүү тодорхойлжээ:

- (1) Христийн ятгалга
- (2) Хайраас урган гарах анхаарал халамж
- (3) Сүнсний хуваалцал
- (4) Хүнлэг болон өрөвч сэтгэл⁹

Элч биднийг Христийг хайрлах нэг сэтгэлтэй, Ариун Сүнсийг хамтран эзэмшиж байгаа тул эв нэгдэлтэй байхыг уриалж байна. **Христ дотор** байгаа бүхний улмаас Түүний биеийн эрхтнүүд нэг зорилго, ижил хайр, эв эе, энэрэлээр нэгдэх учиртай.

[2:2]

Ийнхүү дурьдсан шалтгаанууд нь филиппойчуудад чухал бол тэдгээр дээр үндэслэж **намайг гүйцэд баярлуул** гэж Паул тэднээс гуйж байна. Энэ цаг мөчийг хүртэл филиппойчууд Паулыг үнэхээр баярлуулж байв. Түүнийг нь Паул үгүйсгээгүй харин одоо баяр хөөрийг нь бялхуулахыг гуйж байна. Тэд **адил**

сэтгэж, адил хайртай байж, сэтгэлээрээ нэгдэн, нэгэн бодолтой байснаараа тэгж чадна.

Энэ нь бүх христитгэгчид яг ижилхэн сэтгэж, ижилхэн үйлдэл хийж байх ёстой гэсэн үг үү? Бурханы үгийн хаана ч ингэж хэлээгүй. Бид христитгэлийн агуу суурь асуудлуудыг хүлээн зөвшөөрөх ёстой ч, жижиг сажиг зүйл дээр хүмүүс өөр өөр үзэл бодолтой байлгүй яах вэ? *Нэгэн хэв загвар* болон *нэгдмэл* байдал гэдэг бол ижил ойлголт биш. Нэг загварт баригдалгүй нэгдмэл байх боломжтой. Хэдийгээр бид жижиг сажиг зүйл дээр санал нэгдэхгүй байж болох ч зарчмын асуудал биш бол бусдын сайны төлөө өөрсдийнхөө үзэл бодлоо дарж болно.

Адил сэтгэнэ гэдэг нь Христийн бодол санаатай байхыг хэлэх бөгөөд аливаа зүйлийг Христийн харж байгаа шиг харж, Түүн шиг хариу үйлдэхийг хэлдэг. **Адил хайртай** байна гэдэг нь Эзэн биднийг хайрласан, золиос тооцоогүй хайраар бусдыг **адилхан хайрлахыг** хэлнэ. **Сэтгэлээрээ нэгдэн** гэдэг нь нэг зорилго уруу хамтдаа нэгдэн ажиллахыг хэлдэг. Эцэст нь, **нэгэн бодолтой** байна гэдэг нь Христийн бодол

санаа биднийг удирдаж байгааг харуулахаар нэгдэж ажиллахыг хэлнэ.

[2:3]

Юуг ч өрсөлдөх сэтгэлээр, эсвэл бардам зангаар хийж болохгүй. Яагаад гэвэл энэ хоёр нь Бурханы хүмүүсийн эв нэгдэлд саад болдог хамгийн том дайсан юм. **Өрсөлдөх сэтгэл** гэдэг нь ямар ч үнээр хамаагүй хамгийн тэргүүнд байхыг хүсэх явдал юм. **Бардам зан** гэдэг нь өөрийгөө дөвийлгөн харуулах гэсэн оролдлогыг хэлнэ. Өөрийгөө бусдаар хүрээлүүлэх юмуу өөрсдийн амин сонирхлыг эрдэг хүмүүс таарвал өрсөлдөөн болон маргааны үндэс байгааг харах болно. Үүнийг өөрчлөх арга зам нь энэхүү ишлэлийн төгсгөлд байна. **Харин даруугаар бие биеэ өөрөөсөө дээр гэж үз.** Энэ нь гэмт хэрэгтнүүдийг ёс суртахууны хувьд биднээс илүү дээгүүр гэж үзнэ гэсэн үг биш харин хувиа хичээлгүй бусдын төлөө амьдрах, тэдний ашиг сонирхлыг өөрсдийнхөөсөө дээгүүр тавихыг хэлнэ. Ийм уриалгыг Бурханы үгээс уншихад хялбар боловч утгыг нь бүрэн ухамсарлаж, бодит амьдрал дээр хэрэгжүүлэх нь өөр хэрэг. **Бие биеэ**

өөрөөсөө дээр гэж үзэх нь хүний ухаанд үнэхээр харь зүйл бөгөөд бид үүнийг өөрсдийнхөө хүч чадлаар хийж чадахгүй. Үүнийг бид зөвхөн Ариун Сүнс дотор байж, Түүний хүчээр хэрэгжүүлж чадна.

[2:4]

Бурханы хүмүүсийн хоорондох асуудлыг шийдвэрлэх арга зам бол **бусдын ашиг сонирхлыг** хувийн амьдралаас илүү анхаарах нь юм. **Бусад** гэдэг үг энэ бүлгийн түлхүүр үг болж байна. Бид бусдын төлөө үйлчилж амьдралаа зориулснаар хувиа хичээх хандлагаа ялан өсөж чадна.

Бусдын төлөө, Эзэн минь, бусдын төлөө!

Барьж явах уриа лоозон минь ийм байг

Бусдын төлөө амьдарснаар

Бурхан тань шиг болоход минь туслаач

–Чарльз Д.Мейгс

[2:5]

Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай. Паул одоо филиппойчуудад Эзэн

Есүс Христийг үлгэр жишээ болгон харуулж байна. Тэр ямар хандлага харуулсан бэ? Тэр бусдад яаж ханддаг байсан бэ? Гай Кинг Эзэн Есүсийн бодол санааг дараах байдлаар маш сайн тодорхойлжээ: (1) хувиа хичээдэггүй бодол санаа; (2) золиос гаргадаг бодол санаа; (3) үйлчлэх бодол санаа юм. Эзэн Есүс үргэлж бусдын талаар боддог байв.¹⁰

Тэрээр өөрийнхөө уй гашуугаас болж
нулимс унагаагүй,

Харин миний төлөө цусаа урсгасан.

-Чарльз Х.Габриел

[2:6]

Христ Есүс **Бурханы мөн чанараар оршин байсан** гэдэг нь Тэрээр мөнхөд **Бурхан** байсан гэдгийг хэлж байна. Энэ нь Түүнийг Бурхан шиг байсан гэсэн үг биш харин ч үнэхээр Бурхан *мөн* гэсэн үг.

Гэвч Тэрээр **Бурхантай тэгш байх явдлыг өөртөө хадгалах зүйл гэж үзсэнгүй**. Энд хамгийн гол нь Бурхантай мөн чанарын хувьд тэгш үү эсвэл байр суурийн хувьд тэгш үү гэдгийг ялгаж салгаж ойлгох нь чухал байна.

Мөн чанарын хувьд Христ бол өнгөрсөн, одоо, ирээдүйд Бурхантай эн тэнцүү. Тэр энэ мөн чанараа үгүйсгэх боломжгүй. Гэвч байр суурийн тэгш байдал бол өөр хэрэг. Христ өнө мөнхөөс Өөрийн Эцэгтэйгээ эн тэнцүү байр суурьтай, тэнгэрийн алдар сууг эдэлж байв. Гэхдээ Тэрээр энэ байр сууриа ямар ч үнээр хамаагүй Өөртөө **хадгалж байх ёстой гэж үзээгүй.** Нүгэлд унасан хүн төрөлхтнийг аврах хэрэгтэй болоход Тэрээр **Бурхантай эн тэнцүү байр суурь, тэнгэрийн тав тух, аз жаргалаасаа татгалзсан.** Эдгээрийг бүх нөхцөлд үүрд зуурах зүйл **гэж үзээгүй.**

Тиймээс Тэрээр энэ дэлхийд ирж нүгэлтнүүдийн эсэргүүцлийг тэвчин туулахад бэлэн байлаа. Эцэг Бурхан хэзээ ч нулимуулж, зодуулж эсвэл цовдлогдоогүй. Энэ утгаараа Эцэг нь Хүүгээс агуу, гэхдээ мөн чанарын хувьд биш харин байр суурь, амьдрал байдлын хувьд агуу. Үүнийг Есүс Иохан 14:28-д: “Хэрэв та нар Намайг хайрласан бол Эцэгтээ очиж байгаад минь баярлах байсан. Яагаад гэвэл Эцэг Надаас илүү аугаа юм” гэж илэрхийлжээ. Өөрөөр хэлбэл дагалдагчид нь Түүнийг тэнгэрийн улсынхаа гэр рүү явж байгааг ойлгоод баярлах ёстой байв.

Дэлхий дээр байхад нь Түүнд аймшигтай харгис хандаж, Түүнийг үгүйсгэсэн. Тэрээр Эцэгээсээ доор нөхцөл байдалд амьдарч байсан. Энэ талаас нь харвал Түүний Эцэг илүү аугаа. Тэрээр тэнгэртээ буцаж очихоороо Эцэгтэйгээ *мөн чанарынхаа* хувьд эн тэнцүү шигээ *нөхцөл байдлын* хувьд эн тэнцүү болно.

Гиффорд үүнийг:

[“Бурхантай тэгш байх явдлыг Өөртөө хадгалах зүйл гэж үзсэнгүй”] гэх өгүүлбэрт мөн чанарыг биш оршин тогтнох хэлбэрийг өгүүлжээ. Оршин тогтнох хэлбэр нөгөөгөөр солигдож болох ч мөн чанар өөрчлөгдөшгүй. Элч Паулын өгүүлсэн 2Ко 8:9-ийг авч үзвэл “Хэдийгээр Тэр баян байсан боловч Өөрийнхөө ядуурлаар та нарыг баян болгохын тулд та нарын төлөө Тэр ядуу болжээ.” Энд аль алины *оршин тогтнох хэлбэр* өөрчлөгдөж байгаа ч мөн чанар өөрчлөгдөхгүй байна. Ядуу хүн баян болоход түүний *оршин тогтнох хэлбэр* өөрчлөгдөх боловч хүний мөн чанар өөрчлөгдөхгүй. Бурханы Хүү ч адилхан, бурханлаг мөн чанарт нь тохирсон, түүнийг

нь төгс илэрхийлэх оршин тогтнох хэлбэрээ бидний төлөө орхиж, хүний мөн чанарыг авахдаа түүнтэй хамт хавьгүй дорд бөгөөд ядуу *оршин тогтнох хэлбэрийг* авчээ.¹¹

[2:7]

Харин Өөрийгөө хоосолжээ. “Эзэн Есүс юугаараа хоосорсон юм бэ?” гэдэг асуулт шууд гарч ирнэ.

Энэ асуултанд хариулахдаа бид маш хянуур хандах учиртай. Хүн энэхүү хоосорлыг тайлбарлах гэж оролдохдоо Түүний Бурханлаг мөн чанарыг үгүй болсон мэт дүгнэлтэд хүрдэг. Жишээлбэл зарим нь Эзэн Есүс дэлхий дээр байхдаа бүхнийг мэдэх, бүхнийг чадах байдлаа алдсан гэдэг. Тэрээр нэгэн зэрэг хаа сайгүй оршин байхаа больсон гэдэг. Тэд Түүнийг дэлхий дээр Хүн болж ирэхдээ, эдгээр бурханлаг чанараа Өөрийн хүслээр орхисон гэлцдэг. Зарим нь бүр Түүнийг хүний хязгаарлагдмал хэвэнд орж алдаа хийдэг болсон бөгөөд тухайн цаг үеийнхээ үлгэр домог, түгээмэл ойлголтыг хүлээн авсан ч гэж хэлдэг!

Үүнийг бид бүрэн няцааж байна. Эзэн Есүс дэлхий дээр ирэхдээ Бурхан чанарынхаа алийг нь ч орхиогүй.

Тэрээр бүхнийг мэдэгч хэвээрээ байсан.

Тэрээр хаа сайгүй оршигч хэвээрээ байсан.

Тэрээр бүхнийг чадагч хэвээр байсан.

Юу болсон юм бэ гэвэл, Тэрээр байр суурийн хувьд Бурхантай тэгш байх явдлыг орхин Өөрийгөө хоосолж, Бурханлаг алдраа хүний махан биеэр далдлан хучсан. Алдар нь далд хэдий ч бүхлээрээ Түүнийх байсаар байсан бөгөөд уулан дээрх хувирал шиг зарим тохиолдолд цацарч гарч ирдэг байв. Тэрээр дэлхий дээр байх хугацаандаа Бурхан чанаруудаа хормын төдийд ч алдаж байгаагүй.

“Өөрийгөө хоосолсон” гэдэг үгийг тайлбарлахдаа маш хянуур байх ёстой гэж бид өмнө нь хэлж байсан. Дараа нь гарах илэрхийллээр тайлбар хийх нь хамгийн аюулгүй арга зам болно. Тэрээр **боолын дүрийг авч, хүнтэй адил болсноор** Өөрийгөө хоосолсон. Өөрөөр хэлбэл, Тэр урьд өмнө нь Өөрт байгаагүй зүйл болох *хүн мөн чанарыг* авснаараа Өөрийгөө хоосолсон. Тэр Бурхан мөн чанараа халаагүй,

зөвхөн тэнгэр дэх байр сууриа л орхисон. Гэхдээ түр зуур шүү!

Тэрээр зөвхөн хүн байсан бол Өөрийгөө хоосолсон гэж тооцогдохгүй. Хүн болж мэндэлж байгаа минь бид өөрсдийгөө хоосолж байгаа хэрэг биш. Харин Бурханы хувьд Хүн болно гэдэг нь Өөрийгөө хоосолж байгаа хэрэг. Үнэндээ зөвхөн Бурхан л үүнийг хийж чадна.

Боолын дүрийг авах. Аврагчийн хүн болж ирснийг болон Түүний амьдралыг, Иохан 13:4-т өгүүлсэн сайхан үгсээр: “Есүс ... гадуур хувцсаа тайлаад, алчуур авч бүслэв” гэж дүгнэж болно. Алчуур буюу хормогч нь үйлчлэлийн тэмдэг юм. Үүнийг боолууд хэрэглэдэг байсан. Мөн үүнийг ерөөлт Эзэн Есүс хэрэглэсэн. Учир нь Тэрээр “үйлчүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд ирсэн бөгөөд амиа олны төлөө золиос болгон өргөхөөр” ирсэн билээ (Мт 20:28). Энд хэсэгхэн азнаад юу хэлснийг эргэцүүлж бодъё. Филиппой хотын ариун хүмүүсийн дунд маргаан байсан. Паул тэднийг Христийн бодолтой байхыг ятгасан. Тэр ятгалгыг товчхон тайлбарлавал христитгэгчид өөрсдийгөө дорд болгож, бусдад үйлчлэн, амьдралаа золиос болгон өргөвөл

хэрүүл маргаан байхгүй болно гэсэн үг. *Бусдын төлөө үхэхэд бэлэн байгаа хүмүүс ер нь тэдэнтэйгээ маргаад байдаггүй.*

Христ үргэлж оршин байсан боловч **хүнтэй адил болж** дэлхий дээр ирж, “жинхэнээс Хүн болсон.” Эзэн хүн болсон нь Тэр бол Бурхан мөн гэдэгтэй адил бодит зүйл. Тэр бол жинхэнэ Бурхан, бас жинхэнэ Хүн. Ямар гайхалтай нууц вэ! Бүтээгдсэн оюун ухаан үүнийг хэзээ ч ойлгож чадахгүй.

[2:8]

Энэ хэсгийн ишлэл бүр Бурханы хайртай Хүү улам даруу дорд болж байгааг дүрсэлжээ. Тэрээр тэнгэрийн сүр жавхлан алдар суугаа орхиод зогссонгүй! Тэр Өөрийгөө хоосолсон! Тэрээр боолын дүрийг авсан! Тэр Хүн болсон! Гэтэл одоо бид Түүнийг **Өөрийгөө даруу болгов** гэснийг уншиж байна! Нүгэлт биднийг аврахын тулд Тэр ямар ч гүн рүү ороход бэлэн байв. Түүний алдарт нэр мөнхөд ерөөгдөг!

Тэрээр үхэлд хүртэл дуулгавартай байснаараа Өөрийгөө даруу болгов. Энэ биднийг гайхашруулж байна! Амиа алдах байсан

ч Тэр дуулгавартай дагасан. **Үхэлд хүртлээ дуулгавартай байна** гэдэг нь Тэрээр эцэс хүртэл дуулгавартай байсан гэсэн үг. Тэр үнэхээр маш үнэтэй ширхэг сувдыг олоод, явж, өөрт байсан бүхнээ зарж тэр сувдыг худалдаж авсан тэр Худалдаачин байжээ (Мт 13:46).

Загалмайн үхэлд ч хүртэл дуулгавартай байсан. Загалмайд цовдлогдож үхнэ гэдэг хамгийн ичгүүртэй **үхэл** байв. Үүнийг дүүжлүүр, цахилгаан сандал, юмуу эсвэл хорт хийгээр утах зэрэг зөвхөн хүн амины хэрэг үйлдсэн хүмүүст ногдуулдаг ялтай харьцуулж болно. Гэтэл тэнгэрийн улсын шилдэг Сайн нь энэ ертөнцөд ирэхэд **үхлийн** ийм л **хэлбэрийг** ногдуулжээ. Түүнд хорвоогийн жамаар орон дээрээ үхэхийг зөвшөөрөөгүй. Тэр ослоор үхэж болохгүй байжээ. Тэр **загалмайн** ичгүүрт **үхлээр үхэх** ёстой байв.

[2:9]

Одоо энд эрс өөрчлөлт гарч байна. Өмнөх ишлэлүүдэд Эзэн Есүсийн хийсэн зүйлийг

дүрсэлсэн. Тэрээр өөрийгөө үгүйсгэх замыг сонгожээ. Тэр алдар нэр хөөцөлдөөгүй. Тэр Өөрийгөө даруу болгов.

Одоо бид *Бурханы* хийсэн зүйлийг харж байна. Аврагч Өөрийгөө даруу болгоход **Бурхан Түүнийг үлэмжийн дээдээр өргөмжилсөн**. Тэр Өөртөө алдар нэрийг эрэлхийлээгүй байхад **Бурхан Түүнд аливаа нэрээс дээд нэрийг соёрхжээ**. Түүнийг өвдөг сөгдөн бөхийж бусдад үйлчлэхэд, Бурхан Түүний өмнө **бүх юмс өвдөг сөгдөхийг** тушаажээ.

Эндээс филиппойчууд, бас бид юуг ойлгож авах вэ? Өгсөхийн тулд эхлээд буух хэрэгтэйг ойлго. Бид өөрсдийгөө өргөмжлөх хэрэггүй, харин бусдад үйлчилж байвал цаг нь болохоор Бурхан биднийг өргөмжилнө.

Бурхан Христийг үхлээс амилуулж, тэнгэрийн улсын үүдийг нээж Түүнийг буцаан Өөрийн баруун гарт хүлээн авч өргөмжилсөн. Түүгээр ч барахгүй – **Бурхан аливаа нэрээс дээд нэрийг Түүнд соёрхов**.

Энэхүү нэр нь юу вэ гэдэг дээр эрдэмтэд санал зөрдөг. Зарим нь энэ нэрийг *Ёхова* нэрийг агуулдаг *Есүс* гэдэг нэр гэж үздэг. Исаиа 45:22,

23-т өвдөг бүхэн Ёховагийн (Бурхан) нэрд өвдөг сөгдөнө гэж тунхаглажээ.

Бусад нь аливаа нэрээс дээд нэр гэдгийг өөрчлөлтийн хамгийн өндөр газар, хамгийн дээд байр суурь болон ноёрхлыг хэлж байна гэж үздэг. Хоёулаа байж болохоор тайлбар байна.

[2:10]

Тэрээр тэнгэрт байгаа, газар дээр байгаа, газрын доор байгаа бүх юмсыг Түүнд өвдөг сөгдүүлэхээр тогтоосныг харахад Христийн золилтын ажил Бурханы таалалд бүрэн нийцжээ. Энэ нь энд дурдагдсан бүхэн аврагдана гэсэн үг биш. Түүний өмнө *сайн дураараа* өвдөг сөгдөөгүй хүмүүс нэг өдөр *хүчээр сөгдөх* болно. Түүний нигүүлслийн өдөрт Түүнтэй эвлэрээгүйг Түүний шүүлтийн өдөр номхтгох болно.

[2:11]

Эзэн эгнэшгүй нигүүлслээрээ алдараас бууж, Бетлехем, Гетсемани, Гавлын толгод уруу аялсан. Хариуд нь Бурхан Түүнийг Эзэн гэж орчлон ертөнц даяар мэдүүлж, даян дэлхийгээр хүндлүүлнэ. Түүний тунхагийг эсэргүүцэгчид

нэг л өдөр мунхагласнаа, том алдаа хийснээ ухаарч, Назарын Есүс үнэхээр алдрын Эзэн мөн болохыг хүлээн зөвшөөрнө. Эзэн Есүсийн мөн чанар болон ажилтай холбоотой энэхүү гайхалтай хэсгийг орхихоосоо өмнө үүнийг Филиппой хотын чуулган дахь жижигхэн асуудлаас болж тайлбарласныг санах хэрэгтэй. Паул Эзэний талаар нарийн дэлгэрэнгүй тайлбар бичихийг бодоогүй. Харин ариун хүмүүст байсан хувиа хичээсэн, талцдаг сэтгэлгээг засахыг л хичээсэн. Тэдний нөхцөл байдлыг анагаах түлхүүр нь Христийн бодол санаатай адил болох явдал байв. Паул ямар ч нөхцөлд Эзэнийг оролцуулж байна. Эрдман: “Нарийн, хэцүү, тааламжгүй асуудлыг шийдвэрлэхдээ ч тэрээр үнэнийг яг л газрын хөрсөн дэх үнэт эрдэнэс мэт харагдуулахаар яруу сайхан өгүүлж чаддаг” гэж бичжээ.¹²

[2:12]

Элч Христийн үлгэр дууриаллыг гялалзсан жишээ болгон хэлээд түүнд үндэслэн ятгалга хийж байна.

Филиппойчууд Паулыг хамт байхад нь **үргэлж дуулгавартай байжээ. Эдүгээ байхгүй байхад нь тэд бүр ч илүү өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр биелүүлэх ёстой аж.**

Бичээсийн энэ хэсгийг буруу ойлгох нь их. Паул авралыг үйлсээр ирдэг гэж заагаагүйг юуны түрүүнд, маш сайн санаж байх хэрэгтэй. Тэрээр бичээсүүддээ аврал үйлсээр бус харин Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр ирдэг гэж дахин дахин онцолсон байдаг. Тэгвэл энэ ишлэл ямар утгатай юм бэ?

- (1) Бурхан бидний дотор хийж өгсөн авралыг **биелүүлэх ёстой** гэсэн үг байж болох юм. Бурхан бидэнд мөнх амийг үнэгүй бэлэглэсэн. Бид ариун амьдарснаар үүнийг хэрэгжүүлэх ёстой.
- (2) **Аврал** гэж энд филиппойчуудад байсан асуудал бэрхшээлийн шийдлийг хэлж байж болно. Тэд маргаан тэмцэлд баригдсан байв. Элч тэдэнд үүнийг залруулах арга замыг өгчээ. Одоо тэрхүү

арга замыг хэрэгжүүлэхийн тулд Христийн бодол санаатай байх ёстой ажээ. Тэд ингэж **өөрсдийн авралыг** буюу асуудлын шийдлийг **биелүүлэх** юм.

Энд **аврал** гэж байгаа нь сүнсний авралыг биш, харин христитгэгчдийг Бурханы хүслийг гүйцэтгэхэд саад болж байгаа урхинаас мултрахыг хэлж байна. Үүний нэгэн адил Ваин үүнийг өнөөгийн амьдралын хорон муугаас чөлөөлөгдөх тухай гэж дүрслэн хэлжээ.

Аврал нь ШГ-нд олон өөр утгаар гардаг. 1:19-р ишлэлд үүнийг шоронгоос суллагдахыг хэлж байсныг үзсэн. 1:28-р ишлэлд бидний бие эцэстээ аливаа нүглээс аврагдахыг хэлдэг. Ямар утгаар хэлж байгааг ойлгохын тулд тодорхой хэмжээнд хам сэдвийг харах хэрэгтэй. Энэ хэсэгт **аврал** гэж филиппойчуудыг шаналгаж байсан маргааны шийдлийг хэлж байна гэж бид итгэдэг.

[2:13]

Одоо Паул тэдэнд **Өөрийн сайн тааллын дагуух зүйлсийг үйлдүүлж, хүсүүлэхийн тулд та нарын дотор ажиллаж буй нь Бурхан** тул авралаа биелүүлэх боломжтой болохыг сануулж

байна. Юуны түрүүнд Түүний хүслийг гүйцэтгэх хүсэл эрмэлзлийг бидэнд төрүүлдэг нь **Бурхан** гэсэн үг. Дараа нь тэр хүслийг биелүүлэх хүчийг Бурхан бидний дотор ажиллуулдаг.

Энд бид тэнгэрлэг оршихуй хүн хоёрын ууслыг дахиад харж байна. Нэг талаар бид авралаа биелүүлэхээр дуудагдсан. Нөгөө талаар зөвхөн Бурхан л биднээр энэ зүйлийг хийлгэж чадна. Бид өөрсдийн зүгээс хийх юмаа хийж, Бурхан Өөрийнхөө зүйлийг хийх болно. (Гэхдээ энэ нь гэм нүглийн уучлал юмуу шинээр төрөхтэй хамаагүй. Золилт бол бүхэлдээ Бурханы ажил юм. Бид зүгээр л итгэхэд үүн рүү ордог.)

[2:14]

Бид Түүний сайн тааллыг үйлдэхдээ гомдоллож, дургүйцэлгүй хийх учиртай: “ядсан байдалтай биш харин ялгуусан сэтгэлээр хий.” **Гоморхож маргах нь асуудлыг улам лавшруулна.**

[2:15]

Гомдол маргаанаас зайлсхийснээр бид **гэм зэмгүй, буруугүй** (чин үнэнч болон заль мэхгүй) байх юм. **Гэм зэмгүй** гэдэг нь түүнд ямар ч ял тулгах аргагүй гэсэн үг (Дан 6:4-ийг үз.) **Гэм зэмгүй** хүн нүгэл үйлдэж болох ч уучлал гуйгаад, гэмшээд боломжтой бол залруулга хийдэг. **Буруугүй** гэдэг нь энд чин сэтгэлтэй буюу заль мэхгүй гэсэн үг.

Бурханы хүүхдүүд буруу, гажууд үеийнхний дотор гэм зэмгүй, буруугүй байх учиртай. Бурханы хүүхдүүд гэм зэмгүй амьдарснаар энэхүү харанхуй ертөнцөд эрс ялгарах болно.

Үүнээс ургуулан Паулд тэднийг харанхуй шөнө харагдах **гэрэл мэтээр** боджээ. Шөнө харанхуй байх тусам гэрэл улам тод харагддаг. Христитгэгчид **гэрэл** буюу гэрлийг тээгчид. Тэд гэрэл бүтээж чадахгүй ч Эзэний алдрыг тусган харуулбал бусад хүн тэдний доторх Есүсийг олж харна.

[2:16]

Амийн үгээс баттай баригтун. Бид гэрэл харууллаа гээд үг хэлээрээ гэрчлэх үүргээсээ чөлөөлөгдөхгүй. Бидний гэрчлэл бидний

амьдрал болоод амаар аль алинаар нь гарч байх учиртай.

Филиппойчууд эдгээр үйл хэргээ гүйцэлдүүлж байгаа цагт элч **Христийн өдөр** сайрхах үндэслэлтэй болно гэдгээ мэдэж байгаа. Сүнс аврагдаж байгааг хараад зогсохгүй хүн бүрийг Христ дотор төгс болгон толилуулах хариуцлага мэдэрч байв (Кол 1:28).

Христийн өдөр гэдэг нь Түүний дахин ирэх цаг үе болон итгэгчдийн үйлчлэл шүүгдэх өдрийг хэлж байна (1:6, 10). Филиппойчууд Эзэний төлөөх ажил үйлчлэлдээ итгэмжтэй байвал Паулын үйлчлэл **дэмий байгаагүй** нь тэр өдөр тодорхой болно.

IV. Паул, Тимот, Епафродит гурвын христэч үлгэр жишээ (2:17-30)

Өмнөх хэсэгт Паул Эзэн Есүсийг номхон даруу санаа сэтгэлийн гол жишээ болгон тайлбарласан. Гэвч хүмүүс “Өө, гэхдээ Тэр бол Бурхан харин бид ердөө л хүн” гэж хэлж болох юм. Тиймээс Паул Христийн бодол санаагаар амьдарч үзүүлсэн гурван хүний жишээ татсан нь

тэр өөрөө, Тимот бас Епафродит болно. Хэрэв Христийг нар гэвэл эдгээр гурван хүн нарны алдрыг тусгаж байгаа сар юм. Тэд харанхуй ертөнцөд гэрэл билээ.

[2:17]

Элч филиппойчуудын болон өөрийнхөө үйлчлэлийг маш сайхнаар илэрхийлэн дүрсэлжээ. Тэрээр еврейчүүд хийгээд харийнхны аль алиных нь амьдралд нийтлэг байсан тахил дээр асгадаг **ундаан өргөлийн** жишээ ашиглажээ.

Тэрээр филиппойчуудыг өргөл өргөгчид гэж хэлж байна. Тэдний **итгэл** нь **тахил** байв. Паул өөрийгөө **ундаан өргөл** гэж хэлжээ. Тэрээр тэдний **итгэлийн үйлчлэл ба тахил** дээр өөрийгөө золиослон **асгагдаж байгаа ч** баярлах болно.

Виллиямс тайлбарлахдаа:

Элч филиппойчуудын гаргаж байгаа золиосийг болон эрч хүчийг өөрийнхтэйгээ харьцуулахдаа тэднийхийг дөвийлгөж, өөрийнхийгөө бууруулж байна. Аль аль нь өөрсдийнхөө амьдралыг сайн мэдээний

төлөө зориулж байсан боловч тэдний үйлдлийг тэрээр агуу их тахил гэж үзэн өөрийнхийгөө дээр нь асгагдаж байгаа ундаан өргөл төдий гэж хэлжээ. Энэхүү яруу тансаг хэллэгээр тэрээр сайн мэдээний төлөө амиа өргөж болзошгүй байгаагаа хэлж байна.

13

Ийм тавилан ногдвол тэрээр **баярлах** болно.

[2:18]

Түүнчлэн филиппойчууд ч **баярлаж**, Паултай баяр хөөрөө хуваалцах хэрэгтэй. Тэд түүний үхлийг гашуудал гэж үзэлгүй, харин гэр рүүгээ ийнхүү сүр жавхлантайгаар явж байгаад баяр хүргэх ёстой.

[2:19]

Энэ мөчийг хүртэл Паул өөрийгөө золиослох хайрын хоёр жишээ татсан - Эзэн Есүс болон өөрөө. Хоёулаа амиа үхэлд тушаан асгая гэсэн. Хувиа хичээдэггүйн өөр хоёр жишээ нь **Тимот**, **Епафродит** нар юм. Элч **Тимотыг** филиппойчууд уруу ойрын ирээдүйд **илгээж**,

тэдний талаар сонсож **урам** авахыг найдаж байсан.

[2:20]

Филиппойчуудын сүнсний нөхцөл байдалд хувиа хичээлгүй халамж тавьж байснаараа Тимот, Паулын хамтрагч нөхдийн дотроос онцгой байв. Паулд тэдэн рүү, тийм итгэлтэйгээр илгээчих хүн **өөр хэн ч** байсангүй. Тимот шиг залуухан хүнд энэ бол үнэхээр том сайшаал байв!

[2:21]

Бусад нь **өөрсдийн** хувийн ашиг сонирхолдоо живжээ. Тэд энэ амьдралдаа хамаг анхаарлаа төвлөрүүлээд **Христ Есүсийнхэд** зарцуулах цаггүй байв. Энэ нь өнөөдөр өөрсдийн гэр, хөргөгч, телевиз болон бусад *эд зүйлсийн* төлөө тулга тойрон амьдарч буй бидэнд дохио өгч байгаа бус уу? (Лк 8:14-ийг үз.)

[2:22]

Тимот бол элчийн итгэлийн хүүхэд байсан бөгөөд тэр үнэхээр итгэмжтэй байсан. Тэд түүний жинхэнэ үнэ цэнэ, **сайн мэдээний төлөө**

хүү нь эцэгтээ үйлчлэх сэтгэлээр Паултай хамт үйлчлэн өөрийгөө хэрхэн нотолсныг мэдэх ажээ.

[2:23, 24]

Тимот өөрийгөө ийнхүү нотолсон учраас Паул, Цезарьт давж заалдсан хүсэлтийнхээ хариуг мэдмэгцээ түүнийг филиппойчууд уруу **илгээнэ** гэж найдаж байв. Энэ нь **миний байдал надад илэрхий болмогц даруй** гэж элчийн хэлсэн үгнээс илэрхий байна. Тэрээр амжилттай давж заалдаж суллагдаад филиппойчууд уруу дахин нэг удаа очино гэж найдаж байлаа.

[2:25]

Дараа нь бид **Епафродит** Христтэй адил бодол санаатай байсныг олж харна. Епафродит гэж Колоссай 4:12-г гарч байгаа Епафр мөн эсэхийг бид мэдэхгүй. Аль нь ч бай тэрээр Филиппойд амьдарч байсан бөгөөд тэндхийн чуулганаас илгээгдсэн элч байжээ.

Паул түүнийг: (1) **миний дүү**; (2) **хамтран зүтгэгч**; (3) **хамт байлдагч** гэж хэлжээ. Эхнийх нь хайрлах сэтгэл, хоёр дахь нь шаргуу хөдөлмөр,

гурав дахь нь зөрчлийн тухай өгүүлж байна. Тэрээр бусадтай хамт ажиллаж чаддаг нэгэн байсан бөгөөд энэ нь христитгэлийн амьдрал болон үйлчлэлд нэн шаардлагатай зүйл юм. Итгэгч хүн бие дааж бүх зүйлийг өөрийнхөөрөө хийх нь нэг хэрэг. Харин бусадтай хамтарч “хоёрдогч байр сууринд байх”, хувь хүмүүсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, нийтийн ашгийн төлөө өөрийн хүсэл бодлыг арагш тавих нь илүү хэцүү. **Хамтран зүтгэгч, хамт байлдагчид** болцгооё!

Үүний дээр Паул түүнийг **та нарын элч, хэрэгтэй үед минь надад үйлчилдэг** гэжээ. Энд түүний мөн чанарыг таних бас нэг чухал түлхүүрийг өгч байна. Тэрээр энгийн, барлагийн ажлыг хийхэд бэлэн байдаг байж. Өнөөдөр хүмүүсийн олонх нь зөвхөн олны нүдэнд харагддаг, таатай ажил сонирхдог. Бид тэр бүр хүний нүдэнд өртөлгүй, нэгэн хэвийн ажлыг чимээгүй гүйцэтгэж байдаг хүмүүсийн төлөө талархах хэрэгтэй! Хүнд хүчир ажил хийснээр Епафродит өөрийгөө даруу болгожээ. Харин Бурхан түүний итгэмжит үйлчлэлийг ирээдүйн бүх хойч үеийнхэнд нь уншуулахаар Филиппой

номны 2-р бүлэгт тэмдэглэн үлдээж өргөмжилсөн.

[2:26]

Ариун хүмүүс Епафродитыг Паулд туслуулахаар, багаар бодоход 1126 км зайтай газар уруу илгээжээ. Ингэж яваад итгэмжит элч **өвчин** тусаж, бүр үхлийн ирмэгт иржээ. Тэр үүнээсээ болж шаналсан. Гэхдээ өвчиндөө биш харин ариун хүмүүс үүнийг сонсох вий гэж эмээжээ. Тэд сонсвол түүнийг илгээж, амь насыг нь аюулд өртүүлснийхээ төлөө өөрсдийгөө зэмлэх байж. Епафродитоос бид “өөрийгөө түрүүнд боддоггүй сэтгэлийг” олж харна. Христитгэгч олон хүн үйл ажил эсвэл өвчин зовлонгоо нуруцдаг золгүй зуршилтай. Энэ нь ихэвчлэн өөрийгөө өрөвдөх, өөрийгөө дөвийлгөх, өөр дээрээ төвлөрөх гэм нүглийн илрэл байдаг.

[2:27]

Епафродит үхтлээ **өвдсөн, харин Бурхан түүнийг өршөөсөн.** Энэ хэсэг бидэнд тэнгэрлэг эдгэрлийн талаар мэдээлэл өгдөг учраас үнэ цэнэтэй:

(1) Юуны өмнө хэлэхэд, өвчин үргэлж гэм нүглийн үр дагавар байдаггүй. Энэ хүн ажил үйлчлэлээ итгэмжтэйгээр хийж явснаас болоод өвдсөн байна (ишлэл 30-г үз) “**...Христийн ажлын төлөө үхэлд ойрхон очсон билээ.**”

(2) Хоёрдугаарт, Бурханы хүсэл гэхээр өвчнийг үргэлж тэр дор нь гайхамшигаар эдгээхийг хэлдэггүй. Үүнийг Епафродит удаан өвдөж аажмаар эдгэрснээс харж болно (2Тм 4:20; 3Иох 2).

(3) Гуравдугаарт, эдгэрэл бол Бурханы нигүүлсэл бөгөөд бид Түүнээс, эдгэрлийг өөрсдийн эрх мэт шаардаж болохгүй.

Бурхан зөвхөн Епафродитыг ч биш, **уй гашуу дээр уй гашуу нэмэгдэх вий** гэж **мөн** түүнийг ч бас **өршөөснийг** Паул хэлж байна. Элч шоронд хоригдож байгаадаа хэдийн гашуудаж байлаа. Епафродит үхвэл, түүний уй гашуу нэмэгдэх байв.

[2:28]

Одоо Епафродит сайхан эдгэрч, Паул түүнийг гэр рүү нь **яаран илгээж байна**. Филиппойчууд

хайртай ахыгаа эргэн ирсэнд **баярлаж, ингэснээр** Паулын зовнил нимгэрэх юм.

[2:29]

Тэд Епафродитыг баяр хөөртэйгөөр хүлээн аваад зогсохгүй Бурханы энэ эрхэм хүнийг **хүндлэх** учиртай. **Эзэний** үйлчлэлд байх нь агуу нэр хүндийн хэрэг. Ариун хүмүүс тухайн хүнтэй хичнээн ойр дотно байсан ч үүнийг хүлээн зөвшөөрөх ёстой.

[2:30]

Епафродит **Христийн** төлөөх цуцашгүй үйлчлэлийнхээ улмаас өвдсөн гэж өмнө нь дурьдсан. Энэ нь Эзэний хувьд маш үнэ цэнэтэй. Христийн төлөө *зэвэрч муудсанаас элэгдэж муудсан* нь дээр. Зүгээр л өвчин эсвэл зуурдаар нас барагсдын тоог нэмж үхсэнээс Есүст үйлчилж яваад үхсэн нь дээр.

Та нарыг орлож надад үйлчлэхийн тулд гэдэг нь филиппойчууд Паулыг үгүйсгэж, тэдний хийх ёстой байсныг Епафродит хийсэн гэсэн үг үү? Үгүй биз ээ, яагаад гэвэл

Епафродитыг Паул уруу илгээсэн хүмүүс нь филиппойчууд юм.

Та нарыг **орлож** буюу **үйлчлэлийн** дутууг нөхнө гэдэг нь тэд Ромоос хол байснаасаа болоод Паул уруу биеэрээ очиж, түүнд туслах *боломжийг* хэлж байж болно. Элч тэднийг ажлаа хийгээгүй гэж буруутгах гээгүй зүгээр л Епафродит тэдний төлөөлөгчөөр тэдний биеэрээ хийж чадаагүй зүйлийг хийсэн гэж хэлж байна.

V. Хуурамч багш нарын эсрэг сануулга (3:1-3)

[3:1]

Эцэст нь ах дүүс минь, гэдэг нь Паул захидал төгсөж байгааг хэлээгүй. Энэ нь шууд утгаараа “Бусад асуудлын хувьд” гэсэн үг бөгөөд энэ үг 4:8-р ишлэлд дахиад хэрэглэгджээ.

Тэр тэднийг **Эзэн дотор баярла** гэж уриалж байна. Нөхцөл байдал ямар ч байсан, христитгэгч хүмүүс **Эзэн дотор** үнэн баяр хөөрийг олно. “Түүний баяр хөөрийн эх үүсвэр нь дээд тэнгэрт байгаа.” Түүнийг Аврагчаас нь

салгахгүй л бол баяр хөөрийг нь юу ч хулгайлж чадахгүй. Гэтэл мэдээж юу ч түүнийг Аврагчаас нь салгах боломжгүй. Хүний баяр хөөр өвчин зовлон, ядуурал үгүйрэл, уй гашуунаас хамааралтай байдаг. Харин христитгэгчийн баяр хөөр энэ амьдралын устаж алга болдог бүхнээс дээгүүр байдаг. Үүний баталгааг, Паул шоронд байхдаа ч уриалан ятгаж байгаагаас харж болно. Түүн шиг хүний зөвлөгөөг авч болно!

Тэрээр үүнийг филиппойчуудын аюулгүй байдлын төлөө хэлж байгаагаа мэдэж байсан болохоор тэдэнд давтан хэлэхээс залхаагүй. Гэхдээ тэр юуг давтаж хэлсэн бэ? Түүний өмнө нь хэлсэн **Эзэн дотор баярла** гэдэг ятгалгыг хэлж байна уу? Эсвэл иудейчүүдээс болгоомжлох тухай дараагийн ишлэлийг хэлж байна уу? Хоёр дахийг нь хэлж байгаа болов уу. Тэрээр 2-р ишлэлд **болгоомжлохыг** гурван удаа сануулсан. Түүний хувьд давтаж хэлэхээсээ **төвөгшөөгөөгүй**, тэдний хувьд энэ нь жинхэнэ хамгаалалт болох юм.

[3:2]

Тэднийг **ноходтой адил байгсдаас, бузрыг үйлдэгчдээс** болон **хуурамч хөвч хөндөлтөөс болгоомжлогтун** гэсэн. Энэ гурван хэллэг нэг хэсэг хүнийг буюу христитгэгчдийг иудаизмын хууль дор байлгах гэсэн хуурамч багш нарыг хэлсэн байж болно. Тэр багш нар хууль болоод ёс заншил сахиснаар зөвт байдалд хүрнэ гэж сургаж байлаа.

Нэгдүгээрт, тэд **ноходтой адил байгсад** байв. Библид **нохойг** цэвэр бус амьтан гэдэг. Еврейчүүд харь үндэстнүүдийг ноход гэж хэлдэг байв! Дорнын орнуудад нохой бол гудамжинд тэнүүчилж хоол хүнсээ хулгайлж олдог золбин амьтан байв. Паул эргүүлээд, чуулганыг завхруулахыг санаархагч еврей хуурамч багш нарыг ингэж нэрлэж байна. Тэд үнэхээр гадна амьдрагсад байсан бөгөөд ёс заншил, зан үйлийн дагуу амьдрахыг оролдож байв. “Тэд найрлан суух боломжтой атал гадаа үртэс түүгчид юм.”

Хоёрдугаарт, тэд **бузрыг үйлдэгчид**. Тэд жинхэнэ итгэгч шиг дүр эсгэж, хуурамч сургаалиа тараахаар христитгэлт нөхөрлөлд орж

ирдэг. Тэдний ажлын үр дүн нь зөвхөн хорон муу байдаг.

Паул тэднийг мөн **хуурамч хөвч хөндүүлэгсэд** гэсэн. Энэ бол тэдний хөвч хөндөлтөд хандах хандлагыг ёжилсон хэллэг. Тэд аврагдахын тулд заавал хөвч хөндөлт хийлгэх ёстой гэж шаарддаг байв. Гэвч тэд зөвхөн бие махбодод хийдэг хөвч хөндөх зан үйлийг л анхаардаг. Тэд үүний сүнслэг утгыг огт хайхардаггүй. Хөвч хөндөлт нь бие махбодын үхлийг билэгддэг. Энэ нь бие махбодын хүслийг зөвшөөрч болохгүй гэсэн утгатай. Тэд хөвч хөндөлтийн зан үйлийг хийхийг шаарддаг хэрнээ махбодын хүслээ чөлөөтэй тавьдаг байв. Тэд махбод загалмай дээр үхсэнийг зүрхнээсээ зөвшөөрдөггүй. Паул тэднийг зан үйл болон цаадах утга учрыг ялгадаггүй хуурамч хөвч хөндүүлэгсэд гэж хэлсэн.

[3:3]

Үүний эсрэгээр Паул еврей эцэг эхээс төрсөн эсвэл махбодын хөвч хөндөлт хийлгэсэн нь биш, махбодод ямар ч ашиггүй хүн өөрийн хүчээр Бурханаас сайшаал хүртэх боломжгүйг

ухаарагсад (жинхэнэ итгэгч) **биднийг хөвч хөндүүлэгсэд** гэж нэрлэсэн. Тэгээд Паул жинхэнэ хөвч хөндүүлэгсдийн талаар гурван тодорхойлолт хэлжээ. Үүнд:

(2) Тэд **Бурханы Сүнсээр** (буюу Сүнс дотор)

мөргөдөг. Тэд зан үйл төдий биш харин жинхэнэ сүнслэг мөргөлчид юм. Жинхэнэ сүнслэгээр мөргөж байгаа хүн Бурханы оршихуйд итгэлээр орж, хайр, магтаал, бишрэл хүндлэлээ өргөдөг. Нөгөө талаас, сэтгэлийн хөдөлгөөнөөр мөргөгчид сайхан барилга, тавилга, нуршуу зан үйл, ёслол, санваартны гоёмсог өмсгөл зэрэг сэтгэл татагдах зүйлд анхаардаг.

(3) Жинхэнэ хөвч хөндүүлэгсэд **Христ**

Есүсээр сайрхдаг. Тэдний сайрхлын үндэс бол зөвхөн Тэр. Тэд өөрсдийн хувийн амжилт, гарал үүсэл эсвэл зан үйлийг итгэмжтэй сахьсанаараа сайрхдаггүй.

(4) Тэд **бие махбоддоо түшиглэдэггүй.** Тэд

махбодын хичээл зүтгэлээр аврагдана, хожим өөрийн хүчээр амьдарна гэж үздэггүй. Адам өвгийн мөн чанараас нь авууштай сайн юм байхгүйг мэддэг

болохоороо ямар нэг сайн зүйл олдохгүй
байлаа гээд санаагаар унадаггүй.

**VI. Паул Христийн төлөө өв
залгамжлалаасаа татгалзаж, хувийн
ололт амжилтаа үгүйсгэв (3:4-14)**

[3:4]

Энэ хүмүүс бие махбодын давуу тал, ололт амжилтаараа бардамнаж байгааг бодохоор Паулын инээд хүрч байсан нь дамжиггүй. Тэд тэгж бардамнаж болдог юм бол бардамнах шалтгаан Паулд ямар илүү их байсан гээч! Хүмүүсийн бардамнан бахархдаг тэрхүү төрөлх давуу талуудыг ямар дээд хэмжээнд эзэмшиж байгаагаа дараагийн хоёр ишлэлд дэлгэн харуулжээ. “Хүний хүсэн мөрөөдөж, зүтгэн тэмүүлэх бараг бүх хэргэм зиндаа түүнд байсан мэт.”

Энэ хоёр ишлэлийн талаар Арнот хэлэхдээ: “Өөрийн нүдэнд зөвт фарисайн гайхуулдаг бүх юмыг энд жагсаажээ. Тэрээр бохир муухай хувцасаа гайхуулан дэлгэх дуртай.”

Паулын хэлсэн зүйлсийг харвал: Гарал угсаагаараа бардах (ишлэл 5а); уламжлалаараа бардах (ишлэл 5б); үйл хэргээрээ бардах (ишлэл 6а); ёс суртахуунаараа бардах (ишлэл 6б) тухай ярьж байна.

[3:5]

Паулын төрөлхийн болон махбодын давуу талуудыг энд дурьджээ:

Найм дахь хоногтоо хөвч хөндүүлсэн – Ишмаелын үр угсаа ч юмуу, иудейн шашинд элссэн хүн биш харин төрөхдөө л иудей байсан.

Израиль үндэстэн - Бурханы дэлхийгээс сонгосон ард түмний нэг.

Бениамин овгийн хүн- Язгууртан гэж тооцогддог (Шүү 5:14) овог бөгөөд үүнээс Израилийн анхны хаан гарсан.

Еврей хүнээс төрсөн еврей – тэрээр үндэстнийхээ анхдагч хэл, зан заншил, ахуй соёлоо хадгалж үлдсэн хэсэгт харьяалагдаж байв.

Хуулиар бол фарисай - Фарисайчууд уламжлалт сургаалаа хадгалж үлдсэн, харин садукайчууд амилалтыг үгүйсгэдэг.

[3:6]

идэвх зүтгэлээрээ бол чуулганыг хавчигч – Паул христитгэгчид хэмээх “гаж урсгалыг” арилгах гэж хичээснээрээ Бурханд үйлчилж байна гэж чин сэтгэлээсээ бодож байв. Тэрээр өөрийнх нь шашинд аюул занал учруулна хэмээн газрын хөрснөөс арчин хаях ёстой гэж үзсэн.

Хууль дахь зөвт байдлаар бол гэм зэмгүй - гэдэг нь Паул хуулийг төгс сахьсан гэсэн үг биш. Тийм бус гэж Ром 7:9, 10-д улайсан байдаг. Тэрээр өөрийгөө **гэм зэмгүй** гэсэн болохоос нүгэлгүй гээгүй. Паул аливаа хуулийг зөрчвөл шаардлагатай тахилаа өгдөг байсан гэж л дүгнэхээр байна. Өөрөөр хэлбэл тэр иудейн шашны хууль дүрмийг үгчлэн чанд мөрдөгч байжээ.

Тиймээс төрөлт, гарал угсаа, уламжлал, хичээл зүтгэл, хувь хүний зөвт байдлын хувьд Тарсын Саул онц хүн байв.

[3:7]

Харин одоо элч энэ бүгдийг гайхалтайгаар үгүйсгэж байна. Энд тэрээр бидэнд өөрийн “Ашиг алдагдлын тайлангаа” харуулжээ.

Дэнсний нэг талд түүний дээр дурьдсан зүйлс нь жагсаалттай. Нөгөө талд нь ганцхан **Христ** гэдэг үгийг бичжээ. Энэ бүгдийг Христ дотор олсон эрдэнэтэй нь харьцуулахад юу ч биш аж. Тэрээр **Христийн төлөө** тэдгээрийг **гарз хохирол** болгон **тооцов**. Гаи Кинг “Санхүүгийн бүх ололт, материаллаг бүх ололт, бие махбодын бүх ололт, оюун ухааны бүх ололт, ёс суртахууны бүх ололт, шашны бүх ололт бүгд тэрхүү Агуу Ололттой харьцуулбал ололт биш”¹⁴ гэж хэлсэн.

Тэдгээр зүйлд дулдуйдаж байгаа цагт аврагдах ямар ч боломжгүй. Түүнийг аврагдсан даруйд тэдгээр нь түүний хувьд юу ч биш болсоны учир гэвэл тэр Эзэний алдрыг харсан бөгөөд Эзэний алдартай харьцуулахад нөгөө алдрууд юу ч биш гэж санагдсан.

[3:8]

Христ дээр ирж аврагдахдаа Паул **бүх юмсыг** үгүйсгэж, **Эзэн Христ Есүсийг таньж мэдэхийн давуу агуу байдалтай** харьцуулбал ямар ч үнэ цэнэгүй гэж үзсэн. **Таньж мэдэхийн давуу агуу байдал гэдэг нь** еврей хэлээр “агуу мэдлэг”

юмуу “юм мэдэхийн агуу давуу үнэ цэнэ” гэсэн утгатай.

Элч гарал, яс үндэс, ахуй соёл, нэр хүнд, боловсрол, шашин шүтлэг, хувийн ололт амжилт бүхнээ сайрхах үндэс болгохоо больсон. **Христийг олохын тулд тэр тэдгээрийг хог хаягдал** гэж тооцсон.

Энэ ишлэлд, бас дараагийн ишлэлд одоо цаг хэрэглэсэн ч гэсэн Паул өнгөрсөнөө эргэн дурсаж өөрийн аврагдсан мөчийн тухай ярьж байна. **Христийг олохын тулд** хамгийн эрхэм, үнэ цэнэтэй гэж заалгасаар ирсэн зүйлсээсээ татгалзах шаардлагатай болжээ. Христийг олъё гэвэл тэр эхийнхээ шашин, эцгийнхээ өв болон өөрийн ололт амжилтандаа “баяртай” гэж хэлэх шаардлагатай болсон юм.

Ийнхүү тэрээр үйлдсэн! Тэрээр аврагдахын тулд иудаизмаас бүх холбоогоо тасалсан. Үүнээс болж гэр бүл хамаатан садан өв залгамжлалаасаа түүнийг хассан, найз нөхөд нь хөндийрсөн, нутгийнхан нь түүнийг хавчсан. Христитгэгч болсон тэр **бүх юмаа** шууд утгаар алдсан.

Наймдугаар ишлэлийг одоо цаг дээр бичсэн болохоор Паул **Христийг олохыг** эрмэлзсээр

байгаа мэт санагддаг. Үнэндээ тэрээр анх Түүнийг Эзэн Аврагчаа гэж хүлээн зөвшөөрөхдөө Христийг олсон. Гэхдээ одоо цаг хэрэглэсэн нь Эзэн Есүсийг таньж мэдэхийн үнэ цэнэтэй харьцуулахад бусад бүх зүйл **хог гэж** үзэх хандлага хэвээр байгааг илэрхийлж байна. Түүний зүрхний агуу хүсэл: “Христ миний ололт байгаасай”. Алт юм уу мөнгө эсвэл шашны нэр хүнд биш зөвхөн Христ.

[3:9]

Мөн Түүн дотор олодох. Энд дахиад л Паул Христ дотор олохыг хичээж байх шиг сонсогдож байна. Үнэндээ аврагдахын өмнө өөрт нь тулгарч байсан агуу шийдвэрээ эргэн дурсаж байна. Тэр аврагдахын тулд хичээл зүтгэлээ орхиж, зүгээр л Христэд итгэхэд бэлэн байсан уу? Тэр сонголтоо хийсэн. Христ дотор олохын тулд тэр бусад бүх зүйлээс татгалзсан. Эзэн Есүст итгэх мөчид тэрээр Бурханы өмнө шинэ байр суурьтай болсон. Түүнээс хойш тэр гэм нүгэлт Адамын хүүхэд гэж харагдах биш, харин *Христ дотор* харагдаж Бурхан Эцэгийн

өмнө Эзэн Есүсийн эдэлдэг бүх хувь завшааныг эдэлнэ.

Үүнчлэн тэрээр хууль сахиснаар өөрийгөө зөвтгөх ноорхой бохир хувцас мэт хандлагаа орхиж, Аврагчийг хүлээн авсан хүн бүхэнд соёрхогддог **Бурханы зөвт байдлыг** сонгожээ. Зөвт байдлыг энд хувцас юмуу бүтээлэгтэй адилтгасан байна. Бурханы тааллыг олохын тулд хүнд зөвт байдал хэрэгтэй. Гэвч хүн өөрөө үүнийг бий болгож чадахгүй. Тийм учраас Бурхан Түүний Хүүг Эзэн, Аврагчаа гэж хүлээж авсан хүмүүст *Өөрийн зөвт байдлыг* нигүүлсэн өгдөг. “Тэр (Бурхан) нүглийг үл мэдэгч Түүнийг (Христийг) бидний төлөө нүгэл болгосон. Тэгснээр бид Түүний дотор Бурханы хүртээх зөвт байдал болох юм” (2Ко 5:21).

Дахин хэлэхэд 8, 9-р ишлэлүүд Паул Бурханы зөвт байдлыг хараахан аваагүй байгаа гэж хэлэх гээгүйг онцолж байна. Тэр Дамаск уруу явах замдаа шинээр төрж үүнийг эзэмшил болгон авсан. Одоо цаг дээр ярьсаар байгаа нь тэрхүү чухал үйл явдлын үр дүн одоо ч үргэлжилж байгааг, Паул одоо ч Христийг бүхнээс илүү үнэ цэнэтэй гэж үзэж байгааг илтгэнэ.

[3:10]

Бид энэ ишлэлээс элчийн амьдралын хамгийн дээд сэтгэл хөдлөлийг харна. Ф.Б Мейер үүнийг “Өөрийн Христийг олохын төлөөх сэтгэлийн эрэл” гэж хэлжээ.

Энэ ишлэлийг хүмүүс “сүнслэгээр” тайлбарлах гээд байдаг. Өөрөөр хэлбэл **зовлонгууд, үхэл болон амилалт** гэдгийг шууд утгаар нь хэлээгүй гэж. Тэдгээр нь сэтгэлийн зовлон, өөрийгөө үхүүлэх болон амилсан амьдралаар амьдрах зэрэг сүнсний амьдралыг хэлж байна гэдэг. Гэхдээ бид энэ хэсгийг шууд утгаар нь ойлгохыг зөвлөж байна. Би Христ шиг амьдрахыг хүснэ гэж Паул хэлж байна. Есүс зовлон эдэлсэн бол Паул ч мөн зовохыг хүсэж байна. Есүс үхсэн бол Паул Христэд итгэх итгэл, Түүнд үйлчлэх үйлчлэлийнхээ улмаас үхэхэд бэлэн байна. Есүс үхэгсдээс амилсан бол Паул мөн ингэхийг хүсэж байна. Тэрээр боол нь Эзэнээсээ илүү байдаггүйг ухаарсан. Тиймээс тэрээр Христийг Түүний **зовлон, үхэл болон амилалт** дотор дагахыг хүсэж байлаа. Тэр хүн бүхэн өөрийнх нь энэ санааг дагах ёстой гээгүй харин түүний хувьд үүнээс өөр замгүй байв.

Түүнийг таньж мэдэхийн тулд. Түүнийг мэдэх гэдэг нь өдрөөс өдөрт Түүнтэй танилцаж дотноссоноор улам Христ шиг болохыг хэлж байна. Тэрээр Христийн амьдрал түүний дотроос дахин давтагдаасай гэж хүссэн.

Түүний амилалтын хүч. Эзэнийг үхэгдээс амилуулсан **хүчийг** ертөнц дэлхий дахины урьд хожд үзээгүй хүчний аугаа үзэгдэл гэж Бичээст тайлбарласан (Еф 1:19, 20). Хорон муу бүхэн Түүний биеийг булшинд үлдээхийг санаархсан мэт. Бурханы аугаа хүч чадал, Эзэн Есүсийг, гурав дахь өдөр нь, үхлээс амилуулснаар энэхүү буг чөтгөрийн хүчийг ялсан билээ. Яг энэ **хүчийг** бүх итгэгчид итгэлээр давах боломжтой (Еф 1:19). Паул энэхүү хүчийг өөрийн амьдрал болон гэрчлэлээрээ мэдрэхийг хүсэн зорьсоноо илэрхийлж байна.

Зовлонгуудын нөхөрлөл. Христийн төлөө зовоход тэнгэрлэг хүч шаардагддаг. Тийм учраас **Түүний амилалтын хүч нь Түүний зовлонгуудын нөхөрлөлийн** өмнө тавигдсан.

Эзэн алдаршихын өмнө зовсон. Тиймээс Паулын амьдралд ч ийм зүйл болох ёстой байж. Тэр Христийн **зовлонгуудыг** хуваалцах ёстой.

Христийн эдэлсэн зовлонд байсан эвлэрүүлэх хүч өөрийнх нь зовлонд байхгүй ч тэрээр Эзэнийхээ адлагдаж, ташуурдуулж, цовдлогдсон энэ дэлхий дээр тансаг амьдрах нь зохицохгүй хэрэг болно гэдгийг мэдэж байсан. Жовет үүнийг тайлбарлахдаа: “Тэрээр Чидун уулан дээрх ялалтыг хуваалцаад санаа амраагүй, Гетсемани цэцэрлэгийн ганцаардлын шаналал, жихүүцлийг мөн амсахыг хүссэн” гэжээ.¹⁵

Түүний үхэлтэй адил болгогдоно. Паул цовдлогдсон амьдралаар амьдрахыг хүссэн, өөрөөр хэлбэл гэм нүгэлд, өөртөө болон дэлхийн хувьд үхэж амьдрахыг хэлж байна гэж тайлбарладаг хэмээн дурдсан. Гэхдээ бидний бодлоор ингэж ойлгох нь ер бусын их хүчийг нь үгүйсгэн дарсан хэрэг болно. Энд ийм утга байгаад зогсохгүй үүнээс ч гүн утга бий. Паул Гавлын толгод дээр цовдлогдсон Нэгэнийг сэтгэлээсээ үнэнч дагасан хүн байв. Тэр итгэлийнхээ улмаас амиа алдаж буй анхны христитгэгчийн дэргэд нь байгаад зогсохгүй тэр нэгнийг хороох ажилд гар бие оролцсон хамсаатан байжээ. Паулыг өөрийн амьдралаа яг ингэж асгахыг эрмэлзэж байсан гэж бид итгэдэг.

Тэрээр итгэлээсээ болж алуулахаас өөр, илүү тав тухтай замаар тэнгэрийн улсад очиж, Стефантай уулзсан бол ичих байсан биз. Жовет үүнтэй ийнхүү санал нэг байна:

Олон христитгэгч “цус урсгах” шаардлагагүй золиос гаргаад сэтгэл ханадаг. Тэд тавьж явуулахад хялбар зүйлээ өгч чаддаг. Тэд чухал биш, дайвар зүйлсээ бэлэг сэлт болгон өгдөг бөгөөд тэдгээрийгээ өгөхөд тэдний цус урсдаггүй. Тэд амь амьдралыг нь нэхээгүй бол золиос гаргахыг зөвшөөрдөг. Харин амин чухал зүйл шаардагдахад тэд алга болдог. Тэд ялалтын баяр жагсаалын тэргүүнд алхаж, багахан мөнгөө өнгөлөг гоёл чимэглэл, туг далбаа, дал модны мөчирт зарцуулахад бэлэн. Харин “Хурай”, “Хосанна” гэдэг үгс аюул заналын чимээ болон хувирч, загалмай нүдэнд нь үзэгдээд ирэхээр тэд алсын аюулгүй газарт бүгдэг.

Гэтэл энд энэхүү амин чухал шаардлагыг баяртайгаар хүлээн буй элч байна. Тэр хаанчлалын үйлчлэлийн төлөө үхэн хатан

махран зүтгэж буйгаа чамлан бүхнээ шавхан дуусгахад бэлэн байна! ¹⁶

Хадсон Тейлор мөн үүнтэй ижил бичжээ:

Бидэнд дэлхийн амьдралын төлөө *өөрсдийгөө* зориулах цаг тулгардаг... Үр жимс ургуулахын тулд загалмайгаа үүрэх хэрэг гардаг. “Улаан буудайн үр газар унаад үхэхгүй бол ганцаар л үлддэг.” Эзэн Есүс үр жимс ургуулахын тулд яасныг бид мэднэ. Тэр зөвхөн загалмайгаа үүрээд зогсохгүй загалмай дээрээ үхсэн. Энэ зүйлээр бид Түүнтэй нөхөрлөдөг үү? Назгай христигчдийн төлөө назгай Христ, онцгой итгэгчдийн төлөөх зовсон, тэмцсэн Христ гэж хоёр Христ байдаггүй. Ганц л Христ байдаг. Бид Түүний дотор байж үр жимс ургуулахад бэлэн байна уу? ¹⁷

Эцэст нь С.А. Көүтс хэлэхдээ:

Алдар доторх Христийг таньж мэдэх нь Паулын зүрхний туйлын хүсэл байсан. Энэхүү хүсэл Түүний байгаа газарт очиж Түүнд хүрэх хүслийг нь оргилуулахгүй байж чадаагүй. Ингэж Түүнийг хүсдэг сэтгэл тэрхүү алдарт хүргэсэн зам уруу хөтлөх ба

Түүний туулсан замаар Түүнд хүрэхийг хүснэ. Ийм сэтгэл “Тэр яаж алдарт хүрсэн юм бэ? Үхлээс амилж хүрсэн үү? Үхлээс амилахын өмнө зовлон шаналал болон үхэл байх шаардлагатай юм биш үү?” гэж асууна. Тэгээд: “Түүний замнасан замаар л амилалтын алдарт байгаа Түүнд хүрэхээс өөр юу ч миний санаанд бүрэн нийцэхгүй” гэж хариулна. Энэ нь итгэлийнхээ төлөө үхэх хүний сэтгэл. Паул зүрх сэтгэлийг нь эзэмдсэн ерөөлт Нэгэний явсан замаар л явж, амилалт, алдарт хүрэхийн тулд итгэлийнхээ улмаас алагдахаас буцахгүй зовлон ба үхлийн замыг сонгохыг хүсчээ.¹⁸

[3:11]

Энд бид тайлбарын асуудалтай дахин тулгарч байна. Бид энэ ишлэлийг шууд утгаар нь ойлгох уу эсвэл сүнслэг утгаар нь ойлгох уу? Олон тайлбар байдгаас гол хэдийг дурдъя:

(1) Паул үхлээс амилах эсэхээ баттай мэдэхгүй байсан учраас амилалтанд багтахын тулд байдгаараа чармайж байсан гэж үзэх. Ийм үзэл байж боломгүй! Паул

амилалт бол хүний хичээл зүтгэл буюу ажлаар бус харин нигүүлслээр өгөгдөнө гэж үргэлж заадаг байсан. Нэмж хэлэхэд, тэрээр амилна гэдэгтээ маш тодорхой итгэж байгаагаа илэрхийлсэн (2Ко 5:1-8).

(2) Паул махбодын амилалтын тухай огт яриагүй харин дэлхий дээр амилалтаар амьдрах хүсэлтэй байгаагаа хэлсэн гэж үзэх. Ихэнх тайлбар тольд энэ санааг дэмждэг байх.

(3) Паул махбодын амилалтын тухай ярьж байсан гэхдээ өөрөө амилах эсэхэд эргэлзэх санаа огт илэрхийлээгүй. Харин амилахын өмнө туулах зовлон бэрхшээлийнхээ талаар санаа зовохгүй байна гэсэн. Амилалтад хүрэх замд аймшигтай зовлон зүдгүүр болон хавчлагыг туулах шаардалага байвал тэдгээрийг даван туулахад бэлэн байсан.

Бид гурав дахь тайлбартай санал нэг байна. Элч Христтэй адил болохыг хүссэн. Христ зовлон эдэлж, үхэж, үхэгсдээс амилуулагдсан

болохоор Паул ч үүнийг хүссэн. Ая тухтай, амар хялбар, тансаг амьдралыг хүсдэг сэтгэл маань Библийн эдгээр ишлэлийн хурц ирмэгийг мөлийлгөхөд хүргэдэг болов уу гэж эмээж байна. Библийн бусад хэсэгтэй авцалдахгүй утга гаргаагүй л бол тухайн санааг байгаагаар нь, шууд утгаар нь ойлгох нь найдвартай биш үү?

Энэхүү ишлэлээс цааш явахаас өмнө бид Паулыг **үхэгсдээс амилуулагдах** тухай ярьж байгааг анзаарах хэрэгтэй. Энд бүх үхэгсэд амилах тухай яриагүй байна. Харин зарим нь амилуулагдаж, бусад нь булшин дотроо үлдэх тухай **амилалтыг** хэлж байна. 1Тесалоник 4:13-18 болон 1Коринт 15:51-57-оос харахад итгэгчид бүгд Христийг ирэхэд (зарим нь шүүрэлтээр, зарим нь Зовлонгийн төгсгөлд) амилуулагдана, харин бусад үхэгсэд дэлхий дээрх, Христийн мянган жилийн хаанчлал дуустал амилуулагдахгүйг бид мэднэ (Илч 20:5).

[3:12]

Элч өөрийгөө **хэдийн төгс болчихсон** гэж үзэхгүй байна. Төгс болгогдоно гэдэг нь өмнөх ишлэлийн амилалтын тухай хэлээгүй харин

Христтэй адил болох тухай сэдвийг бүхэлд нь хэлж байна. Тэрээр огт нүгэлгүй болох буюу цаашид сайжруулах боломжгүй байдалд хүрч болно гэж төсөөлж чадахгүй байв. “Сэтгэл ханах нь өсөлтийн төгсгөл” болохыг тэр ухаарчээ.

Тиймээс түүнийг аварсан Эзэн Есүсийн зорилго нь түүний дотор биелэгдэхийн тулд тэр урагш зүтгэсээр байв. Элчийг Дамаск уруу явах замд **Христ Есүс** таарч түүнийг зогсоосон. Энэхүү түүхэн уулзалтын зорилго юу байв? Паул үлгэр жишээ итгэгч болж, Христ хүний амьдралд, юу хийж чаддагийг харуулах Бурханы зорилго байсан. Тэрээр Христтэй бүрэн адил болж амжаагүй байсан. Ингэх үйл явц үргэлжилсээр байсан бөгөөд Бурханы нигүүлсэл улам гүн гүнзгий болж үргэлжлэхийн төлөө Паул дасгалжсан байв.

[3:13]

Ямар л материаллаг зүйл байна, түүндээ сэтгэл хангалуун байж сурсан (4:11) энэ хүн сүнсний ололтууддаа хэзээ ч сэтгэл ханаж чадахгүй байв. Бидний ярьдгаар тэр өөрийгөө “хийдгээ

хийчихлээ” гэж **боддоггүй** байв. Тэр тэгээд яасан юм бэ?

Харин нэг л юмыг хийдэг. Тэр ганцхан зорилготой хүн байсан. Түүнд нэг зорилго, нэг хүсэл тэмүүлэл байсан. Үүгээрээ тэр “Эзэнээс би нэг л зүйлийг гуйя” гэж хэлсэн Давидтай адилхан.

Ардахаа мартана гэдэг нь өөрийнхөө гэм нүгэл, алдаа зөрчлийг хэлсэн төдийгүй энэ бүлгийн эхэнд дурьдаж байсан, өөрт төрөхөөс заяасан давуу талууд, эрх мэдэл, ололт амжилт, тэр ч бүү хэл сүнсний ялалтуудаа ч хэлж байна.

Урьдах зүйлс уруугаа зүтгэн тэмүүлдэг гэдэг нь мөргөл, үйлчлэл болоод христитгэлт зан чанарын төлөвшил, христитгэлт амьдралын давуу талууд болон үүрэг хариуцлагыг хэлжээ.

[3:14]

Паул өөрийгөө уралдаанд гүйгч гэж үзэж, **Христ Есүс дотор Бурханы дээш чиглэсэн дуудлагын шагналын төлөө бариа уруу урагшилахад** бүх хүчээ зориулдаг гэжээ.

Бариа гэдэг нь уралдааны замын төгсгөлд байх шугам. **Шагнал** бол ялагчид олгодог зүйл.

Энд бариа гэдэг нь амьдралын уралдааны төгсгөлийг, бүр тодорхой хэлбэл Христийн шүүх сэнтийг хэлж байж болно. **Шагнал** гэдэг нь Паулын өөр газар уралдаанд сайн гүйсэнд олгодог гэж дүрсэлсэн зөвт байдлын титэм юм (2Тм 4:8).

Христ Есүс дотор Бурханы дээш чиглэсэн дуудлага гэдэгт биднийг аврахдаа бидэнд зориулж Бурханы бодож санасан бүх зорилго орно. Үүнд аврал, Христтэй ижил болох, Түүнтэй хамт өв залгамжлах, тэнгэрийн улсын гэр орон болон тоо томшгүй олон сүнслэг ерөөлүүд багтана.

VII. Элчийн үлгэр жишээгээр тэнгэрлэг алхаанд дуудсан уриа (3:15-21)

[3:15]

Тиймээс төлөвшсөн бүхэн Христийн төлөө зовох болон үхэхэд бэлэн байгаа, Эзэн Есүстэй адилхан болохын төлөө бүхий л хүчин чармайлтаа гаргаж байгаа Паулын байдлыг хуваалцах хэрэгтэй. Энэ бол төлөвшсөн

христитгэгчийн бодол. Зарим нь үүнийг хэтэрхий туйлширсан, мухар сүсэг гэж хэлдэг. Гэвч элч өсөж төлөвшсөн нэгэн өөрийнх нь төлөө Гавлын толгодод цусаа урсгасан Нэгэнд барих цорын ганц ухаалаг, зайлшгүй, утга учиртай хариу үйлдэл гэдгийг ойлгодог гэжээ.

Хэрэв ямар нэгэн юман дээр та нар өөр бодолтой байвал, үүнийг бас Бурхан та нарт илэрхийлнэ. Ийм аюултай үзэл санааг бүгд хүлээж авахгүйг Паул мэдэж байв. Гэвч хэрэв хүн хэрэг явдлын үнэн учрыг мэдэхийг үнэхээр хүсэж байвал **Бурхан түүнд илчлэх болно** гэдэг итгэлээ илэрхийлжээ. Өнөөдөр назгай, алгуур христитгэгчид байгаагийн учир шалтгаан нь бид үнэнийг, төгс христитгэлийн шаардлагыг мэдэхийг хүсдэггүйд оршино. **Бурхан** үнэнийг дагахыг хүссэн хүмүүст үнэнийг илчлэхэд бэлэн байдаг.

[3:16]

Үүний сацуу, Бурханы бидэнд ямар гэрэл тусгасан байна түүний дагуу амьдрах хэрэгтэй гэж элч хэлж байна. Христитгэгч биднээс шаарддаг арай илүү бүрэн дүүрэн мэдлэгт хүртэл

цаг товлох нь илүүц юм. Бурхан бидэнд загалмайн утга учрыг бүрэн илчлэхийг хүлээх зуураа бид өөрсөддөө өгөгдсөн үнэний **хэмжээгээр** дагах хэрэгтэй.

[3:17]

Одоо Паул дахин уриалж байна. Тэр эхлээд филиппойчуудыг өөрийнхөө дагалдагч буюу дууриагчид болоорой гэжээ. Үлгэр жишээ амьдарч байж л ийм үг бичиж чадна. Бид “Миний хийж байгааг биш хэлж байгааг хий” гэж тоглоомоор хэлэхийг олонтаа сонсдог. Элч харин тэгсэнгүй. Тэрээр өөрийнхөө амьдралыг Христэд болон Түүний үйлсэд бүхий л зүрхээ зориулсны үлгэр жишээ болгож чаджээ.

Лейман Штраусс бичихдээ:

Паул өөрийгөө христитгэгч хүн ямар байх ёстойг үлгэрлэн харуулахын тулд Бурханы өршөөлийг хүртсэн гэж үзэн аврагдсаныхаа дараа христитгэгч хүний амьдрал ямар байх ёстойг харуулахын тулд амьдарчээ. Есүс Христ Паулд хийснийгээ мөн бусдад хийж чадна гэдгийг харуулах үлгэр жишээ болгохын тулд Бурхан Паулыг аварсан.

Бидний Эзэн Өөрийнхөө өршөөлийг танд бас надад харуулсан нь энэ л зорилгын төлөө биш гэж үү? Тэрээр ирээдүйд итгэх бүх хүнд үлгэр жишээ болгохын тулд биднийг аварсан гэж би итгэдэг. Түүний нигүүлслээр аврагдсан тэдгээр хүмүүсийн үлгэр жишээгээр бид үйлчилж байна уу? Тийм л байгаасай!¹⁹

Бидний та нарт үзүүлсэн жишээгээр явдаг хүмүүсийг ажигла. Энд Паул шиг амьдралаар амьдарсан бусад хүний тухай ярьж байна. Энэ нь дараагийн ишлэлд хэлсэнчлэн тэднийг буруушаах утгаар биш харин тэднийг ажиглаж алхмуудыг нь дага гэж байгаа ажээ.

[3:18]

Арвандолдугаар ишлэлд итгэгчдийн дагах *ёстой* хүмүүсийг дүрсэлсэн бол энэ хэсэгт итгэгчдийн дагах *ёсгүй* хүмүүсийг хэлжээ. Элч эдгээр хүнийг нарийн тодорхой нэрлээгүй. Тэдгээр нь 2-р ишлэлд дурдагдаж байсан иудаизмын хуурамч багш нар уу, эсвэл эрх чөлөөг бүх зүйлийг хийх зөвшөөрөл гээд нигүүлслийг гэм нүгэл үйлдэх шалтаг болгодог

христитгэгчийн дүр эсгэгчдийг хэлсэн үү гэдэг нь тодорхойгүй байна.

Паул ариун хүмүүсийг эдгээрээс болгоомжил гэж өмнө нь анхааруулж байсан бөгөөд энэ удаа дахин **уйлан** байж хэлж байна. Ийм хурц ширүүн буруушааж байхдаа юунд нулимс унагаа вэ? Энэ хүмүүс Бурханы чуулганд учруулсан хор хөнөөлийн улмаас тэр. Тэдний сүйрүүлсэн амьдралын улмаас тэр. Тэд Христийн нэрийг буруутгагдахад хүргэсэн учраас тэр. Тэд загалмайн жинхэнэ утгыг гуйвуулснаас тэр. Тийм ээ, тэгэхдээ бас Эзэн Есүс алуурчин хот Иерусалимын төлөө уйлсны адил жинхэнэ хайр **Христийн загалмайн дайснуудыг** буруушааж байхдаа ч уйлдаг.

[3:19]

Энэ хүмүүс мөнхийн тамд унах тавилантай. Энэ нь устаж үгүй болно гэсэн үг биш харин Бурханы шүүлтийн дагуу мөнхийн галт нууранд унах болно гэсэн үг.

Тэдний **бурхан** бол **тэдний ходоод**. Тэдний бүх үйл тэр байтугай шашинлаг дүр эсгэсэн үйлчлэл нь хүртэл өөрсдийн идэх уух юмны

төлөө, өөрсдийн махбодын дур хүслээ хангахын тулд байдаг. Ф.Б. Мейер ийм хүмүүсийг тохиромжтой дүрсэлжээ: “Тэдний амьдралд ямар ч мөргөлийн газар байдаггүй. Бүх юм нь гал тогоо.”

Тэдний **алдар** нь тэдний **ичгүүр дотор** байдаг. Тэд ичих ёстой байсан өөрсдийн нүцгэн байдал болон ёс суртахуунгүй зангаараа сайрхдаг.

Тэд **дэлхийн зүйлсээр** эзэмдүүлдэг. Тэдний хувьд амьдралын чухал зүйлс нь хоол хүнс, хувцас, алдар хүнд, ая тух болон зугаа цэнгэл болно. Тэд энэ дэлхийн хог шаарны төлөө нэр нүүрээ баран явдаг атлаа мөнхийн хэрэг болон тэнгэрлэг зүйлсийг огт тоодоггүй. Тэд дэлхий дээр мөнхөд амьдрах юм шиг авирладаг.

[3:20]

Элч одоо жинхэнэ итгэгчийн тэнгэр лүү чиглэсэн хандлагыг эсрэгцүүлэн тавьж байна.

Энэ захидал бичигдэх үед Филиппой хот Ромын хараат хот байсан (Үйл 16:12). Филиппойчууд Ромын иргэд байсан тул Ромын хамгаалалтан дор давуу эрх эдэлдэг байсан. Тэд мөн өөрсдийн орон нутгийн засаг захиргаанд

харьяалагддаг иргэд байсан. Элч итгэгчдийн **иргэний харьяалал нь тэнгэрт** байгаа гэж сануулсан. Мофат үүнийг: “Бид тэнгэрийн улсын колони” гэж хөрвүүлсэн.

Энэ нь христитгэгчид дэлхийн улсын иргэд бус гэсэн үг биш бөгөөд Бичээсийн бусад хэсэгт биднийг засаг захиргаандаа захирагд гэж тодорхой заадаг (Ром 13:1-7). Яагаад гэвэл Бурхан засаг захиргааг зөвшөөрөн тогтоодог гэжээ. Үнэндээ Эзэн л хориглоогүй бол итгэгчид бүх асуудал дээр засаг захиргаагаа бүх талаар дагах учиртай. Филиппойчууд орон нутгийнхаа захиргаа болон Ромын эзэн хаандаа дуулгавартай захирагдах тангарагтай байв. Түүний нэгэн адил итгэгчид дэлхий дээрх засаг захиргаанд дуулгавартай байх үүрэгтэй, гэхдээ нэн тэргүүнд тэнгэрт байгаа Эзэнд үнэнч байх учиртай.

Бид тэнгэрийн улсын иргэн төдийгүй **бид Аврагчийг** тэнгэрийн улсаас ирэхийг **хүлээж байна! Хүлээж байгаа гэдэг нь** (эх хэл дээрээ) тун удахгүй болох зүйлийг тэсэн ядан хүлээж буйг илэрхийлсэн хүчтэй үг байдаг. Энэ нь шууд

утгаараа сонсох юмуу харах гэж хүзүү сунган өлийж байгаа гэсэн утгатай.

[3:21]

Эзэн Есүс тэнгэрийн улсаас ирэхдээ бидний газрын биесийг өөрчилнө. Хүний бие махбодод өөрт нь ямар ч бузар булай эсвэл хорон муу зүйл байхгүй. Харин махбодио буруу зорилгоор хэрэглэвэл хорон муу болдог.

Гэхдээ энэ нь **дорд бие** буюу дорой бие. Энэ бие үрчийдэг, шарх сорви болдог, хөгширдөг, зовж шаналдаг, өвчилдөг бас үхдэг юм. Энэ бие биднийг хязгаарладаг!

Эзэн энэ биесийг алдрын бие болгож **өөрчилнө**. Үүнийг бид бүрэн дүүрэн ойлгож чадахгүй. Энэ бие доройтол юмуу үхэл, цаг хугацаа, байгалийн саад тотгорт захирагддаггүй болно. Бодит атлаа тэнгэрийн улсын нөхцөлд төгс тохирсон бие болж өөрчлөгдөнө. Энэ бие Эзэн Есүсийн амилсан **биетэй** адил болно.

Энэ нь бидний махбод нэг төрхтэй болно гэсэн үг биш! Есүс дахин амилсныхаа дараа бусдаас ялгаран танигдахаар байсан бөгөөд хүн бүр

өөрийн онцлог төрхөө мөнхөд хадгалах нь дамжиггүй.

Энэ хэсэгт бид Бурханлаг мөн чанарын хувьд яг Эзэн Есүстэй адил болно гэж хэлээгүй. Бид хэзээ ч бүгдийг мэдэж, төгс хүчийг эзэмшиж эсвэл нэг цагт хаа сайгүй оршихгүй.

Гэхдээ бид ёс суртахууны хувьд яг Эзэн Есүс шиг болно. Бид үүрд гэм нүглээс чөлөөлөгдөнө. Энэхүү хэсэг нь бидний сониуч занг бүрэн дарахгүй байгаа ч бидэнд тайвширлыг өгч, найдвар төрүүлж байгаа нь хангалттай.

Тэр бүх юмсыг Өөртөө захируулж чадах хүчээрээ. Бидний махбодын өөрчлөлт нь Эзэн хожим **бүх юмсыг Өөртөө захируулахдаа** хэрэглэх тэр л тэнгэрлэг хүчээр хийгдэх болно. Тэрээр “аврах чадвартай” (Евр 7:25). Тэрээр “туслах чадвартай” (Евр 2:18). Тэрээр “хамгаалах чадвартай” (Иуд 24). Одоо энэхүү ишлэлээс бид Бурхан **захирах чадалтай** гэдгийг мэдэж авч байна. “... энэ Бурхан бол мөнхийн мөнхөд бидний Бурхан билээ. Тэр биднийг үхэн үхтэл хөтлөх болно” (Дуу 48:14).

VIII. Эв эе, харилцан туслалцаа, баяр хөөр, тэвчээр, залбирал ба оюун бодолдоо сахилга баттай байх тухай уриалга (4:1-9)

[4:1]

Элч өмнөх ишлэлд итгэгчдэд толилуулсан гайхалтай найдвар дээрээ үндэслэн одоо тэднийг **Эзэн дотор баттай зогсогтун** гэж уриалж байна. Энэхүү ишлэлд итгэгчдийг олон дотно нэрээр дуудсан. Юуны өмнө Паул тэднийг **ах дүү нар** минь гэжээ. Гэхдээ зүгээр л ах дүү нар минь гээгүй харин **хайрт ах дүү нар** минь гэж дуудсан байна. Тэгээд тэдэнтэй дахин хамт байхын хүслэн болж байгаагаа бичжээ. Тэднийг өөрийнх нь **баяр хөөр** ба **титэм** гэж нэрлэсэн. Тэд тэр үед түүний баяр хөөр байсан бөгөөд Христийн шүүхийн сэнтий өмнө түүний **титэм** болно. Элч хүмүүсийг үнэхээр хайрладаг байсан бөгөөд энэ нь түүний **Эзэн дотор үр нөлөөтэй** ажилладаг байсны нэг нууц биз ээ.

[4:2]

Юодиа Сунтухе нар нь Филиппойн чуулганы түнжин хагарсан эмэгтэйчүүд байв. Тэдний маргааны шалтгаан бидэнд тодорхой бус байна (магадгүй тэр нь ч сайн биз!).

Гуйя гэдэг үгийг хоёронтоо хэрэглэсэн нь аль алинд хандан ятгаж буйгаа харуулж байна. Паул тэднийг **Эзэн дотор санаа нэгтэй байгаарай** гэж ятгажээ. Бид амьдралын өдөр тутмын хэрэг бүхэн дээр нэг бодолтой байх боломжгүй ч Эзэний ажил урагшилж, Түүнийг алдаршуулахын тулд Эзэний холбогдолтой юмсын хувьд бид аахар шаахар, хувийн ялгаагаа хойш тавьж болно.

[4:3]

Энэ ишлэлд Паулын хэрэглэсэн **үнэнч нөхөр минь** (буюу адил буулга үүрэгч ²⁰) гэж хэн болохыг янз бүрээр таамагладаг. Тимот болон Лук байж болох ч Епафродитыг хэлсэн болов уу. Түүнийг **сайн мэдээний төлөө** Паултай **хамтран зүтгэсэн тэдгээр эмэгтэйчүүдэд туслаарай** гэж ятгаж байна. Бид эдгээр эмэгтэйчүүдийг Юодиа болон Сунтухе нар

байсан ба элч Паул хамгийн амьдралтай зөвлөгөө өгч байна гэж бид үздэг. Хоёр хүний хэрүүл маргааныг сүнсээр төлөвшсөн, хөндлөнгийн гуравдагч этгээдээр шийдвэрлүүлэх нь хамгийн сайн арга байдаг. Ингэхдээ тэрээр хэргийг зүгээр л шүүгээд шийдвэр гаргах биш харин сөргөлдөгч хүмүүсийг Бурханы үгээр гуйн ятгаж, тэдний асуудлыг Бичээс яаж шийдэх вэ гэдэг арга замыг харуулах чадвартай байхыг хэлж байна.

“[Тэд] **сайн мэдээний төлөө надтай хамтран зүтгэсэн**” гэдэг үгийг тайлбарлахдаа хянуур байх хэрэгтэй. Яаж ч ургуулан бодоод тэднийг элч Паултай хамт сайн мэдээг тунхагласан гэж ойлгож болохгүй. Эмэгтэйчүүд олон нийтэд заах юмуу номлох гэж булаацалдалгүй, Христийн зарц нарт зочломтгой хандах, айл хунараар орж эргэж тойрох, хүүхэд, залуу эмэгтэйчүүдэд зааж сургах гээд сайн мэдээн дотор ажиллах олон арга зам байна. **Клем** нэртэй бас нэгэн хамтран ажиллагчаа дурьджээ. Түүний талаар илүү тодорхой юм бичээгүй. Тэгээд Паул **нэрс нь амийн номонд бичигдсэн бусад хамтран зүтгэгчдээ** дурьдаж байна. Христэд итгэх итгэл

болон Түүнд үйлчлэх үйлчлэлийг дагаж ирдэг мөнхийн бөгөөд үгээр хэлшгүй ерөөлийг гайхалтай илэрхийлжээ.

[4:4]

Одоо Паул бүх чуулганд хандан дуртай ятгалгаа давтан хэлж байна. Түүний ятгалгын нууц нь **Эзэн** дотор гэдэг үгэнд оршдог. Амьдралын нөхцөл байдал хичнээн баргар байсан ч христитгэгчид **Эзэн дотор** үргэлж **баярлах** боломжтой.

Христитгэгчийн баяр хөөрийн талаар өөрийн туршлагыг Жовет хуваалцахдаа:

Христитгэгчийн баяр хөөр бол нөхцөл байдлаас хамаардаггүй төлөв байдал. Хэрэв энэ нь бидний эргэн тойрон дахь зүйлсээс шалтгаалдаг байвал салхитай шөнөөр хамгаалалтгүй асаж байгаа лаа шиг тогтворгүй байна. Лаа нэг харахад тогтуун асаж тод гэрэлтэнэ, хормын төдийд дөл нь дөнгөж үзэгдэхтэй үгүйтэй сүүтэгнэнэ. Гэхдээ христитгэгчийн баяр хөөр нь амьдралын зуурдын зүйлсээр хамаардаггүй болохоор өнгөрч одох өдрүүдийн золиос болдоггүй.

Нөхцөл байдал нэг өдөр яг л зуны нартай өдөр шиг байснаа нүд ирмэхийн зуур намрын бороотой өдөр шиг болж хувирдаг. Нэг өдөр би хурим дээр байхад маргааш нь онгорхой булшны дэргэд зогсож байдаг. Нэг өдөр би арван хүнийг Эзэн дээр ирүүлж байхад удаан хугацааны туршид нэг ч хүн өөрчлөгдөхгүй байх жишээтэй. Тиймээ өдрүүд яг цаг агаар шиг өөрчлөгдөж болох ч христитгэгчийн баяр хөөр тогтвортой байж болдог. Энэхүү ялгуусан тогтуун чанарын нууц нь юу вэ?

Нууц нь энэ байна. “Хар! Би *өдөр бүр* чамтай хамт байна. Өдрүүд өөрчлөгдөж байсан ч “Тэр өөрчлөгддөггүй, ядардаг ч үгүй.” Тэр амьдрал муугаар эргэхэд орхидог муу нөхөр биш. Тэр миний мандан бадарч явах өдрүүдэд дэргэд минь байчихаад ялагдан уруудах цагт орхидог нэгэн биш. Тэр намайг алдрын титэм өмсөж байхад хажууд байгаад өргөст титмэнд хатгуулах мөчид нүүр буруулдаг нэгэн биш. Тэрээр “хөгжин дээшлэх хийгээд доройтон зовох өдрүүдэд, гашуудлын дуу хийгээд хуримын дууны алинд ч "бүхий л өдрүүдийн" турш надтай хамт байдаг.

“Бүхий л өдрүүдэд.” Амьд ахуйд, үхэж үрэгдэхүйд, шүүлтийн өдөр ч хамт байдаг. ²¹

[4:5]

Одоо Паул та нарын тэвчээр бүх хүнд мэдэгдэг гэж уриалж байна. Үүнийг мөн бууж өгөх, сайхан эерүү байдал, өөрийнхөө байр суурийг хойш тавихад бэлэн байх зэргээр орчуулдаг. Үүний утгыг *ойлгоход* биш харин **бүх хүнд** хандсан зарчмыг *дуулгавартайгаар дагах* нь хэцүү. **Эзэн ойрхон байна** гэдэг нь Эзэн энд яг одоо байгаа эсвэл Эзэн маш ойрхон ирж байгаа гэсэн утгатай байж болно. Хоёулаа үнэн, гэхдээ хоёр дахийг нь хэлж байгаа болов уу.

[4:6]

Христиггэгчид үнэхээр **юунд ч санаа зовохгүй** байх боломжтой юу? Итгэлийн залбирал байгаа цагт энэ нь боломжтой. Энэхүү ишлэлийн үлдсэн хэсэг нь биднийг гэм нүгэл, санаа зоволтоос хэрхэн чөлөөтэй байж болохыг тайлбарлаж байна. Бүх зүйлийг **Эзэнд залбирлаар** өргөх хэрэгтэй. **Аливаа зүйл** гэдэг

нь *бүх зүйлийг* хэлнэ. Түүний хайрын халамжийн өмнө юу ч дэндүү том эсвэл жижиг биш!

Залбирал бол үйлдэл болон уур амьсгал хоёулаа юм. Бид тодорхой хүсэлтээ өргөхөөр тодорхой цагт Түүний өмнө ирдэг. Бид мөн залбирлын уур амьсгалаар амьдрах боломжтой. Бидний амьдралын төлөв залбирлын төлөв байж болно. Энэхүү ишлэлийн залбирал гэдэг үг нь бидний амьдралын ерөнхий хандлагыг илэрхийлж байгаа бөгөөд **гуйлт** гэдэг нь Эзэнд өргөж байгаа онцгой **хүсэлтийг** хэлдэг.

Гэхдээ бид **хүсэлтээ Бурханд талархалтайгаар мэдүүлэх ёстойг** анхаарах хэрэгтэй. Нэг хүн үүнийг бид “юунд ч санаа зоволгүй, бүх зүйл дээр залбирч, ямар ч зүйлд талархах ёстой” гэж дүгнэн хэлжээ.

[4:7]

Бид ийм хандлагатай амьдардаг бол **бүх оюун ухаанаас дээгүүрх Бурханы амар тайван нь Христ Есүс дотор бидний зүрх сэтгэл, санаа бодлыг хамгаална. Бурханы амар тайван гэж итгэгч хүн Бурханд баттай түшиглэж яваа цагт**

сэтгэлийг нь дүүргэдэг ариун итгэл, сэтгэлийн дүүрэн байдлыг хэлнэ.

Ёховагийн өмнө зогсоход

Бүхэлдээ сэтгэл маань ерөөгдөж,

Түүний амласан

Төгс амар тайван, амралтыг олдог.

-Францес Ридли Хавергал

Энэхүү **амар тайван нь бүх оюун ухаанаас дээгүүр** байна. Дэлхийн хүмүүс үүнийг огт ойлгож чадахгүй, тэр ч бүү хэл үүнийг эзэмшигч христитгэгчид үүнийг гайхалтай нууцлаг шинжтэй гэдэг. Тэд зовлон зүдгүүр, хүнд хэцүү нөхцөл тулгарахад санаа зовохгүй байгаадаа гайхдаг.

Энэхүү **амар тайван** зүрх сэтгэл болон бодол санааг хамгаалдаг. Мэдрэлийн ядаргаа, ухаан санааны самуурал, тайвшруулах эм, стрессээр дүүрсэн өнөө үед ямар хэрэгтэй зүйл вэ.

[4:8]

Элч бодол санааны талаар эцсийн зөвлөгөөг өгч байна. Биднийг бодол санаагаа хянан захирч чадна гэж Библид олон газар заадаг. Зохисгүй бодол оюун санааг дүүргэхэд бид яаж ч чадахгүй

гэж бууж өгөх нь ямар ч тусгүй. Юу гэвэл бид чаддаг юмаа. Үүний нууц нь эерэг бодол санаанд оршино. Шинээр төрсөн сэтгэл бусад бодлыг шахан зайлуулах хүчтэй гэдэг зарчмыг эдүгээ сайн мэддэг болсон. Хүн хорон мууг болон Эзэн Есүсийг нэгэн зэрэг бодож чадахгүй. Тэгэхээр, хүнд хорон муу бодол санаа орж ирвэл тэр даруй Христийн мөн чанар болон хийсэн ажлыг тунгаан бодож, тэр муу бодлыг үлдэн хөөх хэрэгтэй. Сэтгэл судлаач болон сэтгэцийн эмч нар Паултай санал нэг байдаг. Тэд сөрөг бодолтой байхын аюулыг анхааруулдаг.

Наймдугаар ишлэл Эзэн Есүс Христийг хэлж байгаа гэдгийг хараад мэдэж болно. **Үнэн, хүндэтгэлтэй, зөв, цэвэр ариун, сайхан, сайшаалтай, сайн үйл, магтууштай** бүхэн нь Түүнд байдаг. Эдгээр сайн чанарыг нэг нэгээр нь авч үзье. **Үнэн** гэдэг нь худал юмуу найдваргүй биш харин жинхэнэ, бодит гэсэн утгатай. **Хүндэтгэлтэй** гэдэг нь хүндэтгэл хүлээсэн юмуу ёс суртахууны хувьд сэтгэл татмаар гэсэн утгатай. **Зөв** гэдэг нь Бурханд болон хүнд зөв байхыг хэлнэ. **Цэвэр ариун** гэдэг нь хүний амьдралын өндөр ёс суртахууныг илэрхийлж

байна. **Сайхан** гэдэг нь харахад ба бодоход тааламжтай, зохимжтой гэсэн утгатай. **Сайшаалтай** гэдгийг мөн "сайнаар хэлэгддэг" "сайнаар яригддаг" гэж орчуулдаг. **Магтууштай** гэдэг нь магтаал хүлээсэн гэсэн утгатай.

Бурхан ариун хүмүүсийн зүрх сэтгэл, бодол санааг Христ Есүсийн дотор хамгаалдаг гэж Паул 7-р ишлэлд батлан өгүүлжээ. Гэхдээ тэд өөрсдөө бас хариуцлага үүрнэ гэдгийг орхигдуулсангүй. Бодол санаагаа цэвэр ариун байлгахыг хүсдэггүй хүний бодлыг Бурхан хамгаалдаггүй.

[4:9]

Элч Паул дахиад өөрийгөө үлгэр жишээ болгож байна. Тэрээр итгэгч хүмүүсийг түүнээс **суралцсан** болон түүний амьдралаас **харсан зүйлээ ажил хэрэг болгохыг** уриалсан.

Наймдугаар ишлэлийг залгуулаад эдгээрийг бичсэн нь онцгой ач холбогдолтой. Зөв зүйтэй амьдрал нь зөв бодлоос эхтэй. Хүний бодол цэвэр ариун байвал тухайн хүний амьдрал цэвэр ариун байна. Нөгөө талаар хэрэв хүний бодол санаа нь ёс бус байдлын ундарга байвал эндээс

эх авсан гол нь бохир заваан байж таарна. Хүн ёрын муу бодлыг тээсээр удвал түүнийгээ гарцаагүй хэрэгжүүлдэг гэдгийг бид санаж байх хэрэгтэй.

Элчийн үлгэр дууриаллыг дагахдаа итгэмжтэй байгаа хүмүүстэй **амар тайвны Бурхан хамт байх болно** гэж амласан. Долдугаар ишлэлд Бурханы амар тайван нь залбирдаг хүмүүсийн хувь гэсэн бол энд **амар тайвны Бурхан** ариун хүмүүстэй хамт байх болно гэж өгүүлсэн. Энэ нь Бурхан үнэнээр амьдарч байгаа хүмүүст ойр дотно байна гэсэн санаа.

IX. Ариун хүмүүсийн өгсөн мөнгөн тусламжийн төлөөх Паулын талархал (4:10-20)

[4:10]

10-19-р ишлэлд Паул санхүүгийн тусламжийн хувьд Филиппой хотын чуулгантай ямар холбоотойг хэлж байна. Санхүү мөнгөний гачигдал дарамт туулахаар дуудагдсан Бурханы

ариун хүмүүсийн хувьд энэ ишлэлүүд ямар их утга учиртай болохыг хэн ч хэлж чадахгүй!

Эзэний ажилд хэрэгтэй байсан мөнгөн тусламжийг **эцэст нь** буюу тодорхой хугацаа өнгөрсний дараа филиппойчууд илгээсэнд Паул баярлаж байна. Паул тусламж ирүүлэлгүй удлаа гэж тэднийг буруутгаагүй, харин тэднийг өөрт нь бэлэг илгээхийг хүсэж байсан боловч **боломж олдоогүй** гэж үнэлж байна. Мофат үүнийг: “та нарт халамжлах сэтгэл дутаагүй харин түүнийгээ харуулах боломж олдохгүй байсан” гэж орчуулжээ.

[4:11]

Санхүүгийн талаар ярихдаа Паулын ямар торгон мэдрэмжтэй хүндэтгэлтэй хандаж байгааг харахад таатай байна. Тэрээр мөнгө төгрөгөөр гачигдлын талаар гомдоллож буй мэт сэтгэгдэл төрүүлэхийг хүсээгүй. Харин тэрээр амьдралын өдөр тутмын аахар шаахар нөхцөл байдлаас хамаараад байдаггүй болохоо мэдүүлж байна. Тэрээр санхүүгийн нөхцөл байдал ямар ч байсан **сэтгэл хангалуун байж сурсан**. “Хэрэв сэтгэл хангалуун байдал нь эд баялгийг бий

болгохгүй юмаа гэхэд тэдгээрийн араас шунах сэтгэлийг арилгаснаар зорилгодоо хүрдэг” тул сэтгэл хангалуун байх нь эд баялгаас эрхэм.

“Итгэгч хүмүүс ходоод хоосон байсан ч толгой цэх, түрийвч хоосон ч зөв харцтай, цалингаа аваагүй ч аз жаргалтай алхаж, хүмүүс итгэлгүй байсан ч Бурхан дотор баяр хөөртэй амьдрахад суралцсан нь ерөөлт нууц юм” (Сонгомол).

[4:12]

Паул амьдралын наад захын хэрэгцээ ч хангагдахгүй **тарчигхан байхыг** мэднэ, өөрт хэрэгтэй гэснээс нь илүү их зүйлсээр хангагдаж **элбэг дэлбэг байхыг** ч мэднэ. **Ямар ч, аливаа нөхцөл байдалд цатгалан болон өлсгөлөн байх, элбэг байх, дутагдахын, аль алины нууцад тэр суралцсан.** Үүнийг элч яаж сурсан бэ? Тэр зүгээр л Бурханы хүслийн дагуу байгаадаа итгэлтэй байсан. Тэрээр хаана ч, ямар ч нөхцөл байдалд орсон тэнгэрлэг томилгооны дагуу гэдгээ мэдэж байв. Тэр **өлсөж** байгаа бол Бурхан түүнийг өлсгөхийг хүссэн хэрэг. Хэрэв тэр **цатгалан** байгаа бол Эзэн тийнхүү төлөвлөсөн

учраас тэр. Завгүйхэн агаад итгэмжтэйгээр Хаандаа үйлчилж явахдаа тэр: “Эцэг минь, ямар ч байсан энэ бүгд Таны мэлмийд тааламжтай байгаа ажээ!” гэж хэлж чаддаг байв.

[4:13]

Тэгээд элч олон хүн учрыг нь ойлгож чаддаггүй: **“Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна”** гэдэг үгийг нэмж хэлсэн. Тэр үүнийг шууд утгаар хэлж байна гэж үү? Элч үнэхээр бүхнийг хийж чадна гэдэгтээ итгэлтэй байсан уу? Үүний хариулт нь: Элч Паул **бүх зүйлийг хийж чадна** гэдэг нь Бурханы түүгээр хийлгэхийг хүссэн **бүхнийг** гэдэг санааг хэлжээ. Эзэний тушаалууд нь Эзэний хүчирхэгжүүлэлт гэдгийг тэр ойлгож байв. Бурхан түүнд үүрэг өгөхдөө тэр үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай нигүүлслийг өгөхгүйгээр дуудахгүйг тэр мэдэж байв. **Бүхнийг** гэж агуу зүрх зориг гэхээсээ илүү агуу их гачигдал, өлсгөлөнг хэлсэн болов уу.

[4:14]

Энэ үгийг хэлсэн мөртлөө филиппойчууд **зовлонгоос нь хуваалцахдаа сайн байсныг нь**

мэдүүлэхийг хүсчээ. Энэ нь түүнийг хоригдож байх үед хэрэгцээнд нь зориулж илгээсэн мөнгийг хэлж байж болно.

[4:15]

Өнгөрсөн хугацаанд филиппойчууд **өгөх** нигүүлслээр тэргүүн сайн байсан. Паулын үйлчлэлийн эхэн үед, **Македониос явсных нь дараа** филиппойчуудаас өөр нэг ч **чуулган** мөнгө санхүүгийн дэмжлэг өгч байгаагүй.

Нэг их чухал биш болов уу гэмээр энэ зүйлийг Бурханы эрхэм нандин үгэнд үүрд дурьдаж үлдээсэн нь гайхалтай. Энэ нь бидэнд, Эзэний зарцад өгөх нь Эзэнд өгч байгаа хэрэг гэж сургаж байна. Тэрээр илгээсэн бутархай мөнгийг ч үлдээлгүй тооцож байсан. Энэ бүгдийг Түүнд өгсөн гэж тэмдэглэж, үүний хариу шахагдсан, чигжсэн, бялхсан сайн хэмжээгээр шагнадаг.

[4:16]

Түүнийг **Тесалоникт байхад нь** хүртэл тэд **нэг биш удаа түүнд хэрэгтэй юмыг нь илгээсэн.** Филиппойчууд Эзэнд маш ойрхон байсан тул өгөх талаар чиглүүлэх боломжийг

Эзэнд олгожээ. Ариун Сүнс тэдний зүрх сэтгэлд элч Паулыг сануулж байв. Тэд хариуд нь түүн рүү **дахин нэг удаа** буюу хоёр ч удаа мөнгө илгээсэн байна. Паул Тесалоникт тун богино хугацаанд байсныг бодохоор тэдний энэ халамж бүр ч онцгой болж байна.

[4:17]

Паулын огт хувиа хичээдэггүй байдал энэ ишлэлээс харагдана. Тэр тэдний өгсөн **бэлгэнд** гэхээсээ ингэснийхээ улмаас авах тэдний үр ашигт нь баярлав. Түүнд санхүүгийн тусламж авах хүслээс илүү итгэгчдийн **үнэлгээнд** нэмэгдэж **буй үр ашгийг** чухалчлах сэтгэл байжээ. Эзэнд мөнгө өргөхөд тийм л зүйл болдог. Энэ нь дансанд бичигддэг бөгөөд ирэх өдөр 100 дахин ихээр эргэн төлөгдөнө.

Бидэнд байгаа бүхэн Эзэнийх бөгөөд Түүнд өгөх нь үнэндээ Өөрийнх нь зүйлийг эргүүлэн өгч байгаа хэрэг. Христитгэгчид аравны нэгийг өргөх эсэх талаар маргадаг хүмүүс үүний утга учрыг ойлгоогүй байна. Аравны нэгийн өргөл бол израильчуудад өгөгдсөн хууль бөгөөд өгөх хамгийн доод хэмжээ. Нигүүлслийн энэ үед

хүмүүс “Би Эзэнд хэр ихийг өргөх вэ?” гэж асуухын оронд “Би өөртөө хэр ихийг үлдээж зүрхлэх вэ?” гэж асуувал дээр. Хүмүүсийг Христийн сайн мэдээг сонсож чадалгүй сүйрэхээс аврахын тулд христитгэгчид ашиг орлогоосоо байнга өсгөн өргөж, санхүүгийн ч золиостой, цомхон амьдрах учиртай.

[4:18]

Паулын надад **бүх зүйл байна** гэдэг нь *би хэрэгтэй бүхнээрээ хангагдсан* гэсэн утгатай. Худалдаа наймааны хорьдугаар зуунд Эзэний зарц мөнгө гуйлгүй харин ч эсрэгээрээ хэрэгтэй бүх зүйл надад байгаа гэх нь хачин сонсогдох биз. Өнөөгийн хэмжээ хязгааргүй гуйланчлах зар Бурханы жигшил зэвүүцлийг төрүүлж, Христийн нэр сэвтэхэд хүргэдэг. Ингэх шаардлага огт байхгүй. Хадсон Тейлор нэгэнтээ: “Бурханы ажил Бурханы арга замаар хийгдэж байгаа цагт Бурханы нөөц баялгаар тасардаггүй” гэж хэлсэн. Өнөөдөр бид Бурханы төлөө ажиллах, Бурханы ажил хийх гэсэн хоёр зүйлийг ялгаж ойлгохгүйд асуудал байна. Хүн христитгэлийн үйлчлэл нэртэй боловч Бурханы

хүсэлд нийцэхгүй ажил хийж байх боломжтой. Мөнгө арвин байгаа газар тэнгэрээс соёрхоогүй ажил хэрэгт хутгалдах аюул хамгийн их байдаг. Хадсон Тейлорын хэлсэн бас нэг үгийг иш татъя: “Бид мөнгө санхүү хүрэлцэхгүй байх вий гэхээс зорилгогүй мөнгө хэтэрхий их болох вий гэж санаа зовох хэрэгтэй.” **Епафродитын филиппойчуудаас авчирсан хайрын бэлгийг Паул Бурханд таашаагдах тааламжит тахил ба анхилуун үнэр** гэж хэлсэн. Эдгээр үгийг өөр газар нэг л удаа зөвхөн Христийг Өөрийг нь хэлэхэд (Еф 5:2) хэрэглэсэн. Паул филиппойчуудын өргөсөн золиос Бурханы хувьд ямар их утга учиртай болохыг нь тайлбарлан хүндэтгэл үзүүлжээ. Энэ нь Түүнд өргөсөн анхилуун үнэртэй **тахил** болон уугив. Энэ нь **хүлээн зөвшөөрөгдөхүйц** бөгөөд **тааламжтай** байсан.

Жовет үүний талаар:

Энүүхэндээ хийж байгаа сайхан сэтгэлийн ажил хичнээн алсад хүрдэг вэ! Бид ядууст үйлчилж байгаа гэж бодож байтал үнэндээ Хаанд үйлчилсэн хэрэг байж. Бид анхилуун үнэрийг хөршийн хашаанаас цааш гарахгүй

гэж бодож байтал тэр нь ертөнц даяар тархдаг байна шүү. Бид зөвхөн Паултай харьцаж байна гэж бодтол үнэндээ Паулын Аврагч бөгөөд Эзэнд үйлчилжээ.²²

[4:19]

Одоо Паул энэ бүлгийн хамгийн алдартай, хамгийн хайрлагддаг ишлэлийг бичиж байна. Няравын итгэмжит үйлчлэлийг өгүүлсний дараа энэ амлалт өгснийг бид анзаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл тэд амьдралаа аюулд өртүүлэн байж эд юмсаа Бурханд өргөсөн болохоор **Бурхан** тэднийг **хэрэгтэй** бүхнээр нь **хангана** гэжээ. Бүх мөнгөө зөвхөн өөртөө ашиглаад Бурханы ажлын тухай бараг боддоггүй итгэгчдэд энэ ишлэлийг хам сэдвээс салгаж аваад өөрийгөө хайцаалах амархан. “Зүгээр ээ. Бурхан бүх хэрэгцээг чинь хангана.”

Бурхан Өөрийн хүмүүсийн хэрэгцээг **хангадаг** нь ерөнхий утгаар үнэн боловч энд Христэд итгэмжтэйгээр зориулан өгсөн хүмүүс хэзээ ч юугаар ч дутагдахгүй гэдэг онцгой амлалт өгч байна.

Бурхан Өөрийн хүмүүсийн хэрэгцээг хангана гэж олон удаа хэлсэн байдаг. Ингэхдээ баялгаасаа авч өгөх биш харин **Бурхан алдар дахь баялгаараа Христ Есүс дотор** хангана. Хэрэв саятан хүн нэг хүүхдэд нэг төгрөг өгвөл баялгаасаа өгч байгаа хэрэг. Харин тэр чухал үйл хэргийн төлөө 100 мянган долларыг өгвөл энэ нь баялгаараа өгч байгаа хэрэг. Бурханы хангалт бол **Бурханы алдар дахь Христ Есүс доторх баялаг юм**. Үүнээс илүү баялаг байхгүй!

Виллиямс 19-р ишлэлийг итгэлийн банкны чекээр дүрслэхдээ:

Миний Бурхан- банкны эзэний нэр

Хангана- төлбөр төлөх амлалт

Хэрэгтэй бүхнээр- төлбөрийн хэмжээ

Өөрийн алдар дахь баялгаар- банкны хөрөнгийн хэмжээ

Алдар дахь- банкны хаяг

Христ Есүсээр-гарын үсэг, гарын үсэггүйгээр банкны чек хүчин төгөлдөр болдоггүй гэжээ.²³

[4:20]

Бурханы бялхам дүүрэн хангалтыг бодохоор элч өөрийн эрхгүй магтаал өргөж байна. Зөвхөн эд материал бус мөн заавар чиглүүлэг авах, уруу таталтаас хамгаалагдах, сүнсний амьдрал сэргэх хэлбэрээр Бурханы хайр халамжийг өдөр бүр хүртдэг хүүхэд яг ийм хэлээр ярьж байгууштай.

Х. Төгсгөлийн мэндчилгээ (4:21-23)

[4:21]

Паул итгэгчдийг цуглаад энэ захидлыг уншиж байгаа гэж төсөөлөн **Христ Есүс дотор ариун хүн бүрд мэндчилж, хамт байгаа бүх ах дүү нараас мэнд хүргэж байна.**

[4:22]

Цезарийн гэрийнхний тухай болохоор энэ ишлэл бидэнд эрхэм. Бид энд хэнийг ярьж байгаа талаар хэтэрхий олон юм ургуулан боддог. Нерогийн гэр бүлийн гишүүдээс хэнийг хэлээд байна вэ? Элч Паулыг цагдах үүрэгтэй байгаад, түүний үйлчлэлээр аврагдсан цэргүүд үү?

Ордонд ажиллаж байсан боол эсвэл чөлөөлөгдсөн хүмүүс үү? Эсвэл Ромын төрийн албан хаагчдыг хэлсэн үү? Бид яг хэнийг хэлж байгааг нарийн мэдэхгүй ч христитгэгчид эгээ л нарны туяа лугаа адил хэдийнэ хааны ордонд ч гийсэн жишээг харахад таатай хэрэг байна (Сур 30:28)! Сайн мэдээнд хил хязгаар гэж үгүй. Хамгийн чанд хориотой ханыг ч нэвтэлж чадна. Өөрийг нь устгахаар занаж байгаа хүмүүсийн дунд ч ургаж чадна. Үнэхээр тамын үүд хаалга ч Есүс Христийн чуулганыг дийлэхгүй.

[4:23]

Одоо Паул захидлаа өөрийн өвөрмөц мэндчилгээгээр төгсгөж байна. Захидлын эхний хуудсанд гялалзаж байсан **нигүүлсэл** гэдэг үг төгсгөлд нь ч байна. Зүрхний бялхалаас ам ярьдаг. Паулын зүрх сэтгэл бүх цаг үеийг эзэлсэн агуу сэдэв болох **Христээр** ирэх Бурханы **нигүүлслээр** бялхаж байв. Тэгээд энэ бялхал нь түүний амьдралын бүх сувгаар халин урсахад гайхаад байх зүйлгүй.

Паул Рийс бидний өмнөөс ийнхүү дүгнэжээ:

Хамгийн агуу хүн хамгийн халуун дулаан захидлаа бичжээ. Хайрын үүрэг гүйцэлдсэн. Өдрийн ажил дууслаа. Элчийн гар гинжлээстэй л байна. Цэрэг эр манаандаа зогссоор. Тэгэхдээ зүгээр ээ, Паулын сүнс эрх чөлөөтэй байна! Түүний бодол санаа цэлмэг байна. Түүний зүрх сэтгэл гэрэлтэж байна!

Маргааш өглөө нь Епафродит Филиппой хот уруугаа буцаваа! ²⁴

КОЛОССАЙН ЧУУЛГАНД БИЧСЭН ЗАХИДАЛ

Оршил

*“Колоссай номд орж, Сүнсний хэлээр бичигдсэн
Сүнсний бодлыг дахин
тунгаан энэхүү бодлын гэрэл, хүчээр
сэтгэлээ дүүргэж, амьдралаа
хэлбэржүүлэх нь энэ цагийн болоод өнө мөнхийн
баялаг мөн.” -Р.С.Х.Ленски-*

I. БИЧЭЭСТ ЭЗЛЭХ ОНЦГОЙ БАЙР СУУРЬ

Паулын ихэнхи захидал томоохон буюу чухал ач холбогдолтой хотуудад байгаа чуулгануудад хандаж бичигджээ. Тухайлбал, Ром, Коринт, Ефес, Филиппой байна. Харин Колоссай хөгжлийнхөө оргилд хэдийнээ хүрээд буурч явсан хот байв. Колоссай хотын чуулган ч эртний чуулганы түүхэнд төдийлөн алдаршаагүй.

Товчхондоо тэнд байсан христитгэгчдэд хандсан энэхүү богинохон захидал бичигдээгүй байсан бол Колоссай хэмээх нэрийг зөвхөн эртний түүх судлаач оюутнууд л мэдэх байсан болов уу.

Хэдийгээр энэ газар тийм ч чухал байгаагүй ч элч Паулын тэнд хандаж бичсэн захидал маш чухал юм. Иохан 1 ба Еврей 1-ийн хамт Колоссай 1-д бидний Эзэн Есүс Христ туйлаас Бурхан гэдгийг гайхалтай илчлэн танилцуулсан байдаг. Энэхүү сургаал нь христитгэлийн бүх үнэний суурь учир ямар үнэ цэнэтэй нь ойлгомжтой.

Түүнчлэн энэхүү захидал нь харилцаа, хуурамч шашин, христитгэлт амьдралын талаар баялаг сургаалыг агуулдаг.

II. ЗОХИОГЧ

Захидлыг Паул бичсэн гэдэг нь баталгаатай байсан тул 19-р зуунаас өмнө үүнд эргэлзэж байсан тухай баримт байдаггүй. *Гадаад нотолгоо* ялангуяа их байгаа. Паулыг бичсэн хэмээн энэхүү захидлаас иш татсан хүмүүсийг дурдвал Игнатиус, Эзэний төлөө амиа өргөсөн Жастин, Антиохын Теофил, Иренаеус,

Александрын Клемент, Тертуллиан ба Ориген байна. Марсионы болон Мураторийн бичээст аль алинд нь Колоссайг үнэн хэмээн хүлээн авчээ.

Дотоод нотолгоо гэвэл зохиогч нь өөрийгөө Паул гэсэн, агуулга нь ч үүнд нийцэж байна. Сургаалыг тайлбарласны дараа итгэгч хүний биелүүлэх үүргийг хэлж өгдөг нь элч Паулын бичдэг арга барил юм. Мөн Паулын бичсэн гэдгийг хүн бүр хүлээн зөвшөөрдөг Филемон номтой нягт холбоотой байгаа нь хамгийн үнэмшилтэй нотолгоо болж байна. Тэрхүү богино захидалд дурдсан таван эрэгтэйг мөн энэхүү захидалд ч дурджээ. Ренан хэмээх шүүмжлэгч хүртэл *Колоссай номын талаар эрэлгэлзэж байсан* боловч Филемонтой төстэй шинж чанарт гайхширч байв.

Паул бичээгүй хэмээх нотолгоо нь үгийн сан, Христийн тухай сургаал, гностисизмын талаар илт өгүүлж байгаа дээр төвлөрдөг. Эхний асуудлын хувьд Паулын хэлэх дуртай үгийнхээ оронд шинэ үг хэрэглэсэн байна. Өнгөрсөн зууны консерватив үзэлтэй Британийн судлаач Салмон энэхүү нотолгоог ухаалгаар няцаажээ. “Шинэ зохиол бичиж байгаа хүн өмнө нь

хэрэглэж байгаагүй үг хэрэглэснээрээ шинэ зохиолынхоо зохиогч нь байж болохгүй гэсэн сургаалд би орж чадахгүй нь” гэж тэр хэлжээ.¹ Колоссай номд байгаа Христийн тухай сургаал Филиппой болон Иохантай яг нийцэж байна. Хоёрдугаар зууны паганизмаас урган гарч ирсэн санаа гэж Христийн бурхан байдлыг үгүйсгэх хүсэлтэй хүмүүст л энэ сургаал таалагдахгүй.

Гностисизмын асуудлыг авч үзвэл либераль үзэлтэй Шотланд судлаач Моффатт Колоссай номд дурдагдсан гностисизм эхэн үеийнхээ шатанд нэгдүгээр зуунд байсан байж болох юм гэж үзжээ.²

Тэгэхээр Паул Колоссай номыг бичсэн гэдэг нь баталгаатай байна.

Ш. БИЧИГДСЭН ОГНОО

“Шоронгоос бичсэн захидлууд”-ын нэг учир Паул Колоссай номыг Кайсарид хоёр жил хоригдож байх үедээ бичсэн байж болзошгүй юм (Үйл 23:23; 24:27). Гэхдээ тэр үеэр Паул сайн мэдээ тараагч Филиппийнд байсан учраас түүний тухай дурдахгүй байгаа нь Паул шиг эелдэг,

нигүүлсэнгүй христитгэгч хүнд арай л тохирохгүй байна. Ефест хоригдож байхдаа бичсэн байж болзошгүй гэж зарим хүн үздэг ч энэ нь бүр ч магадлал багатай. Энэхүү захидал болон Филемоныг Паул Ромд анх удаа хоригдож байхдаа буюу М.Э. 60 онд бичжээ (Үйл 28:30, 31).

Энэхүү номыг ойлгохын тулд заавал тухайн үеийн нөхцөл байдлын талаар бүрэн дүүрэн мэдэх шаардлагагүй нь завшаантай юм.

IV. ТҮҮХЭН НӨХЦӨЛ, ХӨНДСӨН СЭДЭВ

Колоссай нь одоогийн Бага Ази гэж нэрлэгддэг тэр үеийн Фруг дүүрэгт оршиж байсан хот байв. Энэ нь Лаодикийн зүүн зүгт 16 км, Хиераполоос зүүн өмнөд зүгт 20 км зайд оршиж байв (4:13-ыг үз). Түүнчлэн Ефес хотоос зүүн зүгт ойролцоогоор 160 км зайд оршдог Кадмиан уулын хавцлын амсарт (19 км урт нарийн хавцал) Ефратаас баруун тийш чиглэсэн цэргийн зориулалтаар ашигладаг зам дагуу байв. Баруун зүгт Лаодикийг дайран урсаж Майндер голд цутгадаг Ликус (Чоно) голын хөвөөнд

Колоссай хот байжээ. Тэнд Хиераполын халуун рашаан Колоссайгаас урсах хүйтэн гол мөрнүүдтэй нийлснээр Лаодикийн “бүлээвтэр” нөхцөлийг бий болгодог байв. Лаодик тухайн хөндийн гол хот байх үед Хиерапол нь эмчилгээ болон шашны төв байжээ. Колоссой хот нь ШГ-ний цаг үеэс өмнө илүү том хот байжээ. Нэр нь “колоссис” буюу аварга том гэсэн үгнээс гаралтай гэж үздэг бөгөөд шохойн чулуун ер бусын гайхамшигтай тогтоцтой нь холбоотой байж болзошгүй.

Бид Колоссай хотод анх сайн мэдээ яг хэрхэн хүрснийг мэдэхгүй. Паул энэ захидлаа бичиж байхдаа тэндхийн аль ч христитгэгчтэй уулзаж байгаагүй (2:1). Хамгийн анх Епафр энэ хотод авралын сайн мэдээг тараасан (1:7) гэж үздэг. Олон хүн Епафрыг Ефес хотод 3 жилийг өнгөрөөх үед нь Паулаар дамжин итгэсэн гэж үздэг. Фруг Ромын мэдэлд байсан Азийн нэг хэсэг бөгөөд Паул Колоссайд биш (Үйл 2:1) Фругт байжээ (16:6; 18:23).

Бид захидлаас Колоссай хотын чуулганд бүрэн хэлбэржсэн үедээ гностисизм хэмээн нэрлэгдэх болсон буруу үзэл сургаал орж ирэн,

аюул учруулж эхэлсэн болохыг мэднэ. Гностикчүүд өөрсдийн мэдлэг (гр. гносис)-ээрээ бардамнадаг байв. Тэд элч нараас илүү дээд мэдээллийг авсан гэж тунхаглаж, хүн тэдний буруу шашны гүн нууцад нэвтрэхгүйгээр жинхэнэ аз жаргалтай байж чадахгүй гэдэг сэтгэгдлийг төрүүлэхийг оролдож байлаа.

Зарим гностикчүүд Христийн хүн мөн чанарыг үгүйсгэж байв. Тэд “Христ”-ийг Бурханаас ирсэн бурханлаг нөлөөлөл байсан бөгөөд Есүс хэмээх хүнийг баптисм хүртэхэд дээрээс нь буун ирсэн гэж зааж байв. Тэр байтугай Христ нь Есүсийг загалмай дээр цовдлогдож үхэхээс өмнө орхин гарсан гэж заадаг байлаа. Тэгэхээр тэдний бодлоор Есүс үхсэн боловч Христ үхээгүй байв.

Гностисизмын зарим салбар Бурхан ба материйн хооронд сүнслэг биетийн олон түвшин, давхарга байдаг гэж заадаг байжээ. Тэд хорон муугийн үүслийг тайлбарлахын тулд ийм үзэл бодлыг гаргаж ирсэн. А.Т. Робертсон үүнийг дараах байдлаар тайлбарлажээ:

Гностикийн таамаглал нь үндсэндээ орчлон ертөнц хийгээд хорон муугийн үүслийн

талаар анхаардаг. Тэд Бурхан бол сайн гэж үзсэн боловч хорон муу оршсоор байсан. Тэдний онолоор хорон муу нь материйн зайлшгүй хэсэг юм. Гэхдээ сайн Бурхан хорон мууг бүтээж чадахгүй байв. Тиймээс тэд Бурхан болон материйн хооронд олон сая жил сүнслэг биетүүд, сүнснүүд болон тэнгэр элч нар цувран орж ирсэн гэсэн үзлийг дэвшүүлсэн. Гол санаа нь Бурханаас сүнс гарч, дараа нь тэр сүнснээс бас нэг сүнс гарах мэт явсаар хорон мууг Бурханд нялзаахааргүй Бурханаас хол, гэхдээ Бурханы эрх мэдэл хүрэлцэхээр ойрхон оршдог матери бий болсон гэж тайлбардаг.³

Зарим гностикчууд махан бие бүхэлдээ гэм нүгэлтэй учраас өөрийгөө үгүйсгэх, тэр байтугай өөрийгөө зовоох систем буюу асетисизмыг хийж, сүнсний дараагийн түвшинд хүрэхээр хичээдэг байв. Нөгөө хэсэг нь бүр эсрэгээрээ бие махбодь чухал биш, сүнсний амьдралд ямар ч нөлөө үзүүлэхгүй гэж үзэж, бие махбодио өөгшүүлж дур зоргоороо амьдарчээ.

Үүнээс гадна Колоссай хотод хоёр өөр буруу онол сургаал байжээ. Тэдгээр нь антиномианизм

бөгөөд иудеизм байв. Антиномианизм нь хүн нигүүлслийн доор байдаг учраас биеэ захирах шаардлагагүй, харин ч махан биеийн хүсэл тачаалыг бүрэн хангахаар дур зоргоороо байж болно гэж заадаг. Хуучин гэрээний иудеизм нь улам бүр доройтож, хүн өөрийнхөө хичээл зүтгэлээр шашинлаг ёс жаягийг баримталснаар Бурханы өмнө зөвт тооцогдож болно гэсэн сургаал болж хувирчээ.

Колоссайд байсан эдгээр алдаа өнөөдрийг хүртэл бидний дунд байсаар байна. Гностисизм өнөөдөр Христийн шинжлэх ухаан, Теософи, Мормонизм, Ёховагийн гэрчүүд, Нэгдэл болон бусад тогтолцоогоор дахин гарч ирсэн. Антиномианизм нь бид нигүүлсэл дор байгаа учраас хүссэнээрээ амьдарч болно гэсэн үзэлтэй бүх хүний илэрхийлэл юм. Иудеизм нь анх Бурханы өгсөн илчлэлт байсан бөгөөд хэлбэр болон ёс жаяг нь еврейчүүдэд хандсан захидал ба Шинэ гэрээний бусад хэсэгт үзүүлсэнчлэн хэв шинжүүдийг ашиглан сүнсний үнэнийг зааж сургах зорилготой байлаа. Энэ үзэл эцэстээ хэлбэрийг тахин шүтэж, сүнслэг утга нь ихэвчлэн алдарсан тогтолцоо болжээ. Үүнтэй

ижил төстэй олон шашин өнөөдөр бий болсон ба тэдгээр нь хүний гэм нүгэлтэй байдал, зөвхөн Бурханы хийж чадах авралын ажлыг үгүйсгэж эсвэл үл тоомсорлож, хүн өөрийн зүтгэлээр Бурханд таалагдаж, Түүний тааллыг хүртэнэ гэж заадаг.

Колоссай номд элч Паул бидний Эзэн Есүс Христийн Бодгаль болон ажлын алдрыг тунхаглан харуулснаар энэ бүх алдааг гарамгай няцаасан.

Энэ захидал Паулын Ефес хотод хандаж бичсэн захидалтай гайхалтай адилхан. Гэхдээ ижил байлаа гээд яг давтаж бичээгүй байна. Ефесийн захидалд христитгэгчдийг Христтэй цуг тэнгэрлэг суудалд заларсан байгаагаар харуулдаг. Колоссайн захидалд харин нөгөө талаас христитгэгчдийг тэнгэрт алдаршуулагдсан Христ Тэргүүнтэй дэлхий дээр байгаагаар харуулдаг. *Ефес* номд *христитгэгчид Христ дотор* байна гэдгийг онцолдог, харин *Колоссай* номд *христитгэгч дотор* байгаа *Христ*, алдрын найдварын тухай өгүүлдэг. Ефес номд гол цөм нь Христийн “бие”, “бүхний дотор бүгдийг Дүүргэгчийн дүүрэн

байдал” (Еф 1:23) болох чуулган дээр төвлөрсөн. Тиймээс Христийн биеийн нэгдмэл байдлыг өргөсөн байдаг. Колоссай номын 1-р бүлэгт Христ тэргүүн болох, бид “Тэргүүнээс зуурч”, Түүнд захирагдах шаардлагатай (2:18, 19) гэдгийг дэлгэрэнгүй өгүүлжээ. Ефес номын 155 ишлэлийн 54 нь Колоссай номын ишлэлтэй ижил төстэй байдаг.

ТОЙМ

- I. ХРИСТ БҮХНЭЭС ДЭЭД ГЭХ
СУРГААЛ (бүлэг 1, 2)
 - А. Мэндчилгээ (1:1, 2)
 - Б. Паулын талархал ба христитгэгчдийн төлөөх залбирал (1:3-14)
 - В. Чуулганы Тэргүүн болох Христийн алдар (1:15-23)
 - Г. Паулд даалгасан үйлчлэл (1:24-29)
 - Д. Философи, легализм, мистисизм, асетисизмийн хор хөнөөлийн эсрэг Христ хангалттай (2:1-23)

II. БҮХНЭЭС ДЭЭД ХРИСТИЙН ӨМНӨ
ХРИСТИТГЭГЧДИЙН ХҮЛЭЭСЭН
ҮҮРЭГ (бүлэг 3, 4)

А. Христитгэгчдийн шинэ амьдрал: хуучин хүнээ тайлж, шинэ хүнийг өмсөх нь (3:1-17)

Б. Христитгэлт гэр бүлийн гишүүдэд байвал зохистой зан үйл (3:18-4:1)

В. Итгэгчийн залбирлын амьдрал ба амьдрал, үг яриагаар гэрчлэх нь (4:2-6)

Г. Паулын хамтран ажиллагчдын тухай товчхон (4:7-14)

Д. Мэндчилгээ ба заавар (4:15-18)

I. ХРИСТ БҮХНЭЭС ДЭЭД ГЭХ СУРГААЛ (бүлэг 1, 2)

1. Мэндчилгээ (1:1, 2)

[1:1]

Шинэ гэрээ бичигдэж байх үед захидал эхлэхдээ зохиогчийн нэрийг тавьдаг заншил байжээ. Тиймээс **Паул** өөрийгөө **Бурханы хүслийн дагуух Есүс Христийн элч** гэж танилцуулжээ. Элч гэдэг нь Эзэн Есүсийн онцгойлон илгээсэн хүнийг хэлнэ. Заасан сургаалаа батлахын тулд элч нарт гайхамшиг үйлдэх хүч өгөгдсөн байв (2Ко 12:12). Мөн зарим тохиолдолд элч нар итгэгчдийн дээр гар тавихад, Ариун Сүнс өгөгдөж байлаа (Үйл 8:15-20; 19:6). Өнөөдөр ийм утгаар энэ дэлхий дээр элч гэж байхгүй ба өөрийгөө анхны арван хоёр элчийн залгамжлагч гэж тунхаглах нь утгагүй хэрэг юм. Олон хүн Ефес 2:20 ишлэлийг тайлбарлахдаа элч, эш үзүүлэгчийн онцгой бэлэг авьяастай хүмүүсийн хийх ёстой ажил чуулганы суурийг тавихад оршиж байсан, харин сайн мэдээ тараах, хоньчин болон багшлах бэлэг

авьяасын ажил (Еф 4:11) одоо ч энэ үеийн турш үргэлжилж байна гэдэг.

Паул өөрөө элч болсон уг үндэс бол **Бурханы хүсэл гэж хэлжээ** (Үйл 9:15; Гал 1:1 ишлэлийг мөн үз). Энэ нь Паул өөрөө өөрийгөө томилсон эсвэл хүнээр сургагдсан албан тушаал биш байлаа. Мөн хүний тосолгоогоор өгөгдсөн зүйл ч биш байлаа. Энэ нь “хүнээс” (эх сурвалж), “хүнээр дамжуулж” (хэрэгсэл) өгөгдөөгүй болохыг өгүүлдэг. Харин Паул бүх үйлчлэлээ Бурхан түүнийг элч байхаар сонгосон гэдгийг гүнээ ухамсарлан гүйцэтгэдэг байсан.

Паул энэхүү захидлаа бичиж байхдаа **бидний ахан дүү Тимоттой хамт** байжээ. Паул Тимотын талаар огт албархахгүй байгаа нь олзуурхууштай. Хоёулаа адил тэгш ах дүү байсан бөгөөд чуулганы нэр хүндтэй хүмүүс сүржин цол бүхий зэрэг дэв болон бусдаар ялгагдах хувцас хунар хэрэглэх тухай бодол ч алга.

[1:2]

Захидлыг **Колоссайд байгаа ариун хүмүүст буюу Христ доторх итгэлт ах дүү нарт илгээв** гэж хаяглажээ. Энд бүх христитгэлт хүнд хандан

Шинэ гэрээнд гардаг хоёр сайхан нэр байна. **Ариун хүмүүс** гэдэг нь дэлхийгээс салж, Бурхантай нэгдсэний улмаас ариун амьдрах ёстой болсон хүмүүсийг хэлнэ. **Итгэлт ах дүү нар** гэдэг нь Эзэн Есүст итгэх итгэлээр дамжуулан нэг Эцэгийн хүүхдүүд болсон итгэгч ах эгч дүүсийг тодорхойлж байна. Түүнчлэн христитгэгчдийг ШГ-нд дагалдагчид болон итгэгчид гэж нэрлэдэг.

Христ доторх гэж хэлсэн нь тэдний *сүнслэг* байр суурийг хэлж байна. Бурхан тэднийг авраад Христ дотор оруулж, “хайрлагдсан Түүний дотор биднийг соёрхсон” юм. Үүнээс хойш тэдэнд Түүний амь, мөн чанар өгөгдсөн. Цаашид Бурханы нүдэнд тэд Адамын хүүхдүүд юмуу гэм нүгэлтэй хүмүүс биш харин Өөрийнх нь Хүүтэй адил бүрэн хүлээн авбал зохистой гэж харагддаг юм. **Христ доторх** гэдэг үг хүний ухаанаар ойлгож чадахааргүй ойр дотно, хүлээн зөвшөөрөгдсөн, аюулгүй байдлыг илтгэдэг. *Газарзүйн* байршлын хувьд эдгээр итгэгчид **Колоссайд байгаа** гэж тодорхой бичжээ. Энэ хотын хүмүүст сайн мэдээ хүрч, хүмүүс

аврагдаагүй бол бид уг хотын талаар сонсох байсан гэдэг нь эргэлзээтэй.

Паул ариун хүмүүст: **Бидний Эцэг Бурханаас амар тайван, нигүүлсэл нь та нарт байх болтугай** хэмээн сайхан мэндчилжээ. Христитгэлт хүмүүсийн ерөөлийг **нигүүлсэл, амар тайван** гэдэг хоёр үгээс илүү сайн илэрхийлж чадахгүй. Грекчүүд **нигүүлсэл** гэдэг үгийг өргөн хэрэглэдэг байсан бол еврейчүүд **амар тайван** гэдэг мэндчилгээтэй байсан бөгөөд эдгээр үгийг уулзахдаа болон явахдаа хэрэглэдэг байв. Паул эдгээр үгийг нэгтгэж утга, хэрэглээг нь төгөлдөршүүлсэн. **Нигүүлсэл** гэдэг үг нь Бурхан гэм нүгэлтэй, алдагдсан хүнийг хайрлан энэрч дээрээс бууж ирж буйг дүрсэлж байна. **Амар тайван** бол Бурханы нигүүлслийг үнэгүй бэлэг хэмээн хүлээн авснаар амьдралд нь ирэх бүх үр дүнг илэрхийлж байгаа билээ. Р.Ж. Литтл хэлэхдээ: “Нигүүлсэл маш олон утгатай бөгөөд бөглөж бичээгүй чектэй адил юм. Амар тайван гэдэг бол гарцаагүй христитгэлт хүний хүлээн авдаг өвийн нэг хэсэг бөгөөд үүнийг биднээс хулгайлахыг Сатанд зөвшөөрч болохгүй гэжээ.” Эдгээр үгсийн дараалал нь ач холбогдолтой.

Эхлээд **нигүүлсэл**, дараа нь **амар тайван** байна. Хэрэв Бурхан эхлээд биднийг хайрлаж, өршөөл үзүүлээгүй бол бид гэм нүгэл дотроо үлдэх байсан. Гэвч Тэр санаачлага гаргаж, бидний төлөө Өөрийн Хүүгээ үхүүлэхээр илгээснээр бид Бурхантай амар тайван, хүмүүстэй амар тайван амьдарч, Бурханы амар тайван бидний сэтгэлд орших болсон. Энэ бүхнийг хэлсэн байлаа ч ийм агуу үгсийг хэзээ ч бүрэн тодорхойлох боломжгүй юм.

2. Паулын талархал ба христитгэгчдийн төлөөх залбирал (1:3-14)

[1:3]

Христитгэлт хүмүүсийн уриа болсон үгсээр ариун хүмүүстэй мэндчилчихээд элч маань байнга хийдэг зүйлээ хийсэн байна. Тэрээр өвдөг сөхрөн **талархал**, залбирлаа өргөжээ. Үүнээс үзэхэд элч Эзэнд хандан залбирахдаа үргэлж магтаалаас эхэлдэг байсан бололтой. Энэ нь бидний дагах сайн үлгэр дууриалал болж байна. Түүний залбирал **бидний Эзэн Есүс Христийн Эцэг Бурханд** ханджээ. Залбирал бол ертөнцийн хамгийн дээд Нэгэнтэй уулзах үгээр

илэрхийлшгүй эрх мэдэл юм. “Хэрхэн энгийн нэгэн хүн хязгааргүй дээд Бурханы сүрлэг оршихуйд зогсож чадах вэ?” Энд хариулт нь өгөгджээ. Яруу алдарт цог жавхлантад ертөнцийн Эзэн бол **бидний Эзэн Есүс Христийн Эцэг** юм. Бүхнээс хязгааргүй өндөрт орших Нэгэн Өөрийгөө туйлын ойр дотно болгосон юм. Учир нь Христ доторх христитгэгч бид Түүний амийг хуваалцсанаар Бурхан мөн бидний ч Эцэг болсон (Иох 20:17). Бид Христээр дамжуулан ойртож болно.

Та нарын төлөө үргэлж залбиран. Дангаар нь авч үзвэл эдгээр үгс тийм ч гойд содон санагдахгүй ч Паулын огт уулзаж байгаагүй танихгүй хүмүүсийг хэрхэн анхаарч байгааг харуулсныг санавал шинэ утгатай болно. Бид өөрсдийн хамаатан садан болон найз нөхдийг ч нигүүлслийн хаан суудлын өмнө санахад амаргүй байхад элч Паулын залбирлын жагсаалт ямар байсныг бодоод үз! Тэрээр зөвхөн таньдаг хүмүүсийнхээ төлөө залбираад зогсохгүй мөн хол газар байгаа бусдаас дуулсан христитгэгчдийн төлөө залбирдаг байжээ. Паулын цуцалтгүй залбирлын амьдрал нь

түүний талаар илүү сайн ойлгоход үнэхээр тустай.

[1:4]

Тэрээр колоссайчуудын **Христ Есүст итгэх итгэл болоод бүх ариун хүний төлөөх хайрыг** сонссон байв. Тэрээр эхлээд тэдний **Христ Есүст итгэх итгэлийг** дурьдсан байна. Бид мөн үргэлж итгэлээр эхлэх ёстой. Өнөөдөр энэ дэлхий дээр бусдыг хайрлаж байгаа тухайгаа тасралтгүй ярьдаг сүсэгтэй хүмүүс олон бий. Гэхдээ тэднээс асуувал тэдэнд **Эзэн Есүст итгэх итгэл** огт байхгүйг мэдэж болно. Ийм хайр хоосон бөгөөд утгагүй юм. Нөгөөтэйгүүр өөрсдийгөө **Христэд итгэлтэй** гэж хэлдэг хүмүүс байдаг ч тэдний амьдралаас ямар ч **хайр** илэрдэггүй. Паул мөн хүмүүсийг чин сэтгэлээсээ итгэсэн эсэхийг шалгадаг байв. Аврагчид итгэсэн жинхэнэ **итгэл** байх ёстой бөгөөд энэхүү итгэл Бурханыг болон бусдыг **хайрлах** амьдралаар нотлогдох ёстой. Паул **итгэлийн** талаар ярихдаа үүнийг **Христ Есүс дотор** байх гэж хэлсэн. Үүнийг анзаарах нь маш чухал. Бичээст Эзэн Есүс Христийг үргэлж итгэлийн гол зүйл болгодог. Хүн банкинд

хязгааргүй итгэл найдвар тавьж болох ч энэ нь зөвхөн банк найдвартай үед л хүчин төгөлдөр юм. Хэрэв банкны удирдлага зохион байгуулалт муу байвал хадгалуулсан мөнгөний аюулгүй байдлыг итгэл хангаж чадахгүй. Сүнсний амьдрал ч гэсэн үүнтэй ижил. Итгэл дангаараа хангалттай бус юм. Итгэл Эзэн Есүс Христ дээр төвлөрөх ёстой. Тэр хэзээ ч бүтэлгүйтэхгүй учраас Түүнд итгэлээ тавьсан хэн ч хэзээ ч харамсахгүй.

Паул тэдний **итгэл** болон **хайрын** тухай сонссоноос үзэхэд тэд нууцаар итгэдэг хүмүүс биш байсан нь тодорхой. Үнэн хэрэгтээ ШГ-нд нууцаар дагалдагч байхыг хүсэгч хүмүүсийг өөгшүүлдэггүй. Бурханы Үгэнд хүн Аврагчийг үнэнээсээ хүлээн авсан бол Христийг олны өмнө хүлээн зөвшөөрөх нь гарцаагүй гэж сургадаг.

Колоссайчуудын хайр **бүх ариун хүний төлөө** байсан. Тэдний хайр зөвхөн өөрсдийн бүлэглэл юмуу тухайн нутгаар хязгаарлагдаагүй. Тэд зөвхөн өөрсдийн чуулганы хүмүүсийг хайрлаагүй харин тэдний халуун дотно хайр жинхэнэ итгэгчидтэй таарах бүрдээ чөлөөтэй урсан гардаг байжээ. Үүнээс бид бусдыг хайрлах хайр явцуу байх юмуу зөвхөн өөрсдийн

чуулганаар эсвэл өөрийн улсаас явсан илгээлтийн эздээр хязгаарлагдаж болохгүй гэдэг сургамжийг авах хэрэгтэй. Бид хаана ч явсан Христийн хоньдыг таньж, боломж л байвал тэдэнд хайр үзүүлэх хэрэгтэй билээ.

[1:5]

Энэ ишлэл өмнөх өгүүлсэн ишлэлтэй хэрхэн холбогдож байгаа нь тийм ч тодорхой биш байна. 3-р ишлэлтэй холбоотой бол: Бид талархал өргөдгийн шалтгаан нь... **тэнгэрт та нарт зориулж хадгалагдсан найдварын учраас юмуу?** Эсвэл 4-р ишлэлийн сүүлийн хэсэгтэй холбоотой байвал: ариун хүмүүсийн төлөөх та нарын хайр нь **тэнгэрт та нарт зориулж хадгалагдсан найдварын учраас** байж болох юм. Аль ч тайлбар байх боломжтой. Элч Паул зөвхөн тэдний итгэл, хайрын улмаас бус мөн нэг л өдөр тэднийх болох ирээдүйн өв залгамжлалын төлөө талархсан байж болох юм. Нөгөө талаар, бидний өмнө юу байгааг мэдэж Христ Есүст итгэн бүх ариун хүнийг хайрладаг нь үнэн. Юутай ч Паул христитгэлт хүний амьдралын үндсэн гурван үнэт зүйлийг итгэл, хайр, **найдвар**

гэж жагсаасныг харж болно. Эдгээрийг мөн 1 Коринт 13:13 болон 1 Тесалоник 1:3; 5:8-д дурьдсан байдаг. Лаитфүүт хэлэхдээ: “Итгэл өнгөрсөн үетэй холбоотой; хайр одоо ч үйлчилдэг; найдвар ирээдүй рүү хардаг” гэжээ. ⁴

Энэ зүйлд **найдвар** нь хүлээх хандлага юмуу ямар нэгэн зүйл болохыг хүсэн тэмүүлэх гэсэн үг биш, харин хүний найдаж буй зүйлийг өгүүлж байна. Биднийг тэнгэрийн улсад аваачиж, бид мөнхийн өв залгамжлал уруугаа орох үед биелэх бидний авралын биелэлтийг энд хэлжээ. Колоссай хотынхон энэхүү **найдварын** тухай урьд нь, магадгүй Епафр тэдэнд сайн мэдээ хуваалцах үед сонссон байна. Тэдний сонссон зүйлийг **сайн мэдээ болох үнэний үг** хэмээн хэлжээ. **Сайн мэдээг** энд *үнэн* сайн мэдээ хэмээн тодорхойлжээ. Паул үүнийг бичиж байхдаа гностикчүүдийн *хуурамч* сургаалын талаар бодож байсан байж магадгүй. Өөр нэгэн “үнэн” гэдгийг аливаа зүйлийн талаар Бурхан юу гэснийг хэлнэ гэж тодорхойлжээ (Иох 17:17). **Сайн мэдээ** бол Бурханы үг учраас үнэн юм.

[1:6]

Сайн мэдээний үнэн тухайн үед мэдэгдэж байсан **бүх дэлхийд** хүрсэн шигээ Колоссай хотынхонд хүрчээ. Үүнийг шууд утгаар авч болохгүй. Энэ нь дэлхийн *бүх хүн* сайн мэдээ сонссон гэсэн утгатай байж боломгүй. Харин *үндэстэн бүрээс* зарим нь авралын сайн мэдээг сонссон (Үйл 2) гэж хэлж байж болох юм. Мөн сайн мэдээ бүх хүнд зориулагдаж, санаатай хязгаарлалтад оролгүй гадагшаа түгж байсан гэсэн утгатай байж бас болох талтай. Паул мөн үүнээс ямар үр дүн гарсан тухай нарийн тодорхой дүрсэлжээ. Сайн мэдээ тунхагласан Колоссай болон **дэлхийн** бусад **бүх** газарт **үр жимсээ ургуулж өсгөж** байсан. Эндээс сайн мэдээний ер бусын агуу мөн чанарыг харуулж байна. Байгаль дээр ургамал нэгэн зэрэг үр жимс ургуулж өсдөггүй байна. Жимс ургуулахын тулд маш олон удаа тайрч арчлах хэрэгтэй болдог бөгөөд хэрэв арчлахгүй зөнд нь орхивол хамаг шим шүүс нь жимсний оронд навч, мөчир лүү нь явдаг. Гэвч сайн мэдээний хувьд нэгэн зэрэг ургаж өсдөг байна. Энэ нь сүнсийг аварснаар үр жимс ургуулж, бүх ариун хүнийг босгон

байгуулахын сацуу хотоос хотод, үндэстнээс үндэстэнд түгэн тархдаг.

Энэ нь **Бурханы нигүүлслийг үнэн дотор сонсоод ухаарсан тэр өдрөөс эхлээд** колоссайчуудын амьдралд үзүүлсэн сайн мэдээний нөлөө юм. Колоссай хотын чуулган тооны хувьд ч, дотор нь байсан христитгэгч хүмүүсийн амьдрал сүнсний хувьд ч өсөж байв.

Нэгдүгээр зууны үед сайн мэдээ өргөн тархаж байсан бололтой. Европ, Ази, Африк тивд хүрч, олон хүний бодсоноос цааш явжээ. Гэхдээ л сайн мэдээ бүх дэлхийг бүрхсэн гэж үзэх үндэслэл байхгүй. Сайн мэдээг **Бурханы нигүүлсэл** хэмээн гайхалтай сайхан тодорхойлжээ. Бурханы уур хилэнг хүртэхээс өөр аргагүй гэм буруутай хүн дээр Бурханы нигүүлсэл өгөгдсөн тухай гайхамшигт үнэн гэхээс илүү сайхнаар сайн мэдээг тодорхойлох зүйл байна уу!

[1:7]

Итгэгчид **Епафраас** сайн мэдээ сонсож, амьдрал дээрээ амсаж мэдэх болсон гэдгийг элч тодорхой хэлсэн. Паул Епафрыг өөрсдийнх нь **өмнөөс үйлчилдэг Христийн итгэлт үйлчлэгч,**

тэдэнтэй **хамт боол болсон хайрт** хэмээн сайшаасан. Элч Паулд ямар ч хорсол юмуу атаархал байгаагүй. Өөр нэгэн номлогч “магтаал сайшаал хүртэхэд дүргүйцэх сэтгэл түүнд огт төрдөггүй байсан. Үнэн хэрэгтээ тэрээр Эзэнд үйлчилдэг бусад үйлчлэгчдэд хамгийн түрүүнд талархлаа илэрхийлдэг хүн байв” гэжээ.

[1:8]

Паул Колоссай хотынхны **Сүнс доторх хайрын** талаар Елафраас сонсчээ. Энэ нь зүгээр нэг хүний зүрхнээс гардаг сэтгэл байгаагүй, харин Бурханы **Сүнс** дотор нь оршиход бий болдог Эзэн болон Түүний ард түмнийг хайрлах жинхэнэ **хайрын** сэтгэл байсан юм. Захидалд Ариун Сүнсний тухай ганцхан удаа дурдаж байгаа нь энэ.

[1:9]

Талархлаа илэрхийлж дуусаад Паул одоо ариун хүмүүсийн төлөө зуучлан залбирч эхэлж байна. Элч Паул ямар өргөн хүрээнд олон зүйлийн төлөө залбирдаг байсныг өмнө нь дурьдсан. Түүгээр зогсохгүй тэр ямар ч нөхцөлд

үргэлж Бурханы хүмүүсийн хэрэгцээнд тодорхой нийцсэн залбирал хүсэлт өргөдөг байсан болохыг тэмдэглэх нь зүйтэй. Тэрээр ерөнхий залбирал өргөж байгаагүй. Тэрээр Колоссай хотынхны төлөө дөрвөн тусгай хүсэлт өргөж, тэдний (1) сүнсний ойлголт; (2) зохистой явах буюу амьдрах; (3) бялхам хүч; (4) талархах сэтгэлийн төлөө залбирч байна.

Тэрээр залбиралдаа хэзээ ч хорон юмуу харам байсангүй. Үүнийг 9, 10, 11-р ишлэлд *бүх, аливаа, бүхий л* зэрэг үгсийг хэрэглэснээс нь тодорхой харж болно. (1) **Бүх сүнслэг мэргэн ухаан хийгээд ойлголт дотор** (ишлэл 9), (2) “бүх талаар Түүнд таалагдаасай” (ишлэл 10), (3) “аливаа сайн үйлсэд” (ишлэл 10), (4) “бүх хүчээр” (ишлэл 11), (5) “бүхий л тэсвэр, тэвчээрт хүрч” (ишлэл 11) гэжээ.

Тиймээс гэсэн үг нь өмнөх зүйлстэй холбож байна. Энэ нь *Епафрын хэлсэн зүйлээс болж* (ишлэл 4, 5, 8) гэсэн утгатай. Колоссай хотын эдгээр эрхэм ариун хүмүүс, тэдний итгэл, хайр, найдварын талаар **сонссон** мөчөөс эхлэн тэрээр тэдний төлөө тасралтгүй залбирч дадсан байна. Юуны өмнө тэрээр тэднийг **бүх сүнслэг мэргэн**

ухаан хийгээд ойлголт дотор Бурханы хүслийн жинхэнэ мэдлэгээр **бялхаасай** гэж залбирсан. Тэр тэднийг гностикчуудын сайрхуу мэдлэгээр хангагдах хэрэгтэй гэж залбираагүй. Паул Бурхан тэдний амьдралын талаар ямар хүсэлтэй байгаа тухай үгэндээ хэрхэн илчилснийг бүрэн мэдэж аваасай гэж хүссэн. Энэ мэдлэг нь дэлхийн юмуу махан биеийн мэдлэг биш, харин **сүнслэг мэргэн ухаан болон сүнслэг ойлголтоор** бий болдог мэдлэг. **Мэргэн ухаан** нь олж авсан мэдлэгээ хамгийн зөв байдлаар хэрэглэх, **ойлголт** нь Бурханы хүсэлд юу нийцэж, юу нийцэхгүй байгааг ялгахыг хэлж байна.

[1:10]

10 болон 9-р ишлэлийн хооронд маш чухал холбоо байна. Элч Паул яагаад Колоссай хотынхон Бурханы хүслийг мэдээсэй гэж хүссэн бэ? Тэднийг хүчирхэг номлогч юмуу шуугиан дэгдээсэн багш болгох гэж үү? Тэд гностикчуудын хүсдэг шиг араасаа асар олон хүн дагуулаасай гэж үү? Үгүй, сүнслэг мэргэн ухаан болон ойлголтын жинхэнэ зорилго нь

христитгэлт хүмүүсийг **Эзэнд зохистойгоор явж, бүх талаар Түүнд таалагддаг** болгохын тулд юм. Энд удирдлага чиглүүлгийн тухай чухал хичээл байна. Бурхан бидэнд хандсан Өөрийн хүслийг бидний сониуч занг дарахын тулд илчилдэггүй. Бидний бардам хүсэл, бахдалыг хангахын төлөө ч бус юм. Харин Эзэн бидний амьдралын төлөөх хүслээ илчилдэг нь бид юу ч хийсэн Түүний таалалд нийцүүлэхийн тулд юм.

Аливаа сайн үйлсэд үр дүн гаргах. Хүн хэдийгээр сайн үйлсээр аврагдаггүй ч сайн үйлсийн *төлөө* аврагддаг нь гарцаагүй болохыг санах хэрэгтэй. Заримдаа хүнийг аврахад сайн үйлс ямар ч хэрэгцээгүй гэдгийг онцолж байхдаа бид христитгэгчид сайн үйлсэд итгэдэггүй гэдэг сэтгэгдэл төрүүлж мэднэ. Энэ бол огт ташаа зүйл! Ефес 2:10-т “Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн, Түүний бүтээл мөн”. Паул мөн Титэд хандан: “Энэ бол итгэмжит үг. Эдгээр зүйлсийг итгэлтэй яриасай гэж би чамаас хүсэж байна. Тэгвэл Бурханд итгэсэн хүмүүс сайн үйлс сахихдаа хянуур болох юм” гэж бичжээ (Тит 3:8).

Паул тэднийг зөвхөн **аливаа сайн үйлсэд үр дүн** гаргаад зогсохгүй **Бурханы мэдлэгээр өсөөсэй** гэж хүссэн. Үүнийг яаж хийх вэ? Юуны өмнө Бурханы үгийг шаргуу судалснаар үүнийг хийнэ. Тэгээд Түүний сургаалыг дагаж, Түүнд итгэмжтэйгээр үйлчилснээр үүнийг хийх юм. (Итгэмжтэйгээр үйлчлэхийг энд онцолсон бололтой.) Эдгээр зүйлийг хийснээр бид Эзэний тухай илүү гүнзгий **мэдлэгт** хүрэхээр байна. “Тиймээс мэдэцгээе, Эзэнийг мэдэхийн тулд шамдацгаая” (Хос 6:3).

1-р бүлэгт мэдлэгтэй холбоотой үгсийг дахин давтан ашиглаж байгааг анзаараарай. Ийнхүү хэрэглэх бүрд утга санаа нь улам өргөн болж байгааг анхаараарай. 6-р ишлэлд тэд “Бурханы нигүүлслийг *ухаарсан*”, 9-р ишлэлд “Түүний хүслийн жинхэнэ *мэдлэг*”, 10-р ишлэлд “Бурханы жинхэнэ *мэдлэгээр өсөж*” гэжээ. Эндээс 1) авралын тухай, 2) Бичээсийг судлах тухай, 3) үйлчлэл болон христитгэлт амьдралаар амьдрах тухай гэж хэлж болохоор байна. Эрүүл сургаал нь зөв үйл рүү хөтлөх ёстой бөгөөд тэрхүү үйл нь дуулгавартай үйлчлэлээр илэрдэг.

[1:11]

Элчийн гурав дахь хүсэлт нь ариун хүмүүсийг **Түүний цог жавхлант чадлын дагуу бүх хүчээр хүчтэй болгогдохын** төлөө байв. Энд ахиж байгаа үе шатыг анхаар: (*бялхах* ишлэл 9; *үр дүн гаргах* ишлэл 10; *хүчтэй болгогдох* ишлэл 11). Христитгэлт амьдралыг хүний хүч чадлаар амьдрах боломжгүй. Үүнд ер бусын хүч шаардагддаг. Тиймээс Паул итгэгчдийг үхлээс амилсан Бурханы Хүүгийн хүчийг мэдээсэй, ингэхдээ **Түүний цог жавхлант чадлын дагуу** мэдээсэй гэж хүссэн. Залбирлаас харахад энэхүү хүч нь Түүний цог жавхлант *чадлаас* гарах бус харин **чадлын дагуу** гэжээ. **Түүний цог жавхлант чадал** хязгааргүй бөгөөд ийм л цар хүрээний залбирал хийсэн байна. Пийк бичихдээ: “Хүч чадлаар зэвсэглэх хэмжээ нь хүлээн авагчийн хэрэгцээгээр байхаас гадна Бурханы хангалтаар юм”⁵ гэжээ.

Паул яагаад христитгэлт хүмүүсийг ийм хүч чадалтай байхыг хүссэн бэ? Тэднийг гадагш гаргаад олныг алмайруулсан гайхамшиг үйлдүүлэхийн тулд уу? Тэд үхэгсдийг амилуулж, өвчтнийг эдгээж, чөтгөрүүдийг хөөгөөсэй

гэсэндээ юу? Дахиад л хариулт нь “Үгүй” байна. Энэ хүч чадал хэрэгтэй байсан шалтгаан нь Бурханы хүүхэд **бүх хүчээр хүчтэй болгогдон, баяр хөөртэйгөөр бүхий л тэсвэр тэвчээрт хүрэх** явдал юм. Үүнд нарийн анхаарлаа хандуулах хэрэгтэй! Өнөөдөр христитгэлийн хаанчлалд гайхамшиг гэж нэрлэгддэг хэлээр ярих, өвчтнийг эдгээх, олны анхаарлыг татсан үйлдлүүдэд ихээхэн анхаарал тавьж байна. Гэвч бидний амьдарч байгаа цаг үед эдгээр зүйлээс илүү агуу гайхамшиг бол Бурханы хүүхэд зовлон туулахдаа тэсвэр тэвчээртэй байж, сорилт бэрхшээл дунд Бурханд талархал өргөж байгаа нь юм!

1 Коринт 13:4-т тэвчээрийг энэрэнгүй байдалтай холбоотой гэсэн бол энд баяр хөөртэй холбосон байна. Бүтээлийг ёлуулан байгаа зовлонгоос бид зугтаж чадахгүй тул зовдог. Ингэхдээ доторх баяр баясгалан, бусдын төлөөх энэрлийг хадгалахад Бурханы хүч хэрэгтэй. Үүнийг христитгэлийн ялалт гэнэ. **Тэвчээр болон тэсвэрийн** ялгаа бол нэг нь ямар ч гоморхолгүйгээр тэвчих, нөгөө нь өс хонзон саналгүй тэвчих гэсэн утгатай гэдэг. Зовлон

бэрхшээл дунд тэвчээртэй байж, Бурханыг магтаж чадаж байгаа итгэгч хүний амьдралд Бурханы нигүүлсэл гүйцэлдүүлэхийг хүсдэг хамгийн агуу зорилтуудын нэгийг хэрэгжүүлсэн байна.

[1:12]

Энэ ишлэлд **талархал өргөөсэй** гэдэг нь Паулд биш, Колоссай хотынхонд хамаатай юм (эх хувь дээрээ олон тоон дээр байдаг). Паул тэднийг бүх хүчээр хүчтэй болгогдоод зогсохгүй талархах сэтгэлтэй байж, **гэрэл дотор ариун хүмүүсийн өвийг хуваалцахад тэднийг зохистой болгосон** Эцэгт үргэлж талархал өргөөсэй хэмээн залбирчээ. Адамын хүүхдүүд тул бид тэнгэрийн улсын алдарыг хүртэх нь зохисгүй. Үнэн хэрэгтээ аврагдаагүй хүмүүс тэнгэрийн улс уруу ордог байсан бол тэд үүнд баярлахгүй харин ч хамгийн золгүй хүмүүс болох байсан. Тэнгэрийн улсын үнэ цэнийг ойлгохын тулд түүнд тохирч нийцэх шаардлагатай. Эзэн Есүст итгэсэн ч бидэнд өөрсдөд маань тэнгэрийн улсад тохирч нийцэх

зүйл ердөө байхгүй. Бидний алдар хүртэх эрх тэр чигтээ Эзэн Есүс Христ дотор байгаа:

Түүний нэрээр л би зогсож байна,
Өөр зогсох зүйл надад үгүй,
Алдар орших Иммануелын газарт ч
Түүнээс өөр дулдуйдах юу ч үгүй.

– *Анна Росс Козин*

Бурхан хүнийг аварсан тэр даруйдаа тэнгэрийн улсад ороход бүрэн нийцсэн хүн болгодог. Тэрхүү нийцэл бол Христ Өөрөө юм. Үүнийг юу ч сайжруулах боломжгүй. Удаан хугацаанд дуулгавартай амьдарч, дэлхий дээр үйлчиллээ ч гэсэн тэр хүнийг тэнгэрийн улсад ороход илүү нийцтэй болгодог юм юу ч байхгүй, анх аврагдсан өдөртөө хүлээн авсан нийцэл илүү болно гэж байхгүй. Алдар хүртэх бидний эрх бол Түүний цусанд байгаа. Өв залгамжлал нь **гэрэл дотор** байгаа бөгөөд “тэнгэрийн улсад хадгалагдаж” байх зуур дэлхий дээрх итгэгч бидэнд “өв залгамжлалын баталгаа” болгож Ариун Сүнснийг өгсөн юм. Тиймд бид өмнөө байгаа зүйлд баярлахын сацуу одоо ч гэсэн “Сүнсний анхны үр жимс”-ийг амтлах боломжтой.

[1:13]

Биднийг “гэрэл дотор ариун хүмүүсийн өвийг хуваалцахад...зохистой” болгосноор **Тэр биднийг харанхуйн эрх мэдлээс авраад, Өөрийн хайрт Хүүгийнхээ хаанчлалд шилжүүлсэн юм** (1Иох 2:11-тэй харьцуулж үз). Үүнийг Египетээс гарсан нь номд бичсэн Израилийн хүүхдүүдийн амьдралаар дүрсэлж болно. Тэд Египет газарт амьдарч байхдаа харгалзагчдын ташуур зодуур дор ёолон байсан. Тэнгэрээс Бурхан Өөрөө оролцож, гайхамшигаар тэднийг аймшигт хүлээснээс чөлөөлж, амласан газар уруугаа цөл дундуур удирдан авч явсан. Үүнчлэн гэм нүгэлт хүмүүсийн хувьд бид Сатаны хүлээсэнд байснаа түүний савраас Христээр **чөлөөлөгдөж**, одоо бид Христийн **хаанчлалд** орсон юм. Сатаны хаанчлал бол **харанхуйн** хаанчлал, үүнд гэрэл, дулаан, баяр баясгалан байхгүй, харин Христийн хаанчлал бол **хайрын хаанчлал** гэсэн дээрх гурван зүйл бүгд байгаа гэсэн утга санаатай.

Христийн **хаанчлалыг** Бичээст хэд хэдэн өөр өнцгөөс дүрсэлдэг. Тэр энэ дэлхий дээр анх ирээд Израилийн ард түмэнд шууд утгаар газар

дээрх хаанчлалыг санал болгосон. Еврейчүүд Ромын дарангуйллаас чөлөөлөгдөхийг хүсэж байсан ч гэм нүглээсээ гэмшиж эргэхийг хүсээгүй. Христ зөвхөн Өөртэй нь сүнсний зөв зүйтэй харилцаатай хүмүүсийг л хаанчлах боломжтой байсан. Үүнийг тодорхой ойлгуулахад тэд Хаанаа эсэргүүцэж, Түүнийг цовдолсон. Үүнээс хойш Эзэн Есүс тэнгэрийн улс уруу буцаж, бидэнд одоо нууцлаг байдалд оршиж байгаа хаанчлал бий (Мт 13). Энэ нь уг хаанчлал нүдэнд харагдах ил хаанчлал биш гэсэн үг юм. Хаан нь байхгүй байгаа. Гэхдээ Эзэн Есүс Христийг энэ цаг үед хүлээн авсан бүхэн Түүнийг зүй ёсны Удирдагч гэдгийг хүлээн зөвшөөрч, Түүний хаанчлалын албат болдог. Айсуй өдөр Эзэн Есүс энэ дэлхий дээр буцан ирж, Иерусалим хотыг нийслэлээ болгосон хаанчлалаа тогтоож, мянган жил хаанчилна. Тэрхүү цаг үеийн төгсгөлд Христ бүх дайснаа хөл дороо оруулж, хаанчлалаа Эцэг Бурханд өгөх болно. Энэ нь мөнхийн хаанчлалын эхлэл байх бөгөөд мөнхөд үргэлжилнэ.

[1:14]

Бурханы хайрт Хүүгийн хаанчлалын талаар дурьдсаны дараа Паул Эзэн Есүсийн бодгаль болон хийсэн ажлын талаар Бурханы номд бичигдсэн хамгийн агуу багц ишлэлийг өгүүлдэг. Бидний хувьд түүнийг залбирлаа дууссан уу, эсвэл эдгээр зүйлсэд залбирлаа үргэлжүүлж байна уу гэдгийг мэдэхэд хэцүү. Гэвч үүнийг мэдэх нь тийм ч чухал биш, учир нь дараагийн ишлэлүүд дан залбирал биш байсан ч хүндэтгэл мөргөл гарцаагүй мөн.

Стурц “Есүс Христийг хамгийн их өргөмжилсөн энэхүү гайхалтай хэсэгт Түүний нэр ямар ч хэлбэрээр харагддаггүй” гэдгийг хэлсэн. Энэ нь нэг талаасаа гайхалтай ч үүнд гайхаад байх юм байхгүй. Энд өгөгдсөн тодорхойлолтыг бидний ерөөлт Аврагчаас илүү хэн бүрэн хангаж чадах вэ? Уг хэсэг бидэнд Мариагийн цэцэрлэгчээс асуусан асуултыг сануулж байна: “Эзэнтэн, хэрэв та Түүнийг авсан бол хаана тавьснаа надад хэлнэ үү? Би Түүнийг авах гэсэн юм гэв” (Иох 20:15). Тэр Түүнийг нэрээр нь дуудаагүй. Мариагийн бодолд зөвхөн нэг л Хүн байсан.

Эхлээд Христийг дотор нь **бидэнд нүглийн уучлал болох золилт** байгаа Нэгэн гэжээ. **Золилт** гэдэг нь биднийг гэм нүглийн боолын зах дээрээс худалдаж авсан үйлдлийг дүрсэлж байна. Эзэн Есүс бидэн дээр үнийн шошго тавьсан. Тэр биднийг ямар өндөр үнэлээ вэ? Нэг ёсондоо “Би тэднийг маш их үнэлж байгаа тул тэднийг худалдаж авахын тулд цусаа урсгахыг зөвшөөрч байна” гэж хэлж байгаатай адил зүйлийг хийсэн. Нэгэнт биднийг маш өндөр үнээр худалдан авсан тул бид өөрсдийнх бус гэдэг нь бидэнд тодорхой байх ёстой. Биднийг үнээр худалдан авсан. Тиймээс бид өөрсдийн сонгосон замаар амьдрах ёсгүй юм. Йелийн Борден хэлэхдээ “хэрэв бид амьдралаа аваад хүссэн зүйлээ хийх юм бол бид өөрсдийн эзэмшилд байхгүй зүйлийг авч хулгайч болж байна!” гэжээ.

Тэрээр биднийг зольж аваад зогсохгүй бидэнд **нүглийн уучлалыг** өгсөн. Энэ нь Бурхан бидний гэм нүглийн улмаас төлөх байсан өрийг цуцалсан гэсэн үг юм. Эзэн Есүс Христ загалмай дээр ялын төлөөсийг төлсөн ба үүнийг хэзээ ч дахиж төлөх шаардлагагүй. Төлбөр хийгээд

хаагдсан бөгөөд Бурхан биднийг зөвхөн уучлаад зогсохгүй бидний нүглийг өрнө дорноос хэр хол байдаг шиг тийн холдуулсан (Дуу 103:12).

3. Чуулганы Тэргүүн болох Христийн алдар (1:15-23)

[1:15]

Дараагийн дөрвөн ишлэлд Эзэн Есүсийг дүрсэлсэн байна: (1) Бурхантай ямар хамааралтай (ишлэл 15); (2) бүтээлтэйгээ ямар хамааралтай (ишлэл 16, 17); (3) чуулгантай ямар хамааралтай (ишлэл 18) гэдгийг хэлжээ.

Эзэнийг **үл үзэгдэгч Бурханы дүр** хэмээн дүрсэлжээ. **Дүр** гэдэгт багадаа 2 утга санаа багтаж байна. Эхнийх нь Бурхан ямар вэ гэдгийг Эзэн Есүс харуулсан тухай өгүүлж байна. Бурхан Сүнс учраас нүдэнд харагддаггүй. Гэвч Христ Хүн болж ирснээр Бурхан Өөрийгөө хүний нүдэнд харагдахаар болгосон. Тэр утгаар Эзэн Есүс бол **үл үзэгдэгч Бурханы дүр** юм. Түүнийг харсан хэн ч Эцэгийг харсан (Иох 14:9-ийг үз). **Дүр** гэдэг үг нь мөн “төлөөлөгч” гэсэн санааг агуулж байна. Бурхан анх Адамыг Өөрийнхөө

эрх ашгийг төлөөлүүлэхээр дэлхий дээр байрлуулсан боловч Адам тэгж чадаагүй. Тиймээс Бурхан Өөрийнх нь эрх ашгийг анхаарч, хүн төрөлхтөнд хайртай зүрх сэтгэлийг нь илчлэхээр цорын ганц Хүүгээ төлөөлөгчөөрөө илгээсэн. Ийм утгаар Тэр Бурханы дүр мөн. 3:10-д **дүр төрх** гэдэг ижил үгийг ашиглаж, итгэгчдийг Христийн дүр төрх гэж хэлж байна.

Христ мөн **бүх бүтээлийн** буюу “бүх бүтээгдсэн зүйлийн” **ууган** гэжээ. Энэ ямар утгатай вэ? Зарим хуурамч багш нар Эзэн Есүс Өөрөө бүтээгдсэн бүтээл бөгөөд Бурханы бүтээсэн хамгийн анхны бодгаль гэдэг. Тэдний зарим нь Есүсийг Бурханы мутрын хамгийн агуу бүтээл гэж хүлээн зөвшөөрөхөд бэлэн байдаг. Гэвч Бурханы үгийн сургаалыг үүн шиг шууд эсэргүүцэн ташаарсан зүйл алга.

Бичээст гардаг “ууган” хэмээх үг дор хаяж 3 ялгаатай утга илэрхийлдэг. Лук 2:7-д Мариа ууган Хүүгээ төрүүлэхэд үүнийг *шууд утгаар* хэрэглэсэн. Эзэн Есүс Мариагийн төрүүлсэн анхны Хүүхэд байсан. Египетээс гарсан нь 4:22-т *зүйрлэсэн утгаар* “Израиль бол Миний хүү, Миний ууган хөвгүүн” гэж хэлсэн. Энэ ишлэлд

жинхэнэ төрөлтийн талаар яриагүй, Эзэн энэ үгээр Өөрийн төлөвлөгөө, зорилгод Израилийн ард түмэн ямар байр суурь эзэлж байгааг онцолсон байна. Эцэст нь Дуулал 89:27-д “ууган хүү” гэж хэлсэн нь *дээд эрх мэдлийн байр суурийг* илэрхийлж дээдийн дээд эрхэм, онцгой өвөрмөц гэдгийг тодорхойлж байна. Бурхан Давидыг дэлхийн бүх хаадаас дээд хаан Өөрийн ууган хүү болгоно гэж хэлсэн. Давид махан биеийн хувьд Иессийн хамгийн отгон хүү байсан. Гэвч Бурхан түүнд онцгой дээд, тэргүүнд байх хэмжээлшгүй эрх мэдэл өгөхөөр тогтоосон.

Энэ нь Колоссай 1:15-д гарч байгаа **бүх бүтээлийн Ууган** гэдэг үгийн санаа биш гэж үү? Эзэн Есүс Христ бол Бурханы өвөрмөц Хүү билээ. Нэг талаасаа бүх итгэгчид Бурханы хүү боловч Эзэн Есүс бол бусдад байхгүй өвөрмөц байдлаар Бурханы Хүү юм. Тэрээр бүх бүтээлээс урьд оршиж байсан бөгөөд бүх бүтээлээс дээд эрх мэдлийн байр суурьтай. Тэрээр хамгийн дээд, бүхнээс дээгүүр зиндаатай. **Бүх бүтээлийн ууган** гэдэг илэрхийлэл нь төрөлтийн талаар хэлээгүй байна. Мөнхөд үргэлжлэх харилцаагаар Тэрээр Бурханы Хүү гэдгийг л хэлж байна. Энэ

нь зөвхөн цаг хугацааны хувьд зогсохгүй мөн *байр суурийн* хувьд дээд хэргэм зиндааны талаар өгүүлжээ.

[1:16]

Хуурамч багш нар 15-р ишлэлийг авч Эзэн Есүсийг бүтээгдсэн гэж заадаг. Гаж сургаалынхны ашиглаж байгаа бичээсийн хэсгээс эргүүлээд тэднийг няцаах боломжтой. Энд ч гэсэн адилхан. 16-р ишлэл маргашгүй байдлаар Эзэн Есүсийг бүтээл биш харин бүхнийг Бүтээгч гэж хэлсэн. Энэ ишлэлд дэлхий ертөнц дээрх **бүх юмс Түүн дотор** бүтээгдээд зогсохгүй **Түүгээр Түүний төлөө бүтээгдсэн** гэдгийг бид мэдэж авч байна. Энэ бүх угтвар үг ялгаатай утга илэрхийлж байна. Юуны өмнө бид **бүх юмс Түүн дотор бүтээгдсэн** гэж уншсан. Бүтээх хүч Түүн дотор байна гэсэн санаа байна. Тэрээр Уран барилгачин байсан. Цаашилбал энэ ишлэлд **бүх юмс Түүгээр бүтээгдсэн** гэж гарч байна. Ингэж хэлсэн нь бүтээлийн хувьд Түүнийг Төлөөлөгч болгож байна. Гурвалын Бодгаль дотроос Түүгээр дамжуулан бүтээлийн ажил хийгдсэн. Мөн бүх юмс **Түүний төлөө**

бүтээгдсэн. Түүний төлөө бүх юмс бүтээгдсэн буюу Тэр энэ бүх бүтээлийн зорилго нь байв.

Паул **тэнгэр дэх** бүх юмс болон газар дахь бүх юмс **Христээр дамжуулан бүтээгдсэн** гэдгийг ихэд хичээнгүйлэн тайлбарлажээ. Ингэснээр Түүнийг зарим нэг зүйлийг бүтээсэн боловч Өөрөө бүтээгдсэн гэж хэлэх зай хэнд ч үлдэхгүй юм.

Элч цааш нь хэлэхдээ Эзэний бүтээсэн юмсад **үзэгдэх** болон **үл үзэгдэх** зүйлс багтсан гэсэн. **Үзэгдэх** гэдэг үгийг тайлбарлах шаардлагагүй харин элч Паул **үл үзэгдэх** гэж хэлснээр бидний сонирхлыг татна гэдгээ мэдэж байсан бололтой. Тийм учраас тэрээр **үл үзэгдэх** юмс гэдэг нь юу болохыг нарийн тайлбарлаж байна. Үүнд **хаан ширээнүүд, ноёрхлууд, удирдлагууд ба эрх мэдлүүд** орж байна. Бид эдгээр нэр томьёо нь тэнгэрлэг биетүүдийг хэлж байгаа гэж итгэдэг ч тэдгээр оюунлаг биетүүд ямар ямар зиндаатайг мэдэхгүй.

Гностикчууд Бурхан ба материйн хооронд сүнслэг биетүүдийн олон зиндаа ангилал байдаг бөгөөд Христ тэдгээрийн нэгэнд нь хамаардаг гэж зааж байв. Бидний цаг үед сүнслэг

биетүүдийг судлаачид Есүс Христийг зургаа дахь тэнгэрийн өндөр зиндааны сүнс гэдэг. Ёховагийн гэрчүүд бидний Эзэнийг энэ дэлхий дээр ирэхээс өмнө бүтээгдсэн тэнгэр элч байсан буюу Михаел тэнгэр элч байсан гэж заадаг! Энд Паул эдгээр утгагүй санаануудыг хүчтэй няцааж, хамгийн тодорхой бөгөөд ойлгомжтой байдлаар Эзэн Есүс Христ бол тэнгэр элч нарыг буюу үнэндээ **үзэгдэх** хийгээд **үл үзэгдэх** бүх юмсыг бүтээсэн Бүтээгч гэж хэлжээ.

[1:17]

Тэр бүх юмсын урьд байна. Бүх юмс Түүний дотор оршин тогтнодог. Паул “Тэр бүх юмсын урьд **байна**” гэж хэлснээс биш “Тэр бүх юмсын урьд *байсан*” гэж хэлээгүй. Библид Бурханы цаг хугацаанд захирагдашгүй байдлын талаар өгүүлэхдээ ихэвчлэн одоо цагийг хэрэглэдэг. Жишээ нь, Эзэн Есүс: “Абрахамыг бий болохоос өмнө Би БАЙДАГ мөн” гэж айлдсан (Иох 8:58).

Эзэн Есүс бүх зүйл бий болохоос урьд байсан төдийгүй, **бүх юмс Түүний дотор оршин тогтнодог.** Энэ нь Тэр бол дэлхий ертөнцийн Тогтнуулагч, мөнхөд хөдөлгөх Эх үүсвэр гэсэн

үг. Тэр од, нар, сарыг удирддаг. Тэрээр дэлхий дээр байхдаа ч хүртэл дэлхий ертөнцийн эмх журамтай тогтнох зүй тогтлын хуулийг захирч байсан.

[1:18]

Эзэн Есүс зөвхөн байгаль дэлхий, материаллаг ертөнцийг захираад зогсохгүй сүнслэг ертөнцийг ч захирдаг. **Тэр мөн бие болох чуулганы тэргүүн мөн.** Энэ үед Эзэн Есүст итгэсэн бүх итгэгч Христийн **бие** буюу **чуулган** болон хэлбэрждэг. Хүний бие бол тухайн хүний өөрийгөө илэрхийлдэг хэрэгсэл байдаг шиг дэлхий дээр байгаа Христийн Бие бол Бурхан Өөрийгөө энэ ертөнцөд илэрхийлэхээр сонгосон хэрэгсэл юм. Тэрээр энэхүү **биеийн тэргүүн** юм. Тэргүүн чиглүүлэг, удирдамж өгч, хяналт тавьдаг. Тэрээр чуулганд **хамгийн** дээд байр суурьтай.

Тэр бол **эхлэл** мөн. Бид үүнийг шинэ бүтээлийн **эхлэл** гэдгээр нь ойлгодог (Илч 3:14-ийг үз) бөгөөд сүнслэг амьдралын эх сурвалж хэмээн ойлгодог. Үүнийг дараа нь **үхэгсдээс анх төрсөн** (ууган) гэдэг илэрхийллийг хэрэглэн

тайлбарласан байна. Энд бид Эзэн Есүс үхэгсдээс хамгийн анх амилсан гэдгийг хэлээгүй болохыг онцлон тэмдэглэх хэрэгтэй. ХГ-нд болон ШГ-нд үхэгсдээс амилсан тохиолдол гардаг. Гэвч Эзэн Есүс *дахиж үхэхгүйгээр* үхлээс амилсан анхных байсан бөгөөд Тэр алдаршуулагдсан биеэр амилсан анхных байсан ба амилахдаа шинэ бүтээлийн Тэргүүн болж амилсан. Түүний амилалт онцгой өвөрмөц бөгөөд Түүнд итгэгч бүхэн мөн амилна гэсэн баталгаа юм. Энэ нь Түүнийг сүнслэг ертөнцөд хамгийн дээд эрх мэдэлтэй гэдгийг зарлан тунхагласан. Алфред Мейс үүнийг сайхан тодорхойлжээ:

Христ хаана ч хоёр дахь байж таарахгүй. Тэр бүх юмсыг бүтээсэн тул Тэр “бүх бүтээлийн ууган” (Кол 1:15, 16). Мөн Тэр золигдсон тэнгэрлэг гэр бүлээс хамгийн анх төрсөн буюу ууган нь юм. Тиймээс Тэр хэн бэ, юу хийсэн бэ гэдгээс шалтгаалан “Тэр Өөрөө бүх юмсын тэргүүн болохын тулд” бүтээлийн бөгөөд зөлийн ажлаар дамжуулан Түүнд дээд эрх мэдэл өгөгдсөн”. Хаана ч байсан Тэр тэргүүнд байна.

Эзэн Есүс бүтээлд ч, чуулганд ч ууган буюу тэргүүн байр суурийг давхар эзэмшдэг. Бурхан Түүнийг *бүх юмсын* тэргүүн болохыг тунхагласан юм. Паулын үед (болон бидний үед) амьдарч байгаа Христийг Бурхан биш, ямар ч агуу байсан бай зүгээр л бүтээл гэж нотлохыг хичээгсдэд хандсан ямар гээчийн хариулт өгсөн байгааг хараач!

Энэ нь Тэр Өөрөө бүх юмсын тэргүүн болохын тулд юм гэдгийг уншаад бид өөрсдөөсөө “Бурхан миний амьдралын тэргүүн үү?” гэж асуух нь зүйтэй.

[1:19]

Дарби 19-р ишлэлийг дараах байдлаар орчуулжээ: “Түүний дотор Бурханы бялхам дүүрэн байдал оршиход таатай байсан.” Хаан Жеймсийн Библид үүнийг Бурхан Эцэг цаг хугацааны тодорхой мөчид (Грек эхэд байхгүй үгсийг ташуу болгосныг анзаарна уу) бүх бялхам дүүрэн байдлыг Хүүгийн дотор оршихыг таалсан гэсэн санаа өгөхийг хичээдэг. Үнэндээ Бурханы бялхам дүүрэн байдал нь үргэлж Христ дотор байсан гэсэн үг.

Гностик гаж урсгалынхан Христийг Бурханд хүрэх “замын голд байх байшин” буюу зам зуурын холбоос гэж заадаг байв. Гэхдээ түүнээс илүү чухал холбоосууд байгаа ажээ. “Түүнээс цааш явбал бялхам дүүрэнд хүрнэ” гэж тэд хэлдэг байж. Гэвч Паул “Үгүй ээ, Христ Өөрөө төгс дүүрэн мөн!” гэж хариулсан.

Бүх бялхам дүүрэн байдал нь Христ дотор *оршдог*. **Орших** гэдэг нь түр зуурын айлчлах бус байнга оршин суухыг⁷ хэлж байна.

[1:20]

19-р ишлэл нь 20-р ишлэлтэй дараах байдлаар холбогдсон байна: **“Түүний загалмайн цусаар энх тайвныг тогтоон, Түүгээр (Христээр) дамжуулан ... бүх юмсыг Өөртэйгөө эвлэрүүлснийг таалдаг”**. Өөрөөр хэлбэл, Бурхан Христ дотор төгс дүүрэн нь оршихыг (ишлэл 19) таалаад зогсоогүй Христ **бүх юмсыг Өөртэйгөө эвлэрүүлснийг** таалсан.

Энэ бүлэгт хоёр янзын эвлэрүүллийг дурдсан байна: (1) Юмстай эвлэрэх тухай (ишлэл 20) ба (2) хүмүүстэй эвлэрэх тухай (ишлэл 21). Эхнийх нь ирээдүйн талаар ярьж байгаа бөгөөд хоёр дахь

нь Христэд итгэсэн хүмүүсийн хувьд хэдийнээ болж өнгөрсөн зүйлийг хэлж байна.

Эвлэрэл

Эвлэрнэ гэдэг нь зөв харилцаа юмуу стандартыг сэргээх юмуу дайсагнал байсан газар амар тайвныг бий болгох гэсэн утгатай. Библид Бурханыг хүнтэй эвлэрэх ёстой гэж хэзээ ч хэлдэггүй харин хүн Бурхантай эвлэрэх ёстой гэж хэлдэг. Махан биеийн оюун бодол Бурханы эсрэг дайсагнадаг (Ром 8:7) ба үүний улмаас хүнийг эвлэрүүлэх шаардлагатай.

Гэм нүгэл ертөнцөд орж ирэхэд хүн Бурханаас салсан. Тэрээр Бурханы эсрэг дайсагнасан хандлагатай болсон. Тийм учраас хүнийг эвлэрүүлэх хэрэгтэй байв.

Гэм нүгэл зөвхөн хүн төрөлхтөнд нөлөөлөөд зогсохгүй бүх бүтээлд нөлөөлсөн.

(1) Зарим тэнгэр элч нар өмнө нь гэм нүгэл үйлдсэн. (Бурханы үгэнд тэдгээр тэнгэр элчийг эвлэрүүлэх тухай огт дурдаагүй. Тэднийг “агуу их өдрийн шүүлт болтол мөнхөд хүлээстэй нь харанхуйд хорьжээ.” Иуд 6). Иов 4:18-д Елифаз Бурханыг

Өөрийн тэнгэр элч нарын эсрэг алдаа эндлийг нь тулгадаг хэмээжээ.

- (2) Гэм нүгэл орж ирэхэд нөлөөнд нь амьтад хүртэл өртсөн: “Учир нь бүтээлийн тэсэж ядсан тэмүүлэл нь Бурханы хөвгүүдийн илчлэгдэхийн хүслэн болж хүлээдэг. ... Учир нь өнөөг хүртэл бүх бүтээл нь хамтдаа ёолон, хамтдаа төрөх зовлонг эдэлдгийг бид мэднэ” (Ром 8:19-22). Амьтад өвдөж, зовон үхдэг болсоныг харахад тэд гэм нүглийн хараалаас мултраагүй гэдэг нь тодорхой.
- (3) Адам гэм нүгэл үйлдсэний дараа Бурхан газрыг хараасан (Эх 3:17). Үүний нотолгоо нь хогийн ургамал, зангуу, халгай юм.
- (4) Иов номд Билдад: Түүний мэлмийд одод ч цэвэр биш харагддаг гэснээс үзэхэд гэм нүгэл оддын ертөнцөд хүртэл нөлөөлсөн бололтой.
- (5) Еврей 9:23-д хэлснээр тэнгэр дэх юмс нь өөрсдөө цэвэршүүлэгдэх шаардлагатай байв. Бид үүнийг ямар утгаар хэлснийг сайн мэдэхгүй ч Сатан ах дүүсийг буруутгахаар (Иов 1:6, 7; Илч 12:10)

Бурханы өмнө очдог учраас тэнгэр дэх юм нь бузартсан байж болох юм. Зарим хүн энэ хэсгийг Бурханы оршдог газар, зарим нь тэнгэр гэж үздэг. Тэнгэр гэж үздэг хүмүүс Сатан тэнгэрийн орон зайд Эзэний өмнө очих боломжтой гэсэн санааг илэрхийлдэг. Юутай ч байсан бүгд Эзэний сэнтий гэм нүгэлд бохирдоогүй гэж санал нийлдэг.

Христийн үхлийн нэг зорилго нь хүн болон юмсыг Бурхантай эвлэрэх боломж бий болгоход оршиж байв. Үүний тулд Христ дайсагнал болон хагацлын шалтгааныг арилгах шаардлагатай болсон юм. Гэмийн асуудлыг Бурханы сэтгэлд бүрэн нийцүүлэн шийдвэрлэснээр энэ ажлыг үр дүнтэй хийсэн.

Эвлэрүүллийн цар хүрээг Колоссай 1-р бүлэгт дараах байдлаар тодорхойлсон: (1) Эзэн Есүс Христэд итгэгч бүхэн Бурхантай аль хэдийнэ эвлэрсэн (ишлэл 21). Христийн эвлэрүүллийн ажил бүх хүн төрөлхтөнд хангалттай боловч өөрсдөө хүлээн авсанаар л хүмүүст үр нөлөө үзүүлдэг. (2) Эцэстээ газар болон тэнгэр дэх бүх юмсыг эвлэрүүлнэ (ишлэл 20). Үүнд гэм нүглээс

болж бузарлагдсан амьтны ертөнц болон амьгүй эд юмс хамаатай. Гэхдээ үүнд Сатан, унасан тэнгэр элч нар, итгэдэггүй хүмүүс хамаарахгүй. Тэд мөнхийн сүйрэлд орно гэдгийг Бичээст маш тодорхой өгүүлдэг.

Эвлэрүүллийг “газар доорх юмс”-ад хамаардаг гэж хэлээгүй. Эвлэрүүлэх болон эрхшээлдээ оруулах нь ялгаатай. Үүнийг Филиппой 2:10-д “Энэ нь Есүсийн нэрд тэнгэрт байгаа, газар дээр байгаа, газрын доор байгаа бүх юмс өвдөг сөгдөж” гэж хэлсэн ба Дарби үүнийг “тэнгэрлэг, дэлхий дээрх зүйлс, чөтгөрүүд” гэж орчуулжээ. Бүх бүтээл, тэр байтугай унасан тэнгэр элч нар эцэстээ Эзэн Есүсийн өмнө өвдөг сөхөрөхөөс өөр аргагүй болно, гэхдээ тэд бүгд эвлэрүүлэгдэнэ гэсэн үг биш юм. Колоссай 1:20-г ашиглан Сатан ч, унасан тэнгэр элч нар болон итгээгүй хүмүүс ч эцэстээ Бурхантай эвлэрнэ гэж даяараа аврагдах тухай буруу үзэл онол заадаг учраас бид үүнийг онцлон хэлж байна. Бидний үзэж байгаа багц ишлэлд эвлэрүүллийн цар хүрээг газар болон тэнгэр дэх юмсаар хязгаарлажээ. “Газар доорх юмс” буюу чөтгөрүүдийг үүнд оруулаагүй байна.

[1:21]

Паул Колоссай хотынхонд тэдний эвлэрүүллийн ажил аль хэдийнэ хийгдсэн болохыг сануулж байна. Аврагдахаасаа өмнө Колоссай хотынхон гэм нүгэлтэй харь үндэстнүүд, Бурханаас **холдуулагдсан, бузар үйлсээрээ** сэтгэлдээ Бурханы **дайсан болсон байсан** (Еф 4:17, 18). Тэдэнд эвлэрэл үнэхээр хэрэгтэй байсан ба Эзэн Есүс Христ хэмжээлшгүй нигүүлслээр тэднийг эвлэрүүлэх санаачилга гаргасан.

[1:22]

Тэрээр тэднийг Өөрийн **махан биеийн үхлээр эвлэрүүлсэн**. Үүнийг амьдралаараа бус **үхлээрээ** дамжуулж хийжээ. **Махан бие** гэсэн нь зүгээр л Эзэн Есүс загалмай дээр эвлэрүүллийн ажил хийхдээ жинхэнэ хүний **биеэр** үхсэн болохыг илэрхийлж байна (Гностикчуудын тунхагладаг сүнслэг биеэр биш). Христ золилтыг биелүүлэхийн тулд махан биетэй болох шаардлагатай хэмээн тунхагласан Еврей 2:14-16 ишлэлтэй харьцуул. Гностикчүүдын үзэл онол үүнийг үгүйсгэсэн.

Энэхүү эвлэрүүллийн гайхалтай үр дүнг **Өөрийнхөө өмнө ариун, өө сэвгүй бөгөөд гэм зэмгүй болгосон** гэдэг үгээр илэрхийлжээ. Бурханлаг бус нүгэлтнүүд өмнөх хорон муу амьдралаас чөлөөлөгдөж, ийм ерөөлийн оршихуйд шилжиж орно гэдэг ямар гайхалтай нигүүлсэл вэ!

Ч.Р. Эрдман “Христийн дотор бидэнд ойр байдаг, анхаардаг, сонсдог, өрөвддөг, авардаг Бурханыг олно”⁸ гэж оновчтой хэлжээ.

Бид Бурхан Аавын өмнө гэмгүй, өө сэвгүй, бидний эсрэг тулгасан ямар ч ялгүй очиж, Христийг Зохистой Нэгэн гэдгийг баяртайгаар сүсэглэн мэдэх ирж буй тэрхүү өдөр Христийн эвлэрүүллийн ажлын үр дүн бүрэн дүүрэн харагдах болно (Илч 5).

[1:23]

Одоо элч Паул Бурханы олон хүүхдийн сэтгэлийг тавгүйтүүлдэг **хэрэв**⁹ гэдэг үгээр эхэлсэн хэсгийг бичсэн байна. Өнгөн дээрээ энэ ишлэл **итгэл дотор байх** эсэхээс бидний аврал хамааралтай болохыг зааж буй мэт харагдаж байна. Хэрэв тийм бол энэ ишлэл нь Бурханы

үгэнд хэлсэн бусад зүйл, тухайлбал, Иохан 10:28, 29-д Христийн ганц ч хонь мөхөхгүй гэж тунхагласантай хэрхэн нийцэх вэ?

Энэхүү асуултын хариултыг хайхдаа эхлээд итгэгч хүний мөнхийн аюулгүй байдал бол ШГ-ний хуудаснуудад маш тодорхой хэлсэн ерөөлтэй үнэн гэдгийг тунхаглан хэлмээр байна. Бичээст энэ зүйлд хэлсэнчлэн жинхэнэ итгэл ямагт гуйвшгүй чанартай байдаг бөгөөд үнэхээр Бурханаас төрөгсөд эцсээ хүртэл итгэмжтэй амьдардаг гэжээ. Үргэлжид байгаа нь бодит байдлын баталгаа мөн. Мэдээж дахин нүгэл үйлдэх аюул тулгардаг ч гэсэн христитгэгч нь унасан ч дахин босдог (Сур 24:16). Тэр итгэлээ орхидоггүй.

“Хэрэв” хэмээн хэлдэг олон багц үгийг Бурханы Бичээст оруулахаар Бурханы Сүнс шийдсэн нь христитгэгч хэмээн өөрсдийгөө нэрлэдэг хүмүүс үнэхээр тийм эсэхийг шалгадаг. Бид эдгээр үгийн хурц ирийг мохоох ямар ч зүйл хэлмээргүй байна. Хэн нэгний хэлснээр: “Бичээсийн ‘хэрэв’ гэдэг үгс энэ дэлхий дээрх христитгэгч хэмээн тунхагласан хүмүүст

зориулагдсан сэтгэл зүрхээ шалгах эрүүл саруул сорил болдог.”

Придхам эдгээр ойлгоход хэцүү ишлэлийн талаар ингэж хэлжээ:

Үгийг анхааралтай судалбал уншигч Ариун Сүнс нигүүлслийн хамгийн бүрэн дүүрэн бөгөөд туйлбартай зүйлс хэлсний дараа итгэсэн хэмээн амаараа тунхаглахаас цаашгүй хүмүүс сүйрнэ гэдгийг анхааруулдаг хэвшил байгааг анзаарах болно. ... Хуурамчаар дагагсдын чихэнд хатуу ширүүн санагдах сануулгыг бурханлаг сэтгэл эм мэт дуртайяа уулгадаг. ... Эдгээр бүх сургаалын зорилго нь итгэлийг урамшуулж, Христэд итгэсэн хэмээн худал тунхагласан бодлогогүй, өөртөө эрдсэн хүмүүсийг яллахад оршино.¹⁰

Элч голлон гностикчуудын талаар бодсондоо Колоссай хотынхныг **сайн мэдээг** дагалдан ирдэг буюу **сайн мэдээний** төрүүлдэг **найдвараасаа хөдлөхгүй** байхыг ятгаж байгаа нь эргэлзээгүй. Тэд Епафраас суралцсан **итгэл дотроо үргэлжид байж, суурилагдсан бөгөөд бат тогтсон** байх ёстой.

Паул сайн мэдээг **тэнгэрийн доорх бүх бүтээлд тунхаглагдсан** гэж дахин хэлж байна. Сайн мэдээ бүх бүтээлд очсон боловч шууд утгаар бүтээл бүрд хүрсэн биш. Паул дэлхий дахинд сайн мэдээ тунхаглагдсан нь түүнийг жинхэнэ үнэн болохыг гэрчилж байна гэсэн. Энэ нь сайн мэдээ хаа ч байсан хүн бүрийн хэрэгцээнд нийцдэгийг гэрчилж байна гэж тэрээр үзэж байлаа. Энэ ишлэл дэлхийн бүх хүн тухайн цаг үед сайн мэдээг сонссон гэсэн үг биш юм. Энэ нь хэрэгжиж дуусаагүй үйл явц байв. Мөн Библид гардаг ертөнцөд буюу Газар дундын тэнгис хавьцаах ертөнцөд бүхэлд нь хүрсэн.

Паул өөрийгөө **үйлчлэгч** гэж хэлсэн нь “зарц” гэсэн утгатай. Үүнд ямар ч албан тушаалын талаар ярьсан юм байхгүй. Ямар нэгэн өндөр албан тушаал биш харин даруу байр суурийг илэрхийлсэн үг.

4. Паулд даалгасан үйлчлэл (1:24-29)

[1:24]

1-р бүлгийн сүүлийн зургаан ишлэл Паулын үйлчлэлийг дүрсэлдэг. Юуны өмнө энэ үйлчлэл зовлон дотор явагдсан. Паул шоронгоос

бичихдээ **одоо** тэр итгэгчдийн **төлөө зовохдоо баярлаж байна** гэсэн. Эзэн Есүс Христийн зарцын хувьд тэрээр үгээр хэлшгүй бэрхшээл, хавчлага, **зовлонг** тэсвэрлэхийн тулд дуудагджээ. Эдгээр нь түүнд эрхэм нэр төрийн хэрэг байсан - **Христийн зовлон дотор юу дутагдаж буйг нөхөх** нэр төрийн хэрэг байв. Энэ юу гэсэн үг вэ? Юуны өмнө энэ нь загалмай дээр Эзэн Есүс Христийн гүйцэтгэсэн *золилтын* зовлон байж таарахгүй. Тэр зовлон нэг удаа бүгдийн төлөө явагдаж гүйцсэн бөгөөд ямар ч хүн тэрхүү зовлонг хуваалцаж чадахгүй. Гэхдээ Эзэн Есүс одоо хүртэл зовж байгаа гэсэн утга энд байна. Тарсын Саул Дамаск уруу явах замдаа цохиулан газар хөсөр унахдаа тэнгэрээс “Саул аа, Саул аа, юунд чи Намайг хавчина вэ?” гэх дууг сонссон. Паул Эзэнийг санаатай хавчиж байгаагүй, зөвхөн христитгэгчдийг хавчиж байсан. Тэрээр итгэгчдийг хавчина гэдэг нь тэдний Аврагчийг хавчиж байгаа гэсэн үг болохыг ойлгосон. Тэнгэрт байгаа Тэргүүн газар дээрх Өөрийн Биеийн зовлонг мэдэрдэг байна.

Тиймээс элч Паул Эзэн Есүсийн төлөө зовох ёстой христитгэгчдийн бүх зовлон шаналалыг

Христийн зовлонгийн үлдсэн хэсэг гэж хардаг байна. Үүнд зөвт байдлын төлөө, Христийн төлөө (Түүний буруутгалыг тэвчих) болон сайн мэдээний төлөө зовох зовлон хамаарна.

Христийн зовлон гэдэг нь зөвхөн Христийн төлөө зовлон эдлэхийг хэлэх төдийгүй Аврагч дэлхий дээр байх үед эдэлсэнтэй *ижил төрлийн* боловч хамаагүй бага хэмжээний зовлонг бас хэлж байгаа юм.

Элчийн **махан биеэрээ** эдэлсэн зовлон Христийн **бие болох чуулганы төлөө** байсан юм. Аврагдаагүй хүмүүсийн зовлон зорилгогүй байдаг гэж хэлж болно. Тэр зовлонг ямар ч дээгүүрх зүйлс дагалддаггүй. Тэдгээр нь мөнхөд тамд тарчлах зовлонг урьдчилан амсаж байгаа хэрэг юм. Харин христитгэгч хүмүүсийн зовлон үүнтэй адилгүй. Тэд Христийн төлөө зовоход Христ маш бодитойгоор тэдэнтэй хамт зовдог.

[1:25]

Би энэхүү чуулганы үйлчлэгч болсон юм. Паул 23-р ишлэлийн төгсгөлд энэ хэллэгийг хэдийнээ ашигласан билээ. Гэхдээ эдгээрийн хооронд ялгаа байна. Элчид хоёр талтай үйлчлэл

байсан. Нэгдүгээрт, тэрээр сайн мэдээ тунхаглах захирамж авсан (ишлэл 23), хоёрдугаарт, чуулганы агуу нууцыг заахын тулд илгээгдсэн (ишлэл 25). Энд Христийн жинхэнэ үйлчлэгчид хандсан бодит хичээл байна. Бид хүмүүст сайн мэдээ тарааж Христ уруу хөтлөөд өөрсдөө л амьдралаа аргацааг гэж зөнд нь хаяж болохгүй. Харин бид сайн мэдээ тараах хүчин чармайлт тэдний цэвэр ариун итгэл, түүний дотор чуулганы үнэнээр өсөн бойжих боломжтой ШГ-ний нутгийн чуулганыг байгуулахад чиглэх хэрэгтэй. Эзэн өөрийнхөө хүүхдүүдийг тэжээл авч, өсөх боломжтой хоолны газар уруу удирдахыг хүсдэг.

Тэгэхээр Колоссай 1-р бүлгээс бид (1) Христ хоёр талаар бүхнээс дээгүүр, (2) Христ хоёр талаар эвлэрүүлсэн тухай ба (3) Паулын хоёр талт үйлчлэлийн талаар үзлээ. 25-р ишлэлд Паул **“Би энэхүү чуулганы үйлчлэгч болсон юм”** гэж хэлэхдээ өөрийнхөө үйлчлэлийг сайн мэдээ бус чуулганд хамаатуулж хэлсэн. Үүнийг өмнөх: **Бурханы үгийг биелүүлэхийн тулд та нарын тусын тулд Бурханаас надад соёрхсон үүргийн** (буюу “диспенсацийн”) дагуу гэдэг

илэрхийллээс харахад тодорхой байна. Үйлчлэгч буюу нярав нь бусдын ашиг сонирхол болон эд хөрөнгөнд санаа тавьдаг хүн. Паулд чуулганы тухай агуу үнэнийг маш онцгой байдлаар даалгасан тул нярав байсан. Христийн Биеийн нууц ганцхан түүнд илчлэгдээгүй ч гэсэн тэрээр энэ чухал үнэнийг харь үндэстнүүдэд хүргэхээр сонгогдсон нэгэн байв. Христийн хувьд болон диспенсацийн хувьд өөрийн бүрдэл, онцгой найдвар, хувь тавилан, амьдралтай нь холбоотой бусад олон үнэн, Бурханы Паул ба бусад элч нарт өгсөн тушаалын хамт чуулганы эзлэх өвөрмөц байр суурь үүнд хамаарна.

Тэрээр **та нарын тусын тулд надад соёрхсон** гэж хэлэхдээ Колоссай хотынхныг харь үндэстэн гэж бодож байсан. Элч Петр еврей хүмүүст сайн мэдээ тунхаглахаар дуудагдсан бөгөөд Паул харь үндэстэн рүү мөн ижил үйлчлэлд дуудагдсан.

Энэхүү бүлэгт гардаг хамгийн хүнд илэрхийлэл бол **Бурханы үгийг биелүүлэх** гэсэн үг юм. Паул үүгээр яг юу хэлэхийг хүссэн бэ? Юуны өмнө тэрээр сүүлийн номыг оруулснаар Бурханы үгийг бичиж дуусгасан гэж

хэлээгүй юм. Бидний мэдэж байгаагаар цагийн хувьд Иоханы бичсэн Илчлэлт ном ШГ-нд нэмж орох сүүлийн ном байсан. Ямар утгаар Паул **Бурханы үгийг биелүүлэх** буюу гүйцээх гэж хэлсэн бэ?

Юуны өмнө **биелүүлэх** гэдэг нь бүхэлд нь тунхаглаж бүгдэд мэдэгдэхийг хэлж байж болох юм. Тиймээс Паул Бурханы бүх зөвлөгөөг тунхагласан. Бидний санал болгож байгаа дараах тайлбар нь Бурханы үгийг сургаалын хувьд гүйцээсэн гэж хэлсэн байж болох. ШГ-ний илчлэлтийн гол агуулга нь нууцын талаарх агуу үнэн юм. Үнэхээр ШГ-нд гардаг сэдвүүдийн тойргийг энд гүйцээсэн. Паулаас хойш өөр бусад ном бичигдсэн ч элч Паулын бичсэн зүйлсэд дурдаагүй итгэлийн агуу нууцууд байхгүй. Чуулганы нууцын талаарх илчлэлтүүд Бурханы үгийг гүйцээсэн. Үүнээс хойш нэмэгдсэн зүйлс үүн шиг цоо шинэ үнэн байгаагүй.

[1:26]

Энэхүү ишлэлд Паул Бурханы үгийг биелүүлэх ажил нь **нууцтай** холбоотой гэдэг нь харагддаг ба **тэрхүү нууц нь өнгөрсөн үеүдээс,**

үр удмуудаас нууцлагдсан байсан боловч одоо Өөрийнх нь ариун хүмүүст илэрхийлэгджээ. ШГ-нд нууц гэдэг нь өмнө илчлэгдэж байгаагүй, харин одоо ШГ-ний элч нар болон эш үзүүлэгчдээр дамжуулан хүмүүст мэдэгдсэн үнэн юм. Хүн хэзээ ч өөрийнхөө оюун ухаанаар олж мэдэхгүй байсан ба Бурханы соёрхсон нигүүлслээр мэдүүлсэн үнэн.

Энэ нь ХГ-ний үед нууц байсан чуулганы үнэний талаар заасан олон ишлэлийн нэг юм. Тэр нь **өнгөрсөн үеүдээс, үр удмуудаас нууцлагдаж байсан** (Еф 3:2-13, Ром 16:25-27). Тиймээс чуулган нь Адам юмуу Абрахамаас эхэлсэн гэж ярих нь буруу. Чуулган Пентекостын өдрөөс эхэлсэн бөгөөд чуулганы тухай үнэнийг элч нараар дамжуулан илчилсэн. ШГ-ний чуулган нь ХГ-ний Израилиас ялгаатай. Энэ нь урьд өмнө хэзээ ч байгаагүй зүйл юм.

Бурхан бусад үндэстнүүдийг гэм нүгэл, хурамч шүтээнд тушаагаад харин Абрахамыг Халдейн Ураас дуудахад Израиль эхэлсэн. Тэрээр Абрахамын үр удмаас бусад бүх үндэстнээс тусгаар, онцгой үндэстэнг бий болгожээ. Чуулган бол эсрэгээрээ, бүх удам

угсаа, улс үндэстний итгэгчдийг ёс суртахуун, сүнсний хувьд бусдаас тусгаар нэгдмэл нэг Бие болгосон юм. Тэрхүү чуулган нь Израилийн үргэлжлэл биш гэдгийг олон зүйлээс харагддаг, үүний нэг нь Паулын Ром номын 11-р бүлэгт хэрэглэсэн “чидун мод”-ны зүйрлэл билээ. Еврей хүн Христэд итгэхээрээ чуулганы нэг хэсэг болж байгаа боловч Израиль үндэстэн өөрийн гэсэн ялгарах шинж чанараа хадгалж байгаа (Кол 3:10, 11).

[1:27]

Энэхүү нууцын үнэнийг дараах байдлаар дүгнэж болох юм. Үүнд: (1) Чуулган бол Христийн Бие. Бүх жинхэнэ итгэгчид Биений эрхтэнүүд бөгөөд Христийн алдрыг үүрд мөнхөд хувалцах тавилантай. (2) Эзэн Есүс бол Биед амь, тэжээл, чиглэл өгөгч Биений Тэргүүн юм. (3) Еврейчүүд чуулганд хамрагдах давуу эрхтэй ч биш, мөн харь үндэстнүүдэд ч дутуу эрх гэж байхгүй. Еврей хүмүүс болон харь үндэстнүүд хоёулаа итгэлээр дамжуулан шинэ хүн болж Биений эрхтнүүд болсон (Еф 2:15, 3:6). Харь үндэстнүүд аврагдаж болно гэдэг нь ХГ-нд

нууцлагдаагүй үнэн ч, итгэсэн харь үндэстэн Христийн Биеийн эрхтнүүд болж Түүний алдрыг хуваалцагчид болж, Түүнтэй хамт хаанчлах нь урьд хэзээ ч ил болгоогүй үнэн юм.

27-р ишлэлд Паулын тодотгож байгаа энэхүү нууцын нэг онцлог нь Эзэн Есүс харь үндэстнүүдийн зүрхэнд нутаглахыг хүсэж байгаад оршиж байна. **Энэ нь та нарын дотор байгаа алдрын найдвар болох Христ мөн** гэж харь үндэстнүүд байсан Колоссай хотынхонд хэлсэн. Ф.Б.Мейер бахдан өгүүлэхдээ: “Христ Абрахамын хүүхдийн зүрхэнд нутаглана гэдэг нь гайхалтай өршөөнгүй зүйл гэж хэлж болох ч харь үндэстнүүдийн зүрхэнд нутаглана гэдэг бол ер бусын гайхалтай зүйл мөн” гэжээ. “Харь үндэстнүүд энэхүү биеийн хамтран өв залгамжлагчид ба эрхтнүүд болох бөгөөд сайн мэдээгээр дамжуулан Христ Есүс дотор амлалтуудыг хамтран хуваалцагчид болжээ” (Еф 3:6) гэсэн нь энэхүү нууц юуны тухай гэдгийг илэрхийлж байгаа юм. Энэхүү үнэний ач холбогдлыг онцлон тэмдэглэхдээ дагалдагч “энэ нууц” эсвэл “энэхүү нууцын алдар” гэж хэлээд зогсоогүй харин **энэхүү нууцын алдрын баялаг**

гэж хэлсэн байна. Тэрээр уншигчдын анхаарлыг энэхүү гайхамшигтай үнэн рүү татахын тулд үгсээ улам бүр нэмэгдүүлэн тайлбарлажээ.

Энэ нь та нарын дотор байгаа алдрын найдвар болох Христ мөн. Христ дотор байгаа нь итгэгчдийн **алдрын найдвар** юм. Бидэнд Аврагчаас өөр тэнгэрийн улсад орох эрх байхгүй. Тэр бидний дотор байгаа нь биднийг аль хэдийнээ тэнгэрийн улсад орсон мэт баттай болгодог.

[1:28]

Түүнийг тунхаглаж байна гэдэг нь чухал илэрхийлэл юм. **Түүнийг** гэдэг нь Эзэн Есүс Христийг хэлж байна (ишлэл 27). Паул энд Хүнийг тунхагладаг гэж хэлсэн. Тэрээр улс төр юмуу гүн ухаан зэрэгт цагаа зарцуулж байгаагүй, харин тэрээр Эзэн Есүс Христ дээр төвлөрч байсан. Яагаад гэвэл христитгэл гэдэг нь Христ болохыг тэр ойлгосон байв. **Бид хүн бүрийг Христ дотор төгс болгохын тулд бүх мэргэн ухаан дотор хүн бүрд сануулж, хүн бүрд заан Түүнийг тунхаглаж байна.** Энд бид хайрт элчийн үйлчлэлийн талаар илүү ойлголттой

болж байна. Энэ бол хүнээс хүнд хандсан үйлчлэл байжээ. Тэрээр аврагдаагүй хүмүүст аймшигт уур хилэн ирж байгааг сануулж, ариун хүмүүст христитгэлийн агуу үнэнүүдийг зааж байсан.

Эндээс бид түүнийг дагалдуулах ажлыг анхаардаг байсан болохыг харж байна. Аврагч уруу чиглүүлсэн хүмүүсийн төлөө тэрээр үнэхээр хариуцлага мэдэрдэг байсан юм. Тэрээр хүмүүсийг аврагдсан бол боллоо гээд цааш явдаггүй байжээ. Тэрээр **хүн бүрийг Христ дотор төгс болгохыг** хүсдэг байв. Паул өөрийгөө Бурханд өргөл өргөж байгаа тахилч мэтээр дүрсэлсэн. Энд өгүүлсэн өргөл нь хүмүүс юм. Ямар болзлоор тэднийг Эзэнд өргөдөг байсан бэ? Тэд Христ дотор сул дорой юмуу жаахан хүүхдүүд байсан уу? Үгүй, тэрээр тэднийг төлөвшсөн, өсөж том болж насанд хүрсэн христитгэгчид байхыг хүссэн. Тэднийг үнэн дотор бат сайн үндэслэгдээсэй хэмээн хүсэж байжээ. Бид Христ уруу дагуулж буй хүмүүсийнхээ төлөө адилхан ачаа үүрдэг үү?

[1:29]

Энэхүү зорилгын төлөө Паул болон бусад элч нар ажиллаж байсан билээ. Гэхдээ тэрээр үүнийг өөрийнхөө хүчээр хийж байгаа биш, харин түүний **дотор хүчтэй ажиллаж байгаа Түүний хүч чадлаар** ажилллаж байгаагаа ухаарч байсан. Өөрөөр хэлбэл, тэрээр зөвхөн Эзэнээр хүчтэй болгогдож байж л Түүний төлөө үйлчлэх боломжтой гэдгийг ойлгож байв. Тэрээр нэг газраас нөгөө рүү явж чуулган тарьж, Бурханы ариун хүмүүсийг өсгөж байхдаа Эзэн түүний **дотор хүчтэй ажиллаж байгааг** мэдэрч байжээ. Филиппийн орчуулганд 28, 29-р ишлэлийг ийн хэлсэн нь бидэнд хэрэгтэй:

Тиймээс бид Христийг тунхагладаг нь гарцаагүй. Бид уулзсан хүн бүрд сануулга өгч, зааж чадах хүн бүрд Түүний талаар мэддэг бүхнээ зааснаар боломжтой бол бид хүн бүрийг Христ дотор бүрэн төлөвшилд хүргэх юм. Үүний төлөө би Бурханы надад өгсөн бүх хүч чадлаар цаг үргэлж ажилладаг гэжээ.

5. **Философи, легализм, мистисизм, асетисизмийн хор хөнөөлийн эсрэг Христ хангалттай (2:1-23)**

[2:1]

Энэхүү ишлэл 1-р бүлгийн сүүлийн 2 ишлэлтэй маш ойр холбоотой байна. Тэнд элч Паулын хичээл зүтгэлээр зааж, номлож бүх итгэгчдийг Христ дотор төлөвшүүлэхийн төлөө ажилласан тухай хэлсэн. Энд өгүүлэх түүний хичээл зүтгэл дээрхээс арай ялгаатай. Одоо тэрээр залбиралдаа **их тэмцэлтэй** байдаг талаар өгүүлж байна. Тэрээр урьд нь хэзээ ч уулзаж байгаагүй хүмүүсийн төлөө **их тэмцэлдэж** байв. Колоссай хотын талаар сонссон анхны өдрөөс эхлэн **тэдний** төлөө болон хөрш хот болох **Лаодик** хотын төлөө, мөн урьд нь уулзаж байгаагүй бусад христитгэгчдийн төлөө тэр залбирч байсан юм (Илч 3:14-19-д эдгээр чуулганы хожмын харамсалтай байдлын талаар үз).

1-р ишлэл олон нийтэд хандсан үйлчлэлд орох боломж хэзээ ч олдож байгаагүй хүмүүст тайтгарлыг өгдөг. Энд бид зөвхөн хүмүүсийн өмнө хийх үйлчлэлээр хязгаарлагдах хэрэггүй

болохыг зааж байна. Бид өрөөндөө өвдөг сөгдөн
Эзэндээ хувьчлан үйлчилж болно. Хэрэв бид
олны өмнө үйлчилж байгаа бол үүний үр дүн
бидний Бурхантай тогтоосон хувьчилсан
харилцаанаас ихээхэн хамааралтай.

[2:2]

Паулын залбирлын агуулга энд маш тодорхой
өгөгджээ. Паул **тэдний зүрх урамшаасай** гэж
залбирч байна. Колоссай хотынхон
гностикчүүдийн номлолын аюулд өртөөд байсан.
Тиймээс **урамших** гэдэг үг нь энд баталгаажих
юмуу хүчирхэгжих гэсэн утгатай.

Залбиралдаа дурдсан өөр зүйл бол тэд **хайрын
дотор холбогдох** юм гэжээ. Хэрэв ариун хүмүүс
хоорондоо баяр хөөртэй хайрын нөхөрлөл дотор
байвал тэд дайсны дайралтыг эсэргүүцэх хүчтэй
жигүүр болж чадна. Мөн хэрэв тэдний зүрх
Христийг хайрлах хайраар халуун байвал Тэр
тэдэнд христитгэлийн илүү гүн үнэнүүдийг
илчлэх болно. Эзэн Өөрийн нууцуудыг Өөрт нь
ойрхон байдаг хүмүүст илчилдэг нь хүмүүсийн
сайн мэдэх Бичээсийн зарчим юм. Жишээлбэл
Иохан Есүсийн цээжийг налж байсан элч бөгөөд

түүнд Есүс Христийн агуу илчлэлт өгөгдсөн нь санамсаргүй зүйл биш юм.

Тэгээд Паул тэднийг **Бурханы нууцын жинхэнэ мэдлэг болох Христ уруу аваачдаг бүрэн итгэлт ойлголтоос ирдэг бүх баялагт хүрэхийн** төлөө залбирсан. Тэд христитгэлийн талаар **ойлгох** тусам гарцаагүй үнэн гэдгийг нь бүрэн ухаарна. Христитгэгчид итгэлээр илүү бат үндэслэгдэх тусам тухайн үеийн буруу сургаалд уруу татагдах аюул багатай байх юм.

Бүрэн итгэлт гэдэг илэрхийллийг ШГ-нд гурван удаа дурдсан. (1) *Итгэлийн* бүрэн итгэлт байдал - бид Бурханы Үг, бидэнд өгсөн Түүний гэрчлэл дээр суурилдаг (Евр 10:22). (2) *Ойлголтын* бүрэн итгэлт байдал - бид мэдэх ба үнэмшсэн (Кол 2:2). (3) *Найдварын* бүрэн итгэлт байдал - бид гарах үр дүнд бүрэн итгэж урагшилдаг (Евр 6:11).

Паулын залбирлын оргил цэг нь **Бурханы нууцын жинхэнэ мэдлэг болох Христ** гэсэн үгэнд байна. Паул **Бурхан...болон Христийн нууцыг** мэдээсэй гэж хэлсэн нь ямар утгатай вэ? Тэрээр энд чуулганы үнэний талаар ярьсаар байна. Христ бол Биений Тэргүүн бөгөөд бүх

итгэгчид Биеийн эрхтнүүд юм. Гэвч энд өгүүлж байгаа нууцын онцлог санаа нь Христийн тэргүүн байх явдал байв. Тэрээр ариун хүмүүсийг энэхүү үнэнийг мэдээсэй гэж үнэхээр хүсэж байв. Хэрэв тэд Тэргүүн болох Түүнийг ямар агуу болохыг ухаарвал, гностикийн сургаал, тэднийг хөнөөх бусад хорон муу гаж сургаалын нөлөөнд автахгүй юм.

Паул ариун хүмүүсийг Христийг хэрэглээсэй, Түүний баялгийг ашиглаасай, яаралтай асуудал тулгарахад Түүнд түшиглээсэй гэж хүсэж байв. Тэрээр тэднийг Христийг Алфред Мейсийн хэлсний адил ойлгоосой гэж хүсэж байлаа. Энэ нь:

...бол Түүний хүмүүс дотор байдаг, Бурханы бүх чанарыг эзэмшдэг, хязгааргүй, үгээр хэлшгүй, хэмжээлшгүй нөөц баялагтай тул тэд Түүнээс гарч яван ямар ч зүйлийг эрэлхийлэх шаардлагагүй юм. “Тэдэнд Бурхан харь үндэстнүүд дундах ЭНЭХҮҮ НУУЦЫН алдрын БАЯЛАГ гэж юу болохыг мэдүүлэхийг хүссэн. Тэр нь алдрын найдвар болох ЧИНИЙ ДОТОР БУЙ ХРИСТ ЮМ” (Кол 1:27). Хүч дотор илэрхийлэгдсэн

энэхүү үнэн Лаодикчүүдийн бардамнал, рационалист теологи, уламжлалт шашин, чөтгөрүүдийг орогнуулдаг сүнс дуудагч болон эсэргүүцлийн аливаа бусад хэлбэр, хуурамч зүйлээс гарцаагүй баттай хамгаалах зөв эмчилгээ юм.¹¹

[2:3]

Христ дотор мэргэн ухаан болоод мэдлэгийн бүх эрдэнэс нуугдсан байдаг. Гностикчүүд мэдээж тэнгэрлэг илчлэлтийн хуудсанд байгаа зүйлсээс хол давсан ойлголтоор сайрхаж байв. Тэдний мэргэн ухаан бол Христ буюу христитгэлд байдаг юмсаас гадна нэмэлт зүйлс байлаа. Харин Паул энд Христ хэмээн Тэргүүн дотор **мэргэн ухаан болоод мэдлэгийн бүх эрдэнэс нуугдсан байдаг** гэжээ. Тиймээс итгэгч хүмүүс Бичээст бичигдсэнээс цааш хэтрүүлэх шаардлага байхгүй. Христ доторх **эрдэнэс** үл итгэгчдээс нууцлагдсан бөгөөд тэрбайтугай итгэгчид хүртэл Христийг ойр дотно мэдэж байж тэдгээр **эрдэнэсийг** олж авч чадна.

Христ Өөрт нь итгэгч хүмүүсийн дотор Тэргүүн, төв, эх үүсвэр болж оршдог. Түүний

хязгааргүй их эрдэнэс, бүхнээс дээгүүр хэмжээлшгүй агуу байдлын баялаг, Бурханы хувьд Тэр хэн болох, бүтээл болон золилтын хувьд юу хийж гүйцэтгэсэн, Өөрийн мөн чанар, ёс суртахуун, албан ёсны алдараараа Тэрээр Өөрийнх нь эсрэг хүрээлэх бүх эрдэмтэн мэргэд, зохиолч, сүнс дуудагч, шүүмжлэгчийн бүхэл бүтэн армиас агуу билээ. (Сонгомол)

Энэ ишлэлд нүдэнд илт харагдахаас илүү зүйлийн талаар өгүүлж байна. Бүх мэдлэг нь Христ дотор олддог. Тэр бол үнэн юм. Тэрээр хэлэхдээ: “Би бол зам, үнэн, амь мөн” гэсэн. Үнэн зүйл бол Түүний үг болоод үйлстэй зөрчилдөхгүй. **Мэдлэг болон мэргэн ухааны** хоорондын ялгааг дараах байдлаар ихэвчлэн тайлбарладаг. **Мэдлэг** гэдэг бол үнэнийг ойлгох явдал бөгөөд харин **мэргэн ухаан** бол үнэн гэж мэдсэн зүйлээ ашиглах чадвар юм.

[2:4]

Учир нь бүх мэргэн ухаан, мэдлэг нь Христ дотор байдаг бөгөөд христитгэгчид хуурамч шашны **үнэмшилтэй үгэнд** хууртах ёсгүй юм. Хэрэв хүний дотор үнэн байхгүй бол өөрийн

үгийг ухаалаг байдлаар илэрхийлж байж хүнийг татна. Гаж үзлийнхэн үргэлж ийнхүү ажилладаг. Тэд магадгүй юмсаар нотолгоо хийх гэж оролдон түүнээс ургуулан гаргасан дүгнэлтүүд дээр сургаалын тогтолцоог бий болгодог. Нөгөө талаар, хэрэв хүн Бурханы үнэнийг номлох бол уран цэцэн үг хэрэглэх юмуу, ухаалаг мэргэн магадлал дээр төвлөрөх ямар ч шаардлагагүй. Үнэн өөрөө өөрийгөө хамгийн сайнаар нотлох бөгөөд арслан мэт өөрийгөө хамгаалах болно.

[2:5]

Энэхүү ишлэлээс элч Паул колоссайчуудад тулгараад буй асуудал, аюулын талаар ямар сайн мэдэж байсныг илэрхийлсэн. Тэрээр өөрийгөө шалгалтаа өгөхөөр бэлэн цугларсан цэргүүдээ харж байгаа цэргийн даргатай зүйрлэжээ. **Сахилга журам, бат байдал** зэрэг үгс нь цэргийн хэллэг юм. Эхний үг нь эмх цэгцтэй жагссан бүлэг цэргийг дүрсэлж байна. Харин удаах нь тэдгээр цэрэг ямар бат жигүүр болж буйг илэрхийлж байна. Паул колоссайчууд хэрхэн Бурханы үнэн үгэн дээр бат зогсож

байгааг (биеэрээ биш ч гэсэн **сүнсээрээ**) харахдаа баяртай байсан.

[2:6]

Одоо тэрээр тэднийг анх итгэлээрээ хүлээж авсан тэр л байдлаар үргэлжлүүлэн итгэлээр явахыг уриалж байна. **Тиймээс та нар Эзэн Христ Есүсийг хүлээн авсан шигээ Түүн дотор алх.** Энд **Эзэн** гэдэг үгийг тодотгосон мэт харагдаж байна. Өөрөөр хэлбэл, тэд Түүн дотор бүрэн дүүрэн байдал буюу хангамж оршдог болохыг мэдэж байв. Тэр авралын хувьд хангалттай байгаад зогсохгүй мөн тэдний христитгэлийн амьдралын хувьд бүрэн хангалттай. Паул ариун хүмүүсийг Христийг Эзэн хэмээн амьдрахыг ятгасан. Тэд хичнээн үнэмшилтэй сонсогдож байсан ч хүмүүсийн сургаалыг хүлээн авч Эзэнээс төөрөх ёсгүй юм. **Алхах** гэдэг үг нь христитгэлийн амьдралыг дүрслэхэд олонтаа хэрэглэгддэг. Энэ нь үйлдэл ба дэвшлийн талаар өгүүлж байна. Алхаж байгаа бол нэг газраа байгаад байж чадахгүйн адил христитгэлийн амьдрал эсвэл урагшаа ахиж байдаг эсвэл хойшоо ухарч байдаг.

[2:7]

Паул эхлээд хөдөө аж ахуйн үг хэрэглэсний дараа барилга байшингийн үг хэрэглэжээ. **Үндэслэгдэх** гэдэг үг нь биднийг аврагдахад юу болсоныг дүрсэлж байна. Үүнээс харахад Эзэн Есүс Христ хөрс, харин бид Түүн дотор үндэслэгдэж, Түүнээс бүхий л шим тэжээлээ авч байгаа юм шиг. Эндээс бас бидний үндэс гүн байх нь чухал гэдэг нь харагдаж байна. Тэгснээр эсэргүүцлийн салхи салхилахад бид хөдлөхгүй юм (Мт 13:5, 20, 21).

Одоо Паул **Түүн дотор байгуулагдаж** гэж барилгын зүйрлэл рүү шилжсэн. Энд Эзэн Есүсийг барилгын суурь, харин биднийг үеийн үед байх Чулуун дээр буюу **Түүн дээр байгуулагдаж** байгаа гэж хэлжээ (Лк 6:47-49). Бид нэг л удаа **үндэслэгдсэн** ба одоо харин **баригдсаар** байгаа юм.

Итгэл дотроо баталгаажсан. Баталгаажсан гэдэг үгийн утгыг үзвэл христитгэлийн амьдралын туршид тасралтгүй үргэлжлэх үйл явцыг хэлж байна. Колоссайчууд Епафраар христитгэлийн үндэс суурийг заалгажээ. Тэд христитгэлийн замаар үргэлжлүүлэн явахад

тэдгээр асар үнэ цэнэтэй үнэн тэдний зүрх сэтгэл, амь амьдралд баталгаажсан юм. Нөгөө талаас 2 Петр 1:9 ишлэлд сүнсний амьдралдаа ахиц дэвшил гаргахгүй бол эргэлзээ төрж, сайн мэдээний баяр хөөр, ерөөл алдагддаг.

Паул энэ дүрслэлийнхээ эцэст **талархлаар бялхагтун** гэж дүгнэн хэлжээ. Тэрээр христитгэгчдийг дан сургаал номлол баримталсан хүйтэн хөндий байх бус харин тэдний зүрх сэтгэл сайн мэдээний агуу үнэнийг шагширч, өөрсдийн зүгээс Эзэнд өргөх магтаал талархлаар **бялхаасай** гэж хүссэн. Христитгэлийн ерөөлийнхөө төлөө **талархах нь** буруу онол сургаалын хор хөнөөлийн эсрэг гайхалтай ерөндөг болдог.

Артур Вей 7-р ишлэлийг дараах байдлаар орчуулжээ: “Бат үндэслэгдсэн мод мэт, тогтвортой өсөх барилга мэт, чиний талаарх Бурханы оршихуйг мэдэрч, (өөрийн чинь мэдлэг боловсрол үүнд хүргэсэн тул) итгэлээр ганхалгүй, талархлаар бялхагтун” гэжээ.

[2:8]

Одоо Паул Колоссай хотын байрлаж байсан Ликусын хөндийн итгэгчдэд аюул занал учруулсан тодорхой асуудлуудыг шууд хэлэлцэхэд бэлэн болжээ. **Хэн нэгэн нь та нарыг Христийн дагуу биш, харин ертөнцийн үндсэн зарчмууд, хүний уламжлалын дагуух гүн ухаан болон хоосон мэхлэлээр олзлох вий хэмээн сэрэмжлэгтүн.** Хуурамч багш нар хүний үнэ цэнэтэй зүйлээс салгахыг хичээдэг бөгөөд оронд нь дорвитой юм өгч чаддаггүй. Философи гэдгийг үгчлэн орчуулбал “цэцэн мэргэнд дурлах” гэсэн утгатай. Энэ нь өөрөө хорон муу биш боловч хүн Эзэн Есүс Христээс ангид мэргэн ухааныг эрэлхийлбэл хорон муу болдог. Зөвхөн тэнгэрлэг илчлэлтээр мэдэгдэх зүйлийг хүн өөрийн оюун ухаан, судалгаагаар эрж олох гэсэн хүний оролдлогыг илэрхийлэхийн тулд энэ үгийг ашиглажээ (1Ко 2:14). Хүний оюун ухаан, бодол санааг Бурханаас дээгүүр өргөмжилж, Бүтээгчээс илүү бүтээлийг шүтдэг тул хорон муу юм. Өөрсдийн оюун ухаан, рационализмаар бардамнадаг өнөө үеийн чөлөөт үзэлтнүүдэд ийм байдал нийтлэг. **Хоосон мэхлэл** гэдэг нь өөрийн

дотоод хүрээллийн хүмүүст нууц үнэнүүдийг заадаг хэмээх хүмүүсийн худал хуурмаг, ашиггүй сургаал юм. Үүнд юу ч байхгүй. Гэхдээ хүний сониуч занг хөдөлгөдөг учраас олон хүнийг дагуулдаг. Мөн эдгээр хүнийг “сонгогдсон цөөхөн” гишүүд болгосноор тэдний өөрсдийгөө дөвийлгөх гэсэн дэмий хоосон үзлийг ашигладаг.

Паулын дайран шүүмжилж байгаа **гүн ухаан болон хоосон мэхлэл нь Христийн дагуу биш, харин ертөнцийн үндсэн зарчмууд, хүний уламжлалын дагуух ажээ. Хүний уламжлал** гэдэг нь Бичээсээс авсан үнэн үндэслэл байхгүй хүний зохиосон шашны сургаалыг хэлнэ. (Уламжлал гэдэг нь эхэндээ өөрсдийн тав тухад тохируулан эсвэл тодорхой нөхцөл байдалд нийцүүлэн гаргасан зуршил.) **Ертөнцийн үндсэн зарчмууд** гэдэг нь Бурханы тааллыг олохыг найдаж хийдэг еврей ёслол, ёс заншил болон захирамжууд юм.

Мосегийн Хууль нь зорилгоо биелүүлж, ирэх зүйлсийн хэв шинж болж ашиглагдсан. Энэ нь Христ уруу зүрх сэтгэлийг дагуулахад бэлтгэдэг “анхан шатны сургууль” юм. Энэ зүйл рүү буцаж

эргэх юм бол Бурханы Хүүгийн оронд хаягдсан тогтолцоог ашиглахаар хуйвалдсан хуурамч багш нарын гарт тоглоом болно. (Бичээсийн холбооны өдөр тутмын тэмдэглэл)

Паул колоссайчуудыг бүх номлол сургаалыг **Христийн** сургаалд нийцэж байгаа эсэхээр шалгаасай гэж хүссэн. Энэхүү ишлэлийг Филиппийн орчуулганд: “Хэн нэгэн нь та нарын итгэлийг оюун ухааныг дээдэлсэн үзэл эсвэл сүрхий сонсогдож байвч ямар ч утга учиргүй юмсаар хорлохоос болгоомжил. Ийм зүйл сайндаа л ертөнцийн мөн чанарын тухай хүний санаа байдаг бөгөөд Христийг үл хэрэгсдэг!”

[2:9]

Элч Паул уншигчидаа цаг үргэлж **Христ** уруу чиглүүлж байгааг харахад гайхалтай. Энд Паул Эзэн Есүс Христийн бурханлаг шинж чанарын талаарх Библийн хамгийн өргөмжит, ойлгомжтой ишлэлийн нэгийг өгчээ. **Учир нь Түүн дотор Бурханы төгс дүүрэн нь бүхлээрээ биетээр оршдог.** Христ бол Бурхан юм гэж хэлэхдээ олон нотолгоог давхардуулан илэрхийлж байгааг анхаарна уу. Юуны өмнө

Түүний бурханлаг мөн чанар байна: “Түүн дотор... **Бурхан биетээр оршдог.**” Хоёрдугаарт, танд нэг хүний хэлсэнчлэн бялхсан их бурханлаг мөн чанар байгаа: “Түүн дотор Бурханы *төгс дүүрэн нь биетээр оршдог.*” Эцэст нь бурханлаг мөн чанарын туйлын бүрэн дүүрэн байдал байна: “Түүн дотор Бурханы төгс дүүрэн нь *бүхлээрээ биетээр оршдог*”. (Энэ бол Эзэн Есүсийн бурханлаг шинж чанарыг үгүйсгэдэг Христийн шинжлэх ухаан, Ёховагийн гэрчүүд, Нэгдэл, Теософи, Христаделфианизм гэх мэт гностикийн аливаа хэлбэрт өгөх үр дүнтэй хариулт юм.)

Винсент хэлэхдээ: “Энэ ишлэл хоёр тодорхой зүйлийг өгүүлж байна: (1) Бурханы төгс дүүрэн нь Христ дотор мөнхөд оршдог...; (2) Бурханы төгс дүүрэн нь ... хүний биетэй байх үед Түүн дотор оршдог”.¹² Дээр өгүүлсэн олон гаж урсгалынхан Есүсийн дотор ямар нэг төрлийн бурханлаг байдал оршиж байсан гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Энэ ишлэлд **Бурханы төгс дүүрэн нь** Түүний дотор, хүн биеэрээ байхад нь байсан гэдгийг тодорхойлж байна. Үүнд хэлэх зүйл тодорхой байна. Эзэн Есүс Христийн бодгаль ийм бүрэн хангалттай юм бол Түүнийг

доромжилдог эсвэл үгүйсгэдэг номлолоор ханаж
яах юм бэ?

[2:10]

Элч энд ч Эзэн Есүс Христ бүрэн хангалттай, тэд **Түүн дотор** төгс байдалтай гэдгийг уншигчиддаа ойлгуулахаар хичээж байна. 10-р ишлэлд өгүүлсэн үнэнийг 9-р ишлэлд гарсан үнэний дараа хэлснээр Бурханы нигүүлслийг гайхалтай илэрхийлсэн. Христ дотор Бурханы төгс дүүрэн нь бүхлээрээ биетээр оршдог бөгөөд итгэгчид **Түүн дотор төгс болгогдсон**. Энэ нь мэдээж итгэгчдийн дотор Бурханы төгс дүүрэн нь бүхлээрээ оршдог гэсэн үг биш. Энэ үг зөвхөн Эзэн Есүс Христийн хувьд үнэн байсан бөгөөд байх болно. Гэхдээ энэ ишлэл нь итгэгч нарт Христ дотор амьдралд болон бурханлаг байдалд хэрэгтэй бүх зүйл байна гэдгийг зааж байна. Спёржин биднийг төгс болгогдсон тухай зөв тодорхойлолт гаргасан юм. Тэрээр бид (1) Еврей ёс заншлын тусламжгүйгээр төгс. (2) Философийн тусламжгүйгээр төгс. (3) Мухар сүсгийн зохиосон элдэв зүйлгүйгээр төгс. (4)

Хүнээс гардаг чадвар, сайн хичээл зүтгэлгүйгээр төгс гэжээ.

Бид дотор нь орсноор төгс болоод байгаа тэрхүү Нэгэн бол **бүх удирдлага ба эрх мэдлийн тэргүүн нь мөн**. Гностикчүүд тэнгэр элч нарын тухай сэдэвт маш их анхаардаг байв. Үүний талаар энэ бүлгийн төгсгөлд дурьдах болно. Гэтэл Христ бүх тэнгэр элч нарын тэргүүн бөгөөд бидэнд бүх зүрх сэтгэлээ зориулж, нөхөрлөн жаргах Бүтээгч нь байсаар байтал Түүний бүтээл болох тэнгэр элч нарт тийм их анхаарал хандуулах нь мунхаг юм.

[2:11]

Хөвч хөндөлт нь иудеизмын шашны түгээмэл ёслол байв. Энэ нь хутгаар эрэгтэй хүүхдийн махан биед хийдэг жижиг мэс ажилбар юм. Сүнслэг утгаараа хүний хорон муу, ялзарсан, аврагдаагүй мөн чанарыг хойш тавих буюу махан биеийг үхүүлэхийг илэрхийлдэг. Харамсалтай нь еврейчүүд ёс заншлын гаднах үйлдлийг гол болгож, сүнслэг утгыг умартсан. Бурханы тааллыг олохын тулд ёс заншлууд, сайн үйлс хийснээр үнэн хэрэгтээ тэдний махан биед

Бурханд таалагдах зүйл байгаа гэсэн санааг илэрхийлж байгаа юм. Үүн шиг худал юм байхгүй.

Бидний өмнөх энэ ишлэл махан биеийн хөвч хөндөлтийн тухай биш, харин Эзэн Есүст итгэл найдвараа тавьсан бүх хүнд тохиолддог сүнслэг **хөвч хөндөлтийн** тухай юм. Энэ нь **хүний гараар үйлдэгдээгүй хөвч хөндөх** ёслол гэж хэлснээс нь тодорхой байна. Энэ ишлэлээр юу зааж байгаа вэ гэвэл: бүх итгэгч хүн **Христийн хөвч хөндөлтөөр хөвч хөндүүлсэн** юм. **Христийн хөвч хөндөлт** нь Голготын толгойд Түүний загалмай дээрх үхлийг хэлж байгаа юм. Энд Эзэн Есүс үхэхэд, итгэгчид мөн үхсэн гэсэн санаа явж байна. Тэр нүгэлд (Ром 6:11), хуульд, өөрт (Гал 2:20) ба ертөнцөд үхсэн юм. (Энэ хөвч хөндөлт нь “хүний гараар хийгдээгүй” гэдэг нь ямар нэгэн сайшаал авах хүний үйлс үүнд оролцоогүй гэсэн үг. Хүн үүнийг хүртэх зохистой ч биш, юу ч хийгээд хүртэх хэмжээнд хүрч чадахгүй. Энэ бол Бурханы ажил юм.) Тиймээс тэрээр нүгэлт **махбодын биеийг** тайлсан. Өөрөөр хэлбэл хүн аврагдахад тэрээр Христийн үхлээр Түүнтэй холбогддог бөгөөд

махан биеийн хичээл зүтгэлээр авралыг олж авах эсвэл хүртвэл зохистой болох бүх найдвараа үгүй болгодог. Самуел Ридаут бичихдээ: “Бидний Эзэний үхэл зөвхөн үр жимсийг үгүй болгоод зогсохгүй, түүнийг ургуулсан үндсийг тэр чигт нь зэмлэж, зайлуулсан.”

[2:12]

Паул одоо хөвч хөндөлтийн сэдвээс шилжиж **баптисмын** талаар ярьж эхэлж байна. Хөвч хөндөлт махан биеийн үхлийн талаар өгүүлдэг шиг **баптисм** хуучин хүн оршуулагдсан тухай өгүүлдэг. Бид уншвал: **Ингэхдээ та нар баптисм дотор Түүнтэй хамт оршуулагдсан. Түүнийг үхэгсдээс амилуулсан Бурханы үйлсэд итгэсэн итгэлээр баптисм дотор та нар бас Түүнтэй хамт амилуулагдав.** Энд бид зөвхөн Христтэй хамт үхээд зогсохгүй бас **Түүнтэй хамт оршуулагдсан** гэж зааж байна. Үүнийг бидний баптисм бэлэгддэг. Энэ зүйл биднийг аврагдах мөчид явагдсан боловч үүнийг баптисмаар усанд орохдоо бид олны өмнө гэрчлэн илтгэдэг. Баптисм гэдэг нь оршуулгыг, Адамын хүүхдүүдийн хувьд бид хэн байсан тэр бүх зүйл

оршуулагдсан гэдгийг илэрхийлдэг. Бидний доторх юу ч Бурханд таашаагдаж чадахгүй гэдгийг бид баптисмаар хүлээн зөвшөөрдөг байнхүү бид махан биеэ Бурханы хараанаас мөнхөд холдуулдаг. Гэхдээ энэ нь зөвхөн оршуулгаар эцэс болоогүй. Бид Христтэй цуг цовдлогдож, оршуулагдаад зогсоогүй шинэ амьдралаар амьдрахын тулд Түүнтэй хамт амилуулагдсан. Энэ бүхэн биднийг аврагдах цаг мөчид явагдсан. Энэ нь Христийг **үхэгсдээс амилуулсан Бурханы үйлсэд итгэсэн итгэлээр** хийгддэг.

[2:13]

Элч Паул одоо энэ бүгдийг Колоссай хотынхонд ямар хамаатайг хэлж байна. Тэд аврагдахаасаа өмнө тэд **гэм нүглүүдээсээ болж үхсэн байсан.** Энэ нь тэд гэм нүглээсээ болж Бурханы хувьд сүнсээр үхсэн байсан гэсэн үг юм. Энэ нь тэдний сүнс үхсэн гэсэн үг биш харин зүгээр л Бурханы зүг тэдний сүнс огтхон ч хөдөлдөггүй ба Бурханы таалалд нийцэх юу ч хийх чадваргүй байсан гэсэн үг юм. Тэд зөвхөн **гэм нүглээсээ болж үхсэн байгаад** зогсохгүй

Паул бас тэднийг **махан биеийн хөвч хөндөлтгүйгээсээ болж үхсэн** гэж хэлжээ. **Хөвч хөндүүлээгүй** гэдэг үгийг ШГ-нд харь үндэстнүүдийг хэлэхдээ олонтаа хэрэглэдэг байсан. Колоссайчууд харь үндэстнүүд байлаа. Тэд дэлхий дээрх Бурханы ард түмэн буюу еврейчүүдэд хамааралгүй хүмүүс байв. Тийм учраас тэд Бурханаас хол байр суурьтай, махан биеийг хүсэл тачаалдаа бүрэн захируулж байсан. Харин тэд сайн мэдээг сонсоод Христтэй **хамт амьд болгогдсон** бөгөөд тэдний бүх гэм нүгэл **уучлагдсан**. Өөрөөр хэлбэл, колоссайчуудад юу тохиолдсон юм бэ гэвэл тэдний амьдралын хэв маяг бүхэлдээ өөрчлөгдсөн. Тэдний гэм нүгэлтэн байсан түүх дуусаж, одоо тэд Христ Есүс дотор шинэ бүтээл болцгоожээ. Тэд амилалтын талд амьдарч байв. Тиймд махан биеийн хүний хувьд тэдэнд байсан бүх шинж чанарт тэд “баяртай” гэж хэлэх ёстой.

[2:14]

Паул одоо Христийн хийсэн ажил дотор багтаж байгаа өөр нэг зүйлийн талаар тайлбарлаж байна. **Бидний эсрэг зарлигуудаас**

бүрдсэн, бидэнд дайсагнаж байсан өрийн дансыг хүчингүй болгов. Тэр үүнийг загалмайд хадаж, замаасаа зайлуулжээ. Бидний эсрэг зарлигуудаас бүрдсэн өрийн данс гэдэг нь хуулийг хэлж байгаа юм. Бид арван хуулийг төгс сахиж чадаагүй тул тэдгээр хууль бидний эсрэг байсан ба биднийг яллаж байсан. Элч Паул зөвхөн Арван хуулийн талаар биш мөн израильчуудад өгсөн ёслолын хуулийн талаар бодож байна. Ёслолын хуульд ариун өдөр, хоол болон шашны ёс заншлын тухай төрөл бүрийн тушаалууд байдаг. Тэр бүхэн еврейчүүдэд өгөгдсөн шашны хэсэг байв. Тэд бүгд Эзэн Есүсийг ирж буйг зааж байсан. Тэд Түүний мөн чанар болон хийсэн ажлынх нь сүүдэр байсан. Тэрээр загалмай дээрх үхлээр энэ бүхнийг **замаасаа зайлуулж, загалмайд хадан өрийг төлөхөд өрийн дансыг хүчингүй болгодог шиг хүчингүй болгожээ.** Мейер хэлэхдээ: “Христийн загалмайн үхлээр дамжуулан хүнийг ялладаг хууль шийтгэх эрх мэдлээ алдсан ба Христ үхэхдээ хүний өмнөөс хуулийн хараалыг тээж, хуулийн төгсгөл болсон юм.”¹³ Келли үүнийг их

аятайхан дүгнэж хэлжээ: “Хууль бол үхмэл биш, харин бид хуульд үхсэн юм гэжээ.”

Өр хүчингүй болоход зээлдүүлэгч өр авсан байсан хүнээс дахин юм шаардах эрхгүй гэдгийг мэдүүлэхийн тулд олон хөлийн газар энэ тухай зар хаддаг байсан эртний үйлдлийг бодож, Паул ийнхүү хэлсэн байх магадлал өндөр.

[2:15]

Загалмай дээр үхэж, хожим амилуулагдаж, дээш өргөгдсөнөөр Эзэн Есүс хорон муу захирагчид ба эрх баригчдыг ялж, тэднийг нийтэд үзүүлэн болгов. Үүнийг бид Ефес 4-р бүлэгт Эзэн Есүс олон хоригдлыг олзлов гэсэн хэсэгт гарч байгаа ялалттай ижил юм гэдэгт бид итгэдэг. Түүний үхэл, оршуулга, амилалт, дээш өргөгдсөн нь тамын цэргүүд ба Сатаныг ялсан агуу ялалт байсан юм. Тэрээр тэнгэрийн улс уруугаа буцах замдаа агаар мандлаар дайран гарахдаа агаарын хүчний захирагч жононгийн эзэмшил дундуур явсан.

Өмнө нь ад чөтгөрүүдийг шүтдэг байж байгаад итгэл дээр ирсэн боловч одоо ч хорон муу сүнснээс айдаг хүмүүст онцгой

тайвшрууллыг энэхүү ишлэл өгдөг байж болох юм. Бид Христ дотор байгаа бол юунаас ч айх хэрэггүй. Учир нь Тэрээр захирагчид болоод эрх баригчдыг зэвсэггүй болгосон.

[2:16]

Элч Паул сая ярьсан зүйлийг тэдэнд ямар хамаатайг тайлбарлахад одоо бэлэн болжээ. Өмнө дурдсан зүйлсийг бид дараах байдлаар дүгнэж болох байна: Колоссайчууд махан биеэрээ буюу өөрсдийн хичээл зүтгэлээр Бурханы тааллыг олох бүх оролдлогод үхсэн. Тэд зөвхөн үхээд дуусаагүй Христтэй цуг оршуулагдаж, Түүнтэй хамт шинэ төрлийн амьдрал уруу амилсан юм. Тиймд тэд колоссайчуудын үхээд байсан зүйлс рүү эргүүлж оруулах гэсэн иудей шашинтнууд болон гностикчуудтай мөнхөд хамааралгүй болсон. **Тиймд та нар унд, хоол, эсвэл баяр, шинэ сар гарахтай хамаатай асуудлаар, эсвэл амралтын өдрүүдээс болж хэнээр ч бүү шүүгд.** Хүний зохиосон бүх шашин хүмүүсийг журам, дүрэм, дэг болон шашны он тооллын хүлээсэн дор оруулдаг. Энэхүү он тоололд ихэвчлэн

жилийн давтамжтай сахих өдрүүд (ариун өдрүүд), сар бүрийн баяр ёслол (шинэ сар) юмуу долоо хоног бүрийн амралтын өдөр (шаббат өдөр) байдаг. **“Хэнээр ч бүү шүүгд”** гэдэг илэрхийлэл нь христитгэгч жишээлбэл гахайн мах идэх эсвэл шашны тэмдэглэлт баяр юмуу ариун өдрийг сахихгүй байснаараа яллагдах учиргүй юм гэсэн утгатай. Зарим хуурамч шашин, тухайлбал сүнс шүтэгчид гишүүдээ мах идэж болохгүй гэдэг. Олон зууны туршид Ромын католикчууд баасан гарагт мах идэх ёсгүй байсан. Олон сүм Лент баярын үеэр тодорхой нэр төрлийн хоол идэхийг цээрлэхийг шаарддаг байв. Бусад нь жишээлбэл мормонууд гишүүнээ цай юмуу кофе увал дүрэм зөрчсөн гэдэг. Бусад шашнууд, ялангуяа долоо дахь өдрийн адвентистүүд Бурханы таалалд нийцэхийн тулд шаббат өдрийг сахих ёстой гэж үздэг. Христитгэлт хүмүүс эдгээр дэг жаягийн дор байдаггүй. Хууль, шаббат өдөр, легализмын талаар Матай 5:18, 12:8 болон Галат 6:18-р ишлэлийн тайлбараас үз.

[2:17]

Еврейчүүдийн тэмдэглэж байсан шашны ёслолууд **ирж буй юмсын сүүдэр нь юм. Харин бие нь Христийнх юм.** Тэдгээрийг ХГ-нд урьдчилсан дүр зураг болгож тогтоосон. Жишээлбэл Шаббат өдөр нь Эзэн Есүс Христэд итгэгч бүгдийн хувь болох амралтыг бэлэгдэн өгөгдсөн зүйл байв. Одоо Эзэн Есүс нэгэнт ирсэн тул хүмүүс юунд сүүдрээр хөөцөлдсөөр байх гэж? Энэ нь зурган дээрх хүн өөрөө ирчихээд байхад зургийг нь илүү анхаарахтай адил аж.

[2:18]

Бид гностикчууд юу зааж байсныг бүрэн сайн мэдэхгүй учраас энэ ишлэлийн утгыг яг нарийн ойлгоход хэцүү. Тэд даруу болж харагдахын тулд Бурханд шууд ойртохоос эмээж байсан юм болов уу. Гностикчууд Бурхантай тэнгэр элч нараар дамжуулан харьцдаг гэж заасан тул Эзэний оронд **хуурамч даруу байдлаар тэнгэр элч нарт** мөргөдөг байсан байж болох юм. Өнөөдөр ч гэсэн дэлхий дээр үүнтэй төстэй зүйл байна. Ромын католикчууд шууд Бурханд юмуу Эзэн Есүст хандан залбирна гэж огт бодох ч үгүй

бөгөөд тэдний уриа: “Мариагаар дамжуулан Есүст”. Энэ нь тэдний **хуурамч даруу байдал** бөгөөд тэд бүтээлд мөргөж байгаа юм. Христитгэгчид бичээсийн дагуу биш эдгээр зүйлээс болж ямар ч хүнд шагналаа алдах ёсгүй юм. “Бурхан ба хүмүүсийн хооронд ганц зууч байна. Тэр нь хүн болох Христ Есүс билээ” хэмээн Үгэнд тодорхой хэлсэн (1Тм 2:5).

Элч Паул дараа нь **үзсэн үзэгдлээ баримтладаг** гэж яг ямар утгатай нь сайн мэдэгдэхгүй зүйлийг хэлжээ. Гностикчууд гүн нууцуудыг мэддэг гэж хэлж байв. Тэдгээр нууцыг мэдэхийн тулд хүн заавал тэдний эгнээнд элсэх хэрэгтэй ажээ. Эдгээр нууц нь бодвол янз бүрийн үзэгдэл байсан биз ээ. Өнөө үед мормонизм, сүнс шүтэгчид, католикчууд, шведборгианизм зэрэг гаж сургаалд үзэгдэл чухал элемент болдог. Дотоод бүлэглэлийн гишүүд нууц зүйлсийг мэддэг хэмээн бардамнадаг байв. Тийм учраас Паул: **махан биеийн ухаанаар өөрийгөө дэмий хоосон дөвийлгөдөг** гэж нэмж хэлжээ. Тэд өөрсдийгөө бусдаас илүү гэж үздэг байсан бөгөөд зөвхөн эдгээр гүн нууцуудад нэвтрэн орсноор л хүн аз

жаргалтай байж чадна гэсэн сэтгэгдлийг бусдад төрүүлж байв. Энд түр саатан өнөө үед ч гэсэн нууц холбоо байгууллагууд ийм шинжтэй гэдгийг хэлэх байна. Өөрийн Эзэнтэйгээ нөхөрлөн алхаж байгаа христитгэгчид ийм байгууллагуудад зарцуулах цаг юмуу эсвэл сэтгэл байх учиргүй.

Энэ ишлэлд анзаарвал зохистой нэг чухал зүйл бол ийм хүмүүсийн үйлдэж байсан янз бүрийн шашны үйл нь өөрсдийнх нь хүслийн дагуу байжээ. Тэдэнд Бичээсийн дагуу ямар ч эрх мэдэл байгаагүй. Тэд Христийн удирдлаган дор үйлдээгүй. Тэд өөрсдийнхөө хүссэн зүйлээ л Эзэнээс үл хамааран үйлдэж байсан боловч тэдний үйл хэрэг гаднаа даруу бөгөөд шашинлаг харагдаж байсан тул махан биеийн ухаанаар өөрийгөө дэмий хоосон дөвийлгөж байжээ.

[2:19]

Тэргүүнээс зуурдаггүй ажээ. Эзэн Есүсийг энд Биеийн Тэргүүн гэж хэлжээ. “Тэргүүнээс зуурах” гэдэг нь Христийг Тэргүүн гэдгийг ойлгож амьдрахыг хэлж байгаа бөгөөд бүх хэрэгцээгээ Түүний шавхагдашгүй баялгаар

хангуулж, бүхнийг Түүний алдрын төлөө хийхийг хэлнэ. Энэ нь алдаршсан Эзэнээс хангамж ба чиглүүлгийг авахын тулд Түүнд хандаж, Түүнтэй харилцаатай байхыг хэлнэ. Үүнийг дараа нь гарах ишлэлд ингэж талбарлажээ: **Тэд бүхэл биеийг үе мөч болон шөрмөсөөр хамтад нь холбон хангаж, Бурханы өсөлтөөр өсгөдөг Тэргүүнээс зуурдаггүй ажээ.** Хүний биеийн янз бүрийн эрхтнүүд **үе мөч ба шөрмөсөөр холбогддог.** Бие нь өөрөө толгой буюу тэргүүнтэй холбогддог. Бие нь толгойноос удирдлага, чиглүүлэлтийг авдаг. Элч Паул яг энэ санааг тодотгосон байна. Дэлхий дээрх Христийн Биеийн эрхтнүүд Түүн дотор сэтгэл хангалуун байдал болон бүрэн дүүрэн хангамжийг олох хэрэгтэй бөгөөд эдгээр хуурамч багш нарын үнэмшилтэй ятгалганд автан төөрч болохгүй.

Тэргүүнээс зуурах гэдэг нь хором бүрд Эзэнээс хамааралтай байх шаардлагатай гэдгийг тодотгон хэлж байна. Өчигдөр авсан тусламж өнөөдөр хангалттай биш. Бид даланг хальсан усаар тариа цайруулж чадахгүй. Христитгэгч Тэргүүнээс зуурснаар даруй үйлдэл гаргах

бөгөөд тэр нь бусад эрхтэнтэй уялдаа холбоотой байдгийг нэмж хэлэх нь зүйтэй.

[2:20]

Энэ ишлэлд гарч байгаа **дэлхийн үндсэн зарчмууд** гэж ёс, дэг журмыг хэлж байна. Жишээлбэл ХГ-ний ёс заншил нь шашны анхан шатны **зарчмуудыг** буюу цагаан толгойг заадаг байсан тул дэлхийн үндсэн зарчмууд байсан юм (Гал 4:9-11). Паул мөн гностикчууд болон бусад шашинтай холбоотой ёс, дэг журмын талаар бодсон байж болох юм. Элч Бурханы өмнө байр сууриа хэдийнээ алдсан иудеизмаас салбарласан асетисизм эсвэл Бурхантай хэзээ ч холбоотой байгаагүй гностик үзэл буюу бусад гаж сургаалын талаар тухайлан бодож байсан байж болох юм. Колоссайчууд **Христтэй хамт үхсэн юм бол** юунд өөрсдийгөө тэдгээр **зарлиг тогтоолд захируулахыг** хүсээд байгаа юм бэ гэж элч Паул асууж байна. Хэрэв тэгвэл дэлхийтэй холбож байсан уяа хүлээс тасарсан гэдгээ мартсан болж таарна. Зарим хүн ингэж асууж болох юм: “Хэрэв христитгэлт хүн үндсэн зарчмуудад үхсэн юм бол яагаад баптисм хүртэх,

Эзэний зоог барих ёслолыг сахисаар байдаг вэ?”
Үүнд өгөх хамгийн тодорхой хариулт бол ШГ-нд христитгэлт чуулган эдгээр ёслолыг сахих ёстой гэж заасан юм. Гэвч тэдгээр нь биднийг тэнгэрийн улсад илүү тохиромжтой болгодог, Бурханы тааллыг хүртэхэд тусалдаг “нигүүлслийн хэрэгсэл” биш юм. Харин тэдгээр нь Бурханы өмнө дуулгавартай байгаа энгийн үйлдэл бөгөөд Христтэй нэгдсэнийг болон Түүний үхлийг санан дурсаж буйг тус тус илтгэдэг. Тэдгээр нь сахих хууль гэхээсээ илүү тааламжтай онцгой эрх юм.

[2:21]

Паул 20-р ишлэлд “Юунд ертөнцөд амьдарч байгаа юм шиг өөрсдийгөө (ишлэл 21) **“Барьж ч, амсаж ч, гар хүрч ч болохгүй”** гэх зарлиг тогтоолд захируулдаг юм бэ гэжээ”. Хачирхалтай нь зарим хүн Паул колоссайчуудад хүрч, амсаж, гар хүрч ч болохгүй гэж *тушааж байна* хэмээн заадаг! Энэ нь мэдээж ишлэлийн яг эсрэг утга билээ.

Ишлэлд гарч байгаа хориглосон зүйлийн дэс дараалал нь асетисизм улам гүнзгийрч байгааг илэрхийлнэ.

[2:22]

Дээрх утгыг 22-р ишлэлд үргэлжлүүлэн тайлбарласан байна. Эдгээр нь **хүний сургаал ба тушаалууд** гэж хэлсэнчлэн хүний бий болгосон хорио цээр юм. Амьд орших Христийг анхаарахаас илүү мах болон уух юмаар хөөцөлдөх нь үнэн шашны мөн чанар мөн үү? Веймаут 20-22-р ишлэлийг дараах байдлаар орчуулжээ:

Хэрэв та Христтэй хамт үхэж дэлхийн үндсэн ойлголтоос салсан юм бол юунд амьдрал чинь дэлхийд хамааралтай юм шиг “Энийг ч барьж болохгүй”, “Тэрийг ч амсаж болохгүй”; “Өөр бусад зүйлд хүрч болохгүй” хэмээн бүгд эдэлж хэрэглээд устаж үгүй болох зүйлсийн талаар хүний тушаал, сургаалд өөрсдийгөө захируулдаг юм бэ?

[2:23]

Хүний шашины эдгээр заншил нь бүгд **өөрсдийн бий болгосон шашин болоод хуурамч даруу байдал, мөн биеийг зовоох байдлаар мэргэн ухаан мэт үзэгддэг** гэжээ. **Өөрсдийн бий болгосон шашин** гэдэг нь уг хүмүүс Бурханы үгийн дагуу биш харин өөрсдийнхөө зөв гэж үзсэн бодол санааныхаа дагуу мөргөх, сүсэглэх хэлбэрийг дагадаг гэсэн үг. Тэд сүжигтэй харагдаж болох ч энэ нь жинхэнэ христитгэл биш юм. **Хуурамч даруу байдлыг** өмнө нь тайлбарласан. Тэд Бурханд шууд хандахад дэндүү даруу мэт дүр эсгэн тэнгэр элч нараар зуучлуулна гэдэг. **Биеийг зовоох** гэдэг нь асетисизмыг хэлж байна. Уг зүйл нь өөрийгөө үгүйсгэж, биеэ зовоосноор хүн илүү ариун байдалд хүрч чадна гэсэн итгэл үнэмшил юм. Ийм зүйлс Хинди шашин болон дорно дахины бусад далд хүчийг шүтдэг шашинд байдаг.

Энэ бүх үйлдлийн ашиг нь юу вэ? Уг ишлэлийн төгсгөлд үүнийг их сайхан гаргажээ: үүнд **махан биеийн хүслийг эсэргүүцэхэд ямар ч тус байхгүй юм.** Энэ бүгд гаднаа сайхан

харагдавч **махан биеийн хүслийг эсэргүүцэхэд** яаж ч чадаггүй ажээ. (Тэрбайтугай сайн зорилтын төлөө амлалт өгөх нь ч зорилгод хүргэж чаддаггүй.) Бүх хуурамч тогтолцоо нь хүнийг огт сайжруулахгүй. Махан биеэр Бурханы таалалд нийцэх боломжтой мэт сэтгэгдэл төрүүлдэг боловч махан биеийн хүсэл тачаалыг хориглон барьж чаддаггүй аж. Христитгэгчийн хандлага бол бид бүхий л хүсэл тачаалынх нь хамт махан биедээ үхсэн бөгөөд одоо бид Бурханы алдрын төлөө амьдардаг. Бид үүнийг шийтгэгдэхээс айхдаа бус харин бидний төлөө Өөрийгөө өгсөн Нэгэнийг хайрлах хайраар хийдэг. А.Т.Робертсон үүнийг сайхан хэлсэн байдаг: “Хайрын улмаас бид жинхэнэ эрх чөлөөтэйгээр зөвийг үйлддэг. Хайр сонголтыг хялбар болгодог. Хайр бол алба үүргийн нүүр царайг үзэсгэлэнтэй болгодог. Хайр Христийг дагахад тааламжтай болгодог. Хайр сайн үйлчлэлийг эрх чөлөө болгодог.”

II. БҮХНЭЭС ДЭЭД ХРИСТИЙН ӨМНӨ ХРИСТИТГЭГЧДИЙН ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ (бүлэг 3, 4)

1. Христитгэгчдийн шинэ амьдрал: хуучин хүнээ тайлж, шинэ хүнийг өмсөх нь (3:1-17) [3:1]

Тиймээс хэрэв та нар Христтэй хамт амилуулагдсан л юм бол дээгүүрх зүйлсийг эрсээр бай. Тэнд Христ Бурханы баруун талд заларч байгаа. Энэхүү ишлэлд “хэрэв” гэж хэлсэн нь элч Паулын санаанд ямар нэгэн эргэлзээ байсан гэсэн үг биш юм. Энэ нь “хэрэв” та нар тийм юм бол гэсэн ятгалгыг хэлж байгаа бөгөөд *нэгэнт* гэж орчуулж болно: “Тиймээс нэгэнт та нар Христтэй хамт амилуулагдсан юм бол...”

2-р бүлэгт дурьдсанчлан итгэгч хүн Христтэй хамт үхэж, Түүнтэй хамт оршуулагдан Түүнтэй хамт үхлээс амилсан гэж тооцогддог. Энэ бүхний сүнслэг утга нь бид хуучин амьдралынхаа хэв маягт баяртай гэж хэлэн цоо шинэ төрлийн буюу амилсан Эзэн Есүс Христийн амьдрал уруу орсон билээ. Учир нь бид **Христтэй цуг**

амилсан тул дээгүүрх зүйлсийг эрсээр байх ёстой. Бид одоо дэлхий дээр байгаа ч гэсэн тэнгэрийн арга замыг хөгжүүлж байх ёстой.

[3:2]

Христитгэгч хүн газар дээрх зүйл дээр төвлөрөх ёсгүй. Хүн аливаа зүйлийг нүдэнд харагдах байдлаар бус харин Бурханд болон өнө мөнхөд хэр чухал болох талаас бодох хэрэгтэй. Винсент 1-р ишлэлийн “эрэх” гэдэг үгийг амьдрал дээр хичээж зүтгэх, 2-р ишлэлийн **оюун ухаанаа төвлөрүүл** гэдгийг дотоод тэмүүлэл болон хандлага гэж тайлбарлажээ. **Оюун ухаанаа төвлөрүүл** гэдэг нь Филиппой 3:19-р ишлэлд “тэд дэлхийн юмыг л сэтгэж боддог” гэдэгт гардаг үгтэй ижил байна. А.Т.Робертсон: “Баптисм хүртсэн амьдрал гэдэг нь христитгэгч тэнгэрийн улсыг эрж, тэнгэрийн тухай бодож байгааг хэлнэ гэжээ. Бие нь газар дээр байгаа ч оюун бодол, зүрх сэтгэл нь оддын дунд байхыг хэлнэ. Тэрээр газар дээр тэнгэрийн улсын иргэний хувиар амьдардаг.”¹⁴

Дэлхийн II дайны үед нэг христитгэгч залуу төлөвшсөн Христийн үйлчлэгч хүнд урам

зоригтойгоор “Өчигдөр шөнө манай бөмбөгдөгч онгоцнууд дайсны хотуудын дээгүүр дахиад ниссэн гэнээ” гэж мэдээллэжээ. Үүний хариуд олон жил итгэсэн христитгэгч “Би Бурханы чуулганд бөмбөгдөгч нар байсныг мэдсэнгүй гэжээ.” Тэрээр эмэгтэйчүүд, хүүхдүүд үхэж байгаад баярлаагүй харин аливаа зүйлийг тэнгэрлэг өнцгөөс харж байсан юм.

Ф.Б Хөүл бидний байр суурийг тодорхой тайлбарласан юм:

Бид Христийн үхэлтэй холбогдсон юм бол Түүний дахин амилалттай ч холбогдсон. Эхний зүйлийн ачаар бид дэлхий ертөнц, хүний зохиосон шашин, хүний мэргэн ухаанаас салсан. Харин хоёр дахь зүйлийн ачаар бид Бурханы ертөнц болон тэнд байгаа бүх юмстай залгагдсан. 3-р бүлгийн эхний дөрвөн ишлэлд бидэнд өгөгдсөн ерөөлийг дэлгэн харуулсан.¹⁵

[3:3]

Паул итгэгчид **үхсэн** гэж хэлэхдээ байр суурийг хэлсэн бөгөөд үйл хэргийг хэлээгүй. Учир нь бид Христийн үхэлтэй холбогдсоноор

Бурхан биднийг өөрсдийгөө Түүнтэй хамт **үхсэнд** тооцоосой гэж хүсдэг. Бидний зүрх сэтгэл энэ үнэнд эргэлзэхэд үргэлж бэлэн байдаг. Учир нь бид гэм нүгэл болон сорилтод амьд байгаагаа мэдэрдэг. Харин гайхалтай зүйл гэвэл бид итгэлээр өөрсдийгөө Христтэй хамт үхсэнд тооцсоноор энэ нь бидний амьдралд ёс суртахууны бодит байдал болдог. Хэрэв бид нүгэлд үхсэн мэт амьдарвал бидний амьдрал улам бүр Эзэн Есүс Христийн амьдарсан хэв маягт нийцэх болно. Мэдээж бид энэ амьдралдаа хэзээ ч төгс байдалд хүрч чадахгүй ч энэхүү үйл явц итгэгч бүрийн амьдралд явагдаж байх ёстой.

Бид зөвхөн **үхээд** зогсохгүй мөн бидний **амь Христтэй хамт Бурхан дотор нууцлагдсан**. Бидний амьдарч буй гариг дээр дэлхийлэг хүний санаа тавьдаг, сонирхлыг нь татдаг зүйлс байдаг. Харин итгэгч хүний хамгийн их санаа тавьдаг зүйлс бол бидний Эзэн Есүс Христ дотор бүгд агуулагдаж байдаг. Түүний хувь тавилан бидний хувь тавилантай салшгүй холбоотой юм. Паулын хэлж байгаа зүйл бол нэгэнтээ **бидний амьдрал Христтэй хамт Бурхан дотор нууцлагдсан** юм бол бид энэ дэлхийн жижиг сажиг зүйлээр, тэр

тусмаа эргэн тойронд байгаа шашны ертөнцөөр хөөцөлдөх хэрэггүй.

Бидний амьдрал Христтэй хамт Бурхан дотор нууцлагдсан гэсэн үгтэй холбоотой өөр нэг санаа бас байна. Дэлхий ертөнц бидний сүнсний амийг хардаггүй. Хүмүүс биднийг ойлгодоггүй. Тэд биднийг өөрсөд шиг нь амьдраагүйд гайхдаг. Тэд бидний бодол, хандлага, арга замыг ойлгодоггүй. Ариун Сүнсний талаар ертөнц “Түүнийг хардаг ч үгүй, мэддэг ч үгүй” гэсэн шиг бидний сүнсний амь **Христтэй хамт Бурхан дотор нууцлагдсан юм.** 1 Иохан 3:1-д хэлэхдээ: “Иймээс ертөнц Түүнийг мэдээгүй тул биднийг мэддэггүй.” Дэлхийн худал хуурмагаас үнэхээр салах үед дэлхий итгэгч хүнийг ойлгодоггүй, харин буруугаар ойлгодог.

[3:4]

Итгэгч хүн Христ дотор ямар хувьтай гэдгийг дүрсэлж байгаа илэрхийллийнхээ оргил хэсэгт элч Христийн дахин ирэлтийн тухай ярьж байна. **Бидний амь болох Христ илчлэгдэх үед та нар ч бас яруу алдар дотор Түүний хамт илчлэгдэх**

болно. Яг одоо бол бид Түүнтэй хамт амилж, хүмүүст харагддаггүй, ойлгогдоггүй амийг эдэлж байна. Гэхдээ Эзэн Есүс Өөрийн ариун хүмүүсээ авахаар дахин ирэх өдөр айсуй. Тэгэхэд бид **яруу алдар дотор Түүний хамт илчлэгдэх болно.** Тэр үед хүмүүс биднийг ойлгож, бид яагаад тийнхүү үйлдэж байсныг ухаарах болно.

[3:5]

3-р ишлэлд биднийг үхсэн гэж хэлсэн. Энд биднийг **газар дээрх эрхтнүүдээ үхүүл** гэжээ. Эдгээр хоёр ишлэлд итгэгч хүний байр суурь, байдал хоорондын ялгааг маш тодорхой хэлжээ. Түүний байр суурь гэвэл тэр үхсэн. Түүний байр байдал нь **газар дээрх эрхтнүүдээ үхүүлснээр** өөрийгөө гэм нүгэлд **үхсэнд** тооцохыг хэлнэ. Бидний байр суурь гэдэг нь Христ дотор бид хэн бэ гэдгийг хэлнэ. Бидний байдал гэдэг нь бид өөрсдийн дотор юу билээ гэдгийг хэлж байна. Бидний байр суурь бол Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр дамжин ирдэг Бурханы үнэгүй бэлэг юм. Бидний байдал Бурханы нигүүлсэлд хандах бидний хариу юм.

Энд бид хууль болон нигүүлслийн хоорондох ялгааг бас анзаарах хэрэгтэй. Бурхан “Хэрэв чи гэм нүглээс чөлөөтэй амьдарвал Би чамд Христтэй хамт үхсэн гэсэн байр суурь өгнө” гэж хэлээгүй. Тэгвэл тэр нь хууль болно. Бидний байр суурь ч өөрсдийн маань хүчин чармайлтаас шалтгаалах болно, тэгээд ч хэн ч тэрхүү байр суурийг олж авахгүй гэдгийг хэлэх юун. Үүний оронд Бурхан “Эзэн Есүст итгэсэн бүхэнд Миний мэлмийд таалал олсон гэсэн байр суурийг үнэгүй чөлөөтэй өгнө. За, ингээд явж энэ эрхэм дуудлагад нийцсэн амьдралаар амьдар” гэсэн. Энэ бол нигүүлсэл билээ!

Элч биднийг **газар дээрх эрхтнүүдээ үхүүлэх** хэрэгтэй гэж хэлсэн нь шууд биеийнхээ эрхтнийг устгах тухай огт хэлээгүй! Энэхүү илэрхийллийг зүйрлэж хэлсэн бөгөөд дараагийнх нь хэсэгт тайлбарласан байна. **Эрхтнүүд** гэдэг үг нь хүний гаргаж байгаа хүсэл тачаал, үзэн ядалтын олон янз хэлбэрийг хэлж байгаа.

Садар самуун гэдэг нь ихэвчлэн хууль ёсны бус, ялангуяа ганц бие хүмүүсийн хоорондын бэлгийн харьцаа ба ёс бус байдал үйлдэж байгааг хэлэхэд хэрэглэдэг (Мт 15:19; Мк 7:21).

Заримдаа энэ нь илүү өргөн хүрээг хамран бэлгийн ёс суртахуунгүй байдал гэж орчуулагддаг. **Бузар байдал** гэдэг нь цэвэр бус бодол, үг, юмуу үйлдлийг хэлдэг. Энэ нь бие махбодийн хир буртаг бус ёс суртахууны бохир заваан байдлыг хэлж байна. **Тачаал** гэдэг нь хүчтэй, захиргаагүй хүслийг хэлж байна. **Муу хүсэл** гэж маш хүчтэй, ихэвчлэн хүчирхийллийг агуулсан хүслийг хэлдэг. **Шунахайрал** гэдэг үгийн ерөнхий утга нь ховдог шунахай ба илүү ихийг хүсэхийг хэлэх бөгөөд энд бэлгийн дур хүслийг хангахыг хүссэн ариун бус хүсэл эсвэл шүтээн шүтэх явдлыг хэлж байж болно.

Жагсааж хэлсэн үгс нь үйлдлээс эхлэж, хандлага, сэдэл рүү шилжсэн байна. Бэлгийн гэм нүглийн олон янз хэлбэрийг тодорхойлж хэлээд тэдгээрийн үүр буюу хүний зүрх рүү мөшгөн хүрчээ. Бурханы үгэнд бэлгийн харьцаанд угийн бузар зүйл байдаггүй гэдгийг тодорхой хэлсэн. Бурхан хүнийг нөхөн үржих чадвартайгаар бүтээсэн. Гэвч Бурханы маш нигүүлсэнгүйгээр бүтээлдээ даалган өгсөн зүйлийг хорон муу, байж болохгүй зорилгын төлөө ашиглах юм бол тэр нь гэм нүгэл болдог. Паулын үед харь

үндэстний дунд бэлгийн гэм нүгэл хамгийн түгээмэл нүгэл байсан бөгөөд одоо ч эхний байранд явж байгаад эргэлзэх аргагүй байна. Итгэгч хүмүүс Ариун Сүнсэнд захирагдахгүйгээс болж амьдралд нь бэлгийн гэм нүгэл орж ирж тэднийг сүйрэлд хүргэдэг.

[3:6]

Хүн эдгээр аймшигтай гэм нүглийг үйлдсэн хэрнээ шийтгэлээс мултарч чадна гэж боддог. Тэнгэрүүд нам гүм юм шиг санагддаг тул хүн илүү зориг ордог. Гэвч Бурхан элэг доог болохгүй. **Эдгээрээс болж Бурханы уур хилэн [дуулгаваргүй хөвгүүд дээр] ирэх болно.** Тэдний гэм нүглийн үр дагавар энэ амьдралд ч ирдэг бөгөөд хүн бэлгийн ёс суртахуунгүй байдлаас болж махан биедээ үр дагаврыг нь хүртдэг. Үүний дээр тэд ирээдүйн шүүлтийн өдөр аймшигтай ургацаа хураах болно.

[3:7]

Паул Колоссай хотынхонд аврагдахаасаа өмнө эдгээр гэм нүглийг өөгшүүлэн амьдарч байсныг сануулж байна. Гэвч Бурханы нигүүлсэл ирснээр

тэднийг бүх цэвэр бус байдлаас аварчээ. Тэдний амьдралд гэм нүглийн бүлэг байсан боловч тэдгээр хуудсыг одоо Христийн цус бүтээжээ. Тэд одоо Бурханы төлөө амьдрах хүчийг өгөх шинэ амьтай болсон. “Хэрэв бид Сүнс дотор амьд байгаа юм бол, мөн Сүнс дотор явцгаая” Галат 5:25.

[3:8]

Нэгэнт тэд ийм хэмжээлшгүй үнээр золигдсноос хойш эдгээрийг бохир хувцсаа тайлах мэт **зайлуулж хаях** хэрэгтэй. Элч 5-р ишлэлд жагсаасан ариун бус хүсэл тачаалын янз бүрийн хэлбэрийг дурдаад зогсохгүй хорон муу үзэн ядалтын хэлбэрүүдийг ч энд тоочжээ.

Уур бол дургүйцсэн эсвэл дайсагнасан хүчтэй мэдрэмж, өшөө авах хандлага, үзэн ядалт тогтсон мэдрэмж юм. **Хилэн** гэдэг нь уурын илүү хүчтэй хэлбэр бөгөөд ихэвчлэн цочмог дүрсхийсэн хүчирхийллээр илэрч гардаг. **Хорон санаа** гэдэг нь бусдыг бие болон нэр хүндийн хувьд хохироох гэсэн хорон муу үйлдэл юм. Энэ нь бусдын зовлонд баясдаг ямар ч шалтгаангүй дургүйцэл юм. **Гүтгэлэг** гэдэг нь хүчтэй үг

ашиглан, биеэ захирахгүйгээр бусдын эсрэг муулан ярихыг хэлж байна. Энэ нь хатуу ширүүнээр зүхэж, гутаан доромжлохыг хэлж байгаа юм. **Амнаас гарах жигшүүрт үгс** гэдэг нь ичгэвэртэр яриаг хэлэх бөгөөд завхай, ёс журамгүй, ялзарсан гэсэн утгыг илтгэнэ. Энэ нь гутамшигтай бөгөөд цэвэр бус үг яриа юм. Гэм нүглийн энэ жагсаалтад элч сэдэл, хандлагаас эхлээд үйлдэл рүү оржээ. Хорсол нь хүний зүрхэнд бий болж энд дурдсан олон хэлбэрээр илэрдэг.

[3:9]

Элч 9-р ишлэлд нэг ёсондоо “та нарын байр байдал байр суурьтай чинь дүйцэх ёстой” гэж хэлж байна. **Хуучин хүнээ тайлсан**; одоо худал ярихаас татгалзсанаар амьдрал дээр бодитойгоор тайл. Худал ярих нь **хуучин хүнд** харьяалагддаг зүйл бөгөөд Бурханы хүүхдийн амьдралд байх ёсгүй зүйл. Бидний амьдралд өдөр бүр үнэнийг гуйвуулах сорилт тулгардаг. Энэ нь татварын албаны орлогын мэдүүлэг дээр мэдээллийг бичихгүй нуун дарагдуулах юмуу шалгалтан дээрээ хуулах эсвэл болсон явдлыг хэтрүүлж

ярих зэрэг байж болох юм. Худал мэдүүлэг эсвэл буруу сэтгэгдэл төрүүлснээр бусдад хохирол учруулах юм бол худал хэлэх нь хоёр дахин ноцтой болдог.

[3:10]

Бид зөвхөн хуучин хүнээ тайлаад зогсохгүй шинэ хүнийг өмссөн. Энэ нь өөрийг нь бүтээсэн Түүний дүр төрхийн дагуу үнэн мэдлэгт шинэчлэгдсэн хүн юм. Хуучин хүн нь аврагдаагүй мөн чанартай Адамын хүүхдийн хувьд бид хэн бэ гэдгийг бүхэлд нь илэрхийлдэг бол шинэ хүн нь Бурханы хүүхдүүдийн хувьд бид ямар шинэ байр суурьтай болсныг илтгэдэг. Шинэ бүтээл бий болсон бөгөөд тэрхүү шинэ бүтээл нь бид юм. Энэхүү шинэ хүн улам бүр Эзэн Есүс Христтэй адил болон өсөх нь Бурханы зорилго билээ. Бид хэзээ ч одоогийн хүрсэн түвшиндээ сэтгэл ханаж болохгүй харин Аврагчтай улам адил болох зорилгод хүрэхийн тулд тасралтгүй хичээх ёстой. Тэрээр бидний үлгэр жишээ бөгөөд амьдралын маань удирдлага юм. Ирэх өдөрт бид Христийн шүүхийн суудлын өмнө зогсохдоо бид бусдаас хэрхэн илүү сайн

амьдарсан гэдгээрээ бус харин бидний амьдрал
Эзэн Есүсийн амьдралтай харьцуулахад ямар
байсан бэ гэдгээр шүүгдэх болно.

Бурханы дүр төрх бидний бие махбодийн
биет хэлбэрээр үзэгддэггүй боловч
шинэчлэгдсэн бодол санаа, зүрх сэтгэлийн
гоо үзэсгэлэнгээр үзэгддэг. Ариун байдал,
хайр, даруу байдал, дөлгөөн зан, энэрэл
болон уучлал зэрэг нь тэнгэрлэг зан чанарыг
бүрдүүлдэг юм. (Бичээсийн холбооны өдөр
бүрийн тэмдэглэл)

[3:11]

Элчийн ярьж буй шинэ бүтээлд **Грек ба
Иудей, хөвч хөндүүлсэн ба хөвч хөндүүлээгүй,
зэрлэгүүд, skutчууд, боол ба чөлөөт хүн гэж
байхгүй. Харин Христ бол бүгд бөгөөд
бүгдийн дотор байна.** Үндэстэн, шашин, соёл,
нийгмийн анги давхаргын ялгаатай байдал нь
чухал юм ерөөсөө ч биш. Бурханы өмнөх байр
суурийн хувьд итгэгч бүр ижил түвшинд байдаг
бөгөөд орон нутгийн чуулганы нөхөрлөлд ийм
хандлагатай байх ёстой.

Энэ нь чуулган дотор ямар ч ялгаа байхгүй байна гэсэн үг биш юм. Зарим нь сайн мэдээ тараах бэлэг авьяастай байхад, зарим нь хоньчлох, зарим нь заах, багшлах бэлэг авьяастай байдаг. Чуулганд зарим нь ахлагч, зарим нь үйлчлэгч болдог. Тиймээс энэ ишлэл зүй ёсны ялгааг шүүмжлээгүй.

Энэхүү ишлэлийг аваад дэлхийд дээр дурдсан ялгаа зааг байхгүй болсон мэт заах хэрэггүй. Тийм биш. Энд **Грек, Еврей** хүмүүс байсаар байгаа бөгөөд энд гарч байгаа **Грек** нь харь үндэстнүүдийг ерөнхийд нь хэлж байна. **Хөвч хөндүүлсэн** болон **хөвч хөндүүлээгүй** хүмүүс байгаа. Энэ хоёр үг ШГ-нд еврей болон харь үндэстнүүдийг тус тус илэрхийлдэг. Гэхдээ энд еврейчүүдийн үйлддэг, харин харь үндэстнүүдийн үл ойшоодог тэрхүү хөвч хөндөх ёслолыг хэлж байж болох юм.

Мөн энд **зэрлэгүүд** (иргэншээгүй хүн) болон **скутчууд** байна. Энэ хоёр бүлгийг хооронд нь эсрэгцүүлсэн байдалтай хэлээгүй. **Скутчууд** зэрлэгүүд байсан бөгөөд зэрлэг дотроо хэрээс хэтэрсэн хамгийн ширүүн балмад нь байжээ. Сүүлийн эсрэгцүүлэл нь **боол** ба **чөлөөт хүн**

байна. Чөлөөт хүн гэдэг нь хэзээ ч хүлээсэнд байгаагүй төрөхөөсөө л чөлөөтэй хүнийг хэлж байна. Христигэгчдийн хувьд эдгээр дэлхийн ялгаа зааг цаашид чухал ач холбогдолтой байхаа больдог. Христ л үнэхээр чухал болдог. Тэрээр итгэгчдийн хувьд бүгд бөгөөд бүгдийн дотор байна. Тэрээр христигэлт амьдралын төв бөгөөд хил хязгаар нь юм.

Бишоп Раил энэхүү үнэнийг зоригтойгоор ийнхүү хэлжээ:

Христ бол бүгд гэдэг гурван үг христигэлийн цөм ба үндсэн утга чанар юм. Хэрэв бидний зүрх үүнийг үнэхээр хүлээн зөвшөөрч байвал бидний зүрх сэтгэл гайгүй байгаа юм байна... Маш олон хүн Христийг өөрсдийн шашныхаа хүрээнд тодорхой байр суурийг өгдөг боловч Бурханы Түүнд зориулсан, Түүгээр дүүргэхийг хүссэн байр суурийг өгдөггүй. Тэдний сэтгэлд Христ ганцаараа “бүх юм” биш. Үгүй! Энэ нь Христ дээр нэмэх нь чуулган эсвэл Христ дээр нэмэх нь ёслолууд эсвэл Христ дээр нэмэх нь Түүний томилсон үйлчлэгчид эсвэл Христ дээр нэмэх нь тэдний гэмшил эсвэл

Христ дээр нэмэх нь тэдний сайн үйлс эсвэл
Христ дээр нэмэх нь тэдний залбирал юмуу
Христ дээр нэмэх нь тэдний чин сэтгэл
болон хайр тусламж зэрэг зүйлээр тэд
сэтгэлээ амраадаг.¹⁶

[3:12]

10-р ишлэлд Паул биднийг шинэ хүнийг өмссөн гэж хэлсэн. Одоо тэрээр үүнийг бидний өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэгжих арга замыг хэлж өгч байна. Юуны өмнө тэр колоссайчуудыг **Бурханаар сонгогдсон** гэжээ. Энэ нь дэлхийн сууриас өмнө Христ дотор тэд Бурханаар сонгогдсон гэсэн үг юм. Бурханы сонголт хийдэг нигүүлсэл бол тэнгэрлэг илчлэлтийн нууцуудын нэг юм. Бурхан Өөрийн хэмжээлшгүй эрх мэдлээр хүмүүсийг Христийнх болгон сонгон авдаг болохыг Бичээст тодорхой заадаг гэдэгт бид итгэдэг. Бурхан хэнийг ч тамд унагахаар сонгосон гэдэгт бид итгэдэггүй. Ийм сургаал Бичээсийн яг эсрэг байгаа юм. Бид Бурханы сонгосон нигүүлсэлд итгэдэг шиг бид мөн хүний үүрэг хариуцлагад итгэдэг. Бурхан хүнийг хүсээгүй байхад авардаггүй юм. Үүнийг

Библид мөн “Бурханы урьдчилан мэдсэний дагуу сонгогдсон” мөн “Эзэний нэрийг дуудсан хэн боловч аврагдана” гэж хэлсэн.

Дараа нь Паул колоссайчуудыг **ариун хийгээд хайрлагдсан** гэж хэлсэн. **Ариун** гэдэг нь ариусгагдсан буюу дэлхийгээс салан Бурханд тусгаарлагдсан гэсэн үг. Бид байр суурийн хувьд ариун бөгөөд амьдрал дээрээ ч ариун байх ёстой. Бид Бурханы хайрыг хүлээн авсан тул тэр нь бидэнд бүх арга замаар Түүнийг баярлуулах хүслийг төрүүлдэг.

Одоо Паул бид яг хувцас шиг **өмсөх** ёстой христитгэлт нигүүлслүүдийг дүрслэн хэлжээ. **Өрөвч зүрх** гэдэг нь энэрэн хайрлах сэтгэлийг хэлж байна. **Энэрэл** гэдэг нь бусдын төлөөх хувиа хичээдэггүй сэтгэлийг хэлнэ. Энэ нь хайрын хандлага, сайн санаа өвөрлөсөн байдаг. **Даруу байдал** гэдэг нь дорд орох хийгээд даруу болоход бэлэн байж бусдыг өөрөөсөө илүү гэж үзэх явдал юм. **Дөлгөөн зан** гэдэг нь сул дорой байхыг хэлж байгаа бус харин өөрийгөө үгүйсгэж бүх хүнд нигүүлсэнгүй хандах хүчийг хэлнэ. Ваин хэлэхдээ:

Дөлгөөн зантай хүнийг чадалгүй, сул дорой гэж андуурах нь нийтлэг байдаг. Харин Эзэн Бурханы хэмжээлшгүй их нөөц баялаг тушаал дор нь байсан болохоор “дөлгөөн даруу” байсан. Эсрэг утгаар нь тайлбарлавал дөлгөөн зан гэдэг өөрийгөө илэрхийлэх гэсэн хүсэлгүй, хувийн ашиг сонирхол хайдаггүй занг хэлэх ба өөр дээрээ огт төвлөрдөггүй учраас сагсуурдаг ч үгүй, сэтгэлээр ч унадаггүй занг хэлдэг.¹⁷

Хэрэв **даруу байдал** гэдэг нь “бардам зангүй” байхыг хэлдэг бол **дөлгөөн зан** гэдэг нь “уур хилэнгүй” байхыг хэлж байна. **Тэвчээр** гэдэг нь өдөөн хатгахад тэвчээртэй байхыг хэлэх ба өөрийнх нь эсрэг хэн нэгэн буруу юм үйлдэж байхад тэрхүү зовлонг тэсвэрлэн даахыг хэлнэ. Зовлонг тэсвэрлэн даахдаа сэтгэлийн баяр хөөр, бусдыг энэрсэн эелдэг харьцааг хослуулдаг.

[3:13]

Ингэхдээ нэг нэгнээ хүлцэж гэсэн нь бид ахан дүүсийнхээ алдаа болон жигтэй байдалд тэвчээртэй хандана гэсэн үг юм. Бусадтай хамт амьдарч байх үед бид тэдний алдааг олж харах

нь зайлшгүй. Бусдын сонин зан байдлыг хүлцэн тэвчихэд бидэнд ихэвчлэн Бурханы нигүүлсэл шаардагддаг шиг тэдэнд ч бидний элдэв аашийг тэвчихэд нигүүлсэл хэрэгтэй. **Хэрэв хэн нэгэнд чинь нөгөөгийнхөө эсрэг гомдол байвал бие биеэ уучил** гэжээ. Эдгээр зааврыг даган мөрдвөл Бурханы хүмүүсийн дунд хурдан шийдвэрлэгдэхгүй зөрчил тун цөөхөн байх болно. Бусад хүн бидний эсрэг зүйл үйлдэхэд уучлах хэрэгтэй. Бид ихэвчлэн ийм гомдол сонсдог: “Гэхдээ тэр намайг гомдоосон юм чинь...” Яг ийм нөхцөлд л бид уучлах ёстой гэсэн. Хэрэв бусад хүн биднийг гомдоогоогүй бол уучлах шаардлага байхгүй. Хэрэв бид буруутай нэгэн нь бол очоод уучлалт гуйх хэрэгтэй байдаг. Хүлцэн тэвчих гэдэг нь бид гомдохгүй байхыг, уучлах гэдэг нь гомдлыг хадгалахгүй байхыг хэлнэ. **Та нарыг Эзэн уучилсны адил та нар бас уучил** гэдэг ишлэлд зааснаас илүү хүчтэй уучлах шалтгааныг олоход хэцүү биз ээ. **Христ** биднийг хэрхэн уучилсан бэ? Тэрээр биднийг ямар ч шалтгаангүйгээр уучилсан. Бид ч тэгэх ёстой. Тэрээр биднийг уучлаад энэ тухай мартсан. Бид ч тэгэх ёстой. Бид арга барил, цар

хүрээний хувьд ерөөлт Эзэнийхээ энэхүү гайхалтай хандлагыг дагах ёстой.

[3:14]

Хайрыг энд гадуур хувцас юмуу бүс шиг хэлсэн бөгөөд энэ нь бусад бүх сайн чанарыг хамтад нь холбож **төгс** болгодог юм. Хайр бол христитгэлт зан чанарын бүх талыг зохистой хэмжээгээр хамтад нь нийцтэй болгодог. Аливаа хүн зүрхэндээ жинхэнэ хайргүйгээр дээр дурдсан зарим сайн чанарыг гаргаж болох юм. Тиймд Паул энд бид аливаа зүйлийг ахан дүүстээ жинхэнэ **хайрын** сэтгэлээр үйлдэх ёстой гэдгийг онцолжээ. Бид аливаа зүйлийг хийхдээ дуртай дүргүй биш харин бүх зүрх сэтгэлээрээ сайныг санаж үйлдэх ёстой. Гностикчууд мэдлэгийг **төгс** байдлыг бүрдүүлэх **холбоос** гэж үзэж байсан бол Паул **хайрыг төгс холбоос** гэж энэхүү үзлийг залруулжээ.

[3:15]

Христийн амар тайван бидний зүрх сэтгэлд хөндлөнгийн шүүгчийн үүргийг гүйцэтгэх учиртай. Хэрэв бид ямар нэгэн зүйлд эргэлзэж

байгаа бол өөрсдөөсөө “Энэ нь амар тайвныг төрүүлж байна уу?” эсвэл “Хэрэв би шийдээд үүнийг хийвэл сэтгэлд минь амар тайван байна уу?” гэж асуух хэрэгтэй.

Энэхүү ишлэл Эзэний удирдамжийг эрэлхийлж байхад онцгойлон тус болдог. Хэрэв Эзэн танаар ямар нэгэн зүйлийг хийлгэхийг хүсвэл танд **амар тайвныг** өгөх нь гарцаагүй юм. Хэрэв танд амар тайван байхгүй бол та хийх хэрэггүй. Явах талаар ямар ч дохио байхгүй харанхуй байвал үлд гэсэн гэрэл асчээ хэмээн хүлээн аваарай.

Христ биднийг хүн тус бүр болон чуулганаараа хамтдаа Өөрийнх нь амар тайвныг эдлээсэй гэж дуудсан. Энэ ишлэлийн төгсгөлд **үүний тулд л та нар нэгэн бие дотор дуудагдсан юм** гэсэн хэсгийн ач холбогдлыг хэрэгсэхгүй өнгөрч болохгүй. Бид амар тайван байх нэг арга бол бусад бүх христитгэгч хүнээс хол амьдрах. Гэвч энэ нь Бурханы зорилго биш. Тэрээр гэр бүлүүдийн хувьд тус тусдаа бие даан амьдрахаар бүтээжээ. Бурхан биднийг орон нутгийн чуулганд хамтдаа цуглаасай гэж хүсдэг. Хэдийгээр бусад христитгэгчидтэй цуг

амьдрахад тэвчээр шаардагдах боловч Бурхан ийм арга замаар христитгэгчийн амьдралд өөр ямар ч байдлаар бий болохгүй өв тэгш зан чанаруудыг хөгжүүлэх боломжтой болдог. Тиймд бид орон нутгийн чуулганы өмнө хүлээсэн хариуцлагаасаа дайжих хэрэггүй бөгөөд дургүйцэл, бухимдал төрсөн үед орхих ёсгүй юм. Харин тэгэхийн оронд бид бусад итгэгчидтэй таарамжтай амьдрахыг эрэлхийлж, тэдэнд бид хийж байгаа үйлдэл, үг яриа бүрээрээ туслах хэрэгтэй.

Талархагтун. Паул бичвэртээ энэ үгийг дахин дахин давтаж хэлдэг. Ингэх том шалтгаан байгаа ажээ: Бурханы Сүнс **талархалтай** сэтгэлийг маш чухал гэж үздэг нь дамжиггүй. Үнэхээр тийм гэдэгт бид итгэдэг. Энэ нь зөвхөн хүний сүнсний амьдралд чухал төдийгүй бие махбодид бас сайн юм. Эмч нар Бичээсийн олон зууны турш зааж ирсэн зүйлийг илрүүлжээ. Тэр нь юу гэвэл баяр хөөртэй, **талархалтай** хандлага нь биед тустай бөгөөд санаа зоволт, сэтгэл гутрал болон гомдоллох сэтгэл нь биеийн эрүүл мэндэд зайлшгүй хор хөнөөлтэй ажээ. Ер нь бид талархалтай байдал гэдгийг бидний эргэн тойрон

дахь нөхцөл байдлаас хамаардаг гэж боддог боловч Паул энд үүнийг хөгжүүлэх шаардлагатай нигүүлсэл гэдгийг харуулж байна. Бид **талархалтай** байх үүрэгтэй. Дэлхийн бүх хүний дотроос бид хамгийн талархалтай байхаар их зүйлийг хүлээн авсан (Дх 33:29-тэй харьцуул). Бид талархдаггүй нь талархах зүйл дутагдсанаас биш зөвхөн хувиа хичээсэн зүрх сэтгэлээс болдог.

[3:16]

16-р ишлэлийн цэг таслалыг хаана байрлуулах нь маргаантай. ШГ-ний эх хэл дээр ямар ч цэг таслал байдаггүй ба цэг таслал тавьснаар утгын хувьд ихээхэн ялгаа гардаг. Бид дараах байдлаар аваад үзье. **Бурханд хандаж зүрхэндээ баяртайгаар дуулах сүнслэг дуу, магтуу, дууллууд хийгээд бүх мэргэн ухаанаар та нар бие биедээ заан, бие биеэ сэнхрүүлэн Христийн үг та нарын дотор бялхам орших болтугай.**

Энэ ишлэл гурван хэсгээс бүрдэж байна. Юуны өмнө бидний дотор **Христийн үг бялхам оршихыг** зөвшөөрөх хэрэгтэй. **Христийн үг**

гэдэг нь Библи дэх Христийн сургаалыг хэлж байна. Бид зүрх сэтгэл, оюун бодлоо Түүний ариун үгээр дүүргэж, үүний дагуу дуулгавартай алхахыг эрэлхийлвэл **Христийн үг** үнэхээр бидний зүрх сэтгэлд нутаглах болно.

Хоёр дахь санаа нь **бүх мэргэн ухаанаар бие биедээ заан, бие биеэ сэнхрүүлэх** хэрэгтэй. Энэ зүйл дээр христитгэгч бүр итгэлийн ах, эгч, дүү нарын өмнө үүрэг хүлээсэн. **Зааж сургах нь** онол сургаалтай холбоотой байдаг бол **сэнхрүүлэх нь** үүрэг хариуцлагатай холбоотой юм. Бид ахан дүүстээ Бичээсийн мэдлэгээ хуваалцах өртэй бөгөөд амьдралтай холбоотой бурханлаг зөвлөгөө өгч туслахыг эрэлхийлэх хэрэгтэй. **Зааж сургах** хийгээд **сэнхрүүлэхдээ** хүчтэй яривч мэргэн ухаангүй эсвэл хайрын сэтгэлгүй байснаас **мэргэн ухаан** дотор байвал хүлээн авагдах магадлал илүү өндөр.

Гурав дахь зүйл нь **Бурханд хандаж зүрхэндээ баяртайгаар сүнслэг дуу, магтуу, дууллууд** дуулах хэрэгтэй. Дууллууд гэдэг нь Израилийн магтан хүндлэл дээрээ дуулдаг байсан Бурханы амьсгалаар бичигдсэн ийм нэртэй Библийн номыг хэлж байгаа юм. Нөгөө

талаар **магтуу** гэдэг нь Бурхан Эцэг юмуу Эзэн Есүс Христэд зориулсан хүндлэл магтаалын дуу гэж ерөнхийдөө ойлгогддог. Үүнд:

Есүс! Таныг бодмогц л

Амтат жаргал цээжинд дүүрнэм!

Таны царайг харж,

Таны оршихуйд амрах нь үүнээс ч амтат жаргал аж.

–Клейрвауксын Бернард зохиосон гэж үздэг.

Эдгээр **магтуу** дуу нь **дууллын** хэмжээнд Бурханы амьсгалаар бичигдээгүй. **Сүнслэг дуу** нь христитгэлийн амьдралын тухай өгүүлсэн итгэлийн шүлэг найраг юм. Үүнийг үгээр илэрхийлвэл дараах байдалтай байж болох юм:

Бидний нүглийг үүрэгч Есүс ямар сайн Найз вэ
Бүхнийг гуйлтаар Бурханд өргөх ямар онцгой
завшаан бэ

Бүхий л зүйлээ Эзэнд даатган залбиран
гуйхгүй болохоор

Бэрх хэцүү дарамт зовлонг бид дэмий үүрэх
юм

-Иосеф Скривен

Ийм янз бүрийн дууг бид **Бурханд хандаж зүрхэндээ баяртайгаар** юмуу талархалтайгаар

дуулах нь зүйтэй. Христитгэгчид ямар төрлийн хөгжим хэрэглэх хэрэгтэй талаар ялган таних шаардлага байна. Өнөөдрийн “христчин” гэж нэрлэдэг олон аялгуу хөнгөн бөгөөд хийсвэр байна. Энэ аялгууны дийлэнх хэсэг нь Бичээсийн эсрэг бөгөөд дэлхийн “поп” болон рок аялгуутай их төстэй байгаа нь Христийн нэрийг гутаах хэмжээнд хүрээд байна.

16-р ишлэл Ефес 5:18, 19-тэй их төстэй байна. Үүнийг уншвал: “Дарсанд бүү согтуур. Ингэвэл дураараа дургих байдалд автагдана. Харин Сүнсээр дүүрэн байж, дуулал, магтуу ба сүнслэг дуунуудаар нэг нэгэнтэйгээ ярилцаж, Эзэнд хандаж зүрхэндээ дуулж, ая дуу зохиогтун.” Колоссай 3:16-р ишлэлийн гол ялгаа нь “Сүнсээр дүүрэн байх” гэж хэлэхийн оронд Паул **“Христийн үг та нарын дотор бялхам орших болтугай”** гэжээ. Өөрөөр хэлбэл, Сүнсээр дүүрэн байх ба Бурханы үгээр бялхах гэдэг нь хоёулаа баяр хөөртэй, ашигтай, үр жимстэй амьдралын нөхцөл юм. Бид Бурханы үгээр бялхахгүйгээр Сүнсээр дүүрэхгүй бөгөөд бид өөрсдийгөө бүхэлд нь Ариун Сүнсний удирдлагад захируулахгүйгээр Бурханы үгийг

судлах нь үр өгөөжөө өгөхгүй. Тиймээс бид Сүнсээр дүүрэн байна гэдэг нь Бурханы үгээр бялхам байна гэж дүгнэж болохоор байна. Энэ нь амьдралд тохиолддог сэтгэл хөдөлгөсөн нууцлаг хямрал биш харин өдөр өдрөөр Бичээсээр тэжээгдэж, тэдгээрийг тунгаан бясалгаж, дуулгавартай даган тэдгээрийн дагуу амьдарна гэсэн үг юм.

[3:17]

17-р ишлэл нь христитгэгчийн хувьд зан үйлээ шалгах боломжийг өгдөг бүх зүйлийг агуулсан дүрэм аж. Өнөөдөр ялангуяа залуу хүн зарим зүйлийг зөв үү буруу юу гэдгийг шийдэхэд бэрх болсон цаг үе. Энэ ишлэлийг санаснаар эдгээр асуудлыг тайлах түлхүүр болж чадна. Би үүнийг **Эзэн Есүс Христийн нэрээр хийж** чадах уу? гэдэг нь агуу шалгалт болно. Энэ нь Түүний алдрын төлөө юу? Би уг зүйлийг Бурхан ерөөнө гэж найдаж болох уу? Түүнийг дахин ирэх хүртэл би үүнийг хийх хүсэлтэй юу? Энэ шалгалт бидний ярих үг, хийх үйл хэрэгт хамаатай байх ёстой. Энэхүү тушаалд дуулгавартай захирагдах нь бидний амьдралыг

бүхэлд нь өргөж болгоно. Христитгэгчид бүхнийг Эзэний төлөө болон Түүний алдрын төлөө хийж сурах нь үнэ цэнэ бүхий нууц юм. Элч дахиад **“Түүгээр дамжуулан Эцэг Бурханд талархал өргө”** гэж нэмж хэлжээ. Таларх! *Таларх!* **Таларх!** Энэ бол нигүүлслээр аврагдаж, тэнгэрийн улс уруу орох болсон хүмүүсийн мөнхөд хийх үүрэг юм.

2. Христитгэлт гэр бүлийн гишүүдэд байвал зохистой зан үйл (3:18-4:1)

Паул одоо христитгэлийн гэр бүлийн гишүүдэд сургамж өгч байна. Энэ нь 4:1-р ишлэл хүртэл үргэлжилж байна. Тэрээр эхнэр, нөхөр, хүүхэд, эцэг эх, зарц болон эздэд зөвлөсөн байна. Эхлээд Паул ярьж байгаа сэдвээсээ гэнэт хазайж гэр бүлийн амьдрал мэтийн энгийн юм уруу орсон юм шиг санагдаж болох юм. Гэвч энэ нь үнэндээ хамгийн чухал зүйл юм.

ХРИСТИТГЭЛТ ГЭР

Бурхан гэрийг христитгэлийн амьдралын маш чухал хүчин зүйл гэж үздэг. Гэр бүлийн нэгжийг Эзэн энэ амьдралын үнэ цэнэтэй бүхнийг

хадгалж хамгаалахын тулд бүтээсэн юм. Гэр бүлдээ тавих анхаарал багасах тусам соёл иргэншил маань маш хурдацтай муудаж байна. Паул Тимотод бичсэн анхныхаа захидалдаа Бурхан гэр бүлийн амьдралаар сүнслэг зан чанарыг хөгжүүлэхийг зорьжээ. Тухайлбал хүний зан чанар гэртээ батлагдаж байж чуулганыг удирдах хэмжээнд хүрнэ гэсэн.

Дараа дараагийн ишлэлд бид христитгэлт гэр бүлийг барьж байгуулахад удирдлага болгох үндсэн зарчмуудыг харж болно. Энэ хэсгийг судалж байхдаа бид “заавал хийх ёстой” дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

- (1) Гэр бүлүүдэд Ариун Бичээс уншиж, залбирал хийхийн тулд өдөр бүр цугладаг цаг буюу гэр бүлийн тахилын ширээ байх ёстой.
- (2) Эцэг нь гэр бүлдээ удирдлагын байр сууринд байх ёстой бөгөөд эрх мэдлээ мэргэн ухаан болон хайраар хэрэгжүүлэх ёстой.
- (3) Бурхан ба гэр бүлийнхээ төлөө үүрэх нэн тэргүүний хариуцлага гэрт нь байдгийг эхнэр болон ээжүүд ухаарах хэрэгтэй. Ер

нь эхнэр хүн гэрээс гадуур ажил хийх нь ухаалаг зүйл биш. Мэдээж онцгой тохиолдол байж болно.

- (4) Нөхөр болон эхнэр хүн хүүхдүүддээ бурханлаг үлгэр жишээ үзүүлэх хэрэгтэй. Тэд бүх зүйл дээр, шаардлагатай үед хүүхдээ сахилгажуулахдаа ч нэгдэх ёстой.
- (5) Гэр бүлийн нэгжийг хадгалах ёстой. Заримдаа бизнес, нийгмийн амьдрал, тэрбайтугай христитгэлийн үйлчлэлд хэт улайрснаар хүүхдүүдэд халамж хайр, нөхөрлөл, заавар, сахилгажуулалт дутагдах тун магадлалтай. Маш олон эцэг эхчүүд замаа алдсан хүү, охиныхоо талаар гашуудан гэмших хэрэг гардаг: “Таны боол энд ч, тэнд ч ажиллаад завгүй байх үед өнөөх хүн зугтаж одсон” (1Ха 20:40).
- (6) Хүүхдийг сахилгажуулахад гурван үндсэн зарчмыг санал болгож байна. Хэзээ ч уур уцаараар бүү сахилгажуул. Хэзээ ч шударга бусаар бүү сахилгажуул. Шалтгааныг нь тайлбарлахгүйгээр бүү шийтгэ.

- (7) Залуу насандаа буулгыг үүрэх нь (Гаш 3:27), ажлын сахилга батыг сурч, хариуцлагыг хүлээн авч, мөнгөний үнэ цэнийг ойлгох нь хүнд сайн болой.
- (8) Хамгийн гол нь христитгэлт эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ талаар махан биеийн хүсэл, дэлхийн арга замаар амбийц хөөхөөс зайлсхийх хэрэгтэй бөгөөд тэдний өмнө Эзэний үйлчлэлийг амьдралаа зориулах хамгийн ашигтай арга зам гэж танилцуулах хэрэгтэй. Зарим нь бүтэн цагаар илгээлтийн ажил хийж болно, зарим нь энгийн ажил хийгээд Эзэндээ үйлчилж болно. Гэвч аль ч үед Эзэний төлөө ажиллах нь үндсэн гол зорилго байх ёстой. Гэртээ байсан ч, ажил дээрээ байсан ч, хаана ч байсан бид Аврагчаа төлөөлж байгаа гэдгээ мэдэрч, бидний үг, үйлдэл бүр Түүнд зохистой бөгөөд Түүгээр удирдуулах ёстой.

[3:18]

Элч эхлээд **эхнэрүүдэд** хандан үүрэг даалгавар өгчээ. Тэднийг баяртайгаар **Эзэний таалалд**

нийцүүлж нөхөртөө захирагдагтун гэсэн байна. Тэнгэрлэг төлөвлөгөөний дагуу нөхөр нь гэрийн тэргүүн юм. Эмэгтэй хүнд нөхөртөө захирагдах байр суурийг өгсөн. Тэрээр захирах юмуу удирдах ёсгүй харин Христэд үнэнч байдлаа алдалгүйгээр нөхрийн удирдлагыг дагах хэрэгтэй. Мэдээж эмэгтэй хүн нөхөртөө дуулгавартай захирагдах боломжгүй байгаа мөртлөө Христийн өмнө итгэмжтэй байж болно. Ийм тохиолдолд тэрээр юуны түрүүнд Эзэн Есүст үнэнч байх ёстой. Христитгэлт эмэгтэй итгэгч бус нөхөртэй бол энэ ишлэлд тэрээр нөхөртөө гэр бүлд зөв байр суурийг эзлэхэд нь туслана гэж хэлсэн болохоос тэр эмэгтэй илүү ухаантай учраас түүнийг удирдах байр суурийг гартаа ав гэж хэлээгүй юм.

[3:19]

Бурхан үгээ үнэхээр тэнцвэртэй сайхан хэлжээ. Элч зөвхөн эхнэрүүдэд зөвлөгөө өгөөд дуусгаагүй байна. Тэр цааш нь **нөхрүүд ч** гэсэн үүрэг хариуцлагатайг хэлж байна. Тэд **эхнэрээ хайрлаж**, тэдэнд **хатуу хандахгүй** байх үүрэгтэй. Эдгээр энгийн зарчмыг дагаснаар гэрлэсэн

хүмүүст тохиолддог олон асуудал алга болж, гэр бүлүүд Эзэний дотор илүү аз жаргалтай болно. Үнэндээ ямар ч эхнэр өөрийг нь жинхэнээсээ хайрладаг нөхөрт захирагдахаас дургүйцээд байхгүй болов уу. Энд нөхөр хүн эхнэрээ өөртөө дуулгавартай болго гэж бичээгүй байна. Хэрэв эхнэр нь захирагдахгүй байвал энэ асуудлыг Эзэнд өргөх хэрэгтэй. Захирагдах нь эхнэрийн хувьд “Эзэний таалалд нийцүүлэн” сайн дураараа хийх ажил юм.

[3:20]

Хүүхдүүдэд ийнхүү сануулжээ: Хүүхдүүд ээ, бүх талаар эцэг эхдээ дуулгавартай байгтун. Ингэх нь Эзэнд таалагдана. Бүх үеийн туршид гэр бүл хоёр энгийн зарчим дээр оршин тогтдог. Тэр нь эрх мэдэл болон дуулгавартай байдал билээ. Энд дуулгавартай байдлын тухай өгүүлж байна. Бүх талаар дуулгавартай байх ёстойг анзаарна уу. Тэгэхээр зөвхөн хүлээн зөвшөөрч болох зүйл дээр бус харин тийм ч тааламжтай биш зүйл дээр ч гэсэн дагах ёстой гэсэн үг.

Итгэдэггүй эцэг эхтэй христитгэлт хүүхдүүд ихэвчлэн хүнд байдалд ордог. Тэд Эзэний өмнө

үнэнч, зөв байхыг хүсдэг боловч үүний зэрэгцээ эцэг эхийнхээ хүслийг гүйцэлдүүлэх шаардлага тулгардаг. Ер нь ийм хүүхдүүд эцэг эхээ хүндэлбэл Бурхан тэднийг хариуд нь хүндэлнэ. Тэд эцэг эхийнхээ гэрт амьдарч байгаа бол маш тодорхой үүрэг даалгаврыг гүйцэтгэх шаардлагатай болдог. Мэдээж тэд Христийн сургаалын эсрэг аливаа зүйлийг үйлдэх ёсгүй боловч тэдэнд буруу зүйл хийх шаардлага тийм ч их тулгардаггүй. Ихэвчлэн тэдэнд хийх дургүй зүйлээ хийх хэрэг гардаг ба тэр нь үнэхээр буруу юмуу эсвэл гэм нүгэл биш л бол Эзэнд мэт хийхээр шийдэх хэрэгтэй. Ийм арга замаар тэд эцэг эхдээ сайн гэрчлэл болж тэднийг Эзэнд авчрахыг эрэлхийлж чадна.

[3:21]

Эцгүүд хүүхдүүдийнхээ сэтгэлийг мохоохгүйн тулд тэднийг уурлуулахгүй байх хэрэгтэй. Энэ зөвлөгөөг эхчүүдэд хандаж хэлэлгүй **эцгүүдэд** хандаж хэлсэн нь сонирхолтой байна. Тэгэхээр эцгүүдэд ийм алдаа хийх аюул эхчүүдээс илүү гэдгийг илтгэж байгаа

юм биш үү? Келли эхчүүдэд хүүхдүүдээ эрхлүүлэх хандлага нь илүү байдаг гэж хэлжээ.

3:22 22-р ишлэлээс эхлээд энэ бүлгийн төгсгөл хүртэл Бурханы Сүнс **боолуудад** ханджээ. ШГ-нд хичнээн их зайг **боолуудад** зориулсныг тэмдэглэхэд сонирхолтой юм. Энэ нь чухал биш байсан бол тэгэхгүй. Хүн нийгэмд хичнээн доогуур байр суурьтай байсан ч хамаагүй Бурханы үгэнд үнэнч байснаар христитгэлт амьдралын оргилд хүрэх боломжтойг харуулж байна. Бурхан ихэнх христитгэгчид удирдлагын байр суурь эзлэхээс илүү үйлчилгээний ажилтан байх болно гэдгийг урьдаас мэдсэнийг илтгэж байж болох юм. Жишээлбэл, ШГ-нд улс үндэстнийг захирагч нарт хандаж хэлсэн заавар маш бага боловч бусдад үйлчлэхээр дуудагдсан хүмүүст хандсан зөвлөгөө нэлээд их байдаг. Паулын үед боолд бараг анхаарал тавьдаггүй байсан бөгөөд эхэн үеийн христитгэгчид эдгээр захидлуудад боолуудыг хичнээн их анхаарсныг харахад хачирхалтай байсан биз ээ. Гэхдээ хүний байр суурь хичнээн доогуур байсан ч Бурханы нигүүлсэл хүнд яаж бууж ирдэгийг энд харуулж байна. С.Х. Макинтош хэлэхдээ: “Боол хүн

Бурханы үйлчлэлээс хаягддаггүй. Зүгээр л Бурханы мэлмийд ажил үүргээ гүйцэтгэснээр сургаалыг чимэглэж, Бурханд алдрыг авчирдаг” гэжээ.

Боолууд махан биеийнхээ эзнийг бүх талаар дага гэж хэлжээ. Эдгээр эзэд зөвхөн **махан биеийн** эзэд гэдгийг энд зөөлөн сануулсан байна. Тэдэнд бүхнээс дээд өөр Эзэн байгаа бөгөөд Тэр Өөрийн хүүхдүүдийн хамгийн өчүүхэн нэгэнд үйлдэж байгаа бүхнийг хардаг. Боолууд **хүнд таалагдах гэж нүд хууралгүй, харин Эзэнээс эмээн, чин сэтгэлээсээ** үйлчлэх ёстой аж. (Энэ талаар ХГ-ний сайн жишээг Эх 24:33-аас үз.) Ялангуяа хүнийг хатуу харгисаар дарлаж байвал эзнээ хараагүй үед ажлаа хийхгүй баймаар санагдаж соригддог. Гэвч христитгэлт зарц өөрийн Эзэнээ үргэлж харж байдгийг мэддэг бөгөөд хэдийгээр түүний дэлхий дээрх нөхцөл байдал маш зовлон зүдгүүртэй боловч Эзэний төлөө мэт ажиллах болно. **Чин сэтгэлээсээ** гэдэг нь цэвэр сэдлээр буюу зөвхөн Эзэн Есүсийн таалалд нийцүүлэхийн тулд ажиллахыг хэлнэ.

ШГ-нд боолчлолыг хориглоогүй нь сонирхолтой юм. Сайн мэдээ нь нийгмийн институциудыг хувьсгалаар унагаадаггүй. Тэгсэн боловч сайн мэдээ тунхаглагдсан газар бүрд боолчлолыг үндсээр нь таслан устгасан. Тэгснээр эдгээр заавар бидэнд ямар ч хамаагүй гэсэн үг биш. Энд хэлэгдсэн бүх зүйл ажил олгогч болон ажилтан нарт хамаатай байна.

[3:23]

Юу ч хийсэн чин сэтгэлээсээ (үгчилвэл “сэтгэлээсээ”) **хүмүүсийн төлөө бус, Эзний төлөө үйлддэг шиг хийх ёстой.** Амьдралынхаа талбар бүрд, христитгэлийн бүх үйлчлэлд хүмүүст хүлээн авахад хэцүү үүрэг даалгавар олон гарч ирдэг. Бид ийм ажлаас зайлсхийхийг хичээдэг гэдгийг хэлээд яахав. Энэ ишлэлд хамгийн дорд үйлчлэл ч Эзний төлөө үйлдвэл алдаршин, хүндлэгдэх боломжтой гэдэг чухал хичээлийг зааж байна. Үүнээс энгийн болон ариун ажлын хооронд ялгаа байхгүй гэж ойлгож болно. Бүгд ариун. Тэнгэрт шагналыг нэр төр юмуу амжилтанд хүрсэнд эсвэл ур чадвар юмуу боломжийн төлөө бус харин итгэмжтэй байдлын

төлөө өгөх болно. Тиймээс нэрд гараагүй хүмүүс тэр өдөр хэрэв Эзэнд мэт өөрсдийн үүрэг даалгаврыг итгэмжтэй хийсэн бол хөлсөө сайн авах болно. Зарим гэрийн эзэгтэй өдөр тутам давтан хийдэг ажлаа ч гэсэн яаж ийгээд аргалах биш, давуулан биелүүлэх зорилготой ажилладаг бөгөөд гал тогооныхоо угаалтуур дээр “Тэнгэрлэг үйлчлэл энэ газар өдөрт 3 удаа хийгддэг” гэсэн уриа хаддаг байна.

[3:24]

Эзэн одоо болж буй зүйлийг тэмдэглэж хадгалсаар байгаа бөгөөд Түүний төлөө хийсэн бүхэн Түүний анхааралд байдаг. “Хүн энэрснээр Бурханы энэрлийг авна.” Дэлхий дээр багахан өв хөрөнгөтэй хүмүүс тэнгэрт байгаа **өв залгамжлалын шагналыг хүлээн авна.** Дараагийн удаа бид чуулганд, гэртээ эсвэл ажил дээрээ хийх дургүй ажлыг хий гэсэн дуудлага ирвэл үүнийг санацгаая. Ажлыг гоморхолгүйгээр, чадах чинээгээрээ хамгийн сайнаар хийвэл Христийг гэрчлэн харуулна.

[3:25]

Паул 25-р ишлэлд хэний тухай бичиж байгаагаа тодорхой хэлээгүй. Шударга бус, өөрийн зарцаа зовоодог эзэн юуны өмнө санаанд орохоор байна. Тийм хүний христитгэлт зарц шударга бус хүслийг нь дагахаас залхаж ядарсан байж болох юм. “Зүгээр, зүгээр. Эзэн энэ бүхнийг мэднэ, Тэр буруу зүйл хийснийг ч хариуцна” гэж Паул хэлжээ.

Гэхдээ энд эздийн тухай хэлсэн байж болох ч энэ ишлэл гол нь зарц нарт хандсан. Ажлаа хайш яаш хийх, хуурах, ажлаас зугтах болон өөр аливаа хуурамч байдлыг анзаарахгүй орхихгүй. Бурханд **хэн ч бай ялгаагүй**. Тэрээр бүгдийн Эзэн бөгөөд хүмүүсийн дундах ялгаа Түүний хувьд юу ч биш. Хэрэв боолууд эзнээсээ хулгай хийвэл (жишээлбэл Онесим тэгсэн шиг байдаг) тэд Эзэний өмнө хариуцлага хүлээнэ.

[4:1]

Энэхүү ишлэл утгын хувьд 3-р бүлгийн төгсгөл болохоор байна. Эзэд **боолууддаа шударга ёс, тэгш эрхийг соёрхох ёстой**. Тэдний авбал зохих хөлсийг өгөлгүй дарж болохгүй,

харин тэдний хийсэн ажлын хариуд сайн төлөх ёстой. Үүнийг христитгэлт ажил олгогчдод шууд хандан хэлжээ. Бурхан ядуусыг хавчихыг болон шударга бус хөдөлмөрөөр баяжсан хүний бэлгийг үзэн яддаг. Бурхан үнэндээ ингэж хэлдэг: “Чи мөнгөө өөртөө хадгал. Мөнгө олсон арга зам чинь таалагдахгүй байна” (Иак 5:1-4). Эзэд их зантай байж болохгүй харин эмээх ёстой. Тэд **бас тэнгэрт** Өөрийн бүх зам мөрд шударга ба зөвт **Эзэнтэй**.

Энэхүү хэсгийг хаахаас өмнө элч Паул өдөр тутмын амьдралын эдгээр асуудлыг Христийн удирдлагын гэрэл доор дараах байдлаар дахин дахин тавьж байгаа нь сонирхолтой: (1) Эхнэрүүд – Эзэнийн таалалд нийцүүлэн (ишлэл 18). (2) Хүүхдүүд - Эзэнд таалагдан (ишлэл 20). (3) Боолууд - Эзэнээс эмээн (ишлэл 22). (4) Боолууд - Эзэний төлөө үйлддэг шиг (ишлэл 23) гэжээ.

3. Итгэгчийн залбирлын амьдрал ба амьдрал, үг яриагаар гэрчлэх нь (4:2-6)

[4:2]

Паул Бурханы хүмүүсийг **залбирлын** амьдралдаа хичээл зүтгэлтэй бай хэмээн уриалахыг хэзээ ч төвөгшөөж байгаагүй. Бид тэнгэрийн улс уруу орохдоо залбиралд илүү олон цаг зарцуулаагүйнхээ төлөө ялангуяа бидний залбиралд өгсөн ямар хэмжээнд хариулдагийг ухаараад харамсах нь эргэлзээгүй. Залбиралтай холбоотой олон нууцлаг зүйлс байдаг. Гэхдээ христитгэгч залбирлын гүн гүнзгий нууцуудыг задлан шинжилж, ойлгохыг эрэлхийлэхгүй байх нь дээр. Хамгийн зөв хандлага бол оюунлаг эргэлзээгээ орхиод энгийн итгэлээр залбирсаар байх явдал юм.

Өөрсдийгөө зөвхөн **залбиралд зориулах** төдийгүй мөн **сэрэмжтэй байх** ёстой. Даруй бидний санаанд Эзэн Есүсийн Гетсемани цэцэрлэгт дагалдагчдаасаа хүссэн хүсэлт орж ирж байна. “Сорилтод орохгүйн тулд та нар залбирцгаа.” Тэд сэрэмжгүй байсан тул нам унтжээ. Бид зөвхөн нойрноос сэрэмжлээд зогсохгүй мөн хэрэн тэнэсэн бодолд автах,

залхуурах зэргийн эсрэг тэмцэх хэрэгтэй. Мөн залбирлын цагаа алдахгүйн тулд сэрэмжлэх ёстой (Еф 6:18). Тэгээд бас бидний залбирал **талархалтай** байх ёстой. Бид хүлээн авсан залбирлын хариуд талархаад зогсохгүй Эзэнд хандан өргөж байгаа, Түүний хараахан хариулаагүй залбирлын төлөө ч итгэлээр талархаж болно. Гаи Кинг үүнийг гайхалтай сайхнаар дүгнэн хэлжээ: “Түүний хайр бидэнд хамгийн сайныг хүсдэг, Түүний мэргэн ухаан бидэнд хэрэгтэй хамгийн сайныг мэддэг бөгөөд Түүний хүч чадал бидэнд хэрэгтэй хамгийн сайныг өгдөг.”¹⁸

[4:3]

Паул колоссайчуудаас **бас** өөрийнх нь **төлөө**, түүнтэй хамт Ромд байсан Эзэний зарц нарын төлөө залбирахыг хүссэн. Тэрээр шоронгоос суллагдахын төлөө гуйгаагүй харин **Бурхан** түүнд **үгийг** тунхаглахын тулд **хаалга нээж өгөхийг** гуйсныг харахад сайхан байна. Бурхан түүнд хаалга нээж өгөөсэй гэж элч хүссэн. Үүнд бидний сурах ямар чухал хичээл байна вэ! Христитгэлийн үйлчлэлийн төлөө хаалгануудыг

бид өөрсдөө нээгээд явах бүрэн боломжтой. Энэ нь зайлсхийх ёстой аюул ажээ. Хэрэв Эзэн бидэнд хаалга нээж өгвөл бид итгэлтэйгээр түүгээр орж, Түүнийг удирдаж байгааг мэдэх болно. Нөгөө талаас, хэрэв бид өөрсдөө үүд хаалгыг нээвэл бид Эзэний хүслийг дагаж байгаа эсэхээ мэдэхгүй эргэлзэх бөгөөд удалгүй бид Эзэний ажил хэмээх зүйлээ хийхийн тулд дэлхийлэг арга хэрэгслийг сонгож болох юм. **Паул үгэнд зориулсан хаалга нээгдэж, Христийн нууцыг яриулаасай гэсэн тодорхой хүсэлт гаргажээ. Үүний төлөө тэр хоригдсон.** Энэ ишлэлийн **Христийн нууц** гэдэг нь чуулганы тухай үнэнийг буюу тодруулбал “Харь үндэстнүүдийн төлөөх Христ” гэсэн илэрхийллээр тодорхойлж болох тэр хэсгийг хэлж байна. Энэ бол Паулаар тунхаглуулахаар хариуцуулсан сайн мэдээний хэсэг байсан юм. Учир нь харь үндэстнүүд ч еврейчүүдийн адил аврагдаж болох юм гэдгийг зориглож ярьснаар еврей удирдагчид эцэстээ түүнийг Ром уруу хоригдол болгон цөлж чадсан.

Зарим хүн Паулыг шоронд хоригдож байх үед нь чуулганы талаар агуу нууц илчлэгдсэн гэж

заадаг. Тийм учраас тэд “Шоронгоос бичсэн захидлуудад” онцгой ач холбогдол өгч, сайн мэдээний номууд болон ШГ-ний бусад номуудын ач холбогдлыг дутуу үнэлдэг мэт санагддаг. Гэвч нууцын талаар тунхагласан нь түүний шоронд орох *шалтгаан* болсон тул түүнийг барихаас өмнө түүнд илчлэгдсэн гэдэг нь энэ ишлэлээс тодорхой харагдаж байна.

[4:4]

Тэрээр үүнийг **тодорхой болгоход** их анхаарч байна. Өөрөөр хэлбэл хүмүүст амархан ойлгогдохоор маш ойлгомжтой тунхаглахыг хүсэж байна. Христийг мэдүүлэхийг хүсэж байгаа христитгэлт хүн бүрд ийм хүсэл байх ёстой. “Гүн” байх нь тийм ч олигтой биш. Бид хүн төрөлхтөнд хүрэхийг эрмэлзэх ёстой ба үүний тулд үгээ энгийн бөгөөд ойлгомжтой илэрхийлэх хэрэгтэй.

[4:5]

Христитгэгчид **гаднах хүмүүстэй мэргэн ухаанаар харьцах** хэрэгтэй. Тэд өдөр бүрийн зан үйлдээ итгэдэггүй хүмүүс анхааран ажиглаж

байгааг ухаарах хэрэгтэй. Дэлхий бидний ярианаас илүү бидний алхаж амьдарч буйг сонирхдог. Эдгар Гейст хэлэхдээ: “Би ямар ч өдөр номлолыг сонсох биш харахыг илүүд үздэг” гэсэн байдаг. Гэхдээ христитгэгч уруулаараа Христийг гэрчилж болохгүй гэсэн үг ердөө биш, гол нь түүний алхаж амьдрах нь ярьсантайгаа нийцэж байх хэрэгтэй гэсэн үг юм. Христитгэгч “үг нь том, үйл нь өчүүхэн” гэж хэлэгдэж огт болохгүй.

Цагийг үнэл (золь) гэдэг нь “боломжуудыг худалдаж ав” гэсэн үг юм. Бидний амьдралд өдөр бүр Эзэн Есүс Христийн авралын хүч чадлыг гэрчлэх боломж гардаг. Эдгээр боломж ирэхэд бид тэднийг алдалгүй барьж авах хэрэгтэй. “Худалдаж авах” гэдэг үг нь ихэвчлэн өртөг зардал гарна гэсэн утгыг агуулж байдаг. Гэхдээ үнэ нь хичнээн их байсан ч бид үнэ цэнэтэй Аврагчаа Түүнийг мэдээгүй нэгэнд хуваалцахад бэлэн байх хэрэгтэй.

[4:6]

Бидний яриа үргэлж нигүүлсэнгүй бөгөөд давсаар амт оруулсан мэт байх ёстой.

Ингэснээр бид хүн болгонд яаж хариулах ёстойгоо мэдэх юм. Хэрэв бидний үг яриа үргэлж **нигүүлсэнгүй** байх ёстой бол энэ нь эелдэг, даруу бөгөөд Христийнх шиг байх ёстой юм. Үүнд хов жив, тулга тойрсон яриа, цэвэр бус зүйл бөгөөд хорсол байх ёсгүй. **Давсаар амт оруулсан мэт** гэдэг илэрхийлэл нь маш олон утга агуулдаг. Зарим тайлбарлагч бидний яриа нигүүлсэнгүй байхаас гадна үнэн, хоёр нүүргүй байх ёстой гэдэг. Бусад хүн **давс** амт оруулдаг тул Паул бидний яриаг хэзээ ч мунхаг, үлбэгэр юмуу амтгүй байж болохгүй харин үргэлж үнэ цэнэтэй, үр ашигтай байх ёстой гэж хэлж байна гэдэг. Лаитфүүт хэлэхдээ итгэдэггүй зохиолчид “давс” гэдэг үгийг “ухаан” гэсэн утгаар хэрэглэдэг байсан гэжээ. Паул ухаан гэдгийг мэргэн ухаан болгон өөрчилжээ. Энэ илэрхийллийг хамгийн зөв тайлбарлахын тулд Эзэн Есүсийн хэл яриаг судлах нь зүйтэй болов уу. Завхайрч байгаад баригдсан эмэгтэйд хандан Тэрээр: “Би ч гэсэн чамайг яллахгүй: яв, дахин нүгэл бүү үйлд” гэсэн. Үүнд нигүүлсэл ч байна, давс ч байна. Юуны өмнө нигүүлслээр “Би ч гэсэн чамайг яллахгүй” гээд “яв, дахин нүгэл бүү

үйлд” гэсэн нь давс ажээ. Өөр нэг тохиолдолд Эзэн Есүс Иаковын худагны дэргэд нэгэн эмэгтэйд: “Надад уух юм өгөөч... Явж, нөхрөө дуудаад ир.” Эхнийх нь нигүүлсэл, дараагийнх нь бидэнд давсыг сануулж байна.

Ингэснээр та нар хүн болгонд яаж хариулах ёстойгоо мэдэх юм. Элч Паул энд колоссайчууд дээр үнэмшилтэй онол сургаал барьж ирсэн гностикчуудын тухай бодсон байж болох юм. Тэд эдгээр хуурамч багш нарт мэргэн ухааны үгс болон итгэлтэй байдлаар **хариулахад** бэлэн байх хэрэгтэй.

4. Паулын хамтран ажиллагчдын тухай товчхон (4:7-14)

[4:7]

Тухик гэдэг нь Ромоос Колоссай хот уруу энэхүү захидлыг хүргүүлэхээр элч Паулын сонгосон хүн бололтой. Макларен бичихдээ “хэрэв Тухикт эдгээр цаасыг тэрхүү хотын сүр жавхлант байдлаас илүү урт насалж, түүний нэр үүн дотор бичигдсэн тул дэлхийн цаг үеийн төгсгөл хүртэл бүх хүнд мэдэгдэнэ гэж хэлсэн бол ямар их гайхах бол доо” гэжээ.

Паул энд Тухик очоод тэдэнд элчийн үйлчлэлийн талаарх **бүх мэдээллийг мэдэгдэх** болно гэж ариун хүмүүст батлан хэлж байна. Өмнө нь өгүүлсэн шиг Паул энэхүү дүүдээ өгч байгаа өргөмжлөлүүдийг уншихад сайхан байна. Түүнийг **Эзний дотор хайрт дүү, итгэлт үйлчлэгч, хамтран зүтгэгч, боол** гэж дуудсан. Өнөөдөр сүм чуулганы албан хаагчдад өгдөг янз бүрийн том хэргэм цолоос хамаагүй дээгүүр өргөмжлөлийг соёрхжээ!

[4:8]

Тухикийн Колоссай хот уруу явсан аялал хоёр зорилготой байжээ. Юуны өмнө, тэрээр ариун хүмүүст Паул болон Ромд байгаа хамтран зүтгэгч нарынх нь талаар нүдээрээ харж, чихээрээ сонссон мэдээллийг өгөх, бас Колоссай хотынхны **зүрхийг тайвшруулах** зорилготой байлаа. Энд дахиад л **тайвшруулах** нь сэтгэлийг засахаас илүү “хүчирхэгжүүлэх” юмуу “урамшуулах” (2:2-ыг үз) гэсэн утгатай байна. Түүний үйлчлэл тэдэнд тэр үед өргөн тархаад байсан худал хуурмаг номлолын эсрэг бат зогсоход тус болсон.

[4:9]

Онесим гэдэг нэрийг дурдахад Паулаас Филемонд бичсэн захидалд гардаг сайхан түүхийг сануулж байна. Онесим бол шийтгэлээс зугтааж Ром уруу оргосон боол байв. Ямар нэгэн байдлаар тэр хүн Паултай холбогдож, Христ уруу эргэсэн байна. Одоо Онесим Колоссай уруу буцаж өөрийн өмнөх эзэн Филемон дээр очих гэж байна. Тэрээр Паулын бичсэн захидлыг Филемонд өгч байх зуур Тухик энэ захидлыг Колоссай хотын чуулганд хүргэж байжээ. Колоссай хотын итгэгчид энэ хоёр ахан дүүсийг Паулаас захидал аваад ирэхэд ямар их догдолж баярласныг төсөөлөөд үзээрэй! Тэд орой хүртэл сууж, Ром дахь нөхцөл байдлын талаар асуун Аврагчийн төлөөх үйлчлэлдээ Паул ямар эр зориг гаргаж буйг сонссон нь эргэлзээгүй.

[4:10]

Аристархийн талаар өмнө нь Үйлс 19:29-т тэмдэглэсэнчлэн Эзэний үйлчлэлээс болж баригдаж байсан гэснээс өөр зүйл бараг байдаггүй. Одоо тэрээр Паултай **хамт** Ромд **хоригдож** байна.

Маркийг энд **Барнабын үеэл** гэж дурьджээ. Энэ залуу Паул болон Барнабтай илгээлтийн ажилд анх гарсан. Алдаа гаргасан тул Паул түүнийг гэрт нь үлдээхээр шийдэж, харин Барнаб түүнийг өөртэйгээ хамт авч явсан. Үүнээс болж хуучны хамтран ажилагсдын хооронд ан цав үүссэн. Гэвч Марк алдаагаар дуусаагүй харин хайрт Паулын итгэлийг олох хэмжээнд сэргэсэн гэдгийг мэдэхэд сайхан байна.

Хэрэв Марк Колоссайд очвол ариун хүмүүст түүнийг **хүлээж аваарай** гэжээ. Колоссайчуудыг түүний талаар **заавар авсан** гэдэг нь заавал Маркийн талаар өмнө нь заавар өгсөн гэсэн утгатай биш. Харин Паулын тэдэнд одоо өгч байгаа зааврыг хэлж байж болно: Хэрэв тэр **та нар уруу очвол хүлээж аваарай. Авсан** гэдэг үйл үгийн цаг нь колоссайчууд энэхүү захидлыг уншиж байх үеийг хэлж байж болох бөгөөд тэд заавар авч байна. Сайн мэдээний хоёр дахь номыг бичсэн Маркийг дурьдсан нь бид ч гэсэн өдөр өдрөөр сайн мэдээг бичдэг болохыг сануулж байна:

Бидний хүн нэг бүр сайн мэдээг өдөр бүр
бүлэг бүлгээр бичдэг,

Үйлсээр, харагдах байдал, дур сонирхол,
хэлж байгаа үгээрээ бичдэг ба
Бидний үйлс биднийг илчилж, итгэмжит
бөгөөд үнэн үгс
“Таны сайн мэдээ юу вэ?” хэмээн
өгүүлнэм.

[4:11]

Паулын өөр нэгэн хамтран ажиллагчийг **Иуст** гэж нэрлэгддэг **Есүс** гэжээ. **Есүс** гэдэг нэр тухайн үед ч, бас өнөөдөр ч зарим улс орнуудад их түгээмэл нэр юм. Еврейгээр “Иошуа” гэдэг нэрийн грек хувилбар аж. Түүний христитгэгч найзууд түүнийг Бурханы Хүүтэй адил нэрээр дуудахад эвгүй байсан тул **Иуст** гэж дууддаг байсан нь эргэлзээгүй.

Уг гурван хүн гурвуулаа итгэсэн еврейчүүд байсан. Үнэндээ еврейчүүдээс **зөвхөн** тэд Паултай хамт **Бурханы хаанчлалын төлөө хамтран зүтгэгчид** байсан бөгөөд түүнийг **тайтгаруулсан** юм.

[4:12]

Паул захидлаа төгсгөж байх үед Епафр өөрийнхөө хувийн мэндчилгээг Колоссайн эрхэм ариун хүмүүст уламжлахыг сануулжээ. Епафр Колоссай хотын уугуул байсан бөгөөд **залбиралдаа үргэлж** итгэгчдийг санаж, Эзэнд хандан тэднийг **гүйцэд болж, төгс зогсож байхын** тулд гуйдаг байв.

[4:13]

Паул Епафрыг зөвхөн колоссайчуудын төлөө залбиран тэмцээд зогсохгүй бас **Лаодик** болон **Хиераполд байгаа хүмүүсийн төлөө** залбирдаг болохыг **гэрчилж** байна. Энэ хүн өөрийн таньдаг Бурханы хүмүүсийг хувьчлан анхаардаг байжээ. Түүнд залбирлын урт жагсаалт байсан бөгөөд өдөр бүр нэг бүрчлэн тэдгээрийг санаж залбирдаг байсан гэхэд гайхаж, эргэлзэх зүйл алга. “Та нарыг бат зогсож, итгэл үнэмшлээрээ төлөвшин Бурханы хүслийг гүйцэлдүүлэхэд өөрсдийгөө бүрэн зориулаасай гэж тэр үргэлж та нарын төлөө хичээнгүйлэн залбирдаг” (NEB).

[4:14]

Одоо Паул **хайрт эмч Лук болон Демийн мэндийг** дамжуулж байна. Энд эрс тэрс харьцуулалтын судалгаа байна. **Лук** Паултай хамт явж, түүнийг өвчтэй, хавчигдаж, шоронд байхад нь бие махбодийн болон сүнсний хувьд үйлчилдэг байсан болов уу.

Дем нөгөө талаар элчтэй хэсэг хугацаанд хамт байсан боловч эцэстээ элч түүний талаар ийн өгүүлэх шаардлага тулгарчээ: “Дем энэ өнөө үеийг хайрлаж, намайг орхиод Тесалоник уруу явсан” (2Тм 4:10).

5. Мэндчилгээ ба заавар (4:15-18)

[4:15]

Лаодикт байгаа ахан дүү нарт болон Нумфад, түүнчлэн түүний гэрт цугладаг чуулганд мэнд хүргэжээ. Бид Илчлэлт 3:14-22-оос Лаодикийн чуулганы талаар дахин уншиж болно. Уг чуулганыг Бурханы зүйлсийн талаар бүлээвтэр болсон гэсэн. Чуулган бүхэлдээ материаллаг зүйлд төвлөрч, өөртөө хангалуун болжээ. Бүх юм сайн байгаа гэж итгэсэн тэр хүмүүс өөрсдийгөө нүцгэн байгаагаа ухаараагүй.

Бичвэрүүд зарим нь Нумфас (эрэгтэй), зарим нь Нумфа (эмэгтэй) хэмээн ялгаатай байдаг. Гэхдээ Колоссайд тэр хүний гэрт чуулган байсан гэдгийг л мэдэхэд хангалттай. Тухайн үед христитгэгчдэд өнөөдрийнх шиг гоё сайхан байшин байхгүй байжээ. Гэвч ихэнх маань орон нутгийн чуулган дахь Бурханы хүч гоё сайхан байшин юмуу тавилга тохижилтоос илүү чухал гэдгийг бид бараг бүгдээрээ зөвшөөрөх биз дээ. Хүч чадал эдгээр зүйлээс хамаардаггүй, харин ч сүмийн тансаг барилга байшин хүч чадалд ихэвчлэн саад болдог.

[4:16]

Энэ захидлыг Колоссайд уншсаныхаа дараа лаодикчуудын чуулганд илгээж уншуулах ёстой байв. Үүнийг хийсэн гэдэг нь мадаггүй. Гэхдээ Илчлэлт 3-р бүлгээс лаодикчууд энэ захидалд хэлсэн зүйлийг дагаагүй буюу ядаж л тууштай дагаж чадаагүй.

Мөн Паул **Лаодикаас ирсэн захидлыг Колоссайд унших хэрэгтэй хэмээн зааварласан.** Ямар захидлыг хэлээд байгааг мэдэх боломжгүй юм. Зарим хүн Паулын Ефес гэгддэг захидлыг

энд хэлж байна гэж үздэг. Зарим эртний гар бичвэрүүдэд “Ефест байгаа” гэдэг үгийг Ефес 1:1-т дурддаггүй. Тиймээс тайлбарлагчид Ефест хандсан захидлыг Ефес, Лаодик болон Колоссай зэрэг хэд хэдэн чуулганд дамжуулж унших ёстой байсан гэж итгэдэг. Бас Ефес номд Колоссайтай харьцуулбал хувь хүнтэй холбоотой зүйл маш бага дурддаг тул ийм үзэл илүү үнэмшилтэй мэт.

19

[4:17]

Эзэн дотор хүлээж авсан үйлчлэлээ биелүүлэхийн тулд үйлчлэлдээ анхаарал тавь гэж Архийпт хэлжээ. Энд мөн л ямар **үйлчлэлийн** талаар хэлсэн нь тодорхойгүй байна. Олон хүн Архийгийг Филемоны хүү бөгөөд Колоссайн чуулганд идэвхтэй үйлчилдэг байсан гэж итгэдэг. Хэрэв бид Архийгийн оронд байсан бөгөөд Бурханы Сүнс бидэнд: “Эзэн дотор хүлээж авсан үйлчлэлээ биелүүлэхийн тулд үйлчлэлдээ анхаарал тавь” гэж хэлэхийг сонсож байна гэж төсөөлвөл энэхүү ишлэл бидэнд маш утга учиртай болно. Бидний хүн нэг бүрд Эзэн ямар нэгэн үйлчлэл өгсөн бөгөөд хэзээ

нэгэн цагт түүнийгээ хэрхэн гүйцэлдүүлсэн тухай тайлангаа тавих үе ирнэ.

[4:18]

Энэ мөчид элч **өөрийн гараар** үзэг аван төгсгөлийн **мэндчилгээг** бичихдээ Паул хэмээн харь хэлний нэрээ ашиглажээ. Түүний гар **хүлээстэй** байсан тул юм бичихэд хэцүү байжээ. Харин үүнээс болж тэрээр колоссайчуудад **миний хүлээсийг санаарай** гэж хэлжээ. “Үзэг болон хүлээс хамтдаа бичигдсэнээс харахад номлогчийн хүлээс Бурханы Үгийг хорьж чадахгүй гэдэг нь тодорхой.” Тэрээр захидлаа **Нигүүлсэл та нартай хамт байх болтугай** хэмээн төгсгөжээ. А.Т.Робертсон бичихдээ: “Нигүүлсэл гэдэг үг Хүүгээ бидэнд бэлэг болгон өгсөн Бурханы хайрыг бүхэлд нь тээдэг тул үүнээс илүү баялаг үг байхгүй” гэжээ.

ФИЛЕМОНД БИЧСЭН ЗАХИДАЛ

Оршил

“Энэ бол захидал бичгийн бяцхан сод бүтээл” –

Эрнест Ренан

“Бид бүгдээрээ (Эзэний) Онесимууд”

– Мартин Лютер

I. БИЧЭЭСТ ЭЗЛЭХ ОНЦГОЙ БАЙР СУУРЬ

Зарим хүн бид Паулын бичсэн энэ богинохон захидалтай захидалгүй болох байсан гэж хэлж мэднэ. Тэгвэл тэд үнэхээр буруудана. Юуны түүрүүнд энэ нь элчийн хувьчилсан, чин зүрх сэтгэлээсээ бичсэн захидал гэж дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн. Тийм учраас эрдэнийн шигтгээ гэсэн үг. Үүнийг Ромын итгэдэггүй зохиолч Залуу Плинигийн бичсэн “Оргосон боолын найздаа бичсэн захидал”-тай олонтаа

жишин авч үздэг. Гоёмсог үг хэллэгээс бусад талаараа Паулын захидал бол шилдэг бүтээл юм.

Уг богино захидлаас бага зэргийн наргиан хавчуулсан эелдэг зан, арга ухаан бас Паулын хүнийг хайрлах сэтгэл үнэртэнэ. Шууд сургаал айлддаггүй ч, “үүнийг надтай тооцоорой” гэдэг үгээрээ “бусдын буруутгалыг үүрэх” сургаалыг төгс харуулсан. Онесимын алдаа эндэгдлийг Паулд тохож, Паулын тэр бүхнийг үүрэх, өр төлөөсийг төлөх чадварыг арчгүй Онесимд хамаатуулсны адил христитгэлт хүний гэм нүглийг бидний Эзэнд “тохсон” буюу ял шийтгэлийг нь Эзэний данснаас нэхэмжилж, Эзэний аврах сайн мөн чанарыг христитгэгчид хамаатуулсан буюу түүний данс уруу оруулсан. Агуу шинэчлэгч Мартин Лютер ийнхүү бичсэнийг гайхах юун:

Эндээс бид Паул хөөрхий Онесимын төлөө хэрхэн өөрийнхөө бүх л зүйлийг зориулж, чадлаараа түүний өмнөөс эзэнээс нь гуйж байгааг харна. Ингэснээрээ өөрөө Филемоны өмнө буруутай Онесим шиг болсон. Христ бидний төлөө Бурхан Эцэгт яаж хандсантай адил Паул Онесимийн төлөө

тийнхүү Филемонд хандав... Миний бодлоор
бол бид бүгд Түүний Онесимүүд.¹

II. ЗОХИОГЧ

Хамгийн их сөргөөр шүүмжлэгчдээс бусад нь бүгд Филемон номыг Паул бичсэн гэж хүлээн зөвшөөрдөг. Тэр ч бүү хэл Ренан хүртэл үүнд бат итгэлтэй байсан тул энэхүү захидалтай нягт холбоотой Колоссай хотынхонд бичсэн захидлыг Паул бичээгүй гэсэн няцаалтаасаа ухрах тухай бодоход хүрсэн байна.

Филемон маш товч, маш хувийн чанартай болохоор эртний ном бичмэлүүдэд Захидлаас иш татсан өгүүлбэр ховорхон байгаад гайхах хэрэггүй юм.

Гадаад нотолгоо

Филемонд бичсэн захидлыг Игнатиус, Тертуллиан, Ориген нарын бичээсүүдэд дурьдсан эсвэл иш татсан байдаг. Юсибиус үүнийг бүх христитгэгчдээр хүлээн зөвшөөрөгдсөн ном (homologoumenia) гэж хэлсэн. Марсион энэ номыг өөрийн “ариун

бичээс”-т багтаасан бөгөөд энэ номыг Мураторийн ариун бичээс ч хүлээн зөвшөөрсөн.

Дотоод нотолгоо

Ийм богино захидалд Паул нэрээ гурвантаа дурьдаад авсан (ишлэл 1, 9, 19). 2, 23, 24-р ишлэлүүд Колоссай номын 4:10-17-той тун ойрхон дүйдэг учраас энэ хоёр захидал нэг хүнээр бичигдсэн гэдгийг баталдаг. Ингэж дотоод нотолгоонууд нь гадаад нотолгоонуудтай таарч байна.

III. БИЧИГДСЭН ОГНОО

Энэ захидал болон Колоссай хотынхонд бичсэн захидлыг нэг цаг хугацаанд (М.Э. 60 он) Эзэн маань дээш одсоноос гучаад жилийн дараа илгээсэн.

IV. ТҮҮХЭН НӨХЦӨЛ, ХӨНДСӨН СЭДЭВ

Энэ захидлын цаана байгаа түүхийг бид захидлаас өөрөөс нь мөн Паулын, Колоссай хотынхонд бичсэн захидлаас гаргаж авах ёстой.

Филемон, элч Паулаас сайн мэдээг хүлээж авсан (ишлэл 19) Колоссай хотын хүн байсан бололтой (Кол 4:17-ыг Филемоны 2-той харьцуул). Түүний боолуудын нэг болох Онесим гэгч түүнээс оргон зугтсан (ишлэл 15, 16), дээр нь эзнийхээ эд хөрөнгөөс хумслаад арилсан (ишлэл 18) гэсэн санаа цухалзаж байна.

Паулыг Ромд хоригдож байхад оргодол маань тэнд хүрчээ (ишлэл 9). Тэр үед Паул шоронд орсон эсвэл түрээсийн байрандаа гэр хорионд байсан эсэхийг нарийн хэлж мэдэхгүй юм (Үйл 28:30). Сонирхолтой нөхцөл байдлын учигаар Онесим Паултай их хотод таарч Христийг таньж мэджээ (ишлэл 10). Улмаар тэд бие биенээ харилцан хайрлаж Онесим Паулын хувьд тустай хүн болох нь илэрчээ (ишлэл 13). Гэсэн ч Онесим эзэндээ эргэн очиж өнгөрсөнд хийсэн алдаагаа засах нь зөв гэж тэд хоёул тохиров. Тэгээд Паул энэ захидлыг Филемонд бичиж Онесимын өмнөөс эзэнд нь зуучилж, эзэн нь яагаад түүнийг нигүүлсэнгүйгээр хүлээж авах ёстой тухай хүчирхэг шалтгаан, үндэслэлийг өчжээ (ишлэл 17). Энэ үед Паул мөн Колоссай хотынхонд захидал бичсэн. Тэр Тухикийг шууданчаа

болгож, Онесимийг түүнтэй хамт Колоссай уруу илгээв (Кол 4:7-9).

Энэ бол Паулын захидлууд дотроос хамгийн хувийн чанартай захидал юм. Тимогод мөн Титэд бичсэн захидлууд нь хувь хүнд хандсан боловч хувь хүний гэхээсээ чуулганы асуудлуудыг хөндөж бичсэн байдаг.

ТОЙМ

- I. МЭНДЧИЛГЭЭ (1-3)
- II. ФИЛЕМОНЫ ТӨЛӨӨХ ПАУЛЫН ТАЛАРХАЛ БА ЗАЛБИРАЛ (4-7)
- III. ОНЕСИМЫН ТӨЛӨӨХ ПАУЛЫН ГУЙЛТ (8-20)
- IV. ТӨГСГӨЛИЙН ҮГ(21-25)

V. МЭНДЧИЛГЭЭ (1-3)

1-р ишлэл Паул өөрийгөө элч гэхийн оронд **хоригдол гэж** танилцуулж байна. Тэр өөрийн эрх мэдлийг ашиглаж болох байсан ч тэгэлгүй харин ч дорд байдлаас хандахыг сонгожээ. Тэгсэн хэрнээ элч маань доод байр сууриа тэнгэрийн алдараар чимэглэсэн байна. Тэрээр **Есүс Христийн хоригдол** ажээ. Тэр хэзээ ч өөрийгөө Ромын хоригдол гэж бөхөлзөж байгаагүй! Тэр эзэн хаанаас цаадахыг буюу хаадын Хааныг харж байна. Түүнийг энэ захидлаа бичиж байхад **Тимот** түүнтэй хамт байсан бөгөөд хэдийгээр тэр захидлыг өөрөө бичсэн боловч үүнийгээ итгэмжит дагалдагч Тимотод хамаатуулжээ.

Захидлыг үндсэндээ **Филемонд** хандаж бичсэн. Түүний нэр “хайрт” гэсэн утгатай бөгөөд Паул түүнийг **бидний хайрт болон хамтран зүтгэгч** гэснээс харахад нэрэндээ тохирсон хүн байсан бололтой.

2-р ишлэл **Апфиа** гэдэг нь эмэгтэй хүний нэр учраас эрдэмтэн судлаачид түүнийг Филемоны эхнэр гэж таамагладаг. Захидалд тэр эмэгтэйг

дурдан хандсан байгаа нь бидэнд христитгэл нь эмэгтэйчүүдийг өргөмжилдөгийг сануулж байна.² Дараа нь боолуудыг хэрхэн өргөмжлөхийг бид харах болно. Ариун хүмүүсийн төсөөллөөр **Архийп** Филемоны хүү байсан гэдэг. Бид үүнийг багтай мэдэхгүй ч түүнийг христитгэлийн тэмцэлд идэвхтэй оролцож явсныг нь мэднэ. Паул түүнийг **хамтран дайтагч** гэж хүндэтгэн нэрлэж байна. Бид түүнийг Эзэн Есүсийн ариун хүслээр дүрэлзсэн тууштай, цогтой дагалдагч байсан гэж төсөөлж болно. Колоссай номонд Паул түүнийг “Архийпт Эзэн дотор хүлээж авсан үйлчлэлээ биелүүлэхийн тулд үйлчлэлдээ анхаарал тавь гэж хэлээрэй” гэж онцлон анхаарчээ (Кол. 4:17).

Филемон, Апфия, Архийп нар ШГ-ний христитгэгч гэр бүлийн жишээ болж байгаа бол танай гэрт чинь цугладаг чуулган гэдэг үг ШГ-ний **чуулганы** дүр зургийг бидэнд харуулж байна. Үүнээс харахад Филемоны гэр орон итгэгч нарын цугладаг газар байсан нь тодорхой. Тэд тэнд магтан хүндлэхээр цуглаж, залбирч, Библи судалдаг байжээ. Тэндээсээ тэд мэдээг нь уриалгахан хүлээж авахгүй хэрнээ мартаж бас

чадахгүй тэр л дэлхий рүү Христийг гэрчлэхээр явцгаадаг байсан. Христитгэгчид Филемоны гэрт цуглаж байхдаа бүгд Есүс Христийн дотор нэг байсан. Баян ядуу, эрэгтэй эмэгтэй, эзэн боолгүй бүгд Бурханы гэр бүлийн даль жигүүр нь ургаж гүйцсэн гишүүд байв. Ажил хэргийн ертөнцөд орохоороо тэдний нийгмийн зэрэг дэв, ялгаа нь эргээд гарч ирнэ. Харин жишээ нь Эзэний зоогийг барихад тэд бүгд ялгаагүй ариун тахилч нарын түвшинд орно. Тэнд Филемон Онесимоос дээгүүр байр суурийг эзлэхгүй.

3-р ишлэл Паулын хэрэглэдэг түгээмэл мэндчилгээ хайртай хүмүүстээ хүсэн ерөөж чадах бүхнийг нь нэгтгэсэн байна. **Нигүүлсэл** гэж хүмүүс авах зохисгүй, Бурханы цутган асгаж өгдөг хувь завшааныг хэлнэ. **Амар тайван** гэдэг нь Түүний нигүүлслээр сургагдсан бүгдийн амьдралыг тогтоож өгдөг сүнсний амар амгалан ба тэнцвэр юм. Энэ хоёр ивээл хоёулаа **Бидний Бурхан Эцэг бөгөөд Эзэн Есүс Христээс** ирдэг. Энэ бол ач холбогдлоор дүүрэн зүйл. Энэ нь **Эзэн Есүс нигүүлсэл** болоод **амар тайвныг** өгөхийн хувьд **Бурхан Эцэгтэй** эн тэнцүү гэдгийг харуулна. Хэрэв Христ үнэхээр, бүрэн

дүүрнээр Бурхан биш байсан бол Түүнийг ингэж хүндлэх нь Бурханыг доромжилсон хэрэг болно.

VI. ФИЛЕМОНЫ ТӨЛӨӨХ ПАУЛЫН ТАЛАРХАЛ БА ЗАЛБИРАЛ (4-7)

4-р ишлэл Паул Филемоний төлөө залбирах бүрдээ энэхүү сайн ахынхаа төлөө **Бурханд** талархаж байна. Түүнийг анд найз эсвэл хуурай ах дүүс бололцож баймаар, Бурханы нигүүлслийг авууштай хүн гэж үзэх бүх шалтгаан бидэнд байна. Зарим тайлбарлагчид Паулыг тал засаж, Онесимийг хүлээн авахуулахын тулд Филемоны сэтгэлийг “зөөллөх” зорилгоор бичсэн гэдэг. Ингэвэл элчийг дотроо олиггүй санаа өвөрлөсөн мэт, Ариун Сүнсний амьсгалаар бичигдсэн үгийг хорон муу мэт болгож байна. Паул үнэн сэтгэлээсээ л хэлээгүй бол ингэж бичихгүй байх байсан.

5-р ишлэл Филемоны **Эзэн Есүст ба бүх ариун хүмүүст хандсан хайр ба итгэл** гэсэн хоёр чанар нь Паулд асар их баяр хөөрийг өгч байв. Христэд итгэх итгэл нь түүнд тэнгэрлэг амийн үндэс байгааг, **ариун хүмүүсийг** гэсэн

хайр нь үүний үр жимс ч байгааг харуулж байна. Түүний итгэл үйлстэй байв.

Ефес 1:15, 16 болон Колоссай 1:3, 4-д Паул захидал илгээсэн ариун хүмүүстээ үүнтэй төстэй талархал дэвшүүлсэн байдаг. Гэхдээ тэр үед хайр гэдгийн өмнө итгэл гэдэг үгийг тавьсан байсан. Энэ удаад хайрыг итгэлийн өмнө тавьжээ. Яагаад ийм ялгаатай байгаа хэрэг вэ? Үүнийг Макларен: “Энэ дараалал задлан шинжилгээний дараалал юм. Үр дүнгээс учир шалтгааныг ухан гаргажээ. Нөгөө ишлэлүүдэд үндэснээс нь цэцэг рүү өгсөж байгаа үр жимс бий болох дараалал байна” гэж тайлбарлажээ.

Энд Паулын бас нэг сонирхолтой илэрхийлэл харагдаж байна. “Бүх ариун хүмүүст хандсан хайр” гэсэн хэллэгийг **Эзэн Есүст хандсан итгэл** гэсэн үгийн дунд оруулжээ. Бид үүнийг “Эзэн Есүст (ариун хүмүүст хандсан хайр) итгэл” гэж бичиж болох юм. **Итгэл нь Эзэн Есүст, хайр нь бүх ариун хүмүүст хандсан** байна. Гэтэл Паул итгэлийн тухай гишүүн өгүүлбэрээр хайрын тухай гишүүн өгүүлбэрийг ороосон байна. Ингэснээр Филемонд боол Онесимдээ хайр үзүүлснээр итгэлээ бодит гэдгийг харуулах

онцгой боломж ирж байгаа тухай урьдчилан мэдэгдэж байгаа мэт. Иймээс энд *бүх* гэдэг үгийг - **бүх ариун хүмүүс** гэж онцолжээ.

6-р ишлэл Өмнөх хоёр ишлэл Филемоны төлөө талархсан Паулын талархал байсан. Энэ ишлэл нь түүний төлөөх элчийн залбирлыг агуулна. **Итгэлийн нөхөрлөл** гэдэг нь Филемоны бусдад үзүүлдэг практик энэрэл юм. Бид итгэлээ зөвхөн Христийг номлосноор биш харин өлссөнийг хооллож, нүцгэнийг хувцаслаж, өнчрөгсдийг тайвшруулж, дарлагдагсдыг чөлөөлж, тиймээ, оргосон боолоо уучилснаар хуваалцаж чадна. Паул дараа нь Филемоны энэрэлт сайхан сэтгэл олон хүнд хүрч түүний бүх сайн үйлс **Христ Есүсийн** улмаас ирж байгааг мэдүүлэх болтугай гэж залбирч байна. Бурханы хайр илэрхий харагддаг амьдрал аугаа хүчтэй бөгөөд нөлөөтэй. Хайрын тухай номноос унших нэг хэрэг, харин Үг хүний амьдралд биеллээ олохыг харах хичнээн хүчтэй вэ!

7-р ишлэл Филемоны бялхам өгөөмөр сэтгэл болоод өөрийгөө зольсон хайр нь Колоссайгаас гаран Ромд хүрч, Христийн хоригдолд **маш их баяр баясгалан**³ болон тайвшралыг авч ирэв.

Паулд Филемоныг Эзэн рүү хөтлөх агуу завшаан тохиожээ. Одоо тэр итгэлийн хүүгээ Эзэний төлөө сайн явааг нь сонсоод хичнээн их урамшсан бол доо. **Ариун хүмүүсийн зүрх** энэхүү хайрт **ахын** улмаас, ялангуяа түүний **хайрын** улмаас тэнхэрснийг дуулах хичнээн сайхан бэ. Хэн ч зөвхөн өөрөөрөө амьдардаггүй бөгөөд өөрөөрөө үхдэггүй. Бидний хийж байгаа үйлдлүүд бусдад нөлөөлдөг. Бид нөлөөнийхөө цар хүрээг хэмжиж чадахгүй. Бид сайныг болон бузар муут үйлдэх хязгааргүй их боломжтой.

VII. ОНЕСИМЫН ТӨЛӨӨХ ПАУЛЫН ГУЙЛТ (8-20)

8-р ишлэл Паул одоо захидлынхаа гол зорилгыг хөндөж байна. Тэр Онесимын төлөө зуучлан гуйх гэж байна. Тэр асуудлыг хэрхэн илэрхийлэх бол? Тэр элчийн хувьд Филемонд “За дүү минь, чи итгэгч хүний хувьд энэ оргодол боолоо эргүүлэн хүлээж авах ёстой. Тэг гэж би чамд хэлж байна” гээд хэлчихэж болох байсан. Паул тэгж тушааж болох байсан. Филемон ч үг

дуугүй дагах байсан. Гэхдээ тэгсэн бол энэ нь хоосон ялалт байх байлаа.

9-р ишлэл Элч Филемоны сэтгэлийг байлдан дагуулаагүй бол Онесимыг хүйтэн хөндий уур амьсгал угтах байсан болов уу. Гагцхүү хайраар хөглөгдсөн дуулгавар байж байж л энэхүү боол тэр гэрт боломжийн амьдрах байсан. Паул үүнийг бичиж байхдаа Аврагчийн хэлсэн “Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь” (Иох 14:15) гэдэг үгийг бодож байсан байх. Тиймд **хайрын улмаас** тушаахын оронд **хичээнгүйлэн гуйхаар** шийджээ. Филемоны хайр далайн чанадад, Эзэн Есүсийн төлөө хоригдсон, Христийн **настай** элчин сайдад⁴ хүрэх болов уу? Паул **настай**, бас **эдүгээ хоригдол** гэсэн хоёр шалтгааныг бодоод сэтгэл нь хөдлөх болов уу? Түүнийг энэ үед хэдтэй байсныг бид мэдэхгүй. Тавин гураваас жаран гуравын хооронд байсан гэж барагцаалдаг. Өнөөдөр үүнийг өндөр нас гэж үзэхгүй ч Христэд үйлчлэхийн төлөө өөрийгөө элээсэн тул наснаасаа эрт хөгширсөн байх. Тэгээд тэр одоо **Христ Есүсийн** төлөө **хоригдол** болсон. Ингэж хэлснээрээ тэр өрөвдүүлэх гээгүй ч Филемон

шийдвэр гаргахдаа энэ байдлыг харгалзаж үзээсэй гэж хүссэн.

10-р ишлэл Энэхүү ишлэлийн эх бичвэрт *Онесимын* нэр хамгийн сүүлд дурьдагдаж байгаа. “Би чамаас **хүлээтэй байхдаа төрүүлсэн** нэг хүүгийнхээ төлөө **гуйя**. Түүнийг минь **Онесим** гэдэг” гэж бичсэн гэсэн үг. Энэ адлагдсан боолын нэрийг сонсох үедээ Филемон хэдийнээ уярсан байв. Тэр “өөдгүй новш” эзэнд итгэснээр барахгүй хоригдол Паулаар дамжуулан итгэсэн гэдгийг сонсоод яаж гайхсан бол гэдгийг төсөөлөх гээд үз.

Бурхан Өөрийгөө илчлэхдээ санамсаргүй гэхийн аргагүй алмайран гайхмаар нөхцөл байдал, арга замаар дамжуулан ажиллахыг харах нь христитгэлт амьдралын далдлагдсан таашаалуудын нэг болой. Паул эхлээд Филемоныг Эзэн рүү авч ирсэн. Тэгээд хожим элч баривчлагдаад шүүгдэхээр Ромд хүргэгдсэн. Тэгтэл Филемоны боол оргож яваад Ромд ирж. Ямар замаар яаж явсан юм, тэр Паултай учирч Эзэнд итгэжээ. Эзэн боол хоёулаа нэг хүнээр дамжин дахин төрсөн, гэхдээ хоёр өөр газар хоёр

өөр нөхцөл байдалд. Энэ тохиолдол байсан гэж үү?

11-р ишлэл Онесим гэдэг нэр **ашигтай** гэсэн утгатай. Гэхдээ түүнийг оргож одоход Филемон түүнийг хэрэггүй амьтан гэж дуудмаар байсан байх. *Тиймээс ч* Паул “**Тэр чамд урьд нь ашиггүй байсан боловч, харин одоо чамд ч, надад ч ашигтай**” гэж хэлсэн байна. Филемоноос зугтсан боол илүү дээр болоод эргэж ирэв. ШГ-ний цаг үед христитгэлт боолууд итгэдэггүй боолуудаас илүү үнэлэгддэг байсан гэдэг. Өнөөдөр ч христитгэлт ажилтан итгэдэггүй ажилтнаас илүү үнэ цэнэтэй байх учиртай.

12-р ишлэл Энэ захидалд боолыг үзэх ШГ-ний хандлага тодорч байна. Паул боолчлолыг буруутгах буюу хориглоогүй нь анзаарагдаж байна. Тэр ч бүү хэл Онесимыг эргүүлээд эзэн рүү нь явуулж байна. Гэхдээ боолтой зүй бус харьцаж, хүчирхийлэхийг ШГ тууштай буруутган, хоригложээ. Макларен бичихдээ:

Шинэ гэрээ нийгэм улс төртэй шууд хутгалдаагүй боловч эдгээрт гүнзгий

нөлөөлөх зарчмуудыг суулган, хүний оюун санаанд шингээж өгсөн.⁵

Нийгэмд бугласан бузар мууг хүч түрэн эргэлт хийх замаар өөрчил гэж Библи заадаггүй. Хүний хүнлэг бус байдлын шалтгаан өөрийнх нь муудсан мөн чанарт оршдог. Сайн мэдээ түүний үндсийг довтолж Христ Есүсийн дотор шинэ бүтээл төрүүлдэг.

Сайн эзэнтэй боол толгой дааж амьдарснаас дээр байсан байх боломжтой. Есүс Христийн боол болох итгэгчдийн хувьд энэ бол үнэн. Түүний боолууд эрх чөлөөг жинхэнэ утгаар нь эдэлдэг. Паул Онесимыг Филемон уруу **буцааж явуулсан** нь боолд шударга бус хандаж байгаа хэрэг биш. Эзэн боол хоёулаа итгэгчид байсан. Филемон түүнд христитгэлт сайхан сэтгэлээр хандах үүрэгтэй. Онесим христитгэлт итгэмжит хандлагаар үйлчлэх үүрэгтэй. Онесимыг гэсэн сэтгэлийн гүнээс гарах хайр нь тэр **миний зүрх билээ** гэдэг үгнээс харагдаж байна. Паулд өөрийнхөө нэг хэсгийг таслаад өгчихөж байгаа юм шиг санагдаж байсан байх.

Өр, авлагыг буцааж төлөх тухай чухал зарчим энд байгааг анзаарах хэрэгтэй. Онесим аврагдсан

юм чинь өмнөх эзэндээ буцаж очих шаардлага байна уу? Хариулт нь мэдээж “тийм”. Аврал нүглийн хүч болон шийтгэлийг зайлуулдаг гэхдээ өрийг хүчингүй *болгохгүй*. Дөнгөж Христэд итгэсэн хүн төлөөгүй данс тооцоогоо төлж, хүний хувьд буруудсанаа засах боломжтой бүхнийг залруулах үүргийг хүлээнэ. Онесим эзэндээ буцан очиж үйлчлэх, хулгайлсан бүхнээ эргүүлэн төлөх ёстой байв.

13-р ишлэл Элч хувьдаа Онесимыг Ромд үлдээж, **дэргэдээ байлгахыг** илүүд үзэж байв. Сайн мэдээний төлөө хоригдоод байгаа түүнд, шинэхэн итгэсэн боол маш ихийг хийж өгч чадах байсан. Ингэвэл Филемон ч элчид туслагч өгснөөрөө **үйлчилсэн** хэрэг болох байлаа. Гэхдээ энэ нь Филемонд мэдэгдэлгүйгээр, түүний зөвшөөрөлгүйгээр хийгдэх байсан сул талтай.

14-р ишлэл Паул Онесимыг Ромд үлдээн эзэнээс нь элэгсэг занг албадлагаар гаргуулахгүй. Тэрээр Онесимтэй **холбоотой ямар ч үйлдлийг Филемоны зөвшөөрөлгүйгээр** хэзээ ч хийхгүй. Сайн зүйл нь сайн дураар буюу

хайрын улмаас биш **албадлагаар** хийгдвэл амт нь үгүй болно.

15-р ишлэл Тухайн цаг үеийн зовлон бэрхшээлийг биш харин түүнээс цаадахыг харах буюу Бурхан Түүнд хайртай хүмүүсийн сайны төлөө бүхнийг хамтад нь ажиллуулдагийг харна гэдэг бол сүнсний төлөвшлийн шинж тэмдэг. Онесим оргоход Филемон гашууран хорсож, өөрийнхөө санхүүгийн хувьд алдагдал мэдэрсэн биз. Тэр боолоо дахин харах болов уу? Паул одоо бараан үүлэн дундаас солонго татуулж байна. Онесим Колоссай дахь гэр бүлдээ үүрд буцаан авагдахын тулд түр салж төөрсөн байж. Итгэгч ах дүү, анд нөхөдөө үхэлд алдахад христитгэгчид ингэж тайвшрах учиртай. Энэ салалт түр зуурынх харин дахин уулзахдаа үүрд хамт байна.

16-р ишлэл Филемон Онесимыг хүлээн аваад зогсохгүй түүний урьд өмнө мэддэг ч үгүй байсан хавьгүй илүү дээр нөхцлөөр хүлээн авч байна. Одоо нөгөө байдаг л эзэн-боолын харьцаа үгүй болно. Онесим одоо **боолоос ч илүү байх** бөгөөд харин **Эзэний дотор хайрт дүү** нь болжээ. Одооноос эхлээд айдас биш хайр түүнийг

хөдөлгөнө. **Хайрт дүүгийн** нөхөрлөлийг Паул хэдийнээ амталсан. Гэхдээ одоо тэр Ромд үлдэхгүй нь. Элчийн гарз нь Филемоны олз болох нь. Тэрээр одоо Онесимыг **махан биеийн ч дотор, Эзний ч дотор** ах дүү нь болсныг мэднэ. Урьдын боолын хувьд **махан биеийн дотор** зориулалттай үйлчилж, итгэгчийн хувьд **Эзний дотор** нөхөрлөлийг өгч Паулын хэлсэнийг зөвтгөн харуулах ажээ.

17-р ишлэл Элчийн хүсэлт гайхалтай зоригтой, бас зөөлөн эерүү байна. Паул Филемонаос элчийг өөрийг нь хүлээн авахтай адил Онесимыг хүлээн аваарай гэж хүсжээ. Тэрээр **“Иймд хэрэв чи намайг хамтрагч гэж тооцож байгаа бол намайг хүлээн авахын адил түүнийг ч хүлээн ав”** гэж хэлжээ. Энэ үг Эзний хэлсэн **“Та нарыг хүлээн авсан хүн Намайг хүлээн авсан хэрэг юм. Намайг хүлээн авсан хүн Намайг илгээсэн Түүнийг хүлээн авсан хэрэг юм”** (Мт 10:40), **“Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь, тэр байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг”** (Мт 25:40) гэдэг үгтэй төстэй байна. Мөн Бурхан биднийг Өөрийн Хүү мэт үзэж хүлээн авдаг

буюу Бурханы хувьд бид Христийн нэгэн адил нандин бөгөөд ойр дотно гэдгийг эдгээр үгс бидэнд сануулж байна.

Элч Филемонд “чи намайг **хамтрагчаа гэж** үзэж байгаа бол Онесимыг ч ингэж үзэн хүлээн ав” гэжээ. Ингэх нь тэр гэр бүлээс Онесимыг байнга гийчин шиг ажил хийлгэхгүй байлга гэж шаардсан хэрэг биш ээ. Онесим тэр айлын боол хэвээрээ байгаа, гэхдээ Христэд харьяалагддаг тул итгэлийн ахан дүү байх юм.

18-р ишлэл Энд Онесимыг Филемоноос ямар нэгэн юм хулгайлсан гэж хэлээгүй боловч тиймэрхүү санаа цухуйлгаж байна. Хулгай бол боолуудын томоохон гэм нүгэл байсан нь тодорхой. Филемонд учирсан байж болох ямар ч хохирол алдагдлыг Паул төлж барагдуулахад бэлэн байна. Нөхөн төлбөр хийгдэх ёстойг тэр хүлээн зөвшөөрч байна. Онесим аврагдсан ч хүнд тавьсан өрнөөс чөлөөлөгдөхгүй. Тиймээс Паул Филемонд **өрийг нь надтай тооцоорой** гэжээ.

Үүнийг уншаад нүгэлт бид ямар их өртэй байхад тэр бүгдийг Голготын толгод дээр Эзэн Есүст оноосныг санахгүй байхын аргагүй. Тэр

бидний өмнөөс үхэхдээ бүх өрийг дарсан. Түүнчлэн бидэнд Христийн өмгөөлөгчийн үйлчлэлийг ч энд сануулж байна. Ах дүүсийг буруутгагч Сатан бидний хийсэн гэм нүглийн төлөө биднийг буруутган дайрахад ивээлт Эзэн “Үүнийг надтай тооц” гэж хэлдэг. Энэ номонд эвлэрүүллийн сургаалыг дүрсэлжээ. Онесим буруу зүйл хийснээсээ болж Филемоноос хөндийрсөн. Паулын үйлчлэлийн улмаас (ингэж итгэх бүх нотолгоо бидэнд байгаа) тэрхүү орон зай болон “дайсагнал” арилсан. Боол эзэнтэйгээ эвлэрсэн. Түүнчлэн бид гэм нүглээсээ болоод Бурханаас холдсон байв. Гэхдээ Христийн үхэл ба амилалтаар дайсагналын шалтгаан зайлуулагдаж, итгэгчид Бурхантай эвлэрсэн.

19-р ишлэл Паул ер нь захидал бичихдээ бичих үгээ хэн нэгэнд хэлж өгөөд нөгөө хүн түүнийг нь цаасан дээр буулгадаг, тэр өөрөө зөвхөн төгсгөлийн мөрүүдийг **өөрийн гараар** бичдэг байсан. Тэр энэ захидлыг бүхэлд нь өөрөө бичсэн эсэхийг мэдэхгүй. Харин энэ мөчид тэрээр үзгийг авч Онесимын тавьсан өр, учруулсан хохирлыг өөрөө төлнө гэдгээ өөрийн гараар бичжээ. Ингэхдээ Паул Филемон өөрт нь

томоохон өртэй байсан ч төлнө гэсэн байна. Паул түүнийг Эзэн рүү аваачсан. Бурханы ашигласан хүний хувьд Филемон түүнд сүнсний амьдралынхаа төлөө өртэй. Гэхдээ Паул өрөө төл гэж шахаагүй.

20-р ишлэл Настай Паул Филемоныг дүү гэж дуудан Эзэн доторх ашиг, Христ доторх сэргэлтийг л хүссэн. Онесимыг нигүүлсэн хүлээн авч уучлаад, тэр гэрт хийдэг байсан ажлыг нь буцаан олгоод боол шигээ биш харин Бурханы гэр бүл дэх ах дүү шигээ хандахыг хичээнгүйлэн гуйсан.

VIII. ТӨГСГӨЛИЙН ҮГ (21-25)

21-р ишлэл Филемон өөрийнх нь хүссэнээс илүү ихийг хийнэ гэдэгт Паул бүрэн итгэж байв. Тэр өөрөө Христээр үнэ төлбөргүй уучлуулсан. Тиймээс тэр Онесимд түүнээс дутуугүй хандах нь тодорхой. Тэгэхээр бидэнд “Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биеэ уучлан, нэг нэгнээ энэрч уян зөөлөн сэтгэлээр ханд” гэх Ефес 4:32-ын бодит жишээ энд байна.

22-р ишлэл Гэвч Филемон Онесимд яаж хандсаныг Паул хэрхэн мэдэх вэ? Тэр Колоссай хот уруу очиж, Филемоныд зочилно гэж найдсан. Христитгэгчдийн **залбирлын** хариуд төр засгаас түүнийг шоронгоос суллана гэж тэр горьдож байв. Тэгээд тэр Филемоноос надад **байр бэлдээрэй** гэж хүссэн. “Бидний ах Паулд байр бэлд” гэсэн нь Онесимд оногдсон анхны үүрэг даалгавар байсан ч байж болох юм. Паул Колоссай хотод очиж чадсан эсэхийг бид мэдэхгүй. Гэхдээ түүнд зориулан бэлдсэн **байр** байсан, тэр гэр бүлийн гишүүн нэг бүр түүний ирэхийг тэсэн ядан хүлээж байсан, тэдний зүрх сэтгэл хайраар холбогдон уяатай байсан гэж таамаглаж болох юм.

23-р ишлэл *Енафр* гэгч нь Колоссайд чуулган тарьсан хүн байж мэднэ (Кол 1:7, 8, 4:12, 13). Одоо Паултай **хамт хоригдсон** тэр Филемонд, Ромоос хамт мэнд хүргэж байна.

24-р ишлэл Энэ цагт Паултай **Марк, Аристарх, Дем ба Лук** хамт байв. Энэ нэрс Колоссай 4:10, 14-д ч дурьдагдсан. Харин Иуст хэмээгч Есүсийг Колоссай 4-д дурьдсан боловч ямар нэг шалтгааны улмаас түүний нэрийг энд

дурьдалгүй өнгөрчээ. **Марк** бол сайн мэдээний хоёрдугаар номыг бичигч. Тэрээр анх алдаа гаргасныхаа дараа Эзэний итгэмжит зарц болохоо харуулсан (2Тм 4:11-ийг Үйл 13:13, 15:36-39-тэй харьцуул). Тесалоникийн итгэгч **Аристарх** Паулын хэд хэдэн аялалд хань болж явсаны дотор Ром уруу ч хамт явсан бөгөөд Колоссай 4:10-д Паул түүнийг “надтай хамт хоригдогч” гэж хэлжээ. **Дем** хожим нь энэ ертөнцийг хайрлаад Паулыг орхиж явсан хүн (2Тм 4:10). Лук бол хайрт эмч, итгэмжит хамтрагч бөгөөд эцсээ хүртэл туслагч гэдгээ батлан харуулсан хүн (2Тм 4:11).

25-р ишлэл Энэ захидал Паулын хүн бүрд хувьчлан хандсан адислалаар өндөрлөж байна. Тэр бидний **Эзэн Есүс Христийн нигүүлсэл** Филемоны **сүнстэй хамт** байхыг ерөөжээ. Амьдралд, алхам тутамд, хариу нэхэлгүй өгөх Аврагчийн нигүүлслээс агуу ивээл гэж юу байх билээ. Түүний мөн чанар болоод ажил үйлсийг байнга мэдэрч, түүнд нь баярлан баясахаас илүү юуг хүний зүрх сэтгэл хүсэж чадах билээ.

Паул үзгээ тавиад захидлаа Филемонд хүргүүлэхээр Тухикт гардуулан өгөв. Энэ

захидал нь хичнээн зуунд христитгэгчдийн зан чанарт ямар их нөлөө үзүүлэхийг тэр төсөөлөөгүй биз ээ. Энэ захидал бол бичигдэж байх үедээ ч, өнөөдөр ч хайр ба эелдэг боловсон зангийн сонгодог бүтээл мөн. **Амен.**

Нэмэлт тайлбар

Ефес

1 (Оршил) Виллиям Г. Муурхээд, *Үйлс ба захидлуудын гарчиг судлал*, т.214

2 (1:3) Луис Спери Чафер, *Ефесийн захидал*, т.74

3 (1:4) В.Г.Блейки, “Ефес”, *Номлогчийн тайлбар толь*, XLVI:3

4 (1:10) Жон Г.Беллет, *Ефест хандсан захидлын тэмдэглэл*, т.6, 7

5 (1:17) Р.В.Дейл, *Ефест хандсан захидал, түүний сургаал, ёс зүй*, т.133

6 (1:19) Ф.Б.Мейер, *Дотоод амьдралын түлхүүр үгс*, т.92

7 (1:19) Чафер, *Ефесийн захидал*, т.57

8 (1:20) Мейер, *Түлхүүр үгс*, т.93

9 (2:3) Дээрхтэй адил, т.140

10 (2:4) Жон Ийдий, *Ефест хандсан захидлын тайлбар толь*, т.141

11 (2:5) А.Т.Пийрсон, “Итгэгчийн төлөө хийсэн Христийн ажил”, *Кесвикийн үйлчлэл, Эхний цуврал*, т.118, 119

12 (2:7) Заримдаа 1Ко 13:12 ба 1Иох 3:2 ашиглан бид тэнгэрт бүхнийг мэддэг болно гэж нотлох гэдэг. Гэтэл эхний ишлэлд тэнгэрт бие биеэ танина гэж хэлсэн бол удаахад ёс суртахуун ба махбодын хувьд Христтэй адил болох тухай өгүүлсэн.

13 (2:18) Ийдий, *Ефес*, т.187

14 (2:21) Блейки, *Ефес*, XLVI:68

15 (3:1) Рут Паксон, *Христигээгчийн ахуй баялаг, амь амьдрал, аян дайн*, т.57

16 (3:4) Блейки, *Ефес*, XLVI:104

17 (3:8) Дээрхтэй адил, XLVI:105, 106

18 (3:16) Жемисон, Фоссет ба Браун, *Бүхэл Библийн практик тайлбар толь*, VI:408

19 (3:17) В.Грэм Скрожи, “Паулын шоронд байхдаа өргөсөн залбирал”, *Кесвикийн үйлчлэл, Хоёрдугаар цуврал*, т.49

20 (3:18) Мейер, *Түлхүүр үгс*, т. 53, 54

21 (3:21) Жорж Виллиямс, *Ариун Бичээсийн талаарх суралцагчийн тайлбар толь*, т.925

22 (4:2) Вольтер С. Вraith, *Ефес*, т.85

23 (4:10) Ф.В.Грант, “Ефес”, *Тоот Библи, Үйлсээс 2 Коринт*, VI:341

24 (4:11) “Гранвилл Шарпын дүрэм”-ийн дагуу (грек хэлнээ) офис, албан тушаал эсвэл чанар заасан хоёр нэр үгийг *kai (ба)* гэсэн үгтэй хэрэглэгдэхдээ, ялангуяа эхнийх нь тодорхойлогч угтвар үгтэй байвал нэг хүний тухай хэлж байдаг. Хэлзүйн энэхүү бүтцийн нэг жишээ нь 2Пт 1:1-д гардаг “бидний Бурхан ба Аврагч Есүс Христ”. Олон тоон дээр энэ дүрэм тэр бүр үйлчилдэггүй.

25 (4:12) Ванц Хавнер, *Яагаад зүгээр христитгэгч байж болохгүй гэж?* т.63

26 (4:15) Блейки, “Ефес”, XLVI:150

27 (4:19) Вraith, *Ефес*, т.100

28 (4:21) Блейки, “Ефес”, XLVI:151

29 (4:24) Грант, “Ефес”, т.344

30 (4:32) Р.С.Х.Ленски, *Галат, Ефес, Филиппойд хандсан элч Паулын захидлуудын тайлбар*, т.588

31 (5:2) Мейер, *Тэнгэрлэг газрууд*, т.25

32 (5:13) Блейки, “Ефес”, XLVI:209

33 (5:21) Чарльз Р.Эрдман, *Ефес*, т.106

34 (5:27) Пийрсон, “Христийн ажил”, т.138

35 (5:27) Грант, “Ефес”, VI:350

36 (6:4) Виллиям В.Орр *Хүүхэд өсгөх Библийн санаанууд*-ад иш татсан, т.19

37 (6:6) Эрдман, *Ефес*, т.119

38 (6:17) Энд Паул олон хүний мэддэг logos гэдэг үгийг биш харин тема гэсэн үгийг хэрэглэсэн нь тодорхой хэрэгцээнд Бурханаас тодорхой үг өгөгдөхийг хэлж байгаа.

39 (6:17) Давид Ватсон, *Дагалдагч*, т.183

40 (6:19) Блейки, “Ефес”, XLVI:260

41 (6:20) Ийдий, *Ефес*, т.480

42 (6:24) Х.В.Вебб-Пепло, “Паулын дөрвөн захидлын нигүүлсэл ба амар тайван”, *Кесвикийн үйлчлэл, Эхний цуврал*, т.69

Филиппой

1 (Оршил) Х.А.А.Кеннеди, “Филиппой”, *Тайлбарлагчийн грек гэрээ*, III:407

2 (1:1) Ж.Х.Жовет, *Дээд дуудлага*, т.2

3 (1:7) В.Е.Ваин, *Филиппой ба Колоссайд бичсэн захидлууд*, т.23

4 (1:10) “Цэвэр” (eilikrines) хэмээн орчуулсан үг “хольцгүй” гэх утгатай, тэр байтугай “нарнаас хамгаалагдсан” гэсэн утгатай байж болзошгүй.

Англи хэлнээ *sincere* гэсэн үг нь “лавгүй” гэсэн утгатай аж. Чин сэтгэлтэй барималчин ямар нэгэн өө гарвал чулуугаа ухаж засдаг байсан бол чин сэтгэлгүй нь лаваар өөг нь засдаг байжээ. Гэхдээ нарны туяанд лав нь хайлах учир тэрхүү баримлын өө нь харагддаг байна.

5 (1:11) Лейман Штраусс, *Филиппой номны бишрэлийн судлал*, т.63

6 (1:13) Т.В.Друри, *Элч Паулын шоронд байхдаа явуулсан үйлчлэл*, т.22

7 (1:20) Гаи Кинг, *Баярын зам*, т.33

8 (1:21) Жовет, *Дуудлага*, т.34

9 (2:1) Ф.Б.Мейер, *Филиппой номын бишрэлийн тайлбар*, т.77-79

10 (2:5) Кинг, *Баярын зам*, т.51

11 (2:6) Е.Х.Гиффорд, *Биежилт*, т.44, 45

12 (2:11) Чарльз Р.Эрдман

13 (2:17) Жорж Виллиямс, *Ариун Бичээсийн суралцагчийн тайлбар толь*, т.931

14 (3:7) Кинг, *Баярын зам*, т.51

15 (3:10) Жовет, *Дуудлага*, т.217

16 (3:10) Дээрхтэй адил, т.81, 82

17 (3:10) Хадсон Гейлорын хэлсэн үгийг хатагтай Ховард Гейлор иш татсан ном *Хязгаарын цаана*, т.170

18 (3:10) С.А.Көүтс, *Амьдралын зам ба бусад үгс*, т.202

19 (3:17) Штраусс, *Филиппой*, т.202

20 (4:3) “Хамтран зүтгэгч” (грекээр *sunzigos*) гэсэн нь Синзигус хэмээх хүний нэр байж болно.

21 (4:4) Жовет, *Өдөр өдрөөр*, т.169-171

22 (4:18) Дээрхтэй адил, т.225

23 (4:19) Виллиямс, *Суралцагчийн тайлбар толь*, т.934

24 (4:23) Паул Рийс, *Зохистой хүн*, т.127

Колоссай

1 (Оршил) Жорж Салмон, *Шинэ гэрээний номнуудыг судлах түүхэн удиртгал*, т.384

2 (Оршил) *Библийн Шинэ Тайлбар Толь*, т.1043

3 (Оршил) А.Т.Робертсон, *Паул ба сэхээтнүүд*, т. 16

4 (1:5) Ж.Б.Лаитфүүт, *Колоссай ба Филемонд элч Паулын бичсэн захидлууд*, т.134

5 (1:11) А.С.Пийк, “Колоссайчууд”, *Тайлбарлагчийн грек гэрээ*, III:499

6 (1:18) Алфред Мейс

7 (1:19) Энд ашигласан *oikeo* гэсэн үгийн хүч нэмэгдүүлсэн хэлбэр (*katoikeo*) нутаглах гэсэн утгатай

8 (1:22) Чарльз Р.Эрдман, *Колоссай ба Филемонд бичсэн Паулын захидал*, т.46

9 (1:23) Грек хэлэнд хэрэв гэсэн утгатай хоёр үг байдаг (ei ба ean) ба болзол илэрхийлсэн хэд хэдэн хэл зүйн бүтэц байдаг. Энд ei гэдэг үгийг еrimenete гэсэн нэгдүгээр ангиллын болзлыг илэрхийлсэн бүтэцтэй ашигласан (Паул тэднийг үргэлжид байна гэдэгт эргэлзэхгүй байгаа гэсэн утгатай)

10 (1:23) Придхам

11 (2:2) Алфред Мейс

12 (2:9) Марвин Винсент, *Шинэ гэрээний үг судлал*, II:906

13 (2:14) Х.А.В.Мейер, *Филиппойчууд ба колоссайчуудад хандан бичсэн захидлуудын шүүмж ба тайлбар судлал*, т.308

14 (3:2) Робертсон, *Сэхээтнүүд*, т.149

15 (3:2) Ф.Б.Хөүл, *Паулын захидлууд*, II боть, т.105

16 (3:11) Ж.С.Раил, *Ариун байдал*, т.436

17 (3:12) В.Е.Ваин, *Шинэ гэрээний тайлбар толь бичгийн үгс*, т.56

18 (4:2) Гаи Кинг, *Хил давсан нь*, т.111

19 (4:16) Нөгөө талаас Паул Ефест гурван жил өнгөрөөсөн болохоор олон хүн мэдэх тул хэдхэн хүнийг дурдвал бусдыг нь гомдоохоор байв.

Филемон

1 Ж.Б.Лаитфүүт, *Колоссай ба Филемонд элч Паулын бичсэн захидлууд*, т.317, 318

2 (2-р ишлэл) Христитгэгч эмэгтэйчүүдийн байр суурийг итгэдэггүй ба муслим эмэгтэйчүүдтэй харьцуулбал Эзэн Есүс Христийг “эмэгтэйчүүдийн Чөлөөлөгч” гэдгийг хүлээн зөвшөөрнө

3 (7-р ишлэл) Гар бичмэлүүдийн ихэнх нь *баяр хөөр (charan)* гэхийн оронд *талархал өгөх (charin)* гэсэн байдаг

4 (9-р ишлэл) Грек хэлний “настан” (*presbutes*) гэсэн үг *элч (presbeutes)* гэсэн үгтэй тун адилхан тул Бентли Паулыг “элч” гэж бичсэн хэмээжээ. Хэдийгээр сайхан сонсогдож байгаа ч эртний гар бичмэлүүд үүний эсрэг байна

5 (12-р ишлэл) Александер Макларен, “Колоссай ба Филемон”, *Тайлбарлагчийн Библи*, т. 461

гр. грек хэлээр

евр. еврей хэлээр

ШГ Шинэ гэрээ

ХГ Хуучин гэрээ